



НЭЭЛТТЭЙ  
НИЙГЭМ  
ФОРУМ

# ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН СУДАЛГАА

**ЦУВРАЛ 12**

Улаанбаатар, 2023

ННА 67  
ДАА 340  
Ш-978



## ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН СУДАЛГАА ЦУВРАЛ 12

СУДЛААЧИД:

Д.Ганхүрэл  
Б.Гүнбилэг  
А.Түвшинтөгс  
Э.Золзаяа

Дугаар хариуцсан редактор Д.Золжаргал

© Нээлттэй нийгэм форум, 2023.

Энэхүү цувралд багтсан судалгаануудын дүгнэлт, санал нь судалгааг хийж гүйцэтгэсэн судлаачдын байр суурь, үзэл бодол бөгөөд нээлттэй нийгэм форумын албан ёсны байр суурийг илэрхийлэхгүй болно.

ISBN 978-9919-9990-8-7

# Шүүхийн шийдвэрийн судалгаа

## ЦУВРАЛ 12



# 1

АМЬТНЫ УЧРУУЛСАН ГЭМ ХОРЫГ АРИЛГУУЛАХТАЙ  
ХОЛБОГДОХ ШҮҮХИЙН ШИЙДВЭРТ ХИЙСЭН ДҮН  
ШИНЖИЛГЭЭ

9

# 2

БЭЛЭГЛЭЛИЙН ГЭРЭЭГ ХҮЧИНГҮЙ БОЛГОХ БОЛОН  
ХҮЧИН ТӨГӨЛДӨР БУС ТООЦСОН ТАЛААР МАРГААН  
ШИЙДВЭРЛЭСЭН ШҮҮХИЙН ШИЙДВЭРТ ХИЙСЭН  
ДҮН ШИНЖИЛГЭЭ

73



## **ӨМНӨХ ҮГ**

“Шүүхийн шийдвэрийн судалгаа” цувралын энэхүү дугаараар иргэний хэргийн шүүхийн шийдвэрт хийгдсэн хоёр судалгааны ажлыг танилцуулж байна. Монгол Улсын их сургуулийн эрдэмтэн багш нараас бүрдсэн судлаач нар шүүхийн практикт нийтлэг биш хэдий ч эрх зүйн зохицуулалт, хэрэглээний хувьд нэг мөр болгох шаардлагатай, сонирхолтой сэдвүүдийг сонгон авч судалсан байна.

Бэлэглэлийн гэрээний хүрээнд үүсэх маргааныг шийдвэрлэхтэй холбоотой судалгааг А.Түвшинтөгс ахлагчтай судалгааны баг гүйцэтгэж, Нийслэлийн иргэний хэргийн давж заалдах шатны шүүгч Э.Золзаяа шүүмж бичсэн нь тухайн сэдэвт онолын болон практикийн өнцгийг тусгахад чухал ач холбогдолтой болжээ.

Амьтны учруулсан гэм хорын талаарх маргаан шийдвэрлэх нь шүүхийн практикт нийтлэг биш ч бэлчээрийн мал бусдад хохирол учруулах болон амьтан орон байранд тэжээх явдал нэмэгдэж буйгаас энэ төрлийн маргаан цаашид нэмэгдэх хандлага харж болно. Энэхүү сэдвээр МУИС-ийн ХЗС-ийн багш Д.Ганхүрэл, Б.Гүнбилэг нар судалж, сонирхолтой шийдвэрүүдийг түүвэрлэн дүн шинжилгээ хийсэн нь шүүгч, хуульч нарт хэрэгцээтэй эх сурвалж болно гэж найдаж байна. Судалгааны тайланд Редакцын зөвлөлийн гишүүн, судлаач Г.Оюунболд шүүмж өгч ажиллалаа.

Энэ удаагийн дугаарыг эрхэлсэн редактор, хуульч Д.Золжаргал болон нийт судлаач, шүүмжлэгч нартаа талархал илэрхийлж, цаашдын судлан шинжлэх үйлсэд нь амжилт хүсье. Уншигч Та манай [www.forum.mn](http://www.forum.mn) цахим хуудаснаас Шүүхийн шийдвэр судалгаа цувралын өмнөх дугаарууд болон холбогдох подкастуудыг хүлээн авах боломжтой бөгөөд санал шүүмжээ манай социал сувгуудаар дамжуулан ирүүлнэ үү.

ННФ-ын Гүйцэтгэх захирал  
П.Эрдэнэжаргал

## **РЕДАКТОРЫН ҮГ**

Шүүхийн шийдвэрийн судалгаа цувралын энэ удаагийн дугаарт практик ач холбогдол өндөр хоёр судалгааг багтаан олны хүртээл болгож байна.

Монгол Улсын Иргэний хуулийн Хорин гуравдугаар бүлэгт нэр заан зохицуулсан, нэг талт гэрээний томоохон төлөөлөл болох бэлэглэлийн гэрээний эрх зүйн зохицуулалтын талаарх ерөнхий судалгаа, тайлбар өмнө олонтаа хийгдсэн байдаг боловч бэлэглэлийн гэрээний бусад гэрээнээс ялгарах үндсэн зохицуулалтаас үүдсэн маргааныг шүүх хэрхэн авч үзэж, шийдвэрлэж байгаа талаарх анхны харьцуулсан судалгаа болж буйгаараа судлаач А.Түвшинтөгс, Э.Золзаяа нарын судалгааны ач холбогдол оршино.

Судлаачид бэлэглэлийн гэрээг Иргэний хуулийн 280 дугаар зүйлийн 280.1.1 дэх хэсэгт заасан “бэлэглэгчийг гомдоосон ноцтой үйлдэл хийсэн” үндэслэлээр хүчингүй болгох болон мөн хуулийн 56 дугаар зүйлийн 56.1.3, 56.1.8 дахь хэсгүүдэд заасны дагуу хүчин төгөлдөр бус байх хэлцэлд хамруулан үүсгэсэн маргааныг шийдвэрлэсэн шүүхийн 280 шийдвэрээс түүвэрлэн дүн шинжилгээ хийжээ.

Хууль тогтоогчийн зүгээс “бэлэглэгчийг гомдоосон ноцтой үйлдэл хийсэн” гэдгийг Иргэний хуульд объектив байдлаар нарийвчлан зохицуулалгүй, улмаар ямар үйлдлийг хамааруулан ойлгохыг хууль хэрэглэх бүрэн эрхийнхээ хүрээнд субъектив үзэмжээрээ тогтоох эрхийг шүүгчид олгосон. Гэвч шүүх энэ асуудлыг хэт ялгамжтай авч үзэж, улмаар холбогдох маргааныг хуулийн өөр өөр үндэслэлээр шийдвэрлэж байгаа нь тодорхой бус байдал үүсгэж байна хэмээн судлаачид үзэж, БНХАУ, ХБНГУ, БНСУ-ын хуулийн зохицуулалттай харьцуулсны үндсэн дээр хэм хэмжээний болон хууль хэрэглээний талаар бодит санал дэвшүүлснийг та бүхэнд хүргэж байна.

Харин судлаач Б.Гүнбилэг, Д.Ганхүрэл нарын хувьд гэрээний бус үүрэгт хамаарах “амьтны учруулсан гэм хорыг хариуцах” асуудлыг зохицуулсан Иргэний хуулийн 501 дүгээр зүйлийг хэрэглэж шийдвэрлэсэн зургаан шүүхийн шийдвэрийг судалжээ. Эдгээр шийдвэр нь галзуурсан адуу хүн хазсан хэрэг, тээврийн хэрэгсэл адуутай мөргөлдсөн хэрэг, адуутай харьцах үедээ унаж бэртсэн хэрэг, адуун сүрэг тариалангийн талбай талхалсан хэрэг, нохойд хазуулж эрүүл мэндээрээ хохирсон хэрэг, нохой нохойгоо хазаж гэмтээсэн хэрэгт холбогдох хэргүүд байна. Энэхүү судалгааны хүрээнд ХБНГУ болон Япон улсын холбогдох хууль тогтоомжийг мөн харьцуулан судалсан нь сонирхолтой дүгнэлтэд хүргэжээ.

Судлаачид Иргэний хуулийн 501 дүгээр зүйлийн зохицуулалтад хамаарах “амьтан” гэдэгт юуг ойлгох, амьтны учруулсан гэм хорыг хэн хариуцах талаар судлан өөрсдийн байр сууриа илэрхийлэхдээ бэлчээрийн мал аж ахуйн хувьд өв уламжлалыг харгалзан үзэх ёстойг дурдаад, амьтны эзэн гэм буруутай эсэхээс үл хамааран хариуцлага хүлээх тухай 501.1 дэх заалт, амьтны эзэн гэм буруутай (санаатай, илтэд болгоомжгүй) тохиолдолд хариуцлага хүлээх 501.2 дах зүйлийн зохицуулалтад шүүмжлэлтэй хандсан байна.

Судалгааны үр дүнд судлаачид “гэрийн тэжээвэр амьтан” болон “мэргэжлийн үйл ажиллагааны зүйл болдог амьтан”-ы талаарх байр сууриа илэрхийлэн, улмаар таван хошуу малын учруулсан гэм хорыг Иргэний хуулийн 501 дүгээр зүйлийн аль заалтаар зохицуулбал илүү зохимжтой талаар бодит санал дэвшүүлсэнтэй та бүхэн танилцана уу.

Нийт судлаачиддаа цаашдын эрдмийн ажилд нь амжилт ерөөн, судлаачдын үзэл бодол, судалгааны эрх чөлөөг хүндэтгэхийг нийт уншигчдаасаа хүсье.

Дугаар эрхэлсэн редактор Д.Золжаргал



# I

## АМЬТНЫ УЧРУУЛСАН ГЭМ ХОРЫГ АРИЛГУУЛАХТАЙ ХОЛБОГДОХ ШҮҮХИЙН ШИЙДВЭРТ ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

### СУДЛААЧДЫН ТАНИЛЦУУЛГА



#### **ДАМБЫН ГАНХҮРЭЛ**

2017 онд МУИС-ийн Хууль зүйн сургууль, Япон Улсын Нагояагийн их сургуулийн эрх зүйн хөтөлбөрийг зэрэг дүүргэн Японы Чүо их сургуульд хууль зүйн магистрын зэрэг хамгаалсан. Одоо МУИС-ХЗС-ийн Хувийн эрх зүйн тэнхимд багшилж байгаа бөгөөд үүргийн, өмчийн, гэрээний болон гэм хорын эрх зүйгээр мэргэшин тогтмол судалгаа явуулж байна.



#### **БОЛДБААТАРЫН ГҮНБИЛЭГ**

Хууль зүйн ухааны доктор, МУИС-ХЗС-ийн ахлах багш. УИХ-ын даргын ахлах зөвлөх, Монголын Хуульчдын Холбооны Ерөнхийлөгч, өмгөөлөгч, арбитрч, Хууль зүйн Үндэсний Хүрээлэнд эрдэм шинжилгээний ажилтан, эрдэмтэн нарийн бичгийн даргаар ажиллаж байсан туршлагатай.

Судлаачид:

Д.Ганхүрэл  
Б.Гүнбилэг

## **АГУУЛГА**

УДИРТГАЛ.....	11
НЭГ. МОНГОЛ УЛС ДАХЬ АМЬТНЫ УЧРУУЛСАН ГЭМ ХОРЫН ЭРХ ЗҮЙН АСУУДАЛ.....	14
1.1. ЗОХИЦУУЛАЛТ, ТҮҮНИЙ ҮЗЭЛ БАРИМТЛАЛ.....	14
1.2. УРЬДЧИЛСАН НӨХЦӨЛ, НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ.....	15
1.3. ҮГҮЙСГЭХ НӨХЦӨЛ.....	18
ХОЁР. ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭ.....	22
2.1. МАЛЫН УЧРУУЛСАН ГЭМ ХОРЫН ТОХИОЛДОЛ.....	23
2.2. ГЭРИЙН ТЭЖЭЭВЭР АМЬТНЫ УЧРУУЛСАН ГЭМ ХОРЫН ТОХИОЛДОЛ.....	44
ГУРАВ. ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА.....	52
3.1. ХБНГУ.....	53
3.2. ЯПОН УЛС.....	60
ДҮГНЭЛТ, САНАЛ.....	64
АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ.....	70

## УДИРТГАЛ

Хүн төрөлхтөн эртнээс амьтныг гаршуулан тэжээж, тэдгээрийг аж ахуйн болон амины хэрэгцээндээ өсгөж ирсэн билээ. Амьтан нь эрх зүйн чадамжгүй бөгөөд тухайн эзнийхээ өмч хөрөнгөд тооцогддог. Энэ үүднээс өөрийнх нь өмчөөс улбаатай үр дагаврыг тэдгээрийн эзэн нь хариуцан арилгах үүрэгтэй. Энэ хүрээнд аль Ромын эрх зүйгээс амьтны учруулсан гэм хорыг түүний эзэн хариуцах тогтолцоо байсан бөгөөд энэ тогтолцоо одоо ч ач холбогдолтой хэвээр байна.

Учир нь, дэлхий дээр маш олон тооны амьтад хүний нийгэмд бидний ойролцоо хамт амьдарч байх бөгөөд амьтны ухамсаргүй буюу инстинктээр бусдад хохирол учруулах эрсдэл их бага хэмжээгээр байсаар байна. Ялангуяа, гэрийн тэжээвэр амьтад хүнтэй илүү ойр хүрээлэлд байх бөгөөд тэдгээрт зориулсан хууль, дүрэм, зохицуулалтыг улс бүр өөрийн онцлогт тохируулан харилцан адилгүйгээр бий болгож байна. Маргаангүй, зөрчилдөөнгүй харилцаанд зохицуулалт шаардлагагүй. Хууль дүрмээр зохицуулах шаардлага үүсэж байна гэдэг нь тухайн харилцаанд оролцогчид өөрсдөө хэлэлцэн тохиролцож шийдэлд хүрч чадахгүйг илтгэнэ.

Манай улсын хувьд, бэлчээрийн мал аж ахуйд суурилсан хөдөө аж ахуйтай байсан боловч сүүлийн жилүүдэд газар тариаланг түгээмэл эрхлэх нь элбэгшжээ. Үүнээс улбаатай бэлчээрийн мал тариалангийн талбай сүйтгэх зэрэг асуудал цөөнгүй гарч буй бөгөөд түүнээс бий болох хохирлыг хэн хэрхэн хариуцах вэ гэдэг нь тийм ч илэрхий тодорхой бус байна. Түүнчлэн, орон нутгийн

засмал зам дээр адуу, үхэр зэрэг бод мал тээврийн хэрэгсэлтэй мөргөлдөж осол гарах тохиолдол их биш боловч нэлээдгүй гардаг. Түүнчлэн, адуунд өшиглүүлсэн, хазуулсан тохиолдлуудыг ч дурдаж болно. Мөн суурин газарт нохойд хазуулж эрүүл мэнд болон эд хөрөнгөөрөө хохирох явдал цөөнгүй гарсаар байна.

Тодруулбал, 2020 онд Монгол Улсын хэмжээнд нохойд хазуулсан шалтгаанаар осол, гэмтэлд өртөж, эмнэлгийн байгууллагад хандсан нийт 3,855 тохиолдол бүртгэгджээ. Нохойд хазуулсан шалтгаанаар бэртсэн хүмүүсийг насны бүлгээр авч үзвэл 37 хувь нь 0-15 насны хүүхдүүд, тэр дундаа 5-9 насны хүүхдүүд гэмтэж бэртсэн тохиолдол 17 хувийг эзэлж байна.<sup>1</sup>

Дээрх шиг амьтны учруулсан гэм хорыг хэн хэрхэн хариуцахтай холбоотой харилцааг Иргэний хуулийн 501 дүгээр зүйлээр зохицуулдаг. Энэ заалт нь ерөнхий зохицуулалт бөгөөд амьтны учруулсан гэм хорд холбогдох тухайн тохиолдлоос шалтгаалаад дэлгэрэнгүй тайлбар хийх шаардлагатай. Энэ асуудлыг, шүүх хуулийн зохицуулалт ерөнхий байна гээд орхих бус, түүнийг тодорхой тохиолдлуудад тайлбарлан хэрэглэж эрх зүйн жишиг бий болгох замаар шийдвэрлэх боломжтой.

Тиймээс энэхүү судалгаагаар дамжуулан Иргэний хуулийн 501 дүгээр зүйлийг тодорхой хэрэг маргаануудад хэрхэн тайлбарлан хэрэглэж буй талаар шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээ хийх замаар тэдгээр тайлбар нь маргааныг зохистойгоор шийдвэрлэж чадаж буй эсэхэд дүгнэлт хийхийг зорилоо.

Энэ хүрээнд, галзуурсан адуу хүн хазсан хэрэг, тээврийн хэрэгсэл адуутай мөргөлдсөн хэрэг, адуутай харьцах үедээ унаж бэртсэн хэрэг, адуун сүрэг тариалангийн талбай талхалсан хэрэг, нохойд хазуулж эрүүл мэндээрээ хохирсон хэрэг, нохой нохойгоо хазаж гэмтээсэн хэрэгт холбогдох тус тус хоёр хяналтын шатны

<sup>1</sup> Гэрийн тэжээвэр амьтны тухай хуулийн төслийн үзэл баримтлал. [https://d.parliament.mn/tusul/78dd320f-e6f5-42ff-9c72-ebf8e3d1a2d5?fbclid=IwAR2lE4ZQt3aGODXX3BuBNpg3ZqNW3YmFjvFIACUSUfGhg\\_RYsw-4ZcasaoQ](https://d.parliament.mn/tusul/78dd320f-e6f5-42ff-9c72-ebf8e3d1a2d5?fbclid=IwAR2lE4ZQt3aGODXX3BuBNpg3ZqNW3YmFjvFIACUSUfGhg_RYsw-4ZcasaoQ)

шүүхийн тогтоол, нэг давж заалдах шатны шүүхийн магадлал, гурван анхан шатны шүүхийн шийдвэр, нийт зургаан шүүхийн шийдвэрийг сонгож дүн шинжилгээ хийлээ. Тэдгээрийг хэрхэн сонгосон талаар хоёрдугаар бүлгээс үзнэ үү.

Энэхүү шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээ бүхий судалгааг гүйцэтгэхэд дараах бүтэц, аргыг ашиглалаа. Нэгдүгээр бүлэгт, судалгаагаар хөндөгдөж буй гол зохицуулалтыг танилцуулан, түүний үзэл баримтлал зэргийг тодруулах үүднээс өмнөх хуулийн ижил зохицуулалтыг мөн харуулав. Түүний дараа тус зохицуулалтад хэрэглэгдэж буй нэр томъёонд үг зүйн тайлбар хийх гэж оролдов. Эцэст нь, тус зохицуулалтад хамаарах шаардах эрхийн урьдчилсан нөхцөл болон үгүйсгэх нөхцөлийг авч үзлээ. Хоёрдугаар бүлэгт, шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээ хийлээ. Ингэхдээ, шүүхийн шийдвэрийг товч танилцуулаад, түүний үндэслэлд дурдагдаж буй хууль хэрэглээ нь логик авцалдаатай эсэхийг гол төлөв харуулахыг зорив. Гуравдугаар бүлэгт, Холбооны Бүгд Найрамдах Герман Улс (цаашид ХБНГУ гэх) болон Япон Улсын ижил зохицуулалт, тэдгээрийн үзэл баримтлал, урьдчилсан нөхцөл, үгүйсгэх нөхцөлийг харьцуулан судлав. Тэдгээрийн эцэст Монгол Улсын Иргэний хуулийн 501 дүгээр зүйлийн хууль хэрэглээ нь практик дээр шийдэхэд төвөгтэй асуудлуудыг хэрхэн тайлбарлаж зохицуулж буйд дүгнэлт хийн, илүү зохимжтой байж болохуйц хууль хэрэглээ, хуулийн тайлбарыг санал болгов.

Ташрамд дурдахад, Эрүүгийн хуулийн 20.15 дугаар зүйлд “Орчиндоо аюул учруулж болох амьтныг зохих хамгаалалтгүй байлгах” гэмт хэргийн талаар зохицуулсан байх бөгөөд энэхүү судалгааны хүрээг зөвхөн Иргэний эрх зүйн гэм хороос үүсэх хохирлын харилцаагаар хязгаарласан учир гэмт хэрэг болон ял оногдуулахтай холбоотой харилцааг хөндөхгүй.

## **НЭГ. МОНГОЛ УЛС ДАХЬ АМЬТНЫ УЧРУУЛСАН ГЭМ ХОРЫН ЭРХ ЗҮЙН АСУУДАЛ**

### **1.1. ЗОХИЦУУЛАЛТ, ТҮҮНИЙ ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Монгол Улсад амьтны учруулсан гэм хортой холбоотой зохицуулалт гэвэл нэн тэргүүнд Иргэний хуулийн 501 дүгээр зүйл яригдана. Зарим төрлийн тусгай харилцаанд нарийвчилсан хууль болон дүрэм, журам ашиглагддаг. Тухайлбал, зам тээвэртэй холбогдох тохиолдолд Замын хөдөлгөөний дүрэм, тариалангийн талбай зэрэгт холбогдох тохиолдолд Тариалангийн тухай хууль, Улаанбаатар хотод нохой, муур бусдын эд хөрөнгөд хохирол учруулсан тохиолдолд Нийслэлийн нутаг дэвсгэрт нохой муур тэжээх, арчлах, золбин нохой муур устгахад мөрдөх журам зэргийг дурдаж болно.

#### **Иргэний хуулийн 501 дүгээр зүйл. Амьтны учруулсан гэм хорыг хариуцах**

501.1. Амьтны үйлдлээс хүний амь нас, эрүүл мэндэд учирсан гэм хорыг тухайн амьтныг өмчлөгч буюу эзэмшигч хариуцна.

501.2. Гэрийн тэжээвэр амьтан, эсхүл мэргэжлийн үйл ажиллагааны зүйл болдог бусад амьтны үйлдлээс бусдад гэм хор учирсан нь тухайн амьтныг өмчлөгч буюу эзэмшигчийн санаатай буюу илт болгоомжгүй үйлдэлтэй холбоогүй бол тэрээр гэм хорыг хариуцахгүй.

Энэхүү зохицуулалтын үзэл баримтлалыг тодруулах үүднээс 2002 оны Иргэний хуулийн Үзэл баримтлалыг үзэж судалсан ч амьтны учруулсан гэм хорын талаар бичигдсэн зүйл байсангүй. Тиймээс түүний өмнөх хууль болох 1994 оны хуулийг үзвэл, одоогийнх шиг амьтны учруулсан гэм хорыг нарийвчлан зохицуулсан заалт байхгүй байна. Харин тус хуулийн 379 дүгээр зүйлд “Орчин тойрондоо аюул учруулж болох зүйлээс гарах хариуцлага” гэсэн зохицуулалт буй бөгөөд энэ зүйлээр ерөнхийлөн зохицуулдаг байсан бололтой.<sup>1</sup>

2002 оны Иргэний хуулийн 101 дүгээр зүйлийн 101.3-д “Мал, амьтан өмчлөгч нь өмчлөх эрхээ хэрэгжүүлэхдээ мал, амьтан, байгаль орчныг хамгаалах, эрүүл ахуйн шаардлага, бусдын аюулгүй байдлыг хангах талаар тогтоосон хэм хэмжээг сахин биелүүлэх үүрэгтэй” гэж заасан бөгөөд мал, амьтныг хараа хяналтгүй орхисонтой холбоотойгоор бусдад гэм хор учруулсны хариуцлагыг түүний өмчлөгч эзэмшигч нь гэм буруутай эсэхээс үл хамааран хариуцах талаарх зохицуулалт нь Иргэний хуулийн 501 дүгээр зүйл гэж Дээд шүүхээс гаргасан “Гэрээний бус үүргийн эрх зүй” бүтээлд<sup>2</sup> дурджээ.

## 1.2. УРЬДЧИЛСАН НӨХЦӨЛ, НЭР ТОМЬЁНЫ ТОДОРХОЙЛОЛТ

Энэхүү зохицуулалт хэрэглэгдэхийн тулд дараах урьдчилсан нөхцөл хангагдсан байх шаардлагатай.

<sup>1</sup> 1994 оны Иргэний хуулийн 379 дүгээр зүйл. Орчин тойрондоо аюул учруулж болох зүйлээс гарах хариуцлага

1. Орчин тойрондоо аюул учруулж болох зүйлийг эзэмшигч нь түүнээс учирсан гэм хорыг хариуцан арилгах үүрэгтэй.

2. Гэм хор учруулсан нь гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал, түүнчлэн хохирогчийн санаатай үйлдэл, эс үйлдэл, хэтэрхий болгоомжгүйгээс болсон бол орчин тойрондоо аюул учруулж болох зүйлийг эзэмшигч хариуцлагаас чөлөөлөгдөнө.

<sup>2</sup> Монгол Улсын Дээд шүүх, Монгол Улсын Иргэний хуулийн тайлбар (Гэрээний бус үүрэг IV), 2016, 68 дахь тал.

Нэн тэргүүнд хохирлыг амьтан учруулсан байна. Амьтан гэдэгт, амьтны тухай хуулийн 4.1.1-д “Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 4 дэх заалтад заасныг” гэж эшилжээ.<sup>3</sup> Байгаль орчныг хамгаалах тухай хууль 3.2.4-д

“амьтан” гэдэгт Монгол Улсын нутаг дэвсгэрт байнга буюу түр нутагшсан хөхтөн, шувуу, мөлхөгч, хоёр нутагтан, загас, хавч хэлбэртэн, шавж, зөөлөн биетэн, эгэл биетэн хамаарна;

Амьтан гэдгийг тухайн хуульд тодорхойлсон байгаа нь Иргэний хуульд ч ижил утгаар ойлгогдох албагүй гэж Дээд шүүх үзжээ. Ингэхдээ, Иргэний хуулийн 4.3-д заасан “тусгай харилцааг тухайлан зохицуулсан хэм хэмжээг бусад харилцаанд төсөөтэй хэрэглэж үл болно” гэснийг үндэслэжээ. Энэ шүүхийн маргаан нь адуу буюу мал нь амьтанд хамаарах эсэх талаар байсан бөгөөд Хяналтын шатны шүүхээс тийнхүү тайлбарласан боловч, адуу зэрэг мал нь хөхтөн амьтанд хамаарах эсэх дээр маргах нь утгагүй. Харин шүүхийн тайлбарыг зөвтгөх үндэслэл нь “эгэл биетэн”-г Иргэний хуульд заасан амьтан гэдэгт оруулах эсэх дээр гарч ирж буй юм. Харьцуулсан судалгаа хийсэн улсуудын туршлагаас авч үзвэл, эгэл биетэнг Иргэний хуульд заасан амьтанд оруулаагүй байна. Өөрөөр хэлбэл, шавжнаас ч жижигхэн бичил биетэн, бактерийн асуудал энд яригдаж байгаа юм.

Дараагийн урьдчилсан нөхцөл нь хариуцлагыг тухайн амьтны эзэмшигч, өмчлөгч хүлээнэ буюу хариуцагч нь тухайн амьтны өмчлөгч, эсхүл эзэмшигч байна. Өөрөөр хэлбэл, заавал өмчлөгч байх албагүй. Малын тооллогоор мал тоолуулаагүй хүн ч адуут

<sup>3</sup> Амьтны тухай хууль, 2012. <https://legalinfo.mn/mn/detail/8670>



өөрийн эзэмшилдээ байлгаж байсан гэдгээр хариуцлага хүлээнэ гэжээ.<sup>4</sup>

Энэ заалт дахь өмчлөгч гэдэгт өөрийн эзэмшил, ашиглалтад байлгаж, захиран зарцуулах эрхтэй этгээдийг ойлгоно. Харин эзэмшигч гэдэгт бусдын ашиг сонирхлын үүднээс гэр орон, хашаа, ажлын байр зэрэгт байлган тэжээж, өсгөн үржүүлж, асран хамгаалж, улмаар зорилго, үйл ажиллагаандаа ашиглаж буй этгээдийг ойлгоно гэжээ.<sup>5</sup> Тодорхой байгууллагын ажиллагаанд ашиглаж буй амьтны тухайд, тухайлбал, цагдаагийн үнэрч нохой бусдад гэм хор учруулсан бол түүний эзэмшигч нь тухайн албан тушаалтан байх бөгөөд хариуцлага хүлээх этгээд нь түүний байгууллага буюу төр байна.<sup>6</sup>

Нэхэмжлэгчид хохирол учирсан байх, амьтны үйлдэл болон хохирол хооронд шалтгаант холбоотой байх талаар нарийвчилсан зохицуулалт байхгүй учир тэдгээрийн талаарх ерөнхий зохицуулалт үйлчилнэ. Хариуцагчийн гэм буруугийн тухайд гэм буруутай эсэхээс үл хамааран хариуцлага хүлээнэ. Харин хохирогч өөрөө амьтны эрсдэлтэйг мэдсээр байж сайн дураараа тэр эрсдэлийг хүлээн авсан бол (assumption of risk) хэрхэх вэ гэдэг талаарх асуудал хуулийн зохицуулалт болон ном, бүтээлүүдэд тусгагдаагүй байна. Жишээ нь, хангал адуунаас унаж бэртэх эрсдэлтэйг урьдчилж мэдсээр буй хэр нь сайн дураараа түүнийг сургахаар мордсоны улмаас унаж бэртсэн бол хэрхэх вэ гэдэг асуудал урган гарч байна. Судлаачийн зүгээс, энэ тохиолдолд Монголын уламжлалт соёл талаасаа, мөн нутаг усныхан бие биедээ тус болох сайхан сэтгэлийн үйл гэдэг талаас, мөн эрсдэл нь илэрхий байхад сайн дураараа шийдвэр гаргаж

<sup>4</sup> Дархан-Уул аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн Дугаар 227 шийдвэр.

<sup>5</sup> Монгол Улсын Дээд шүүх, Монгол Улсын Иргэний хуулийн тайлбар (Гэрээний бус үүрэг IV), 2016, 68 дахь тал.

<sup>6</sup> Монгол Улсын Дээд шүүх, Монгол Улсын Иргэний хуулийн тайлбар (Гэрээний бус үүрэг IV), 2016, 69 дэх тал.

буй гэдэг өнцгөөс үзвэл, хариуцлагын асуудал яригдахгүй. Харин тухайн хангал адуунд мордсон этгээд нь насанд хүрээгүй хүн бол энэ тохиолдолд эрсдэлийг сайн дураараа хүлээн зөвшөөрсөн гэж үзэх боломжгүй. Учир нь насанд хүрээгүй хүн нь эрх зүйн бүрэн чадамжтай этгээд биш учраас зарчмын бус байна.

Иргэний хуульд зааснаар долоо хүртэл насны хүүхэд нь эрх зүйн чадамжгүй. Долоогоос арван дөрвөн насны хүүхдийн хувьд өөрт нь хохиролгүй хэлцлийг л зөвшөөрсөн тул адуу сургах эрсдэлтэй шийдвэрийг дангаараа гаргах боломжгүй. Түүний өмнөөс хууль ёсны төлөөлөгч (эцэг, эх, асран хамгаалагч) нь шийдвэр гаргах бөгөөд энэ тохиолдолд шийдвэр гаргасан хүнийг эрсдэлийг зөвшөөрсөн гэж үзэж болох юм. Гэсэн хэдий ч, энэ нь хүүхдийн тэвчишгүй хөдөлмөрт орох тал бий. Арван дөрвөөс арван найман насны хүүхдийн тухайд хууль ёсны төлөөлөгч (эцэг, эх, харгалзан дэмжигч)-ийн бичгээр олгосон зөвшөөрлийн үндсэн дээр эрсдэлтэй хэлцэл хийх боломжтой болно. Бичгээр өгсөн зөвшөөрөл үгүй бол, адуу сургах явцад бий болох эрсдэлийг хүүхэд сайн дураараа хүлээн зөвшөөрсөн гэж үзэхгүй учир, амьтны өмчлөгч, эзэмшигч хүлээнэ гэж тайлбарлах нь хүүхдийн эрх талаасаа зөвтгөгдөх үндэслэлтэй тайлбар юм.

### 1.3. ҮГҮЙСГЭХ НӨХЦӨЛ

501 дүгээр зүйлд заасан хариуцлага нь зарчмын хувьд гэм буруутай эсэхээс үл хамааран хариуцлага хүлээх зохицуулалт байна.<sup>7</sup> Зарчмын бус онцгой тохиолдол нь бусдад гэм хор учруулсан амьтан нь “гэрийн тэжээвэр амьтан”, “мэргэжлийн үйл ажиллагааны зүйл болдог амьтан” байх тохиолдолд түүний эзэмшигч, өмчлөгч нь өөрийгөө санаатай, эсхүл илт болгоомжгүй гэм буруугүй гэдгээ нотолбол хариуцлагаас чөлөөлөгдөнө.

<sup>7</sup> Б.Буянхишиг, Иргэний эрх зүйн тусгай анги, УБ., 2010.

“Гэрийн тэжээвэр амьтан” гэдгийг хуульд тухайлан тайлбарлаагүй байна. Энгийн ухамсрын хүрээнд аж ахуйн зорилгоор бус амин хувийн хүрээнд тэжээж өсгөдөг амьтан гэж ойлгож болох юм. “Гэрийн тэжээвэр амьтны тухай” хуулийн төсөлд дараах байдлаар томъёолжээ.

3.1.1. “гэрийн тэжээвэр амьтан” гэж нохой, муур болон ашиг шимийг нь ашиглахаас бусад зорилгоор гэршүүлсэн, хүнтэй хамт амьдрах боломжтой Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1, 4.1.2, 4.1.3-д зааснаас бусад амьтныг;<sup>8</sup>

Гэрийн тэжээвэр амьтан нь “тэжээвэр амьтан” гэдгээс ялгаатай. Өөрөөр хэлбэл, “гэрийн” гэх тодотгол авсан учир тэжээвэр амьтан доторх нарийвчилсан ангилалд хамаарна. Тухайлбал, “Мал, тэжээвэр амьтад, хашаа, худгийн тооллого”-д тэжээвэр амьтан гэдэгт гахай, тахиа, зөгий зэрэг эрчимжүүлсэн мал аж ахуй (ферм, farm)-н амьтдыг ойлгож байна.<sup>9</sup>

Харин мал гэдэгт Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн (2017) 4.1.1-д “уламжлагдан маллаж ирсэн таван хошуу малыг” ойлгоно гэж заажээ. Мал нь амьтан дотроо төрөлжүүлсэн ангилал учраас бүх мал нь амьтан байна гэдэг нь ойлгомжтой. Харин амьтан болгон мал биш гэсэн логик гарч ирнэ. Мал гэдэгт таван хошуу малыг оруулж байгаа ч сарлаг, хайнаг зэргийг үхэрт тооцох уу, цаа бугыг мөн хэрхэх вэ зэрэг асуудал нээлттэй хэвээр байна. Ямартай ч, малыг гэрийн тэжээвэр амьтан гэж үзэх боломжгүй. Учир нь малыг тодорхой эдийн засаг болон аж ахуйн зорилгоор өсгөн үржүүлдэг. Гэтэл гэрийн тэжээвэр амьтныг өсгөх үндсэн

<sup>8</sup> Гэрийн тэжээвэр амьтны тухай хуулийн төсөл. [https://d.parliament.mn/tusul/78dd320f-e6f5-42ff-9c72-ebf8e3d1a2d5?fbclid=IwAR2lE4ZQt3aGODXX3BuBNpg3ZqNW3YmFjvFIaAcUSUfGhg\\_RYsw-4ZcasaoQ](https://d.parliament.mn/tusul/78dd320f-e6f5-42ff-9c72-ebf8e3d1a2d5?fbclid=IwAR2lE4ZQt3aGODXX3BuBNpg3ZqNW3YmFjvFIaAcUSUfGhg_RYsw-4ZcasaoQ)

<sup>9</sup> [https://www.1212.mn/tables.aspx?TBL\\_ID=DT\\_NSO\\_1001\\_030V1](https://www.1212.mn/tables.aspx?TBL_ID=DT_NSO_1001_030V1)

зорилгод тийм шинж байхгүй (Зарим гадаад эх сурвалж дээрх бүтээлд “luxury animals” гэсэн байна).

“Мэргэжлийн үйл ажиллагааны зүйл болдог амьтан” гэдэгт мөн л хуульд заасан тодорхойлолт үгүй. Монгол Улсын Дээд шүүхийн шүүгчдээс 2016 онд эрхлэн гаргасан “Монгол Улсын Иргэний хуулийн тайлбар (Гэрээний бус үүрэг IV)”<sup>10</sup> номд зарим амьтны үнэр ялгах чадвар зэргийг ашиглан хил гааль, цагдаа, цирк гэх мэт тодорхой мэргэжлийн болон урлагийн үйл ажиллагаанд ашигладаг амьтан гэсэн нь “Мэргэжлийн үйл ажиллагааны зүйл болдог амьтан”-ыг илэрхийлж буй. Үнэрч нохой, хөтөч нохой зэрэг нь ердийн ухамсрын түвшинд гэрийн тэжээвэр амьтан мөн боловч тэжээж буй зорилго нь аж ахуйн зорилготой учир энэ ангилалд багтаах нь оновчтой.

“Гэрийн тэжээвэр амьтан” болон “мэргэжлийн үйл ажиллагааны зүйл болдог амьтан”-ы тухайд аль нь ч байсан 501 дүгээр зүйлийн 501.2-д заасан урьдчилсан нөхцөлийн объект мөн боловч, тэдгээрийн өмчлөгч, эзэмшигчийн гэм буруугийн асуудлыг тодорхойлох тохиолдолд дээрх хоёр агуулгыг ялгамжтайгаар авч үзнэ. Жишээ нь, гэрийн тэжээвэр амьтны өмчлөгч, эзэмшигч нь гэрийн тэжээвэр амьтныг олон нийтийн газар хошуувчтай авч явах үүргийг хүлээдэг бол ажлаа хийж буй үнэрч нохойн хувьд заавал хошуувч зүүлгэх шаардлагатай юу гэдэг асуулт гарч ирж байна.

Үгүйсгэх нөхцөлийн дараагийн шалгуур нь дээрх хоёр төрлийн амьтны өмчлөгч, эзэмшигч нь өөрийн санаатай, эсхүл илтэд болгоомжгүй гэм буруутүй гэдгээ нотлох үүрэгтэй. Санаатай гэм буруугийн хувьд амьтныг турхирсан, амьтнаар хүн айлгасан зэрэг үйлдлээр илэрч болно. Энэ төрлийн гэм буруу байгаагүй гэдгийг нотлоход харьцангуй хялбар. Харин илтэд болгоомжгүй

<sup>10</sup> Монгол Улсын Дээд шүүх, Германы хамтын ажиллагааны сан (GIZ) “Монгол Улсын Иргэний хуулийн тайлбар (Гэрээний бус үүрэг IV)”, 2016.

гэдгийг хэрхэн нотлох вэ гэдэг нь нэлээд төвөгтэй асуудал. Учир нь, болгоомжгүйн гэм буруу нь тухайн үр дагаврыг урьдчилан харах боломжтой байсан эсэх болон зайлсхийх боломжтой байсан эсэх гэсэн хоёр шалгуураар үнэлэгддэг. Жишээ нь, нохой хүн урах, хүн рүү дайрах боломжтой гэдгийг энгийн ухамсрын түвшинд мэдэх боломжтой. Харин нохойны эзэмшигч, өмчлөгч нь урьдчилан сэргийлэх арга хэмжээ авсан эсэхээс түүний илт болгоомжгүйн гэм буруутай юу, эсхүл ялимгүй буруутай юу гэдэг нь тодорхойлогдоно.

Иргэний хуулийн 101 дүгээр зүйлийн 101.3-д зааснаар амьтны өмчлөгч нь түүний аюулгүй байдлыг хангах үүрэгтэй учир дээр дурдсан урьдчилан сэргийлэх арга хэмжээг өргөн хүрээнд ч тайлбарлах боломжтой байна. Өөрөөр хэлбэл, шүүгчийн хууль тайлбарлаж жишиг тогтоох орон зай гэж хэлж болно. Ямартай ч, Нийслэлийн нутаг дэвсгэрт нохой муур тэжээх, арчлах, золбин нохой муур устгахад мөрдөх журмын 1.1-д “нохой, муур эзэмшигч байгууллага, иргэд нь орон сууц, гэр хорооллын хашаанд тусгай бэлтгэсэн байр, талбайд бат бэх уяатай байлгаж, гадаа гудамж талбайд зугаалуулах, эмчилгээ үйлчилгээ хийлгэхээр авч явахдаа амны хошуувчтай байлгана” гэж заасныг шүүхээс үндэслэн нохойг уяагүй болон хошуувчгүй байлгасан нь түүний эзнийг илт болгоомжгүй гэм буруутай гэж үзэх үндэслэлтэй гэсэн шүүхийн шийдвэр бий.<sup>11</sup>

<sup>11</sup> Хан-Уул дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2022 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн шийдвэр, Дугаар 183/ШШ2022/00452 шийдвэр.

## ХОЁР. ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭ

Амьтны учруулсан гэм хорд холбогдох шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийх үүднээс шүүхийн шийдвэрүүдийг Шүүхийн ерөнхий зөвлөлөөс цуврал болгон гаргадаг “Монгол Улсын шүүхийн сонгомол шийдвэрийн эмхэтгэл”<sup>12</sup> болон шүүхийн шийдвэрийн цахим сан болох <https://shuukh.mn><sup>13</sup> зэрэг эх сурвалжаас хайж үзсэн болно. Монгол Улсын шүүхийн сонгомол шийдвэрийн эмхэтгэлд анхан, давж заалдах, хяналтын шатны шүүхийн маш олон тооны шийдвэр байх боловч зарим шийдвэр нь ямар ач холбогдолтой болоод тус эмхэтгэлд багтсан гэдэг нь тодорхой бус буйг тэмдэглэе. Тэдгээрээс амьтны учруулсан гэм хорд холбогдох Хяналтын шатны нэг шүүхийн шийдвэрийг (Дүн шинжилгээ 1-ээс үзнэ үү) сонголоо.

Харин шүүхийн шийдвэрийн цахим сангаас “амьтны учруулсан гэм хор”, “Иргэний хуулийн 501 дүгээр зүйл”, “амьтан”, “амьтны эзэмшигч”, “амьтны өмчлөгч” зэрэг түлхүүр үгээр хайлт хийв. Хайлт тус бүрд давхардсан тоогоор 100 шийдвэр гарч ирэх бөгөөд ховор ан амьтан агнаантай холбогдох буюу байгаль орчинд учруулсан гэм хорд холбогдох шийдвэрүүдийн илэрц түлхүүр тохиолдоно. Илэрц бүрийг шалгаж нягталсны үндсэн дээр энэхүү судалгааны сэдэвт шууд холбогдох 10 шүүхийн шийдвэрийг олж тогтоов. Тэдгээрт дүн шинжилгээ хийх ач холбогдолтой эсэхийг дүгнэхийн тулд урьдчилсан байдлаар тус

<sup>12</sup> [http://judcouncil.mn/site/news\\_full/10574](http://judcouncil.mn/site/news_full/10574).

<sup>13</sup> <https://shuukh.mn/>.

бүрчлэн уншиж танилцсаны үр дүнд маргааны үйл баримт нь хууль хэрэглээний хувьд төвөгтэй, нөгөөтэйгүүр жишиг тайлбар шаардлагатай асуултуудад эхний ээлжид хариулт өгсөн таван шийдвэрийг сонгов.

Тийнхүү, “Монгол Улсын шүүхийн сонгомол шийдвэрийн эмхэтгэл” болон шүүхийн шийдвэрийн цахим сангаас нийт зургаан шүүхийн шийдвэрийг сонгон дүн шинжилгээ хийлээ. Дүн шинжилгээг “малын учруулсан гэм хорын тохиолдол” болон “гэрийн тэжээвэр амьтны гэм хорын тохиолдол” гэж төрөлжүүлэн ангилахыг зорив.

## 2.1. МАЛЫН УЧРУУЛСАН ГЭМ ХОРЫН ТОХИОЛДОЛ

### **ДҮН ШИНЖИЛГЭЭ 1.** Галзуурсан азарга хүний эрүүл мэндэд гэм хор учруулсан тохиолдол

Шүүхийн шийдвэрийн дугаар, огноо: УДШ-ийн Хяналтын шатны иргэний хэргийн 2015 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 88 дугаар тогтоол.<sup>14</sup>

### **МАРГААНЫ ҮЙЛ БАРИМТ**

Д (нэхэмжлэгч)-ийн хүү 2012 оны 07 дугаар сарын 13-нд малаа хариулж явахдаа малчин Г (хариуцагч)-ийн өмчлөлийн галзуурсан азарганд хазуулснаас хүнд гэмтэл авчээ. Д нь хүүгийнхээ эрүүл мэндийн хохирол болон эмчилгээний зардалд нийт 32 сая төгрөгийг Иргэний хуулийн 501 дүгээр зүйлд заасан үндэслэлээр Г-ээс гаргуулахаар шүүхэд нэхэмжлэл гаргажээ.

Хариуцагчаас нэхэмжлэлийн үндэслэлийг хүлээн зөвшөөрөхгүй хариу тайлбар гаргасан үндэслэл нь адууг мал адгуус учир амьтанд хамаарахгүй гэж маргажээ.

<sup>14</sup> Шүүхийн ерөнхий зөвлөл, Монгол Улсын шүүхийн сонгомол шийдвэрийн эмхэтгэл, II боть, УБ., 2016, 266-273 дахь тал.

## ШИЙДВЭРЛЭСЭН БАЙДАЛ

*Анхан шатны шүүхийн шийдвэр:*<sup>15</sup>

Анхан шатны шүүх Иргэний хуулийн 501 дүгээр зүйлийн 501.1-д заасныг үндэслэн хариуцагчаас 32 сая төгрөгийг гаргуулж, нэхэмжлэгчид олгохоор шийдвэрлэжээ.

*Давж заалдах шатны шүүхийн шийдвэр:*<sup>16</sup>

Давж заалдах шатны шүүх давж заалдах гомдлын шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээжээ.

*Хяналтын шатны шүүхийн шийдвэр:*

Дээд шүүхээс анхан шатны шүүхийн шийдвэр, давж заалдах шатны шүүхийн магадлалыг дараах үндэслэлээр хэвээр үлдээжээ.

“Малыг хүн төрөлхтөн өөрийн өмчлөл, эзэмшилдээ байлгаж амин зуулга, аж ахуйн шаардлагаар ашиг шимийг нь хүртэхээр өсгөж үржүүлэн маллаж ирсэн бөгөөд мал нь “амьтан” гэсэн ойлголтод хамаарна. Харин “адгуус” гэдэг нь мал, ан амьтдын ерөнхий нэр гэж Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь бичиг (2006 он)-т тайлбарлажээ.”

Түүнчлэн малын өмчлөгч, эзэмшигч нь Малын удмын сан эрүүл мэндийг хамгаалах тухай хуулийн 14 дүгээр зүйлд заасныг хэрэгжүүлж эрүүл, аюулгүй байдлыг нь хангах үүргээ хэрэгжүүлээгүй тохиолдолд амьтны үйлдлээс гэм хор учирсны хариуцлагыг түүний өмчлөгч хариуцна гэж үндэслэжээ.

<sup>15</sup> Сум дундын 25 дугаар шүүх 2014 оны 09 дүгээр сарын 04-ний өдрийн Дугаар 50/762/А шийдвэр.

<sup>16</sup> Иргэний хэргийн давж заалдах шатны 6 дугаар шүүхийн 2014 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн Дугаар 138 магадлал.



## ДҮН ШИНЖИЛГЭЭ:

Энэхүү шүүхийн шийдвэр нь нэгдүгээрт малыг Иргэний хуулийн 501 дүгээр зүйлийн 501.1-д заасан “амьтан” гэдэгт хамааруулна, хоёрдугаарт малын өмчлөгч, эзэмшигч нь тухайн малын эрүүл, аюулгүй байдлыг хангах үүрэгтэй бөгөөд энэ үүргээ биелүүлээгүйгээс учирсан хохирлыг хариуцна гэж шийдвэрлэсэнээрээ зарим ойлгомжгүй асуудалд хариулт өгсөн гэж хэлж болохуйц ач холбогдолтой.

Азарга буюу адууг Иргэний хуулийн 501 дүгээр зүйлд заасан “амьтан” гэдэг ойлголтод хамааруулсантай маргах зүйл байхгүй. Гэвч, адууны хувьд Иргэний хуулийн 501.1-д заасныг дангаар нь хэрэгжүүлэх ёстой юу гэдэг дээр эргэлзээ төрнө. Учир нь, 501 дүгээр зүйлийн 501.1-д заасан хариуцлагын тогтолцоо нь хариуцагч гэм буруутай эсэхээс үл хамааран хариуцлага (strict liability) хүлээдэг онцлогтой зохицуулалт юм.<sup>17</sup> Харин 501 дүгээр зүйлийн 501.2 дахь заалт бол зарим амьтны эзэмшигч, өмчлөгч өөрийн санаатай болон илтэд болгоомжгүй гэм буруугүй гэдгээ нотолбол хариуцлагаас чөлөөлөгдөж болох зохицуулалт юм. Дээрх хариуцлагаас чөлөөлөгдөх боломжтой амьтад гэдэгт нэгдүгээрт гэрийн тэжээвэр амьтан, хоёрдугаарт мэргэжлийн үйл ажиллагааны зүйл болдог амьтан орно.

Шүүхийн шийдвэрийн үндэслэлээс үзвэл, адуу буюу малыг гэрийн тэжээвэр амьтан, эсхүл мэргэжлийн үйл ажиллагааны зүйл болдог амьтанд оруулаагүй байна. Гэрийн тэжээвэр амьтан гэдгийг одоогийн (2022 оны 07 дугаар сарын 13-ны өдөр) хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжоор тодорхойлсон зүйл байхгүйч, малгэдгийг Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн<sup>18</sup> (2017) 4.1.1-д зааснаар таван хошуу мал гэж тайлбарлажээ. Үүнээс үзвэл мал нь гэрийн тэжээвэр амьтан биш гэдэг нь

<sup>17</sup> Монгол Улсын Дээд шүүх, Монгол Улсын Иргэний хуулийн тайлбар (Гэрээний бус үүрэг IV), УБ., 2016, 68 дахь тал.

<sup>18</sup> <https://legalinfo.mn/mn/detail/13026>.

тодорхой байна. Тэгвэл, мэргэжлийн үйл ажиллагааны зүйл болдог амьтан гэдэгт юу хамаарах вэ гэвэл, мөн л одоогоор хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжоор тодорхойлсон зүйл үгүй. Харин Дээд Шүүхийн шүүгчид 2016 онд гаргасан “Монгол Улсын Иргэний хуулийн тайлбар (Гэрээний бус үүрэг IV)”<sup>19</sup> номд “зарим амьтны үнэр ялгаж мэдрэх эрхтний давуу талыг ашиглан хил, гааль, цагдаа, цирк гэх мэт тодорхой мэргэжлийн болон урлагийн байгууллагын үйл ажиллагаанд ашиглах” гэсэн хэсгээс бага зэрэг ойлголт авч болно. Дээрхээс үзвэл, хууль сахиулах байгууллагад ашиглагдаж буй адуу, циркэд ашиглагдаж буй адуу зэрэг нь мэргэжлийн үйл ажиллагааны зүйл болдог амьтанд хамаарна. Гэтэл, бэлчээрт байгаа адуу үүнд хамаарах уу гэдэг нь бүрэн тодорхой биш байна.

Өөрөөр хэлбэл, адууг уналга болон ачлагын зорилгоор ашигладаг гэдгээс мэргэжлийн үйл ажиллагаанд орох магадлалтай гэж харж болно. Шүүхээс бэлчээрт буй адууг Иргэний хуулийн 501.2-д заасан “мэргэжлийн үйл ажиллагааны зүйл болдог амьтан” гэдэгт оруулах эсэх талаар бүрэн тодорхой хариултыг энэ шийдвэрт өгөөгүй. Учир нь 501.2 дахь заалт бол хариуцагчаас өөрийгөө хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болгож гаргах зохицуулалт юм. Хариуцагч адууг 501 дүгээр зүйлд заасан “амьтан” гэдэгт орох эсэх дээр маргаснаас бус “мэргэжлийн үйл ажиллагааны зүйл болдог амьтан” гэх өнцгөөс маргасан зүйл байхгүй байна. Тиймээс шүүх энэ асуудалд хариулт өгөөгүй ажээ.

Судлаачийн байр сууриас үзвэл, 501 дүгээр зүйлийн 501.1 болон 501.2 дахь заалтын ялгаа нь тухайн амьтны орчин тойрондоо аюул учруулахуйц эрсдэлээр тодорхойлогдоно. Өөрөөр хэлбэл, гэрийн тэжээвэр амьтан болон мэргэжлийн үйл ажиллагааны зүйл болдог амьтны хувьд бусад амьтнаас харьцангуй бага орчин тойрондоо аюул учруулна гэж үзсэн гэж тайлбарлаж болно.

<sup>19</sup> Монгол Улсын Дээд шүүх, Германы хамтын ажиллагааны сан (GIZ) “Монгол Улсын Иргэний хуулийн тайлбар (Гэрээний бус үүрэг IV)”, 2016.

Тийм бол, циркт үзүүлбэр үзүүлдэг бар, арслан, заан зэрэг нь бэлчээрт буй малаас илүү аюул багатай юу гэсэн ойлголт бий болно. Бэлчээрт байгаа малын хувьд түүний өмчлөгч, эзэмшигч нь байнга дэргэд нь байдаггүй гэх эрсдэл буй боловч, манай нийгмийн энгийн ухамсрын түвшинд таван хошуу малыг төдийлөн аюултай амьтанд тооцдоггүй.

Дээрхэд үндэслэн судлаачийн зүгээс, адууны өмчлөгч, эзэмшигчид гэм буруутай эсэхээс үл хамааран хариуцлага хүлээлгэдэг байдлаар 501 дүгээр зүйлийг тайлбарлах нь зохимжгүй гэж үзэж байна. Харин тус зүйлийн 501.2-д заасан мэргэжлийн үйл ажиллагааны зүйл болдог амьтанд оруулан тайлбарлавал манайх шиг нүүдэлчин ахуйтай улсад илүүтэй нийцнэ гэж харж болно. Энэ нь дээрх шиг галзуу азарганы хүний биед хохирол учруулсан тохиолдолд хариуцлагаас шууд чөлөөлнө гэсэн үг биш бөгөөд тухайн малчин (өмчлөгч, эзэмшигч) өөрийн өмчлөл, эзэмшлийн малаа бусдад хохирол учруулахгүй байх тал дээр анхаарах, урьдчилан сэргийлэх боломжийг олгож буйгаараа ач холбогдолтой. Хэрэв тийм биш бол, хохирол учирсан ямар ч тохиолдолд (хохирогчийн илт болгоомжгүй тохиолдлоос бусад) малчин хариуцлага хүлээх болж байна.

Мөн шүүхээс хариуцагчийг өөрийн өмчлөл, эзэмшлийн малын эрүүл аюулгүй байдлыг хангах үүрэгтэй талаар шийдвэрийн үндэслэл хэсэгт тусгасан байдаг. Малын өмчлөгч, эзэмшигч нь энэ үүргээ хангалттай биелүүлээгүй буюу анхаарал болгоомжтой байгаагүй гэсэн үндэслэлээр хариуцлага хүлээнэ гэж тайлбарласан бол илүү оновчтой байхаар байна. Өөрөөр хэлбэл, азаргаа галзуу өвчин тусахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг аваагүй, адуу руу нь галзуурсан чоно орсон гэдгийг мэдэж байсан, эсхүл адуугаа ойрхон эргэж тойрч эрүүл эсэхийг шалгаагүй гэх үндэслэлээр болгоомжгүйн гэм буруутайд тооцох юм. Хэрэв дээрх байдлаар малын өмчлөгч, эзэмшигчид гэм

буруутай байх шаардлага тавихгүй тохиолдолд, эрүүл номхон адуу, эсхүл бусад хонь ямаа гэх мэт малаас улбаатай хохирлын хувьд малын өмчлөгч, эзэмшигч нь гэм буруутай эсэхээс үл хамааран хариуцлага хүлээх бөгөөд энэ нь манай улсын уламжлалт аж ахуйтай нийцэхгүй.

## **ДҮН ШИНЖИЛГЭЭ 2. Адуу автомашинд мөргүүлсэн тохиолдол**

Шүүхийн шийдвэрийн дугаар, огноо: УДШ-ийн Хяналтын шатны иргэний хэргийн 2021 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 001/ХТ2021/01551 дүгээр тогтоол.<sup>20</sup>

### **МАРГААНЫ ҮЙЛ БАРИМТ**

2017 оны 07 дугаар сарын 27-ны шөнийн 00 цаг 20 минутын үед Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сумын нутаг, Алтанбулаг-Сүхбаатар чиглэлийн төв асфальтан зам дээр А (нэхэмжлэгч) Тоёото приус маркийн тээврийн хэрэгслийг жолоодож яваад иргэн Б (хариуцагч)-ийн нэг тооны адууг дайрсан зам тээврийн осол гарсан бөгөөд тус зам тээврийн осолд иргэн Б малаа хариулгагүй байлгасан буруутай үндэслэлээр Зөрчлийн тухай хуулийн 14.7 дугаар зүйлийн 52.1 дэх хэсэгт зааснаар хорин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгуулж шийтгэгджээ.

Дээрх ослын улмаас нэхэмжлэгчийн автомашинд 3,085,000 төгрөгийн хохирол учирсан үндэслэлээр хариуцагчаас дээрх хохирлыг гаргуулахаар нэхэмжлэл гаргасныг хариуцагч эс зөвшөөрч, хурдан удмын морь дайрсан үндэслэлээр морины үнэ 3,500,000 төгрөгийг нэхэмжилж, сөрөг нэхэмжлэл гаргажээ.

<sup>20</sup> УДШ-ийн Хяналтын шатны иргэний хэргийн 2021 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 001/ХТ2021/01551 дүгээр тогтоол. [https://shuukh.mn/single\\_case/8829?start\\_date=&end\\_date=&id=3&court\\_cat=1&bb=1](https://shuukh.mn/single_case/8829?start_date=&end_date=&id=3&court_cat=1&bb=1).

## ШИЙДВЭРЛЭСЭН БАЙДАЛ

*Анхан шатны шүүхийн шийдвэр:*<sup>21</sup>

Анхан шатны шүүх Иргэний хуулийн 497 дугаар зүйлийн 497.1, 499 дүгээр зүйлийн 499.1, 510 дугаар зүйлийн 510.1 дэх хэсэгт заасныг баримтлан Б-ээс 2,655,000 төгрөг гаргуулан А-д олгож, үлдэх 430,000 төгрөгийн нэхэмжлэлийн шаардлагыг хэрэгсэхгүй болгож, А-аас 3,500,000 төгрөг гаргуулан сөрөг нэхэмжлэгч Б-д олгож шийдвэрлэжээ.

*Давж заалдах шатны шүүхийн шийдвэр:*<sup>22</sup>

Сэлэнгэ аймаг дахь сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн 134 дугаартай шийдвэрийг хэвээр үлдээж, нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн давж заалдах гомдлыг хангахгүй орхиж шийдвэрлэжээ.

*Хяналтын шатны шүүхийн шийдвэр:*

“Хяналтын шатны шүүхээс хоёр шатны шүүхийн нотлох баримт үнэлэх журам зөрчсөн алдааг засаж, хэрэгт цугларсан баримтад тулгуурлан өөрийн эрх хэмжээний хүрээнд дүгнэлт хийж, шийдвэр, магадлалд өөрчлөлт оруулах нь зүйтэй” гэж үзсэн байна.

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад нийт таван шинжээчийн дүгнэлт<sup>23</sup> авагдсан бөгөөд дөрвөн шинжээчийн

<sup>21</sup> Сэлэнгэ аймаг дахь сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн 134 дүгээр шийдвэр.

<sup>22</sup> Сэлэнгэ аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2020 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн 32 дугаар магадлал.

<sup>23</sup> Үүнд: 1. Зам тээврийн ослыг шалгах явцад гарсан шинжээч Г.Н-ын буюу 2017 оны 08 дугаар сарын 02-ны өдрийн №52 дугаартай дүгнэлтээр ... жолооч замын хөдөлгөөний дүрэм зөрчөөгүй, ... малчин \*\*\*\*\* ЗХД-ийн 23.7 Суурин газрын гаднах засмал замаар малыг зорчих хэсгийн дагуу тууж явахыг хориглоно. Засмал замд 50 метрээс дотогш хариулгагүй мал байлгахыг хориглоно... гэсэн заалтыг зөрчсөн гэж,  
2. хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хариуцагчийн өмгөөлөгч Р.А-ын хүсэлтээр шүүхээс томилогдсон шинжээч Л.М, Н.Д, Д.М нарын 2017 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн №117 дүгнэлтээр ... жолооч \*\*\*\*\* ЗХД-ийн 9.2., 9.4.6 заалтыг зөрчөөгүй байна... гэж,  
3. хариуцагчийн өмгөөлөгч Р.А-ийн дахин бүрэлдэхүүнтэй шинжээч томилж дүгнэлт гаргуулахыг

дүгнэлт нь зам тээврийн осол гарахад А замын хөдөлгөөний дүрэм зөрчөөгүй гэж гарчээ. Хяналтын шатны шүүх “дээрх дөрвөн шинжээчийн дүгнэлтээр тогтоогдсоноор нэхэмжлэгч гэм буруугүй болох нь нотлогдсон гэж үзэхээр байна” гэжээ.

Тийнхүү, нэхэмжлэгч А нь “Иргэний хуулийн 497 дугаар зүйлийн 497.2-д зааснаар гэм хор учруулсан этгээд ийнхүү гэм хор учруулсан нь түүний буруугаас болоогүй гэдгийг нотолбол хуульд зааснаас бусад тохиолдолд гэм хор учруулсны хариуцлагаас чөлөөлөгдөнө”, мөн хариуцагчид учирсан гэм хорыг хариуцахгүй тул хариуцагчийн сөрөг нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгож, энэ талаар гаргасан нэхэмжлэгчийн гомдлыг хангах үндэслэлтэй гэж үзжээ.

### ДҮН ШИНЖИЛГЭЭ:

Анхан болон давж заалдах шатны шүүх нэхэмжлэл болон сөрөг нэхэмжлэлийг шийдвэрлэхдээ, энэ хэрэгт ижил байр суурьтай байна. Тодруулбал, Замын хөдөлгөөний дүрмийн 9.2-д заасан “жолооч хөдөлгөөнд аюул, саад бий болохыг мэдсэн үед тээврийн хэрэгслийн хурдыг хасаж, зайлшгүй тохиолдолд зогсоох арга хэмжээ авна” гэсэн дүрмийн заалт зөрчсөн, малчин мөн дүрмийн

хүссэн хүсэлтийг үндэслэн шүүхээс томилогдсон шинжээч Д.М, С.Э, С.Б нарын 2018 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн №85 дугаартай дүгнэлтээр ... жолооч \*\*\*\*\* ЗХД-ийн заалт зөрчөөгүй байна, малчин \*\*\*\*\* ЗХД-ийн 23.7 дахь заалтыг зөрчсөн. Малчин \*\*\*\*\* ЗХД зөрчсөн нь зам тээврийн осол гарах нөхцөлийг бүрдүүлсэн... гэж,

4. хариуцагчийн өмгөөлөгч Р.А-ийн хүсэлтээр Дархан-Уул аймаг дахь Цагдаагийн газрын Замын цагдаагийн тасгийн шинжээч Х.Г, Б.А, Х.М, Б.Н, Д.Ү нарын 2019 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн №23 дугаартай дүгнэлтээр жолооч \*\*\*\*\* ЗХД-ийн 9.1-д заасан жолооч хөдөлгөөний эрчим, тээврийн хэрэгслийн онцлог байдал, тээж яваа ачаа, замын болон цаг агаарын нөхцөл, хөдөлгөөний дагуу үзэгдэлтийг харгалзан тээврийн хэрэгслийн хурдны энэ дүрэмд тогтоосон хязгаараас хэтрүүлэхгүйгээр сонгож явна, мөн дүрмийн 9.2-д заасан жолооч хөдөлгөөнд аюул, саад бий болохыг мэдсэн үед тээврийн хэрэгслийн хурдыг хасаж, зайлшгүй тохиолдолд зогсоох арга хэмжээ авна гэсэн дүрмийн заалт зөрчсөн, малчин \*\*\*\*\* ЗХД-ийн 23.7-д засмал замд 50 метрээс дотогш хариулгагүй мал байлгахыг хориглоно гэсэн дүрмийн заалт зөрчсөн... гэж,

5. дээрх дүгнэлтийг эс зөвшөөрч, шинжээчийн дүгнэлтүүд зөрүүтэй гарсан нь эргэлзээ төлүүлж байна гэх нэхэмжлэгчийн хүсэлтээр шүүх дахин шинжээч томилсноор Тээврийн Цагдаагийн албаны Замын цагдаагийн газрын техникийн шинжээч М.Г, Б.А, Х.А, Д.Г, Б.Г нарын бүрэлдэхүүнтэй 2019 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн №558 дүгнэлтээр ... жолооч \*\*\*\*\* ЗХД-ийн 9.1., 9.2., 9.4 заалт зөрчсөн нь тогтоогдохгүй байна, адуу харж байсан \*\*\*\*\* ЗХД-ийн 23.7. ...Суурин газрын гаднах засмал замаар малыг зорчих хэсгийн дагуу тууж явахыг хориглоно. Засмал замд 50 метрээс дотогш хариулгагүй мал байлгахыг хориглоно... гэсэн заалтыг зөрчсөн байх үндэслэлтэй байна... гэж тус тусын дүгнэлтийг гаргажээ.

23.7-д “засмал замд тавин метрээс дотогш хариулгагүй мал байлгахыг хориглоно” гэсэн дүрмийн заалтыг тус тус зөрчсөн гэсэн 2019 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн №23 дугаартай дүгнэлтийг үндэслэжээ. Үүнээс үзвэл, анхан болон давж заалдах шатны шүүх талуудыг аль аль нь гэм буруутай байх тул, тэдгээрийн нэхэмжлэлийн шаардлагыг нотлогдож буй хүрээнд хангаж шийдвэрлэх нь үндэслэлтэй гэж үзжээ.

Харин хяналтын шатны шүүх дээрхээс бусад дөрвөн дүгнэлт нь малчин буюу хариуцагч Б-г засмал замаас тавин метрийн зайд малаа хариулгагүй байлгасан, харин жолооч буюу нэхэмжлэгч А-г замын хөдөлгөөний дүрэм зөрчөөгүй гэж үзсэн тул, А нь Иргэний хуулийн 497.2-д зааснаар гэм буруугүй учир хариуцлагаас чөлөөлөгдөнө гэж үзжээ.

Энэхүү шийдвэрт дурдагдаж буй нэхэмжлэгчийн нэхэмжлэл болон хариуцагчийн сөрөг нэхэмжлэлд тус тусад нь дүн шинжилгээ хийх шаардлагатай. Учир нь, тэдгээрийн шаардах эрхийн үндэслэл болох зохицуулалтууд нь ялгаатай бөгөөд тэдгээр нь өөр өөрийн урьдчилсан нөхцөлтэйгөөс гадна өөр өөрийн үгүйсгэх нөхцөлтэй.

Нэн тэргүүнд жолооч бусдын малыг мөргөж устгасантай холбогдох хариуцагчийн сөрөг нэхэмжлэлийн шаардлагад холбогдох хэсэгт дүн шинжилгээ хийе.

Жолоочийн тээврийн хэрэгслийн оролцоотойгоор хариуцагч Б-ийн морь үрэгдсэн нь тодорхой байна. Хяналтын шатны шүүхээс жолооч А нь Замын хөдөлгөөний дүрмийг зөрчөөгүй нь таван шинжээчийн дүгнэлтээс дөрөвт нь тусгагдсан байх тул Иргэний хуулийн 497.2-д зааснаар гэм буруугүй гэж үзжээ. Гэвч, замын хөдөлгөөний дүрэм зөрчсөн болон зөрчөөгүй гэдэг нь Иргэний хуулийн 497 дугаар зүйлд заасан гэм буруутай эсэх шинжийг шууд тодорхойлж чадахгүй. Өөрөөр хэлбэл, Замын

хөдөлгөөний дүрэм зөрчөөгүй байсан ч гэм буруутай байж болно. Хурд хэтрүүлээгүй гэдэг нь гэм буруугүй гэсэн үг биш.

Түүнчлэн нэхэмжлэгч нь тээврийн хэрэгслээр бусдын эд хөрөнгөд хохирол учруулсан байж болохуйц энэ хэрэгт 497.1 бус 499 дүгээр зүйл хэрэглэгдэнэ. Энэ тохиолдолд тээврийн хэрэгсэл эзэмшигч нь орчин тойрондоо аюул учруулж болохуйц эд зүйлийг эзэмшиж буй тул илүү хянуур болгоомжтой байх үүрэгтэй. Энэ үүрэг нь, Замын хөдөлгөөний дүрмийн 9.2-д заасан “жолооч хөдөлгөөнд аюул, саад бий болохыг мэдсэн үед тээврийн хэрэгслийн хурдыг хасаж, зайлшгүй тохиолдолд зогсоох арга хэмжээ авна” гэсэн заалтаар илүү тодорхой зохицуулагдсан байна. Тиймээс сөрөг нэхэмжлэлтэй холбоотой анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдвэрийг буруушаасан хяналтын шатны шүүхийн шийдвэр үндэслэл дутмаг байна.

Удаах шаардлага болох нэхэмжлэгч А-ийн эд хөрөнгөд хариуцагч Б-ийн эзэмшлийн амьтны учруулсан гэм хортой холбогдох шаардлагад дүн шинжилгээ хийе.

Нэхэмжлэгчийн нэхэмжлэлийн шаардлагын тухайд, амьтны учруулсан гэм хороос улбаатай тээврийн хэрэгсэлд учирсан хохирлыг шаарджээ. Энэ тохиолдолд шаардах эрхийн үндэслэл нь Иргэний хуулийн 501 дүгээр зүйл байна. 501 дүгээр зүйлийн 501.1-ийг баримталбал хариуцагч малчин Б нь гэм буруутай эсэхээс үл хамааран хариуцлага хүлээнэ. Адууг уналгад ашигладаг, уралдуулдаг гэх мэт агуулгыг 501.2-д заасан “мэргэжлийн үйл ажиллагааны зүйл болдог амьтан” гэдэгт хамруулбал, малчин буюу малын эзэмшигч, өмчлөгч нь өөрийн санаатай болон илт болгоомжгүй гэм буруугүй гэдгээ нотолбол хариуцлагаас чөлөөлөгдөнө.

Хариуцагч Б нь адуугаа аргамжиж хонуулсан нь тодорхой хэмжээнд болгоомжтой байсныг илтгэнэ. Гэхдээ адуу аргамжаанаас алдуурсан, адууг алдуурахааргүй аргамжаа хийх



ёстой байсан гэсэн үндэслэлээр Б-г болгоомжгүйн гэм буруутай гэж үзэх боломжтой. Энэ тохиолдолд Б аргамжааг хангалттай сайн бэхэлсэн гэдгээ нотолж гэм буруугүй болно. Гэвч нотолж чадаагүй, ямар шалтгаанаар адуу аргамжаанаас алдуурсан нь тодорхойгүй байна.

Хэрэв тус адуу нь хөдөлгөөнгүй байгаа тээврийн хэрэгслийг өөрөө очиж мөргөсөн, эсхүл хажуунаас нь мөргөсөн, тийрсэн зэрэг тохиолдолд адууны өмчлөгч, эзэмшигч гэм буруутай юм. Гэсэн ч Б гэм буруутай байсан ч, А анхаарал болгоомжтойгоор тээврийн хэрэгслийг жолоодох үүрэгтэй.

Хөдөө орон нутагт тээврийн хэрэгслээр зорчиж буй тохиолдолд адуу, үхэр зэрэг мал зам хөндөлдөх тохиолдол цөөнгүй байх бөгөөд тэдгээр тээврийн хэрэгсэл болон зорчигчдод ямар аюултай болохыг ихэнх жолооч гадарлаж буй. Ялангуяа шөнийн цагт буюу үзэгдэх орчин хязгаарлагдмал үед энэ төрлийн эрсдэл бий гэдгийг урьдчилан тооцоолох боломжтой бөгөөд жолооч анхаарал болгоомжтой байх үүрэгтэй. Нөгөө талд малчин нь өөрийн эзэмшлийн малыг засмал замд ойр байлгах нь осолтой гэдгийг урьдчилан тооцоолох боломжтой учир, мөн л анхаарал болгоомжтой байх үүрэгтэй. Үүнээс үзвэл, жолоочийн хувьд ч, малчны хувьд ч эрсдэлийг урьдчилан тооцоолох боломжтой байхад сайн дураараа үйлдэл, эс үйлдэхүйгээрээ тухайн эрсдэлийг өөртөө авчирч байх тул (assumption of risk) талууд нь өөрт учирсан хохирлыг хувь хувьдаа хариуцах нь зохимжтой юм. Үгүйдээ л, талуудын хохирол бий болоход өөрсдийнх нь болгоомжгүй байдал нөлөөлсөн гэдэг үндэслэлээр хохирлын хэмжээг харилцан тооцох, бууруулах зэрэг зохицуулалтыг хэрэглэх нь оновчтой.

Тийм биш тохиолдолд, жолооч дүрэм зөрчөөгүй боловч тээврийн хэрэгслээр бусдын өмчлөл, эзэмшлийн мал амьтныг мөргөсний улмаас зорчигч нас барсан зэрэг их хэмжээний хохирол

бий болох тохиолдолд түүний хариуцлагыг малчинд ногдуулах нь хэр зохимжтой вэ гэдэг асуулт гарч ирнэ. Судлаачийн зүгээс малчинд хариуцуулах нь зохимжгүй гэж үзэв. Учир нь, адуу, үхэр, тэмээ, сарлаг, хайнаг зэрэг бод малыг байнгын хариулгатай байлгах боломжгүй учир тэдгээр амьтны үйл ажиллагааны эрсдэлийг малчин зарчмын хувьд удирдаж, урьдчилан сэргийлж чадахгүй. Онцгой тохиолдол байж болно.

Энэ хэргийн хувьд нэг үйл баримтад шүүхээс төдийлөн ач холбогдол өгөөгүй. Тэр нь адуу аргамжаатай байсан бөгөөд аргамжаанаас алдуурсан. Адуу аргамжаагаа чирч явсан бөгөөд тэр нь энэ хэрэг гарахад нөлөөлсөн эсэх асуудал юм. Нэхэмжлэгчийн тайлбараас үзвэл, адуу машины урдуур өнгөрч гарсан боловч чирэгдэж явсан аргамжаандаа татагдаж буцаж зам руу орон машины урд хэсэгт унасан гэсэн тайлбар юм. Энэ талаар хариуцагч маргаагүй, шүүх ч дүгнэлт өгөөгүй. Хэрэв энэ тайлбар үнэн бол, жолоочийн хувьд анхаарал болгоомжтой байсан ч, чирэгдэж буй аргамжаанаас улбаатай эрсдэлийг хариуцах, урьдчилан харах боломж бараг л байхгүй юм. Энэ тохиолдолд нэхэмжлэгчийн тээврийн хэрэгсэлд учирсан хохирлыг адууны өмчлөгч, эзэмшигч хариуцах нь үндэслэлтэй.

### **ДҮН ШИНЖИЛГЭЭ 3. Адуутай харьцах үедээ унаж бэртсэн тохиолдол**

ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ДУГААР, ОГНОО: Өмнөговь аймгийн эрүү, иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2020 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн Дугаар 22 магадлал.

#### **МАРГААНЫ ҮЙЛ БАРИМТ**

С (нэхэмжлэгч) нь 2019 оны 07 дугаар сарын 04-ний өдөр Өмнөговь аймгийн Ханхонгор сумын нутаг Мухар шивэрт хэмээх газар унага уях ажиллагаанд оролцохоор Б (хариуцагч)-ийнд очиж адуутай харьцах үедээ унаж зүүн хөлийн шилбээ хоёр хугалжээ.

С нь хугарсан хөлөө эмчлүүлсэн зардалд нийт 2,981,127 төгрөгийг Б-ээс нэхэмжилсэн бөгөөд Б нь С-ийг өөрөө хангал морьтой харьцахдаа анхаарал болгоомжгүй хандсан гэж маргажээ.

## **ШИЙДВЭРЛЭСЭН БАЙДАЛ**

*Анхан шатны шүүхийн шийдвэр<sup>24</sup>*

Анхан шатны шүүх Иргэний хуулийн 497 дугаар зүйлийн 497.1, 501 дүгээр зүйлийн 501.1 дэх хэсэгт зааснаар хариуцагч Б-ээс 1,318,248 төгрөг гаргуулан нэхэмжлэгч С-д олгож шийдвэрлэжээ.

*Давж заалдах шатны шүүхийн шийдвэр*

Давж заалдах шатны шүүх дараах үндэслэлээр анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээжээ.

Иргэний хуулийн 101 дүгээр зүйлийн 101.3 дахь хэсэгт зааснаар мал, амьтан өмчлөгч нь өмчлөх эрхээ хэрэгжүүлэхдээ бусдын аюулгүй байдлыг хангах талаар тогтоосон хэм хэмжээг сахин биелүүлэх үүрэгтэй.

Б-г малын маллагаа, арчилгаа, түүнтэй харьцах дадал, мэдээлэл эзэмшсэн мэргэжил бүхий иргэн гэж үзэх тул малчин Б нь өөрийн өмчлөлийн малыг барьж тусалж буй мэргэжлийн дадалгүй С-ийн аюулгүй байдлыг хангаж хохирол учруулахгүй байх үүрэгтэй. Энэ үүргээ биелүүлж малтай харьцах үед учирч болох аюулаас урьдчилан сэргийлсэн байдал хэрэгт авагдсан баримтаар тогтоогдохгүй байх тул түүний эс үйлдлийн улмаас С-ийн эрүүл мэндэд гэм хор учирсан. Иймд нэхэмжлэгч С нь хариуцагч Б-ийн буруутай эс үйлдэхүйгээс өөрт учирсан хохирлоо арилгуулахаар Иргэний хуулийн 497 дугаар зүйлийн 497.1 дэх хэсэгт зааснаар шаардах эрхтэй.

Харин хариуцагч Б нь бусдын эрх зөрчсөн эс үйлдэхүйдээ буруугүй гэдгээ Иргэний хуулийн 497 дугаар зүйлийн 497.2 дахь

<sup>24</sup> Өмнөговь аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн Дугаар 143/ШШ2020/00166 шийдвэр.

хэсэгт зааснаар нотолбол гэм хор учруулсны хариуцлагаас чөлөөлөгдөх боломжтой. Гэвч, хариуцагч нь өөрийн тайлбараа холбогдох нотлох баримтын хамт гаргаж өгч мэтгэлцэх үүргээ биелүүлж нэхэмжлэгчээс гаргасан эмчилгээний зардлыг үгүйсгэж, холбогдох нотлох баримтыг гаргаж, цуглуулж мэтгэлцээгүй байна гэжээ.

### ДҮН ШИНЖИЛГЭЭ

Анхан болон давж заалдах шатны шүүх адууны эзэн нь түүнээс учирсан хохирлыг арилгах талаар ижил дүгнэлт хийсэн боловч хууль хэрэглээний хувьд ялгаатай байна. Анхан шатны шүүх Иргэний хуулийн 497.1 болон 501.1-д заасныг үндэслэжээ. Харин давж заалдах шатны шүүх Иргэний хуулийн 497.1-д заасныг үндэслэсэн байна. Энэхүү хууль хэрэглээ нь дараах ялгаатай үр дагаврыг үүсгэнэ.

Анхан шатны шүүх Иргэний хуулийн 501 дүгээр зүйлийг үндэслэж буй учир амьтны өмчлөгч, эзэмшигчийн хариуцлагын асуудал яригдана. Энэ тохиолдолд гэрийн тэжээвэр болон мэргэжлийн үйл ажиллагааны зүйл болдгоос бусад амьтны өмчлөгч, эзэмшигчийн хариуцлага нь гэм буруутай эсэхээс үл хамааран хариуцлага хүлээнэ. Өөрөөр хэлбэл, 501 дүгээр зүйлд зааснаар нөхөн төлбөр шаардах тохиолдолд нэхэмжлэгч хариуцагчийн гэм буруутай эсэхийг нотлох шаардлагагүй гэсэн үг. Хохирогч талд ашигтай шаардах эрхийн зохицуулалт юм.

Харин давж заалдах шатны шүүх зөвхөн 497.1-д заасныг үндэслэн тайлбарлаж буй нь хариуцагчийг заавал гэм буруутай байх ёстой бөгөөд түүнийг нэхэмжлэгч тал нотлох шаардлагатай гэж үзэж буй хэрэг юм. Энэ тохиолдолд, хариуцагч өөрийгөө гэм буруугүйг нотолбол, 497.2-д заасны дагуу хариуцлагаас чөлөөлөгдөнө. Өөрөөр хэлбэл, 501 дүгээр зүйлийн гэм буруутай эсэхээс үл хамааран хариуцлага хүлээх тогтолцооноос өөр агуулгатай.

Анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдвэрт тусгасан хууль хэрэглээний талаарх үндэслэл нь дээрх байдлаар ялгаатай үр дагаварт хүргэнэ. Аль нь илүү үндэслэлтэй вэ гэвэл, анхан шатны шүүхийн хууль хэрэглээ үндэслэлтэй. Учир нь, 497 дугаар зүйл бол гэм хорын эрх зүйн ерөнхий шаардах эрх юм. Харин 501 дүгээр зүйл бол амьтны учруулсан гэм хортой л холбогдох тусгайлсан зохицуулалт. Хаалтын зарчмын дагуу тусгайлсан зохицуулалт нь хэрэглэгдэх эрэмбийн хувьд тэргүүнд байна. Үүнээс үзвэл, давж заалдах шатны шүүх магадлалын “хянавал” хэсэгтээ хариуцагчийг гэм буруугүйгээ нотолбол 497.2-д заасны дагуу хариуцлагаас чөлөөлөгдөнө гэж тайлбарласан нь оновчгүй.

Хэдийгээр шүүхийн шийдвэр болон магадлалд үндэслэсэн хуулийн зохицуулалтууд нь ялгаатай боловч, давж заалдах шатны шүүх анхан шатны шүүхийн шийдвэрийг зөв гэж үзсэн байна.

Энэхүү тохиолдолд нэг чухал асуулт гарч ирж буй юм. Тэр нь хохирсон этгээд өөрөө эрсдэлийг сайн дураараа хүлээн зөвшөөрсөн шийдвэр гаргасан байдал (assumption of risk), болон хохирогчийн анхаарал болгоомжгүй байдал (contributory negligence) зэрэг нь шүүхийн шийдвэрт ямар нөлөө үзүүлэх вэ гэх асуулт. Шүүхийн шийдвэрийн агуулгаас үзвэл, энэ асуудал ямар ч нөлөө үзүүлэхгүй байх үр дагавартай шийдвэр гаргасан. Гэвч, судлаачийн зүгээс нөлөө үзүүлнэ гэж харж буй бөгөөд ийнхүү үзэх үндэслэлээ тайлбарлая.

Магадлалд нэхэмжлэгчийг “малыг барьж тусалж буй мэргэжлийн дадалгүй С” гэж тодорхойлсон байна. Өөрөөр хэлбэл, нэхэмжлэгч нь тухайн төрлийн амьтантай харьцахдаа дадал туршлагагүй бол гэмтэл бэртэл авах эрсдэлтэй гэдгийг ухамсарлах бүрэн боломжтой. Жишээ нь, хангал морь сургах зорилгоор мордож буй тохиолдолд мориноос унаж бэртэх эрсдэл

бий нь илэрхий. Энэхүү шийдвэрт дурдагдаж буй тохиолдол хангал морь сургах шиг өндөр эрсдэлтэй биш ч, энгийн ухамсрын түвшинд эмнэг адуутай харьцаж буй эрсдэлийг урьдчилан харах боломжтой гэж тооцогдоно. Тийм байтал, хохирогч өөрөө тухайн амьтантай ойр байх, тухайн эрсдэлд сайн дураараа орж буй нь эрсдэлийг сайн дураараа хүлээн зөвшөөрсөн шийдвэр (assumption of risk) гэж тооцогдоно. Энэ тохиолдолд адууны эзэмшигч, өмчлөгч нь хариуцлага хүлээхгүй байх боломжтой. Хэдийгээр, гэм буруутай эсэхээс үл хамааран хариуцлага хүлээх тогтолцоо байсан ч, дээрх тайлбарт үндэслэвэл, анхнаасаа гэм хор үүссэн гэж үзэхгүй. Ялангуяа монголчууд монгол адуу мал эрсдэлтэй гэдгийг нийтлэг байдлаар гадарлах боломжтойн дээр, нүүдлийн соёлын уламжлал зэргийг ч хууль тайлбарлахдаа бодолцож үзэх ёстой гэж харж байна.

Хэрэв дээрх эрсдэлийг сайн дураараа хүлээн зөвшөөрсөн шийдвэр (assumption of risk) биш, эсхүл тус онолын тайлбар хэрэглэгдэхгүйгэж үзвэл, нэхэмжлэгч өөрөө анхаарал болгоомжгүй байсан, эсхүл мэдлэг туршлагагүй байж эрсдэлтэй алхам хийсэн бол Иргэний хуулийн 514 дүгээр зүйл (Хохирогчийн гэм буруу, гэм хор учруулагчийн эд хөрөнгийн байдлыг харгалзан үзэх)-ийн 514.1-д заасан “Гэм хор учрах буюу түүнээс үүдэн гарах хохирлын хэмжээ нэмэгдэхэд хохирогчийн хэтэрхий болгоомжгүй үйлдэл, эс үйлдэл нөлөөлсөн бол уг нөхцөл байдлыг харгалзан хариуцах гэм хорын хэмжээг багасгаж болно” гэснийг хэрэглэнэ.

Адуунаас улбаатай гэм хор учирсан тохиолдолд 501 дүгээр зүйлийн 501.1 дэх заалт л хэрэглэгдэх үү, эсхүл мөн зүйлийн 501.2 дахь заалт ч хэрэглэгдэх боломжтой юу гэдгийг “Дүн шинжилгээ 1”-ээс үзнэ үү.

#### **ДҮН ШИНЖИЛГЭЭ 4. Тариалангийн талбайд сүрэг адуу орж ургац сүйтгэсэн тохиолдол**

ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ДУГААР, ОГНОО: Дархан-Уул аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн Дугаар 227 шийдвэр.

#### **МАРГААНЫ ҮЙЛ БАРИМТ**

Нэхэмжлэгч “Э” ХХК нь Сэлэнгэ аймгийн Хушаат сумд газар тариалангийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг бөгөөд тус компанийн вандуй тариалсан 10 га талбайд 2019 оны 10 дугаар сарын 05-ны өдөр 58 тооны адуу орж ургацыг гишгэж, идэж сүйтгэсний улмаас зохих хэмжээгээр ургац хураан авах боломжгүй болж 4,500,000 төгрөгийн хохирол учирчээ. Адуунуудыг “Э” ХХК-ийн ажилчид хашиж тогтоосон байна.

Маргааш нь буюу 2019 оны 10 дугаар сарын 06-ны өдөр адууг Б (хариуцагч) талбайгаас ирж аван, хүлээн авсан акт үйлджээ. “Э” ХХК нь адуун сүргээс учирсан хохирлыг шаардсан боловч, Б нь эдгээр адуу миний өмчлөлийнх биш, миний нэр дээр адуу тоологдоогүй учир хохирлыг хариуцахгүй, түүнчлэн тариалангийн талбайг тариалан эрхлэгч нь өөрөө хашаажуулах үүрэгтэй гэж маргажээ.

#### **ШИЙДВЭРЛЭСЭН БАЙДАЛ**

*Анхан шатны шүүхийн шийдвэр*

Анхан шатны шүүх дараах үндэслэлээр Иргэний хуулийн 497 дугаар зүйлийн 497.1, 510 дугаар зүйлийн 510.1, 514 дүгээр зүйлийн 514.1-д заасныг баримтлан хариуцагч Б-ээс 2,250,000 төгрөгийг гаргуулан нэхэмжлэгч “Э” ХХК-д олгож, нэхэмжлэлийн үлдэх 2,250,000 төгрөгийн шаардлагыг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэжээ.

Мал тэжээвэр амьтад хашаа худгийн 2018, 2019 оны тооллогод Б-ын нэр дээр адуу тоологдсон бүртгэл байхгүй боловч тухайн үед Б нь дээрх тооны адууг хариуцан өөрийн эзэмшилдээ байлгаж байсан байна. Хариуцагч Б нь 58 тооны адууг хариуцан эзэмшилдээ байлгаж байсны хувьд болон тариалангийн талбайн ойролцоо өвөлжиж, зусдагийн хувьд Тариалангийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2-д “Тариалангийн талбайн захаас гадагш 500 метрийн зайд мал бэлчээх, оторлох болон бэлчээрийн мал аж ахуйн өвөлжөө, хаваржаа, зуслан, намаржаа байхыг хориглоно”, Сэлэнгэ аймгийн Хушаат сумын Засаг даргын 2019 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн “Таримал ургамлыг малаас хамгаалах тухай” 01 тоот албан даалгаврын 3.3-д заасан “малаа байнгын хариулгатай бэлчээж намарт адуу, үхрийг шөнөдөө хашиж, тариалангийн талбайд таримал ургамал тариалснаас ургац хурааж дуусах хүртэл мал оруулахгүй байх” гэсэн үүргийг тус тус биелүүлээгүй байна.

Тиймээс Иргэний хуулийн 497 дугаар зүйлийн 497.1, 510 дугаар зүйлийн 510.1-д “Бусдын эд хөрөнгөд гэм хор учруулсан этгээд уг гэм хорыг арилгахдаа гэм хор учруулахаас өмнө байсан байдалд нь сэргээх (адил нэр, төрөл, чанарын эд хөрөнгө өгөх, гэмтсэн эд хөрөнгийг засах зэргээр) буюу учирсан хохирлыг мөнгөөр нөхөн төлнө” гэж заасны дагуу хариуцагч Б нь уг учирсан хохирлыг нөхөн төлөх үүрэгтэй.

Гэвч, нэхэмжлэгч “Э” ХХК нь Тариалангийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.1-д “Тариалангийн үйлдвэрлэл эрхлэгч өөрийн эзэмшлийн талбай, ургацаа бусдын халдлага болон малаас хамгаалах үүрэгтэй”, Сэлэнгэ аймгийн Хушаат сумын Засаг даргын 2019 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн “Таримал ургамлыг малаас хамгаалах тухай” 01 тоот албан даалгаврын 2.4-д заасан “Тариалангийн талбайг хашаажуулах ажлыг өөрсдийн санаачилгаар хийх” үүргээ биелүүлээгүй байна. Нэхэмжлэгч



“Э” ХХК-ийн тариалангийн талбайг хашаажуулаагүй дээрх болгоомжгүй үйлдэл, эс үйлдэхүй нь хохирлын хэмжээг нэмэгдүүлэхэд нөлөөлсөн учир, уг нөхцөл байдлыг харгалзан хариуцах гэм хорын хэмжээг 50 хувиар багасгаж буюу 2,250,000 төгрөгийг хариуцагч Б-ээс гаргуулан нэхэмжлэгч “Э” ХХК-д олгож, үлдэх 2,250,000 төгрөг гаргуулах тухай нэхэмжлэлийн шаардлагыг хэрэгсэхгүй болгожээ.

### ДҮН ШИНЖИЛГЭЭ

Шүүхийн шийдвэрийн үндэслэх хэсэг болон тогтоох хэсгийг харвал, шүүх Иргэний хуулийн 497 дугаар зүйлийн 497.1, 510 дугаар зүйлийн 510.1, 514 дүгээр зүйлийн 514.1 дэх заалтуудыг тус тус хэрэгжүүлжээ. Гэтэл энэхүү гэм хорын тохиолдол нь амьтны учруулсан тохиолдол бөгөөд Иргэний хуулийн 501 дүгээр зүйлийг хэрэгжүүлэх учиртай юм. Хэдийгээр шүүхээс 501 дүгээр зүйлийг хэрэгжүүлсэн талаар шийдвэртээ оруулаагүй байх боловч агуулгын хувьд хэрэгжүүлсэн гэдэг нь харагдана.

Тодруулбал, хариуцагч нь өөрийгөө адууны өмчлөгч биш учир нөхөн төлбөрийг хариуцахгүй гэж маргасан боловч, тухайн үед тэдгээр адуу нь Б-ийн эзэмшилд байсан учир гэм хорыг хариуцах ёстой гэж үзжээ. Энэ нь Иргэний хуулийн 501 дүгээр зүйлд заасан амьтны учруулсан гэм хорыг өмчлөгч, эзэмшигч хариуцна гэсний дагуу амьтны эзэмшигч гэм хорыг хариуцах агуулгад үндэслэсэн гэдэг нь харагдаж буй юм.

Дээрх шүүхийн шийдвэрт дурдагдаж буй тохиолдлын хувьд энгийн амьтны учруулсан гэм хороос ялгаатай нь тариалангийн талбайд тухайн гэм хорын үйл явдал болсон учир Тариалангийн тухай хуулийг хэрэгжүүлж буйгаараа онцлогтой. Энэ тохиолдолд тариалангийн бүс нутагт буй малын эзэмшигч, өмчлөгчийн хувьд байнгын хариулгатай байлгах, тариалангийн талбайгаас 500 метр зайтай байлгах гэх мэт тусгай үүргүүд нэмэгдэж байна. Судлаачийн зүгээс тариалангийн бүс нутагт бэлчиж буй малын

өмчлөгч, эзэмшигчийн хувьд бусад бүс нутагт бэлчих малын эзэмшигч, өмчлөгчөөс илүү хэмжээний анхаарал болгоомжтой байх үүрэг нэмэгдэнэ гэдэгтэй санал нийлнэ. Өөрөөр хэлбэл, Тариалангийн тухай хуулиас үзвэл малаас тариалангийн талбайд учруулсан гэм хорын тухайд хариуцах этгээд нь малаа тариалангийн талбайгаас зайтай байлгаагүй, хариулаагүй гэх мэт анхаарал болгоомжгүй байдлыг урьдчилсан нөхцөл болгосон байна. Энэ тохиолдолд, малын эзэмшигч, өмчлөгч нь гэм буруутай байх асуудал хөндөгдөж буй. Гэтэл, Иргэний хуулийн 501 дүгээр зүйлийн 501.1 нь гэм буруутай эсэхээс үл хамааран хариуцлага хүлээлгэх заалт бөгөөд мөн зүйлийн 501.2 нь хариуцагч санаатай, эсхүл илтэд болгоомжгүй тохиолдолд хариуцлага хүлээх заалт юм.

Дээрхээс үзвэл Иргэний хуулийн 501 дүгээр зүйл болон Тариалангийн тухай хуульд заасан малын өмчлөгч, эзэмшигчид ногдуулж буй үүрэг нь логикийн хувьд авцалдахгүй байна. Адуу зэрэг мал нь гэрийн тэжээвэр амьтан биш. Гэхдээ мэргэжлийн үйл ажиллагааны зүйл болдог амьтан гэж тайлбарлах боломж бий. Адууг мэргэжлийн үйл ажиллагааны зүйл болдог амьтан биш гэдэг байр сууринаас үзвэл адуу зэрэг малын өмчлөгч, эзэмшигч нь 501 дүгээр зүйлийн 501.1-д заасны дагуу гэм буруутай эсэхээс үл хамааран хариуцлага хүлээнэ. Иргэний хуулийн энэ байр сууринаас авч үзвэл, Тариалангийн тухай хуульд малын эзэмшигч, өмчлөгчид тухайн малаа тариалангийн талбайгаас зайтай бэлчээх, хариулгатай байлгах зэрэг үүрэг ногдуулах шаардлагагүй юм.

Гэтэл Тариалангийн тухай хуулиар малын эзэмшигч, өмчлөгчид анхаарал болгоомжтой байх үүрэг ногдуулсан байна. Энэ үүргээ биелүүлсэн тохиолдолд хариуцлагаас чөлөөлөгдөх боломжтой гэсэн үг. Өөрөөр хэлбэл, Иргэний хуулийн 501 дүгээр зүйлийн 501.1-д гэм буруутай эсэхээс үл хамааран хариуцлага

хүлээх зарчим Тариалангийн тухай хуульд тусгагдаагүй байна. Үүнээс улбаалан дараах логикийн авцалдаагүй байдал үүсэж байна. Тариалангийн тухай хууль нь тариалан эрхлэгчийг хамгаалах зорилгоор бусад тариалангийн бус бүс нутгаас илүү хатуу шаардлагыг малын эзэмшигч, өмчлөгчид тавих зорилготой гэж ойлгогдоно. Гэтэл тариалангийн бус бүс нутагт, эсхүл тариалантай холбоогүй амьтны гэм хорын тохиолдолд Иргэний хуулийн 501 дүгээр зүйлийн 501.1 хэрэглэгдэх бөгөөд энэ нь Тариалангийн тухай хуульд заасан шаардлагаас хатуу шаардлагыг малын эзэмшигч, өмчлөгчид ногдуулжээ.

Хэрэв адуу зэрэг малыг Иргэний хуулийн 501 дүгээр зүйлийн 501.2 дахь хэсэгт заасан “мэргэжлийн үйл ажиллагааны зүйл болдог амьтан” гэдэгт оруулбал, дээрх логикийн авцалдаагүй байдал залруулагдана. Тодруулбал, адуу зэрэг малын гэм хор учруулсан тохиолдолд Иргэний хуулийн 501.2-д заасны дагуу санаатай, эсхүл илтэд болгоомжгүй гэм буруутай байсан гэдэг урьдчилсан нөхцөл хангагдаж байж түүний өмчлөгч, эзэмшигч нь хариуцлага хүлээнэ. Харин тариалантай холбогдох гэм хорын тохиолдолд малын эзэмшигч, өмчлөгч нь санаатай болон болгоомжгүй гэм буруутай гэсэн үндэслэлээр хариуцлага хүлээх болж байна. Тийнхүү дээрх байдлаар тайлбарлавал, Иргэний хууль нь Тариалангийн тухай хуулиас дараах байдлаар ялгаатай. Иргэний хуулиар гэрийн тэжээвэр болон мэргэжлийн үйл ажиллагааны зүйл болдог амьтны өмчлөгч, эзэмшигчийн ялимгүй болгоомжгүй үйлдэлд хариуцлага хүлээлгэхгүй. Харин Тариалангийн тухай хуулиар малын өмчлөгч, эзэмшигч нь болгоомжгүйн гэм буруугийн хэмжээ их багаас үл хамааран гэм буруутай тохиолдолд хариуцлага хүлээх агуулгатай. Ингэснээр логикийн хувьд, малын учруулсан гэм хор үүссэн гэж үзэхэд нийтлэг байдлаар түүний өмчлөгч, эзэмшигч санаатай эсхүл, илтэд болгоомжгүй гэм буруутай байх шаардлага тавигдана. Харин тариаланд холбогдох малын учруулсан гэм хор үүссэн

гэж үзэхэд санаатай, эсхүл болгоомжгүйн гэм буруутай байх шаардлага тавигдана. Тариалангийн ойролцоох малын өмчлөгч, эзэмшигчид бусад тариалангийн бус бүс нутаг дахь малын өмчлөгч, эзэмшигчээс илүү хатуу шаардлага тавигдаж буй учир, энэ нь логикийн хувьд авцалдаатай.

Шүүхийн шийдвэрийн үндэслэл рүү эргэн орёе. Шүүхээс Тариалангийн тухай хуульд заасны дагуу нэхэмжлэгч болон хариуцагч тал аль аль нь анхаарал болгоомжтой байх үүргээ биелүүлээгүй гэх үндэслэлээр Иргэний хуулийн 514 дүгээр зүйлд заасны дагуу хохирлын хэмжээг бууруулж шийдсэнтэй судлаач санал нийлнэ. Гагцхүү, тавин хувиар бууруулах эсэх нь тухайн хэргээс хамаарч янз бүр байх бөгөөд ямар тохиолдолд хэдэн хувь бууруулж тооцох вэ гэдгийг шүүхийн жишигт даатгаж үлдээх нь оновчтой.

Судлаачийн хувьд дээр дурдсан Иргэний хууль болон Тариалангийн тухай хуулийн логик авцалдааны асуудлаар дамжуулан, адуу зэрэг малыг Иргэний хуулийн 501 дүгээр зүйлийн 501.2-д заасан “мэргэжлийн үйл ажиллагааны зүйл болдог амьтан” гэдэгт оруулж тайлбарлах нь зохимжтой гэдгийг зориуд тэмдэглэж үлдээе.

## 2.2. ГЭРИЙН ТЭЖЭЭВЭР АМЬТНЫ УЧРУУЛСАН ГЭМ ХОРЫН ТОХИОЛДОЛ

**ДҮН ШИНЖИЛГЭЭ 5.** Хохирогчийн хувийн нөхцөл байдал хохирлын хэмжээ ихсэхэд нөлөөлсөн тохиолдол

ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ДУГААР, ОГНОО: Сүхбаатар дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2017 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн Дугаар 2716 шийдвэр.

## МАРГААНЫ ҮЙЛ БАРИМТ

Д (хариуцагч) нь 2015 оны 12 дугаар сарын 19-ний өдөр “С” ХХК дэлгүүрийн хашаан дотор орчиндоо аюул учруулж болзошгүй нохойг зохих хамгаалалтгүй байлгасны улмаас тус дэлгүүрийн хашаанд явж байсан Б (нэхэмжлэгч, хохирогч)-г хазаж, түүний бие махбодод хөнгөн гэмтэл учруулжээ.

Б нь нохойд хазуулсны улмаас эмчилгээний зардал болон бусад эд хөрөнгийн зардалд 2,050,000 төгрөг, нохойнд хазуулсны улмаас харшил сэдэрч эмчилгээ хийлгэсний зардалд 3,723,830 төгрөг буюу нийт 5,773,830 төгрөгийг Д болон “С” ХХК-аас шаардан шүүхэд нэхэмжлэл гаргажээ. Д нь “С” ХХК-ийн гүйцэтгэх захирал юм.

Д нь нохойд хазуулсантай холбоотой эрүүл мэндийн болон эд хөрөнгийн хохирол болох 2,050,000 төгрөгийн шаардлагыг хүлээн зөвшөөрсөн боловч харшлын эмчилгээний зардлыг хариуцахгүй гэж маргажээ.

## ШИЙДВЭРЛЭСЭН БАЙДАЛ, ҮНДЭСЛЭЛ

Шүүх дараах үндэслэлээр хариуцагч “С” ХХК-аас эд хөрөнгөд учирсан хохиролд 2,050,000 төгрөг, эрүүл мэндэд учирсан хохиролд 1,861,915 (3,723,830:2) төгрөг буюу нийт 3,911,915 төгрөгийг гаргуулж нэхэмжлэгч Б-д олгож, нэхэмжлэлийн шаардлагаас үлдэх 1,861,915 төгрөгт холбогдох хэсгийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэжээ.

Шүүхээс хариуцагчийг хохирогч Б-ийн нохойд уруулсан болон хувцас эд хөрөнгөөрөө хохирсонтой холбогдох 2,050,000 төгрөгийн хохирлыг бүрэн хариуцан арилгах үүрэгтэй гэж шийдвэрлэжээ. Харин Б нь хэрэг гарахаас өмнө арьсны хайрст үлд өвчнөөр өвдсөн, байнга эмчилгээ хийлгэдэг байсан нь хэргийн баримтаар тогтоогдсон ба хэрэг гарсны дараа 2016 оны 06 дугаар сарын 22-ны өдрөөс 29-ний хооронд долоо хоног эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн, гэрээр эмчилгээ хийлгэсэн болох нь нотлогджээ. Галзуу өвчний

вакцинаас хамаарч нэхэмжлэгч Б-ийн хайрст үлд өвчин сэдэрсэн гэж үзэх үндэслэлгүй нь тогтоогдсон боловч нохойд хазуулж, таван шарх авсан Б нь уг шархаа эмчлүүлэх явцад биеийн дархлаагаа алдаж, ядарч сульдсаны улмаас хайрст үлд өвчин нь сэдэрсэн байх боломжтой юм.

“Иймд хариуцагчийн гэм буруугийн улмаас нэхэмжлэгчийн өвчин сэдрэх шалтгаан бүрдсэн гэж үзэх үндэслэлтэй тул үүнийг шууд бусаар гэм хор учруулсан гэж дүгнэв. Иймээс Б-ийн суурь өвчин сэдрэх нөхцөлийг бүрдүүлсэн үндэслэлээр гарсан зардлыг зохигчдод хувааж буюу 50:50 хувиар хариуцуулах нь Иргэний хуулийн 229 дүгээр зүйлийн 229.2-д “Гэм хорын хэмжээг тодорхойлохдоо хохирогчийн ашиг сонирхол, гэм хор учирсан нөхцөл байдал, гэм хор учруулагчийн гэм буруугийн хэр хэмжээг харгалзан үзнэ” гэж заасанд нийцнэ хэмээн үзлээ” гэжээ.

### ДҮН ШИНЖИЛГЭЭ:

Энэхүү шүүхийн шийдвэрээр авч үзсэн нь нохойг бусдад аюул учруулахаас сэргийлэх зохих хамгаалалтгүй байлгасны улмаас эзэмшигч нь амьтны учруулсан гэм хорыг хариуцан арилгасантай холбогдох хэрэг юм. Энэхүү шийдвэрт нохойны эзэн нь нохойноос улбаатай шууд хохирлыг бүрэн хариуцахаа хүлээн зөвшөөрчээ. Тэр нь нохойд уруулсны улмаас эрүүл мэндээрээ хохирсон, эмчилгээ хийлгэсэн зардал, мөн тухайн үед хохирогч утсаа унагаж эвдэлсэн, түүнчлэн хувцас болон цүнхээ уруулсантай холбогдох зардал юм. Харин хариуцагч нь хохирогчийн арьсны харшилтай холбоо бүхий зардлыг хүлээн зөвшөөрөөгүй байна.

Шүүхээс хохирогчийн нохойд уруулж галзуугийн тариа хийсэн нь түүний арьсны харшлыг шууд сэдэрээсэн талаар тогтоогдохгүй байгааг дурдсан бөгөөд гэхдээ арьсны харшил сэдэрэхэд нохойд уруулж дархлаа муудсан зэрэг нь нөлөөлсөн байх боломжтой гэж үзжээ. Ингэхдээ, тухайн хохирогч нь хайрст үлд

гэдэг ужиг өвчинтэй байсан учраас хохирол нэмэгдэхэд түүний энэ хувийн нөхцөл нөлөөлсөн гэж үзжээ. Өөрөөр хэлбэл, хайрст үлд гэдэг ужиг өвчингүй хүн байсан бол нохойд уруулсантай холбоотойгоор арьсны харшлын эмчилгээний зардал гарахгүй гэж үзсэн хэрэг юм. Тиймээс хохирогчийн өөрийнх нь хувийн шинж байдал хохирол нэмэгдэхэд нөлөөлсөн учраас Иргэний хуулийн 229 дүгээр зүйлийн 229.2-д заасныг үндэслэн нөхөн төлбөрийн хэмжээг 50 хувь бууруулжээ.

Энэ нь амьтны учруулсан гэм хортой холбогдуулан дараах хоёр асуултад хариулт өгч байна. Нэгдүгээрт, амьтны учруулсан гэм хорын тохиолдолд, амьтны үйлдэл болон хохирлын хооронд заавал шууд шалтгаант холбоо байх ёстой гэж үзээгүй, шууд бус шалтгаант холбоо байж болно. Хоёрдугаарт, нөхөн төлбөрийн хэмжээг тооцохдоо тухайн хохирогчийн хувийн байдал нөлөөлсөн эсэхээс хамааран хууль хэрэгжүүлж буй нь хохирогч хэн байхаас шалтгаалан ялгаатай шийдвэрүүд гарах боломжтойг харуулж байна. Жишээ нь, амьтны учруулсан үйлдэл хүнд биш боловч хохирогч бие султай хүн байснаас болж нас барсан гэж үзвэл, энэ тохиолдолд заавал нөхөн төлбөрийг бүтэн гаргана гэсэн баталгаа байхгүй гэсэн үг. Иймээс, ямар тохиолдолд ямар хэмжээгээр нөхөн төлбөрийг хангах вэ гэдгийг шүүхийн шийдвэрээр жишиг тогтоох байдлаар асуудалд хариулт өгөх нь гарцаагүй. Цаашдаа амьтны учруулсан гэм хортой холбогдох шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийх ач холбогдлыг өсгөж байна.

**ДҮН ШИНЖИЛГЭЭ 6.** Гэрийн тэжээвэр амьтны өмчлөгч, эзэмшигчийн илт болгоомжгүй үйлдэлд холбогдох тохиолдол

ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ДУГААР, ОГНОО: Хан-Уул дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2022 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн Дугаар 183/ШШ2022/00452 шийдвэр.

## МАРГААНЫ ҮЙЛ БАРИМТ

2021 оны 08 дугаар сарын 08-ны орой Т (нэхэмжлэгч) нохойгоо салхилуулж байхад нь түүний нохойг Б (хариуцагч)-ийн эзэмшлийн герман овчарка үүлдрийн нохой хазсаны улмаас Т-ийн нохойны нуруу нь хугарч, цаашид амьдрах боломжгүй болж унтуулга хийгджээ. Т нь нохойны үнэ 2 сая төгрөг, нохойноос олох байсан ашиг болох 8 сая төгрөг, нийт 10 сая төгрөгийг гаргуулахаар шаарджээ.

Хариуцагч нь нэхэмжлэгчийг нохойгоо харж хандах үүргээ биелүүлээгүй, том нохой салхилуулдаг газарт салхилуулж байсан, нохойг хазчихсан байхад татаж нурууг нь хугалсан тул адилхан буруутай, Т-ийн нохой хээлгүй байсан учраас олох байсан ашиг гэж нэхэмжилж байгааг зөвшөөрөхгүй гэж маргажээ.

## ШИЙДВЭРЛЭСЭН БАЙДАЛ, ҮНДЭСЛЭЛ

Шүүх дараах үндэслэлээр Иргэний хуулийн 501 дүгээр зүйлийн 501.2, 510 дугаар зүйлийн 510.1-д зааснаар хариуцагчаас Т-ийн нохойны үнэ болох 2 сая төгрөгийг гаргуулан нэхэмжлэгчид олгож, нэхэмжлэлийн шаардлагаас олох байсан ашиг болох 8 сая төгрөгийг хэрэгсэхгүй болгохоор шийдвэрлэжээ.

Шүүх иргэний хуулийн 501 дүгээр зүйлийн 501.2-ыг үндэслэн хариуцагч санаатай болон илт болгоомжгүй гэм буруутай тохиолдолд гэм хорыг хариуцан арилгана гээд үүний тулд тухайн гэм хорыг учруулагч нь гэрийн тэжээвэр амьтан байх ёстой гэсэн байна. Энэ зүйлд заасан “гэрийн тэжээвэр амьтан” гэдэгт хүний арчилгаа, маллагааны тусламжтайгаар амьдардаг таван хошуу малаас гадна ахуйн хэрэгцээнд зориулан гаршуулсан, өөртөө дасгасан амьтад болох нохой, муур, тахиа, гахай зэргийг ойлгоно гэж тайлбарлажээ.

Хариуцагчийн нохой нь хэрэг гарах үед хошуувчгүй байсан бөгөөд хариуцагч нь шүүх хуралдаанд гаргасан тайлбартаа



“...жижиг нохой буюу өдөөгч зүйл байх юм бол дайрдаг” гэж тайлбарласан атлаа зогсоох арга хэмжээг аваагүй, нохойгоо хөтлөөгүй, хошуувчгүй байхад нь өдөөгч зүйл байвал дайрах боломжтой гэдгийг мэдэх ёстой байсан нь илт болгоомжгүй үйлдэл учир гэм буруутай гэж дүгнэжээ.

Иргэний хуулийн 101 дүгээр зүйлийн 101.3-д “мал, амьтан өмчлөгч нь өмчлөх эрхээ хэрэгжүүлэхдээ мал, амьтан, байгаль орчныг хамгаалах, эрүүл ахуйн шаардлага, бусдын аюулгүй байдлыг хангах талаар тогтоосон хууль дүрмийг сахин биелүүлэх үүрэгтэй” байдаг. Шүүхээс хариуцагчийг Нийслэлийн нутаг дэвсгэрт нохой муур тэжээх, арчлах, золбин нохой муур устгахад мөрдөх журмын 1.1-д “нохой, муур эзэмшигч байгууллага, иргэд нь орон сууц, гэр хорооллын хашаанд тусгай бэлтгэсэн байр, талбайд бат бэх уяатай байлгаж, гадаа гудамж талбайд зугаалуулах, эмчилгээ үйлчилгээ хийлгэхээр авч явахдаа амны хошуувчтай байлгана” гэснийг зөрчсөн тул гэм хорыг хариуцна гэжээ.

Харин нэхэмжлэгчээс олох ёстой байсан орлого гэдэгт түүний нохой эм нохой байсан бөгөөд гөлөглөхөөр нь олох байсан ашиг болох 8 сая төгрөгийг гаргуулах талаарх нэхэмжлэлийг дараах байдлаар шийдвэрлэжээ. Нийслэлийн нутаг дэвсгэрт нохой муур тэжээх, арчлах, золбин нохой муур устгахад мөрдөх журмын 5 дугаар зүйлийн 1-д “байгууллага, аж ахуйн нэгж, иргэдээс нохойг үржлийн зориулалтаар ашиглах, нохойн аж ахуй байгуулах асуудлыг Нийслэлийн Мал эмнэлгийн болон холбогдох мэргэжлийн байгууллагуудын санал дүгнэлтийг үндэслэн тухайн дүүргийн Засаг даргын Тамгын газар шийдвэрлэнэ” гэж заасныг үндэслэн, нэхэмжлэгчийг нохойгоо үржүүлгийн журмаар буюу ашиг олох зорилгоор тэжээж байсан гэж үзэх үндэслэлгүй, энэ талаарх баримтгүй, мөн нохой гөлөглөж, уг гөлгийг нь худалдан ашиг олно гэж тайлбарласан боловч хээлгүй байсан болох нь

баримтаар тогтоогдож буй тул олох байсан ашиг гэж 8 сая төгрөгийг хариуцагчаас шаардсан нь үндэслэлгүй гэж үзжээ.

### **ДҮН ШИНЖИЛГЭЭ:**

Шүүхээс тус хэргийг Иргэний хуулийн 501 дүгээр зүйлийн 501.2 дахь заалтыг баримтлан шийдвэрлэжээ. Иргэний хуулийн 501.2-д заасан үндэслэл нь хариуцагч өөрийн санаатай болон илтэд болгоомжгүй гэм буруу байгаагүйг нотлох үүргийн талаарх зохицуулалт бөгөөд нотолсон тохиолдолд хариуцлагаас чөлөөлөгдөнө. Үүний урьдчилсан нөхцөл нь нэгдүгээрт хариуцагчийн өмчлөл, эсхүл эзэмшилд буй амьтан нь гэрийн тэжээвэр, эсхүл мэргэжлийн үйл ажиллагааны зүйл болдог амьтан байх, хоёрдугаарт хариуцагч нь санаатай эсхүл илтэд болгоомжгүй гэм буруутай байх гэсэн нөхцөлүүд юм.

Эхний урьдчилсан нөхцөлийн тухайд эзэнтэй нохой нь гэрийн тэжээвэр амьтан гэдэгт маргах зүйлгүй. Гэхдээ шүүх гэрийн тэжээвэр амьтан гэдгийг “хүний арчилгаа, маллагааны тусламжтайгаар амьдардаг таван хошуу малаас гадна ахуйн хэрэгцээнд зориулан гаршуулсан, өөртөө дасгасан амьтад болох нохой, муур, тахиа, гахай зэргийг ойлгоно” гэж тайлбарлажээ. Энэхүү мал болон фермийн амьтдыг гэрийн тэжээвэр амьтанд оруулж буй тодорхойлолт нь учир дутагдалтай.

Хоёр дахь урьдчилсан нөхцөлийн хувьд хариуцагч болох амьтны эзэн нь санаатай, эсхүл илт болгоомжгүй гэм буруутай байгаагүй гэдгээ нотлох шаардлагатай. Үүнийг шүүх “Нийслэлийн нутаг дэвсгэрт нохой муур тэжээх, арчлах, золбин нохой муур устгахад мөрдөх журам”-д зааснаар нохойгоо салхилуулах үедээ хошуувчтай байлгах ёстой. Хариуцагч нь нохойгоо жижиг нохой буюу өдөөгч зүйл байх үед дайрдаг гэдгийг мэдсээр байж хошуувчгүй байлгасан нь илтэд болгоомжгүй үйлдэл гэж дүгнэсэн байгаагаар санал нийлнэ. Үүнээс бий болох асуулт нь хошуувчгүй нохойноос айж цочсондоо ямар нэг үйлдэл хийсний улмаас

хохирол амссан бол тухайн нохойны эзэн хариуцлага хүлээх үү гэдэг нь нээлттэй хэвээр үлдэж байна. Ямартай ч, дээрх журмыг баримталбал, нохой муурыг хошуувчгүйгээр гудамж болон нийтийн эдэлбэр газар зэрэгт байлгах нь түүний эзэмшигч, өмчлөгчийг автоматаар илтэд болгоомжгүй гэм буруутай болгож байгааг анхаарах нь зүйтэй.

Гэхдээ энэ нь Нийслэлд хэрэгжих журам бөгөөд бусад аймаг, орон нутагт хэрхэх талаар тухайн орон нутгийн зохих байгууллагаас гарах дүрэм журмаар ялгаатай байх боломжтой. Нийслэлд мөрдөгддөг шиг дүрэм журам байхгүй бол нохой, муурыг ямар түвшинд бусдад аюул учруулахаас сэргийлснийг илтэд болгоомжгүй гэм буруугүй гэж үзэх вэ гэдэг нь нээлттэй хэвээр байна. Цаашид үүнтэй холбогдох шинэ шүүхийн шийдвэр гарвал түүнд дүн шинжилгээ хийх ач холбогдлыг нэмэгдүүлж байна.

Олох ёстой байсан орлого буюу тухайн нохойг ашиг олох зорилгоор өсгөж байсан эсэхэд шүүх үндэслэлтэй дүгнэлт хийсэн. Өөрөөр хэлбэл, арилжааны зорилгоор нохойг өсгөж байгаа тохиолдолд захиргааны байгууллагад бүртгүүлэх зэрэг зарим төрлийн шаардлагыг төрөөс тавьдгийг буруутгах үндэслэлгүй.

## ГУРАВ. ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

Амьтны учруулсан гэм хорын хариуцлагыг аль эрт Ромын эрх зүйн үед хүртэл харьцангуй өргөн хүрээнд хүлээн зөвшөөрч иржээ.<sup>25</sup> Энэ нь үхэр, адуу зэрэг нь уналгад ашиглагддаг буюу одоогоор бол тээврийн хэрэгсэл мэтээр ойлгогддог байсантай холбоотой. Тэр утгаараа амьтны учруулсан гэм хорын хариуцлагын тогтолцоо нь тухайн үедээ чухал үүрэгтэй байсан боловч, тээврийн хэрэгслийг автомашин орлох болсноор уг тогтолцооны ач холбогдол бага зэрэг буурчээ. Гэхдээ орчин үед, гэрийн тэжээвэр амьтныг өсгөн тэжээх давлагаа эхэлсэн нь тус тогтолцооны ач холбогдол эргэн ихсэх магадлалтайг харуулж байна.<sup>26</sup>

Дээр дурдсанчлан, улс орнуудад амьтны учруулсан гэм хорыг түүний өмчлөгч, эзэмшигчид өргөн хүрээнд үүрүүлдэг. Тухайлбал, Франц, Голланд, Итали, Испанид энэ төрлийн хариуцлага нь гэм буруутай эсэхээс үл хамааран хүлээдэг хариуцлага (strict liability) бол<sup>27</sup>, ХБНГУ-д албан хэрэгцээ, аж ахуйн үйл ажиллагаа, эзнийхээ харгалзан туслагч байдлаар ашиглагддаг амьтны учруулсан гэм хорын хувьд зарим тохиолдолд хариуцлагаас чөлөөлөх үндэслэлтэй байдлаар Иргэний хуульдаа тусгасан байдаг. Харин Япон болон Швейцарын хувьд хариуцлагаас чөлөөлөх үндэслэлийг илүү өргөн хүрээнд зөвшөөрсөн байна.<sup>28</sup>

<sup>25</sup> 我妻榮、有泉亨、清水誠、田山輝明（2021）『我妻 有泉コンメンタール民法〔第7版〕—総則 物権 債権—』日本評論社、1576 pg.

<sup>26</sup> 林良平編、前田達明、窪田充見（1989）『注釈判例民法—債権法II—』青林書院、1322pg.

<sup>27</sup> 潮見佳男（2012）『不法行為法II（第2版）』信山社、425 pg.

<sup>28</sup> 我妻榮、有泉亨、清水誠、田山輝明（2021）『我妻 有泉コンメンタール民法〔第7版〕—総則 物権 債権—』日本評論社、1576 pg.

Манай улсын хувьд, гэрийн тэжээвэр болон мэргэжлийн үйл ажиллагааны зүйл болдгоос бусад амьтны хувьд гэм буруутай эсэхээс үл хамааран хариуцлага хүлээхээр байгаа. Дээрхээс гэм буруутай эсэхээс үл хамааран хариуцлага хүлээх тогтолцоо нь хууль хэрэглээний хувьд харьцангуй ойлгомжтой байх тул, Франц Улстай харьцуулах нь төдийлөн ач холбогдолгүй гэж үзлээ. Харин ХБНГУ-ын хувьд манай улсын зохицуулалттай төстэй байх боловч, хууль хэрэглээ буюу зохицуулалтын тайлбар нь ижил төстэй, эсхүл ялгаатай талаар судлах шаардлагатай учир тус улсыг харьцуулсан судалгааны объектоор сонголоо. Түүнчлэн, Швейцар болон Япон Улсын тогтолцоо нь бусад улсаас онцлогтой байх бөгөөд, тэдгээрийн төлөөлөл болгон Япон Улсыг сонгон судаллаа.

### 3.1. ХБНГУ<sup>29</sup>

ХБНГУ-ын Иргэний хуулийн 833 болон 834 дүгээр зүйлд амьтны учруулсан гэм хорын асуудлын талаар зохицуулжээ. Нэн тэргүүнд тус заалтуудын орчуулгыг доор үзүүлж, тэдгээрийн хэрэглэгдэх хүрээ, агуулга, холбогдох ойлголтуудыг авч үзье.

#### I. Зохицуулалт

##### **833 дугаар зүйл. Амьтны эзэмшигчийн хариуцлага**

Амьтнаас үүдэлтэйгээр хүн нас барах, бие болон эрүүл мэнд, эд хөрөнгөөр хохирох тохиолдолд, түүнээс улбаатай хохирлын нөхөн төлбөрийг тухайн амьтны эзэмшигч хариуцаж арилгах үүрэгтэй. Хэрэв хохирол нь албан хэрэгцээ болон аж ахуйн үйл ажиллагааны зорилго бүхий гаршуулсан амьтан, эсхүл эзэмшигчийнхээ харгалзан туслагч амьтнаас улбаатай бол, тэдгээр тохиолдолд амьтны эзэмшигч амьтныг хариуцаж

<sup>29</sup> Dannemann/Schulze (2020) German Civil Code Volume I: Books 1-3 Article-by-Article Commentary, C.H.Beck, Nomos.

байхдаа зохих анхаарал тавьсан, эсхүл тухайн хохирол нь зохих анхаарал тавьсан ч учрахаар байсан бол хохирол нөхөн төлөх үүрэг хүлээхгүй.<sup>30</sup>

### **834 дүгээр зүйл. Амьтан харагчийн хариуцлага**

Гэрээний дагуу амьтны эзэмшигчийн өмнөөс амьтныг харагч этгээд нь амьтны гуравдагч этгээдэд учруулсан хохирлыг 833 дугаар зүйлд заасны дагуу хариуцах үүрэгтэй. Хэрэв уг этгээд нь амьтныг хариуцахдаа зохих анхаарал тавьсан, эсхүл зохих анхаарал тавьсан ч хохирол учрахаар байсан бол хариуцлага хүлээхгүй.<sup>31</sup>

## **II. Үзэл баримтлал**

Амьтан нь бусдад гэм хор учруулах тодорхой эрсдэлүүдийг өөртөө агуулж байдаг гэдэг утгаараа түүний эзэмшигч тухайн амьтнаас улбаатай хохирлыг өөрөө гэм буруутай эсэхээс үл хамааран хариуцах зарчимтай. Өөрөөр хэлбэл, амьтны үйлдэл нь байгалийн ухамсаргүйгээр үйлдэгддэг, зан авир нь тааварлахад бэрх учраас түүний эзэн хариуцлага хүлээх ёстой гэсэн агуулга юм. Гэхдээ 833 дугаар зүйлд гаршуулсан амьтныг (domesticated animal) аж ахуйн үйл ажиллагааны зорилгоор (commercial purpose) тэжээдэг болон аж ахуйн ажиллагааны бус зорилгоор тэжээдэг амьтан (“luxury animal” гэж нэрлэдэг) гэж

<sup>30</sup> Section 833. Liability of animal keeper

If a human being is killed by an animal or if the body or the health of a human being is injured by an animal or a thing is damaged by an animal, then the person who keeps the animal is liable to compensate the injured person for the damage arising from this. Liability in damages does not apply if the damage is caused by a domestic animal intended to serve the occupation, economic activity or subsistence of the keeper of the animal and either the keeper of the animal in supervising the animal has exercised reasonable care or the damage would also have occurred even if this care had been exercised. [https://www.gesetze-im-internet.de/englisch\\_bgb/](https://www.gesetze-im-internet.de/englisch_bgb/)

<sup>31</sup> Section 834. Liability of animal minder

A person who by contract assumes the supervision of an animal for the keeper of the animal is responsible for the damage inflicted by the animal on a third party in the manner specified in section 833. The responsibility does not apply if he exercises reasonable care in supervision or if the damage would also have occurred even if such care had been exercised. [https://www.gesetze-im-internet.de/englisch\\_bgb/](https://www.gesetze-im-internet.de/englisch_bgb/)

ялгасан байдаг. Ийнхүү ялгаатай авч үзсэнээр аж ахуйн үйл ажиллагааны зорилгоор ашигладаг гаршуулсан амьтны эзэмшигч нь гэм буруутай буюу зохих анхаарал тавиагүйгээс үүссэн хохирлыг арилгах үүрэг хүлээх ба аж ахуйн үйл ажиллагааны бус зорилгоор тэжээдэг гаршуулсан амьтны эзний хувьд гэм буруутай эсэхээс үл хамааран хариуцлага хүлээх (strict liability) болж байна.

Дээрх үзэл баримтлал нь аж ахуйн зорилгоор ашиглагддаггүй амьтны эздийн хувьд тэгш бус байдал үүсгэж буй талаар шүүмжлэлд өртдөг боловч, Үндсэн хууль зөрчөөгүй гэж үзэн едий хүртэл өөрчлөгдөөгүй явсаар иржээ. Чухам яагаад зохих анхаарал болгоомжтой байсан тохиолдолд хариуцлагаас чөлөөлөх үндэслэлийг зөвхөн аж ахуйн үйл ажиллагааны зүйл болдог гаршуулсан амьтны эзэн байхаар зохицуулалт оруулсан нь сонирхол татах нь гарцаагүй. Тодруулбал, анх амьтны учруулсан гэм хорын хариуцлага нь гэм буруутай эсэхээс үл хамааран хүлээдэг байсан бол, 1908 онд фермер эрхлэгчдийн лоббигоор хууль тогтоогчид хариуцлагын стандартыг бууруулж, 833 дугаар зүйлд хоёр дахь өгүүлбэрийг нэмэлтээр оруулжээ.

### **III. Хэрэглэгдэх хүрээ**

Дээрх 833 дугаар зүйлийн хэрэглэгдэх хүрээний хувьд, хохирол учирсан этгээд нь гуравдагч этгээд байх ёстой бөгөөд амьтныг хамтран эзэмшигч, эсхүл тухайн амьтныг харгалзаж буй хүн бол хамаарахгүй. Гэхдээ тэдгээр нь 833 дугаар зүйлээс өөр шаардах эрхийг хэрэгжүүлэхэд саад болохгүй.

### **IV. Урьдчилсан нөхцөл, үгүйсгэх нөхцөл, тэдгээрийн тайлбар**

833 дугаар зүйлийн нэг дэх өгүүлбэр болон хоёр дахь өгүүлбэрийн урьдчилсан нөхцөлийн ихэнх нь давхцаж буй. Тухайлбал, амьтан болон амьтан эзэмшигчийн тодорхойлолт, хохирол, шалтгаант холбоо, хууль бус үйлдэл зэрэг нь адилхан.

Ялгаатай нь, тухайн амьтны аюулын төрлөөс хамаарч гэм буруутай эсэхээс үл хамааран хариуцлага хүлээх үндэслэлийг шаардах уу, эсхүл гэм буруутай байх үндэслэлийг шаардах уу гэдэг асуудал юм. Өөрөөр хэлбэл, тухайн амьтан нь субъектив байдлаар сайхан зантай, номхон байх нь ач холбогдолгүй. Харин тухайн амьтны нийтлэг төрөл нь хүн болон хүний эд хөрөнгөд хэр зэрэг аюултай вэ гэдгээр нь дүгнэнэ. Мөн бичигдээгүй нэг урьдчилсан нөхцөл бол тухайн амьтан нь ямар нэг байдлаар аюул учруулахуйц байдлыг илээр гаргасан байх шаардлагатай.

### **Амьтан**

Амьтан гэдэгт хэмжээ болон гаршуулсан эсэх, зэрлэг эсэхээс үл хамааран бүх төрөл, зүйлийн амьтдыг ойлгоно. Зөгий хүртэл 833 дугаар зүйлд заасан амьтанд хамаарна. Мөн тухайн амьтан нь гений өөрчлөлттэй эсэх нь ач холбогдолгүй. Гагцхүү, бичил биетэн амьтанд хамаарах уу гэдэг дээр судлаачдын байр суурь зөрдөг байна. Бичил биетэнтэй хэсэг энэхүү судалгаанд төдийлөн ач холбогдолгүй учир дэлгэрүүлэлгүй орхив.

### **Амьтан эзэмшигч**

Амьтны эзэмшигч гэдэгт амьтныг өөртөө шалтгаангүйгээр богино хугацаагаар байлгаж буй бус өөрөө ашиглаж, бодитоор эзэмшиж буй этгээдийг ойлгоно. Амьтны өмчлөл болон эзэмшил нь амьтны эзэмшигч гэж үзэхэд ихэнх тохиолдолд нотолгоо болдог ч, заавал байх шинж биш юм. Тэдгээрээс гадна хэн зардлыг нь гаргаж, хэн хохирол амсах вэ гэдэг нь бас үзүүлэлт болно. Харин амьтны хүрээлэн болон амьтан хамгаалах байр, амьтны дэлгүүр зэрэгт байгаагаас бусад зэрлэг амьтны хувьд хэний газарт амьдардаг нь ач холбогдолгүй.

Түүнчлэн төрийн байгууллага зэрэг хуулийн этгээд нь амьтны эзэн байж болно. Жишээ нь, цагдаагийн морь болон нохой гэх мэт.



### **Хохирол, шалтгаант холбоо, хууль бус үйлдэл**

Хохирлын хувьд зөвхөн амь нас, хүний эрүүл мэнд, эд хөрөнгөд учирсан хохирлыг ойлгох бөгөөд бусад төрлийн хохирол хамаарахгүй. Шалтгаант холбооны хувьд нийтлэг шалтгаант холбоо болох эквивалентийн онол (Theory of equivalent condition)-д үндэслэнэ. Өөрөөр хэлбэл, тухайн үйлдэл (эс үйлдэхүй) байгаагүй бол уг хохирол учрахгүй байсан гэдэг хүрээнд тодорхойлогдоно. Түүнчлэн хууль бус үйлдлийн улмаас гэм хор учирсан байх ёстой. Жишээ нь, дээрэмчнээс эд хөрөнгөө хамгаалахын тулд амьтнаар хохирол учруулсан бол хууль бус байх шинжид хамаарахгүй буюу хариуцлага хүлээхгүй.

### **Аюултай байдал**

Тухайн амьтан ямарваа нэг байдлаар аюултай үйлдэл хийсэн байх шаардлагатай. Жишээ нь, морь тангарах, нохой хазах, муур самардах гэх мэт. Зарим тохиолдолд заавал идэвхтэй үйлдэл байхыг ч шаардахгүй. Жишээ нь, ямар ч хамгаалах хэрэгсэлгүй бар гудамжинд гарч ирснийг харсан хүн айсандаа сандарч гүйж байхдаа унаж бэртэх, эсхүл тухайн амьтан нь халдварт өвчин тараах гэх мэт. Амьтан нь өөрийн байгалийн дадал (instinct)-аараа хийсэн үйлдэл биш, бусдаар удирдуулж хийсэн аюултай үйлдэл дээрхэд хамаарахгүй.

### **Хохирогчийн болгоомжгүй байдал**

Хэрэв хохирогч өөрөө илэрхий эрсдэлийг мэдсэн боловч, ухамсартайгаар үл хайхарсан бол амьтны эзэмшигч хариуцлага хүлээхгүй. Жишээ нь, морь унах чадвараа сайжруулах зорилгоор эмнэг морь унаж байхдаа мориноос унаж бэртэх тохиолдол үүнд хамаарна.

### **Гэм буруутай эсэхээс үл хамаарах хариуцлага (strict liability)**

Хэрэв ерөнхий урьдчилсан нөхцөл хангагдсан бөгөөд тухайн амьтан аж ахуйн үйл ажиллагаанд ашигладаггүй амьтан (luxury

animal) бол, түүний эзэмшигч нь гэм буруутай эсэхээс үл хамааран хариуцлага хүлээнэ. Тухайн амьтнаа аюулгүй байлгах хангалттай арга хэмжээ авсан эсэх нь хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

### **Аж ахуйн үйл ажиллагааны зорилгоор тэжээдэг гаршуулсан амьтан**

833 дугаар зүйлийн хоёр дахь өгүүлбэрт хамаарах амьтан нь дараах хоёр урьдчилсан нөхцөлийг хамтад нь хангах ёстой. Нэгдүгээрт, гаршуулсан амьтан (domestic animal, Haustierte) байх ёстой. Гаршуулсан амьтан гэдэгт хүн төрөлхтөн эртнээс гаршуулж бий болгосон амьтад болох нохой, муур, морь, үхэр, гахай, ямаа, хонь, тахиа гэх мэт орно. Гаршуулсан амьтдын эсрэг нь зэрлэг амьтад бөгөөд бар, арслан зэргийг хэдийгээр цирк болон амьтны хүрээлэнд сургасан байсан ч гаршуулсан амьтан гэж үзэхгүй. Өөрөөр хэлбэл, зэрлэг амьтдыг аж ахуйн зорилгоор ашигласан гэдэг нь гэм буруутгүйгээр хариуцлага хүлээх зарчмыг тойрч чадахгүй. Жишээ нь, зөгий гаршуулсан амьтанд орохгүй.

Хоёрдугаарт, тухайн амьтныг албан хэрэгцээнд, эдийн засгийн үйл ажиллагаанд, эсхүл эзнийхээ харгалзан туслагчаар ашигладаг байх ёстой. Жишээ нь, үхрийг сүүний болон махны чиглэлээр өсгөх, нохойг хамгаалалтын чиглэлээр, муурыг хулгана бариулах зорилгоор өсгөх нь үүнд хамаарна. Бусад бүх фермийн амьтад (livestock, мал) дээрхэд хамаарна.

### **Хариуцлагаас чөлөөлөх үндэслэл**

Аж ахуйн үйл ажиллагааны зорилгоор тэжээдэг гаршуулсан амьтны эзэн нь зохих анхаарлыг тавьсан бол, эсхүл тавиагүй байсан ч хохирол учрах байсан гэдгийг нотолбол хариуцлагаас чөлөөлөгдөнө. Зохих анхаарал гэдэг нь тухайн амьтны аюултай байдал хийгээд тухайн нөхцөл байдлаас шалтгаалаад харилцан адилгүй байна. Жишээ нь, “Нохойтой, болгоомжил” гэсэн бичиг

хадлаа гэдэг нь зохих анхаарал тавьсан гэж үзэх боломжгүй. Үхэр болон адууны хувьд тэдгээрийг зугтах боломжгүй жүчээ, хашаа зэрэгт оруулах шаардлагатай.

2009 онд таван үхэр фермээс зугтсан ба тэдгээрийн нэг нь зам дээр явж байхдаа машинтай мөргөлджээ. Энэ тохиолдолд, Холбооны дээд шүүхээс (BGH) үхрийн эзнийг хариуцлагаас чөлөөлөхгүй гэж шийдвэрлэжээ. Хэдийгээр үхэрнүүдийг хашаа жүчээ зэрэгт оруулан зохих анхаарал тавьсан гэдгээ нотолсон боловч, шүүхээс түүнийг цагдаа руу утсаар холбогдох ойролцоох замыг түр хаах арга хэмжээ авах ёстой байсан гэж үзжээ.

Амьтны эзэмшигч гэрээний үндсэн дээр амьтныг харгалзах удирдлагыг бусдад шилжүүлсэн бол, тухайн этгээд 834 дүгээр зүйлд заасны дагуу хариуцлага хүлээнэ. Гэхдээ, тохиромжгүй этгээдэд удирдлагыг шилжүүлсэн, эсхүл хангалттай зааварчилгаа өгөөгүй тохиолдолд амьтны эзэмшигч нь 840 дүгээр зүйлд заасны дагуу хамтын хариуцлага хүлээнэ.

*Хүснэгт 1. Хариуцлага хүлээх болон хариуцлагаас чөлөөлөгдөх урьдчилсан нөхцөл*

<b>Амьтныг өмчилж, эзэмшиж буй зорилго</b>	<b>Амьтны ангилал</b>	<b>Зохих анхаарал тавиагүй</b>	<b>Зохих анхаарал тавьсан буюу зохих анхаарал тавьсан ч хохирол үүсэхээр байсан</b>
Аж ахуйн зорилгоор ашигладаг	Гаршуулсан амьтан	Хариуцлага хүлээнэ	Хариуцлага хүлээхгүй
Аж ахуйн зорилгоор ашигладаг	Гаршуулаагүй амьтан	Хариуцлага хүлээнэ	Хариуцлага хүлээнэ
Аж ахуйн зорилгоор ашигладаггүй	Гаршуулсан амьтан	Хариуцлага хүлээнэ	Хариуцлага хүлээнэ
Аж ахуйн зорилгоор ашигладаггүй	Гаршуулаагүй амьтан	Хариуцлага хүлээнэ	Хариуцлага хүлээнэ

## V. Нотлох үүргийн хуваарилалт

Хохирогч 833 дугаар зүйлийн нэг дэх өгүүлбэрт заасан урьдчилсан нөхцөлүүдийг нотлох үүрэгтэй бол хариуцагч нь тус зүйлийн хоёр дахь өгүүлбэрт заасныг нотлох үүрэгтэй. Өөрөөр хэлбэл, хохирогч нь амьтнаас улбаатай хохирол амссан бөгөөд тухайн амьтан нь хариуцагчийн эзэмшил гэдгийг нотолно. Харин хариуцагч нь тус амьтан нь гаршуулсан, аж ахуйн үйл ажиллагааны зорилгоор ашигладаг амьтан бөгөөд зохих анхаарал тавьсан, эсхүл тавиагүй байсан ч хохирол учрах байсан гэдгийг нотлох үүрэгтэй. Түүнчлэн, хохирогчийн гэм буруугийн улмаас хохирол учирсан, эсхүл хэмжээ нь нэмэгдсэн гэдгийг нотлох нь хариуцагчийн үүрэг юм.

### 3.2. ЯПОН УЛС

Япон Улсын Иргэний хуулийн 718 дугаар зүйлд амьтны учруулсан гэм хорын асуудлын талаар зохицуулжээ. Нэн тэргүүнд тус заалтуудын орчуулгыг дор үзүүлж, тэдгээрийн хэрэглэгдэх хүрээ, агуулга, холбогдох ойлголтуудыг авч үзье.

#### I. Зохицуулалт

##### 718 дугаар зүйл. Амьтан эзэмшигчийн хариуцлага<sup>32</sup>

718.1. Амьтан эзэмшигч нь тухайн амьтны бусдад учруулсан хохирлыг нөхөн төлөх хариуцлага хүлээнэ. Гагцхүү, амьтны төрөл болон шинж байдалд тохируулан зохих анхаарал тавьж хариуцаж байсан бол энэ заалт хэрэглэгдэхгүй.

718.2. Эзэмшигчийн оронд амьтныг хариуцаж байсан этгээдийн хувьд ч 718.1-д заасны дагуу хариуцлага хүлээнэ.

<sup>32</sup> (動物の占有者等の責任)

第七百十八条 動物の占有者は、その動物が他人に加えた損害を賠償する責任を負う。ただし、動物の種類及び性質に従い相当の注意をもってその管理をしたときは、この限りでない。

2 占有者に代わって動物を管理する者も、前項の責任を負う。  
<https://elaws.e-gov.go.jp/document?lawid=129AC0000000089>□

## II. Үзэл баримтлал

Япон Улсын хуучин Иргэний хуулийн 375 дугаар зүйлд санаанд оромгүй осол, эсхүл давагдашгүй хүчнээс бусад тохиолдолд амьтны өмчлөгч хариуцлага хүлээх зохицуулалттай байжээ.<sup>33</sup> Энэ заалт нь Францын Иргэний хуулийн 1385 дугаар зүйлд тулгуурласан гэж тооцогддог.<sup>34</sup> Харин одоо үйлчилж буй Иргэний хуульд хохирлыг бууруулах боломж их гэдэг утгаар амьтны эзэмшигчид хариуцлага хүлээлгэх зохицуулалтыг бий болгожээ.<sup>35</sup>

## III. Урьдчилсан нөхцөл

718 дугаар зүйлд заасны дагуу амьтны учруулсан гэм хорыг нөхөн төлөх тохиолдолд дараах урьдчилсан нөхцөл хангагдсан байх шаардлагатай. Үүнд:

- гэм хор учруулагч нь амьтан байх;
- хохирогчийн эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдсөн байх;
- амьтны үйлдэл болон хохирогчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлын зөрчлийн хооронд шалтгаант холбоо байх;
- хохирогчид хохирол учирсан байх;
- хохирогчийн эрхийн зөрчил болон хохирлын хооронд шалтгаант холбоо байх;
- хэрэг гарах үед амьтныг эзэмшигч нь амьтныг өөрөө, эсхүл бусдын тусламжтайгаар эзэмшиж байх;

Амьтан гэдэгт төрлөөс хамаарсан хязгаарлалт байхгүй. Гол төлөв нохойн учруулсан гэм хор байдаг бөгөөд шүүхийн шийдвэрүүдээс харвал үхэр, адуу, сармагчин, тахианы тохиолдлууд ч байжээ.<sup>36</sup>

<sup>33</sup> 林良平編、前田達明、窪田充見（1989）『注釈判例民法 債権法II』青林書院、1322 pg.

<sup>34</sup> 潮見佳男（2012）『不法行為法II（第2版）』信山社、425 pg.

<sup>35</sup> 林良平編、前田達明、窪田充見（1989）『注釈判例民法 債権法II』青林書院、1322 pg.

<sup>36</sup> 能見善久、加藤 新太郎【編】（2019）『論点体系 判例民法〈9〉不法行為〈2〉（第3版）』第一法規出版、451.

Амьтан нь өөрөө байгалийн инстинктээрээ бусдад хохирол учруулж байж шалтгаант холбооны шаардлага хангагдана. Хэрэв амьтан эзэмшигч нь амьтнаар хохирол учруулах шалтгаан нөхцөлийг зориуд өөрөө бий болгосон бол 709 дүгээр зүйлд заасан ерөнхий гэм хорын шаардах эрхийг хэрэгжүүлнэ.<sup>37</sup>

Шалтгаант холбооны хувьд шүүхээс янз бүрийн байдлаар шийдвэрлэжээ. Тухайлбал, өөрийг нь нохой хазах гэж байна гэж буруу ойлгон айсандаа зугтаж яваад унаж хөлөө бэртээсэн тохиолдол, арван настай охин явган хүний зам дээр явж байсан нохойгоос цочсондоо машин зам руу орж зам тээврийн осолд өртсөн тохиолдол, долоон настай охин нохойгоос айсандаа унадаг дугуйны удирдлагаа алдаж унаж бэртсэн тохиолдол зэрэгт амьтны гэм хорын хариуцлагыг зөвшөөрч шийдвэрлэжээ. Харин “Terrier” үүлдрийн аюултай гэж харагдахааргүй төрхтэй нохой үсэрсэнд дугуйтай сундалж явсан хүн бэртэж нас барсан тохиолдол, саалийн үхэрт хөөгдөж явахдаа унаж бэртсэн тохиолдлуудад хохирогч нь энгийн ухамсраас давсан хэмжээнд зугтсан бөгөөд гаргасан үйлдэл нь зөвтгөгдөх үндэслэлгүй гэж үзэн амьтны учруулсан гэм хорыг хүлээн зөвшөөрөөгүй байна.<sup>38</sup>

Хохирлын хувьд, бусдын амь нас, эрүүл мэндээс гадна сэтгэл санаанд учирсан хохирол ч багтдаг.<sup>39</sup>

Амьтны учруулсан гэм хорыг хариуцах этгээд тухайн амьтныг эзэмшигч, эсхүл хариуцагч нь байх шаардлагатай. Хууль тогтоогчоос эзэмшигч гэдэгт эзэмших эрхийг хэрэгжүүлж буй этгээд, харин хариуцаж буй этгээдийг хуульд оруулсан шалтгааныг хэдийгээр амьтныг өөрийнхөө төлөө эзэмшиж буй биш боловч бодитоор өөртөө байлгаж буй этгээдэд ч хариуцлага

<sup>37</sup> 我妻榮、有泉亨、清水誠、田山輝明（2021）『我妻 有泉コンメンタール民法〔第7版〕—総則 物権 債権—』日本評論社、1576 pg.

<sup>38</sup> 能見 善久、加藤 新太郎【編】（2019）『論点体系 判例民法〈9〉不法行為〈2〉（第3版）』第一法規出版、454-455 pg.

<sup>39</sup> 能見 善久、加藤 新太郎【編】（2019）『論点体系 判例民法〈9〉不法行為〈2〉（第3版）』第一法規出版、452 pg.

тооцох зорилготой гэж тайлбарлажээ.<sup>40</sup> Эзэмшлийн хувьд хуульд заасан үндэслэлээр үүссэн байхад хангалттай. Тухайлбал, нохойг хэлцлийн үндсэн дээр өөртөө байлгаж буй этгээд зэрэг юм.<sup>41</sup>

#### IV. Үгүйсгэх нөхцөл

Амьтны эзэмшигч, харгалзагч нь амьтны төрөл болон шинж байдлаас хамаараад зохих анхаарал тавьж харгалзаж байсан гэдгийг нотолж чадвал хариуцлагаас чөлөөлөгдөнө. Зохих анхаарал гэдэгт ердийн үед тавивал зохих түвшний анхаарлыг ойлгоно. Ихэвчлэн жижиг биетэй нохой дээр асуудал гардаг, хариуцлагаас чөлөөлөх үндэслэлийг шүүхээс хүлээн зөвшөөрөхгүй байх талдаа байдаг.<sup>42</sup>

Түүнчлэн, хохирогчийн өөрийнх нь үйлдэл гэм хорыг өөртөө дуудсан бол, гэм хорыг хүлээн зөвшөөрөхгүй байх ч боломжтой бөгөөд үгүйдээ хохирлын хэмжээг тооцож багасгах үндэслэл болдог.<sup>43</sup>

<sup>40</sup> 能見 善久、加藤 新太郎【編】（2019）『論点体系 判例民法〈9〉不法行為〈2〉（第3版）』第一法規出版、455 pg.

<sup>41</sup> 我妻榮、有泉亨、清水誠、田山輝明（2021）『我妻 有泉コンメンタール民法〔第7版〕—総則 物権 債権—』日本評論社、1576 pg.

<sup>42</sup> 能見 善久、加藤 新太郎【編】（2019）『論点体系 判例民法〈9〉不法行為〈2〉（第3版）』第一法規出版、457 pg.

<sup>43</sup> 潮見佳男（2012）『不法行為法II（第2版）』信山社、435 pg.

## ДҮГНЭЛТ, САНАЛ

Энэхүү судалгаагаар амьтны учруулсан гэм хорыг хариуцан арилгуулахтай холбогдох Монгол Улсын Иргэний хуулийн 501 дүгээр зүйлийн үзэл баримтлал, түүний шүүхийн практик дахь хэрэглээ болон дурдагдах амьтны учруулсан гэм хорын хариуцлагын тогтолцооны талаарх харьцуулсан судалгааг хийж гүйцэтгэлээ. Энэ хүрээнд шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээ болон харьцуулсан судалгаагаар сонирхолтой үр дүн илэрснийг зориуд тэмдэглэмээр байна.

Монгол Улсын Иргэний хуулийн 501 дүгээр зүйлийн 501.1 дэх заалт бол гэм буруутай эсэхээс үл хамааран хариуцлага хүлээх тогтолцоо байна. Харин тус зүйлийн 501.2 дахь заалт нь гэм буруутай байх (санаатай, илтэд болгоомжгүй) хариуцлагын тогтолцоо юм. Дээрх бүтцийн хувьд ХБНГУ-ын зохих зохицуулалттай ижил байна. Гэхдээ, Монгол Улсын Иргэний хуулийн 501.2 нь ХБНГУ-ын 833.1-ийн хоёр дахь өгүүлбэртэй агуулгын хувьд ялгаатай. Тодруулбал, хариуцлагаас чөлөөлөгдөх урьдчилсан нөхцөлийн хувьд “гэрийн тэжээвэр амьтан”, эсхүл “мэргэжлийн үйл ажиллагааны зүйл болдог амьтан”-ыг хамааруулсан бол ХБНГУ-ын хувьд “гаршуулсан + албан хэрэгцээ болон аж ахуйн үйл ажиллагааны зорилго бүхий, эсхүл эзэмшигчийнхээ харгалзан туслагч болдог амьтан” гэсэн байна.



Өөрөөр хэлбэл, энгийн гэртээ тэжээдэг гэрийн тэжээвэр амьтны учруулсан гэм хорын хувьд ХБНГУ-д гэм буруутай эсэхээс үл хамааран хариуцлага хүлээнэ. Эсрэгээрээ, малын учруулсан тохиолдлын хувьд “гаршуулсан + аж ахуйн үйл ажиллагааны зорилго бүхий” гэх шинжийг хангах учир түүний эзэн нь гэм буруугүй гэдгээ нотолбол хариуцлагаас чөлөөлөгдөх боломжтой. Харин Монгол Улсын хувьд малыг Иргэний хуулийн 501.2 дахь заалтад хамааруулах талаар оруулж тооцох, өөрөөр хэлбэл, “гэрийн тэжээвэр амьтан”, эсхүл “мэргэжлийн үйл ажиллагааны зүйл болдог амьтан”-ы аль нэгд оруулсан гэж үзэх боломжгүй. Учир нь “гэрийн тэжээвэр амьтан” гэдэгт малыг оруулж ойлгохгүй байгаа нь бусад хуулиас үзэхэд ойлгомжтой байна. “Мэргэжлийн үйл ажиллагааны зүйл болдог амьтан”-ы хувьд хууль тогтоомжид энэ талаарх тодорхойлолт байхгүй бөгөөд ном бүтээлд хил, гааль, цирк, урлагийн үйл ажиллагаагаар төсөөлж ойлгож буй нь илэрхий байна.

Гагцхүү, малын учруулсан гэм хортой холбогдуулан шүүхээс малын өмчлөгч, эзэмшигчийг гэм буруугүй гэдгээ нотолбол хариуцлагаас чөлөөлөгдөх талаар дурдаж байгаа нь, мөн түүнчлэн Тариалангийн тухай хууль, Замын хөдөлгөөний дүрэм зэрэгт малыг тариалангийн талбайгаас, засмал замаас зайтай байлгах, хариулгатай байлгах үүрэг зөрчсөн гэм буруутай гэж үзэж буйгаас үзвэл, гэм буруутай эсэхээс үл хамааран хариуцлага хүлээх тогтолцоо гэж үзэхгүй байгааг харуулна.

Ийнхүү үзэх нь үр дүнгийн хувьд зөв байж болох ч дараах асуудлуудыг үүсгэж байна. Нэгдүгээрт, ерөнхий зохицуулалт болох Иргэний хуулийн 501 дүгээр зүйл нь гэм буруутай эсэхээс үл хамааран хариуцлага хүлээх тогтолцоо юм. Харин засмал зам болон тариалангийн талбайд мал амьтан байх нь илүү их хохирол учруулах эрсдэлтэй гэдэг утгаараа амьтан эзэмшигчийн анхаарал болгоомжтой байх үүрэг нь ч энгийн тохиолдлоос илүү

өндөр байх ёстой. Гэтэл, нарийвчилсан зохицуулалтууд нь гэм буруутай тохиолдолд хариуцлага хүлээлгэх талаар тусгасан байна. Энэ нь нэг төрлийн логик зөрчилдөөнийг бий болгож буй юм. Хоёрдугаарт, Тариалангийн тухай хууль, Замын хөдөлгөөний дүрэм гэх мэт нь зөвхөн хязгаарлагдмал хүрээнд үүсэх амьтны учруулсан гэм хорын тохиолдолд хэрэглэгдэх бөгөөд тэдгээр дүрэм хамаарахгүй ерөнхий тохиолдлуудад Иргэний хуулийн ерөнхий зохицуулалтын дагуу гэм буруутай эсэхээс үл хамааран хариуцлага ногдуулах зарчим хэрэглэгдэнэ. Энэ үр дагавар нь зохистой юу гэдэг асуудал нээлттэй хэвээр үлдэнэ.

Тиймээс, Иргэний хуулийн 501 дүгээр зүйлийн 501.2 дахь заалтын “мэргэжлийн үйл ажиллагааны зүйл болдог амьтан” гэдэгт малыг хамааруулж ойлгох нь зохистой гэж үзэж байна. Үүнд таван хошуу мал (сарлаг, хайнагийг үхэрт оруулж тооцох) орохоос гадна цаа буга, тахиа, гахай зэрэг гэжээвэр малыг оруулна. Энэ нь магадгүй өргөн хүрээтэй байна гэж үзвэл, “уналга, ачлага”-д ашигладаг гэдэг утгаар “адуу, үхэр, тэмээ” зэрэг бод малыг оруулах нь өөрийн орны бэлчээрийн мал аж ахуйн соёлын эрх ашгийг хамгаалах талаасаа зөвтгөгдөх үндэслэлтэй. Нөгөөтэйгүүр, малын эзнийг анхаарал болгоомжтой байх үүргээ хангалттай биелүүлсэн тохиолдолд, хариуцлагаас чөлөөлөгдөх боломжийг олгох нь малын өмчлөгч, эзэмшигч нь тухайн малыг бусдад гэм хор учруулахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг тогтмол авдаг болгох ач холбогдолтой. Малын эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах үүрэг ногдуулсан бусад хууль тогтоомжтой ч логикийн хувьд авцалдаатай болно.

Мөн Иргэний хуулийн 501.2 дахь заалтын гэм буруутай гэдгээ хэрхэн нотлох вэ гэдэг асуулт тохиолдол бүрээс хамаараад ялгаатай байна. Гэхдээ, хууль тогтоомжид мал болон амьтны аюулгүй байдлыг хангахтай холбогдох зохицуулалтууд энэ асуудлыг нөхөх ач холбогдолтойгоор хэрэглэгдэх боломжтой.

Тухайлбал, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулиар малчин нь малаа эрүүл байлгах, урьдчилан сэргийлэх тарилга зэргийг хийлгэх үүрэгтэй байна. Хэрэв мал нь галзуурч бусдад хохирол учруулсан тохиолдолд тухайн малын эзэн нь илт болгоомжгүй гэм буруутай гэж тооцогдоно. Харин гэрийн тэжээвэр амьтны эзний гэм буруугийн тухайд, ялангуяа нохойн хувьд түүнийг аюулгүй байлгахтай холбогдох дүрэм журам нөхөх байр суурьтай байна. Тухайлбал, нийслэлд нохой муурыг хөтөлгөө болон хошуувчгүйгээр салхилуулах зэргээр олон нийтийн газар байлгахыг хориглосон байх тул хошуувчгүй нохой олон нийтийн газар бусдад хохирол учруулбал, түүний эзнийг илт болгоомжгүй байсан гэж үзэж болно.

Тариалангийн талбай руу мал орох тохиолдолд тариалан эрхлэгчийн хашаа, хашлага татаагүй нь хохирлын хэмжээг нэмэгдүүлэх үндэслэл болж буй талаар шүүхээс дүгнэж, хохирлын нөхөн төлбөрийн хэмжээг Иргэний хуулийн 514.1-д заасан үндэслэлээр багасгаж байгаа нь хууль хэрэглээний хувьд оновчтой юм. Харин зам дээр буй малыг мөргөсний улмаас жолооч болон зорчигч цаашлаад малчин малаараа хохирч буй тохиолдлын хувьд, талуудын хохирлыг өөрсдийнх нь сайн дураараа бий болгосон эрсдэлтэй шийдвэрийн үр дагавар гэж тайлбарлах хувилбарыг судлаачийн зүгээс санал болгож байна. Түүний үндэслэл нь, жолооч ослоос сэргийлэх үүднээс анхаарал болгоомжтой байх үүрэгтэй, малчны хувьд малаа засмал замаас зайтай байлгах үүрэгтэй гэдгээр тайлбарлагдана. Энэ тайлбарын үр дагаварт мал автомашины ослын тохиолдолд үүсэх хохирлыг тухайн этгээдүүд өөрсдөө хариуцна гэсэн үг юм. Өөрөөр хэлбэл, автомашин болон зорчигчид учирсан хохирлыг жолооч хариуцна. Малд учирсан хохирлыг түүний эзэмшигч, өмчлөгч өөрөө хариуцна.

Хохирлын хэмжээний хувьд жолооч болон зорчигчийн эрүүл мэнд, амь нас яригдах учир малд учрах хохирлоос өндөр байх нь гарцаагүй. Гэхдээ, энэ төрлийн осол нь гол төлөв орон нутгийн замд байх бөгөөд тэр нь үзэгдэх орчин харьцангуй өргөн. Өөрөөр хэлбэл, зам дээр мал байгааг, эсхүл мал замтай ойрхон байгааг хараад хурдаа тохируулах боломжтой. Хэрэв өндөр газар луу давах, бороо манан, шөнө зэрэг үзэгдэх орчин хязгаарлагдмал байвал, мөн л хурдаа тохируулж анхаарал болгоомжтой байх нь жолоочийн үүрэг юм. Орон нутгийн зам дээр мал хөндөлдөх зэрэг тохиолдол байдгийг жолооч энгийн ухамсрын түвшинд ухамсарлах ёстой гэж тооцох бөгөөд орон нутгийн замд хөдөлгөөнд оролцож буй нь энэ эрсдэлийн үр дагаврыг өөрөө сайн дураараа хүлээн зөвшөөрсөн гэж үзнэ.

Малчны хувьд малаа засмал замаас зайтай байлгах үүрэгтэй. Гэхдээ бэлчээрийн мал аж ахуйн онцлог нь бод малыг байнгын хариулгатай байлгах боломжгүй. Тэр ч утгаараа малтай холбоотой зам тээврийн ослын тохиолдлууд нь адуу болон үхрээс хамааралтай байх нь элбэг. Тэдгээрийг замын дэргэд хариулгатай байлгаж чадаагүйтэй холбоотой эрсдэлийг малчин энгийн ухамсрын түвшинд ухамсарлах ёстой гэж тооцох бөгөөд энэ эрсдэлийн үр дагаврыг өөрөө сайн дураараа хүлээн зөвшөөрсөн гэж үзнэ.

Дээрх шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээ бүхий судалгааны үр дүнд амьтны эзэмшигч, өмчлөгч нь өөрийн эзэмшлийн амьтны учруулсан гэм хорын хохирлын нөхөн төлбөрийг өргөн хүрээнд хариуцна гэдэг нь тодорхой байна. Тиймээс амьтныг өөртөө байлгаж буй этгээд нь анхаарал болгоомжтой байж, бусдад хохирол учруулахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг авсан байвал зохино. Энэ талаар мэдээлэл багатай иргэд олон бий. Учир нь, ямар тохиолдолд анхаарал болгоомжтой байх үүргээ хангалттай биелүүлсэн бэ гэдэг нь хууль болон холбогдох

дүрэмтэй танилцахаас нааш мэдэх боломжгүй. Ялангуяа, гэрийн тэжээвэр амьтныг насанд хүрээгүй хүн тэжээх нь элбэг бөгөөд гудамж талбайд хошуувчгүй байлгах нь энгийн үзэгдэл. Нийслэлд нохой, муурыг хошуувчгүй байх үед бусдад гэм хор учирвал, энэ тохиолдолд түүний эзэмшигчийг гэм буруутай гэж үзэхээр байгааг анхаарууштай. Түүнчлэн малчны хувьд хууль, дүрмийг тэр дор нь хайж үзэх боломж хязгаарлагдмал. Өөрөөр хэлбэл, замын ойролцоо бэлчиж буй малаа хураах зэргээр анхаарал тавихгүй бол болохгүй гэдэг үүргээ мэдээгүйгээс амьтны учруулсан гэм хорын тохиолдлын хариуцагчаар татагдах эрсдэл байсаар буй.

Тиймээс амьтны учруулсан гэм хорын хариуцлагатай холбогдох сургалтыг малчдад болон гэрийн тэжээвэр амьтны эздэд зориулж оруулах нь тухайн этгээд хохирол нөхөн төлөх үүрэг хүлээх эрсдэл болон бусдын өмчлөл, эзэмшилд буй амьтан бусдад гэм хор учруулахаас урьдчилан сэргийлэх нэг арга болж чадна.

## **АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ**

### **Хууль тогтоомж**

1. Иргэний хууль, 1994.
2. Иргэний хууль, 2002.
3. Амьтны тухай хууль, 2012.
4. Тариалангийн тухай хууль, 2016.
5. Байгаль орчныг хамгаалах тухай хууль, 1995.
6. Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль, 2017.
7. Замын хөдөлгөөний дүрэм, 2018.
8. Нийслэлийн нутаг дэвсгэрт нохой муур тэжээх, арчлах, золбин нохой муур устгахад мөрдөх журам, 2019.

### **Ном бүтээл**

1. Монгол Улсын Дээд шүүх, Монгол Улсын Иргэний хуулийн тайлбар (Гэрээний бус үүрэг IV), 2016.
2. Б.Буянхишиг, Иргэний эрх зүйн тусгай анги, 2010.
3. Шүүхийн ерөнхий зөвлөл, Монгол Улсын шүүхийн сонгомол шийдвэрийн эмхэтгэл, II боть, 2016.
4. Х.Доржпалам, Гэм хор учруулснаас үүсэх үүргийн эрх зүй, 2015.
5. Шварц Вандт, Орч. Д.Энхзул, Хуульд зааснаар үүсэх үүргийн эрх зүй, 2017.
6. Dannemann/Schulze (2020) German Civil Code Volume I: Books 1-3 Article-by-Article Commentary, C.H.Beck, Nomos.

7. 我妻榮、有泉亨、清水誠、田山輝明（2021）『我妻 有泉コメントール民法 [第7版] 一総則 物権 債権一』日本評論社.
8. 林良平編、前田達明、窪田充見（1989）『注釈判例民法一債権法II一』青林書院.
9. 潮見佳男（2012）『不法行為法II（第2版）』信山社.
10. 能見 善久、加藤 新太郎【編】（2019）『論点体系 判例民法〈9〉不法行為〈2〉（第3版）』第一法規出版.

### Шүүхийн шийдвэр

1. УДШ-ийн 2015 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 88 дугаар тогтоол.
2. УДШ-ийн 2021 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 001/ХТ2021/01551 дугаар тогтоол.
3. Өмнөговь аймгийн эрүү, иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2020 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн 22 дугаар магадлал.
4. Иргэний хэргийн давж заалдах шатны 6 дугаар шүүхийн 2014 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 138 дугаар магадлал.
5. Сэлэнгэ аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2020 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн 32 дугаар магадлал.
6. Сум дундын 25 дугаар шүүхийн 2014 оны 09 дүгээр сарын 04-ний өдрийн 50/762/А дугаар шийдвэр.
7. Сэлэнгэ аймаг дахь сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн 134 дүгээр шийдвэр.
8. Өмнөговь аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн 143/ШШ2020/00166 дугаар шийдвэр.

9. Дархан-Уул аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 227 дугаар шийдвэр.
10. Хан-Уул дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2022 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн 183/ШШ2022/00452 дугаар шийдвэр.
11. Дархан-Уул аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 227 дугаар шийдвэр.
12. Сүхбаатар дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2017 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн 2716 дугаар шийдвэр.
13. Хан-Уул дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2022 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн 183/ШШ2022/00452 дугаар шийдвэр.

#### **Бусад (цахим гэх мэт)**

1. <https://legalinfo.mn/> (Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем).
2. <https://shuukh.mn/> (Шүүхийн шийдвэрийн цахим сан).
3. <https://www.1212.mn/> (Статистикийн мэдээллийн нэгдсэн сан).
4. <http://judcouncil.mn/> (Шүүхийн ерөнхий зөвлөл).
5. [https://www.gesetze-im-internet.de/englisch\\_bgb/](https://www.gesetze-im-internet.de/englisch_bgb/) (ХБНГУ-ын Иргэний хууль).
6. <https://elaws.e-gov.go.jp/> (Япон Улсын Иргэний хууль).
7. Гэрийн тэжээвэр амьтны тухай хуулийн төсөл. [https://d.parliament.mn/tusul/78dd320f-e6f5-42ff-9c72-ebf8e3d1a2d5?fbclid=IwAR2lE4ZQt3aGODXX3BuBNpg3ZqNW3YmFjvFIAcUSUfGhg\\_RYsw-4ZcasaoQ](https://d.parliament.mn/tusul/78dd320f-e6f5-42ff-9c72-ebf8e3d1a2d5?fbclid=IwAR2lE4ZQt3aGODXX3BuBNpg3ZqNW3YmFjvFIAcUSUfGhg_RYsw-4ZcasaoQ).
8. Гэрийн тэжээвэр амьтны тухай хуулийн төслийн үзэл баримтлал. [https://d.parliament.mn/tusul/78dd320f-e6f5-42ff-9c72-ebf8e3d1a2d5?fbclid=IwAR2lE4ZQt3aGODXX3BuBNpg3ZqNW3YmFjvFIAcUSUfGhg\\_RYsw-4ZcasaoQ](https://d.parliament.mn/tusul/78dd320f-e6f5-42ff-9c72-ebf8e3d1a2d5?fbclid=IwAR2lE4ZQt3aGODXX3BuBNpg3ZqNW3YmFjvFIAcUSUfGhg_RYsw-4ZcasaoQ).



# 2

## БЭЛЭГЛЭЛИЙН ГЭРЭЭГ ХҮЧИНГҮЙ БОЛГОХ БОЛОН ХҮЧИН ТӨГӨЛДӨР БУС ТООЦСОН ТАЛААР МАРГААН ШИЙДВЭРЛЭСЭН ШҮҮХИЙН ШИЙДВЭРТ ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

### СУДЛААЧДЫН ТАНИЛЦУУЛГА



#### АДЪЯАСҮРЭНГИЙН ТҮВШИНТӨГС

А.Түвшинтөгс нь 2017 онд МУИС-ийн Хууль зүйн сургуулийг эрх зүйч мэргэжлээр суралцаж төгссөн. Капитрон банк, Жунсон констракшн зэрэг ХХК-д хуулийн зөвлөхөөр ажиллаж байсан бөгөөд “Эрх зүй”, “Хууль дээдлэх ёс”, “Шүүх эрх мэдэл”, “Хүний эрх” зэрэг хууль зүйн мэргэжлийн сэтгүүлүүдэд 10 гаруй өгүүлэл, судалгааны ажил нийтлүүлсэн.



#### ЭНХБОЛДЫН ЗОЛЗАЯА

Өмгөөллийн “Эм Жэй Эл атторнейс” ХХН-ийн партнер, өмгөөлөгч  
2017 онд МУИС-ийн Хууль зүйн сургуулийг эрх зүйн бакалаврын зэрэгтэй төгсөж, 2022 онд Удирдлагын академид Төрийн удирдлагын магистрын зэрэг хамгаалсан. Одоогоор “Эм Жэй Эл атторнейс” ХХН-ийн партнер, өмгөөлөгчөөр ажиллаж байна. 2021 онд орчуулгын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан.

Судлаачид:

А.Түвшинтөгс  
Э.Золзаяа

## АГУУЛГА

УДИРТГАЛ.....	76
НЭГ. ОНОЛЫН ОЙЛГОЛТ БОЛОН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ .....	76
1.1. Бэлэглэлийн гэрээний үндсэн шинж, онцлог .....	79
1.2. Бэлэглэлийн гэрээний тусгай төрөл .....	80
1.3. Бэлэглэлийн гэрээг хүчингүй болгох нөхцөл .....	82
1.4. Бэлэглэлийн гэрээг хүчин төгөлдөр бус байх хэлцэл гэж үзэх нөхцөл .....	86
ХОЁР. ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭ .....	87
2.1. Бэлэг хүлээн авагч нь бэлэглэгчийг “гомдоосон ноцтой үйлдэл хийсэн” үндэслэлээр гэрээг хүчингүй болгосон талаарх шүүхийн шийдвэрт хийсэн дүн шинжилгээ .....	87
2.2. Гэр бүлийн гишүүдийн хамтран өмчлөх дундын эд хөрөнгийг бусдад бэлэглэсэн болон халхавчилж хийсэн хэлцэлтэй холбоотой маргааныг шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрт хийсэн дүн шинжилгээ.....	117
ГУРАВ. ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА.....	145
3.1. ХБНГУ .....	145
3.2. БНХАУ .....	148
3.3. БНСУ.....	150
ДҮГНЭЛТ .....	152
САНАЛ.....	161
ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ .....	164

## **ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ**

БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
ИХ	Иргэний хууль
ИК	Иргэний кодекс
ХБНГУ	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани

## УДИРТГАЛ

Манай Улсын ИХ-ийн 280 дугаар зүйлийн 280.1.1-д “Бэлэг хүлээн авагч нь бэлэглэгчийг гомдоосон ноцтой үйлдэл хийсэн” бол бэлэглэлийг хүчингүй болгохоор хуульчилжээ. Харин шүүхийн хувьд хэргийн үйл баримт, бэлэг хүлээн авагчийн үйлдлийн хэр хэмжээ болон гэм буруугийн хэлбэр, бэлэглэгчид учирсан хохирол, хор уршиг зэргийг харгалзан гомдоосон ноцтой үйлдэл хийсэн эсэхийг тогтоож шийдвэрлэж байна. Гэтэл ИХ-д ямар үйлдлийг ноцтой гэж үзэх, гомдоосон ноцтой үйлдэл гэдэгт ямар үйлдлүүдийг хамааруулах вэ? гэдэг нь тодорхой бус байна. Түүнчлэн шүүх аливаа тохиолдлыг шийдвэрлэхэд субъектив шалгуурыг бус харин объектив шалгуурыг харгалзан шийдэх ёстой. Мөн бэлэглэлийн гэрээний онцгой төрөл болох тусгай зориулалттай бэлэглэлийн гэрээнд заасан болзол, зорилгыг биелүүлээгүй бол бэлгийг буцаан шаардах эрхтэй. Тусгай зориулалттай бэлэглэлийн гэрээнд заасан болзол, зорилгыг биелүүлээгүйгээс бэлэглэгч гомдох тохиолдолд ИХ-ийн 279 дүгээр зүйлийг хэрэглэх үү, эсхүл 280 дугаар зүйлийн 280.1.1 дэх хэсгийн зохицуулалтыг хэрэглэх үү? гэдэг хууль хэрэглээний асуудал үүсдэг. Иймд тус хууль хэрэглээний асуудлыг судалж, дүн шинжилгээ хийх хэрэгцээ, шаардлага тулгарч байна. Мөн бэлэглэлийн гэрээг хүчин төгөлдөр бус байх хэлцлийн үндэслэл ИХ-ийн 56 дугаар зүйлийн 56.1.3, 56.1.8 дугаар зүйлд тусгагджээ. Тус тохиолдлууд нь практикт ихээхэн гардаг тул шүүхээс дээрх хуулийн зохицуулалтыг хэрхэн хэрэглэж байгаад

дүн шинжилгээ хийхийг зорилоо. Иймээс энэхүү судалгааны зорилго нь бэлэглэлийн гэрээг хүчингүй болгох, хүчин төгөлдөр бус байхтай холбоотой шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийх, хууль хэрэглээний асуудлыг судлах, харьцуулсан судалгаа хийх, дүгнэлт, санал өгөхөд оршино.

Энэхүү судалгааны хүрээнд ИХ-ийн 280 дугаар зүйлийн 280.1-д заасны дагуу гэрээг хүчингүй болгох болон ИХ-ийн 56 дугаар зүйлийн 56.1.3, 56.1.8 дахь хэсэгт заасан үндэслэлээр гэрээ хүчин төгөлдөр бус байхтай холбоотой шүүхийн шийдвэрүүдийг шинжилж дүгнэнэ. Уг судалгааг гүйцэтгэхдээ анализ-синтез, индукц-дидукц, түүвэр, харьцуулах зэрэг нийтлэг аргуудыг; шүүхийн шийдвэрүүдийг сонгон авах зорилгоор шүүхийн цахим мэдээллийн [www.shuukh.mn](http://www.shuukh.mn) санд шүүлт хийсэн ба ингэхдээ мэдээлэл цуглуулах, түүвэрлэх, харьцуулах зэрэг аргыг ашиглалаа. Сонгон авсан шүүхийн шийдвэрийг анализ-синтез, индукц-дидукцын аргаар шинжилж дүгнэв. Манай улсын бэлэглэлийн гэрээг хүчингүй болгохтой холбоотой эрх зүйн зохицуулалтыг бусад улс орны эрх зүйн зохицуулалттай харьцуулан судлахдаа нэг бүлийн улс эсэх, газар зүйн байрлал, эрх зүйн уламжлалын онцлог зэргийг харгалзан харьцуулалтын аргыг ашиглалаа.

Энэхүү сэдвийн талаар Ё.Кают нар Монгол Улсын Иргэний хуулийн тайлбар (*Шинжлэх ухааны тайлбар*, 2015 он), Ц.Амарсайхан нар Монгол Улсын Иргэний хуулийн тайлбар (*Гэрээний эрх зүй*, 2007 он) бүтээлүүд болон Б.Буянхишиг, Иргэний эрх зүйн тусгай анги (Гурав дахь хэвлэлт, 2013 он) зэрэг сурах бичигт хөндсөн байдаг. Дээрх ном, тайлбар, сурах бичгүүдэд ИХ-ийн 280 дугаар зүйлийн 280.1-д заасны дагуу гэрээг хүчингүй болгох болон ИХ-ийн 56 дугаар зүйлийн 56.1.3, мөн хуулийн 56.1.8 дахь хэсэгт заасан үндэслэлээр гэрээ хүчин төгөлдөр бус байхтай холбоотой шүүхийн шийдвэрүүдэд дүн шинжилгээ

хийгээгүй юм. Харин Хууль зүйн ухааны доктор Б.Буянхишиг нь Иргэний эрх зүйн тусгай анги бүтээлдээ ИХ-ийн 280 дугаар зүйлийн 280.1.1-тэй холбоотой гурван шатны шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийснээр онцлог, судалгааны ач холбогдолтой байсан. Тус судалгаагаар бэлэглэлийн гэрээг хүчингүй болгох, хүчин төгөлдөр бус байхтай холбоотой шүүхийн шийдвэрүүдэд дүн шинжилгээ хийж, эрх зүйн зохицуулалтыг бусад улс орнуудын Иргэний хуулийн зохицуулалттай харьцуулан судалж, дүгнэлт, санал өгснөөрөө шинэлэг, онцлог юм.

## НЭГ. ОНОЛЫН ОЙЛГОЛТ БОЛОН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

### 1.1. БЭЛЭГЛЭЛИЙН ГЭРЭЭНИЙ ҮНДСЭН ШИНЖ, ОНЦЛОГ

Бусдад бэлэг өгөх амлалт тодорхой хэлбэрээр илэрхийлэгдсэн тохиолдолд хүчинтэй болдог байсан бөгөөд *Pactum donations* буюу бэлэглэх тухай илэрхийлэл нь бэлэг хүлээн авагчид нэхэмжлэл гаргах эрх олгодог байв.<sup>1</sup> Манай улсын хувьд 2002 онд ИХ-аа батлахдаа бэлэглэлийн гэрээний суурь ойлголт, онцлог, шинжийг агуулсан зохицуулалтыг тусгасан байдаг. Ихэнх улс орны Иргэний хуульд бэлэглэлийг гарын бэлэг (*hand gift*), гэрээгээр зохицуулах бэлэглэл (*contractual gift*) гэсэн хоёр төрөлд хуваан зохицуулдаг. Манай улсын хувьд Иргэний хуулийн 276 дугаар зүйлийн 276.2 дахь заалтаар гарын бэлгийг, 276.1 дэх заалтаар гэрээгээр бэлэглэх харилцааг зохицуулжээ. Бусад хоёр талт гэрээтэй харьцуулахад бэлэглэлийн гэрээг сонгодог, бүрэн хоёр талт гэрээ гэж үздэггүй. Бэлэглэлийн гэрээ нь хоёр талын бэлэг өгч авалцах тухай зөвшилцөл шаарддагаараа хоёр талт хэлцэл, харин үүсэх үүргийн тоогоор нь авч үзвэл зөвхөн бэлэглэгчид үүсэх тул нэг талт гэрээ байдгаараа<sup>2</sup> онцлог юм. Бэлэглэлийн гэрээний нэг үндсэн шинж нь хариу төлбөргүй байдаг. Монгол Улс болон бусад улсын<sup>3</sup> Иргэний хуульд бэлэглэлийн гэрээг хариу

<sup>1</sup> Ж.Оюунтунгалаг, Иргэний эрх зүй II: Гэрээний үүрэг, 2022, 160 дахь тал.

<sup>2</sup> Б.Буянхшиг, Иргэний эрх зүйн тусгай анги, 2021, 98 дахь тал.

<sup>3</sup> ХБНГУ, Швед, Испани, Филиппин, БНХАУ гэх мэт улсууд хамаарч байна.

төлбөргүй гэрээний төрөлд хамааруулдаг. ИХ-ийн 276 дугаар зүйлийн 276.1-д зааснаар хариу төлбөргүй хөрөнгө шилжүүлэх тохиролцоог бэлэглэлийн гэрээ гэж үзэх ба бэлгийн оронд ямар нэг байдлаар хариу үүрэг ногдуулаагүй байхыг хариу төлбөргүй хэмээн үзнэ.<sup>4</sup> Иймээс бусад нэг талт гэрээнүүдтэй харьцуулж үзэхэд, хоёр талын хүсэл зориг нийлсэн байх нөхцөл тавигддагаараа ялгаатай юм. Энэхүү ухагдахууныг ИХ-ийн 276 дугаар зүйлийн 276.1-д “*Бэлэглэлийн гэрээгээр бэлэглэгч нь бэлэг хүлээн авагчийн зөвшөөрснөөр түүний өмчлөлд тодорхой хөрөнгө хариу төлбөргүй шилжүүлнэ*” гэж тодорхой зохицуулжээ.

## 1.2. БЭЛЭГЛЭЛИЙН ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ ТӨРӨЛ

Иргэний хуулийн 279 дүгээр зүйлд тусгай зориулалттай хийсэн бэлэглэлийн гэрээний харилцааг зохицуулсан. Тусгай зориулалттай хийсэн бэлэглэлийн гэрээ гэдэгт ямар нэг болзол хангасан, эсхүл тодорхой зорилгод хүрсэн нөхцөлд гэрээ хүчин төгөлдөр болох гэрээг ойлгоно. Бэлэглэлийн гэрээ нь хариу төлбөргүй тул болзлыг биелүүлэхээс өмнө бэлэглэлийн зүйлийг шилжүүлэх үүрэг үүсгэдгээр болзолт нөхцөл бүхий гэрээнээс ялгаатай байдаг. Шүүхийн шийдвэрүүдийг судлан үзэхэд ямар нэг болзол хангасан гэрээнээс илүүтэй тодохой зорилгод хүрэх тусгай нөхцөлтэйгөөр хийх тохиолдол их байна. Жишээ нь: гэр бүлтэйгээ аз жаргалтай амьдрах, сургуулиа амжилттай төгсөх, аав, ээжийгээ асрамжлан халамжлах зэрэг тохиолдлууд болно.

Шүүхийн практикт тусгай зориулалттай хийгдсэн бэлэглэлийн гэрээний нөхцөлийг биелүүлээгүй тохиолдолд ИХ-ийн 280 дугаар зүйлийн 280.1.1-д заасны дагуу бэлэг хүлээн авагч нь бэлэглэгчийг гомдоосон ноцтой үйлдэл хийсэн гэж үзэж, гэрээг хүчингүй болгож байгаа нь хууль хэрэглээний алдаа юм. Гэтэл ИХ-ийн 279 дүгээр зүйлд тусгай зориулалт бүхий

<sup>4</sup> Б.Буянхишиг, Иргэний эрх зүйн тусгай анги, 2021, 101 дэх тал.



болзол, зорилгыг биелүүлээгүй нөхцөлд бэлэглэлийн зүйлийг буцаан дуудах хэм хэмжээг тусгасан байдаг. Шүүх энэхүү хоёр нөхцөлийг ялгамжтай байдлаар хэрэглэх нь зүйтэй. Тусгай зориулалтаар хийх бэлэглэлийн гэрээг бичгээр байгуулах хэлбэрийн шаардлагыг ИХ-ийн 279 дүгээр зүйлийн 279.4 дэх заалтаар зохицуулжээ. Тусгай зориулалтаар хийх бэлэглэлийн гэрээнд ямар нэгэн болзол хангасан, эсхүл тодорхой зорилгод хүрсэн нөхцөлд бэлэглэлийн гэрээ хүчин төгөлдөр болох талаар тусгасан байвал зохино. ИХ-ийн 279 дүгээр зүйлийн 279.1 дэх заалтад тусгасан гүйцэтгэвэл зохих болзол, зорилго нь гэрээний хариу төлбөр биш. Харин ИХ-ийн 279 дүгээр зүйлд тусгасан байгаа зориулалт нь зөвхөн дагалдах тохиролцооны шинжийг агуулна.<sup>5</sup>

ИХ-ийн 279 дүгээр зүйлд “болзол” тогтоож, зорилгыг тодорхойлох талаар заасан. Бэлэглэлийн гэрээний тусгай төрөлд зааж буй болзол нь ИХ-ийн 44 дүгээр зүйлд заасан болзол биш юм. Энэ нь ИХ-ийн 279 дүгээр зүйлийн 279.3-д “*Бэлэг хүлээн авах эрх бүхий этгээд гэрээнд заасан болзол буюу зорилгыг биелүцлээгүй бол бэлэглэгч гэрээнээс татгалзаж болно*” гэж заасантай холбоотой. Бэлэглэлийн гэрээний зүйл нь нэг бүрийн шинжээр тодорхойлогдох хөрөнгө бол түүнийг буцааж авч болно, харин төрлийн шинжээр тодорхойлогдох хөрөнгө бол үнийг шаардах эрхтэй. ИХ-ийн 279 дүгээр зүйлд тусгагдсан эрх бүхий этгээд гэдэгт бэлэг хүлээн авагчийг өөрийг нь болон бэлэг хүлээн авагчийн хууль ёсны төлөөлөгчийг ойлгож болно.<sup>6</sup>

<sup>5</sup> Ё.Кают нар, Монгол Улсын Иргэний хуулийн тайлбар (Шинжлэх ухааны тайлбар), 2015, 555 дахь тал.

<sup>6</sup> Ц.Амарсайхан нар, Монгол Улсын Иргэний хуулийн тайлбар, 2007, 93 дахь тал.

### 1.3. БЭЛЭГЛЭЛИЙН ГЭРЭЭГ ХҮЧИНГҮЙ БОЛГОХ НӨХЦӨЛ

Бэлэглэлийн гэрээг хүчингүй болгох хоёр нөхцөлийг ИХ-ийн 280 дугаар зүйлийн 280.1-д хуульчилсан. Бэлэглэлийн гэрээг хүчингүй болгох эхний үндэслэл нь “*бэлэг хүлээн авагч нь бэлэглэгчийг ноцтой гомдоосон үйлдэл хийсэн*” байх юм. Хоёр дахь үндэслэл нь “*бэлэг хүлээн авагч нь бэлэглэгчийн, эсхүл түүний төрөл төрөгсдийн эрүүл мэнд, амь насыг санаатай хохироосон буюу хохироохыг завдсан*” байх юм. Энэхүү хоёр үндэслэлийг манай улсаас гадна ХБНГУ, Испани, БНХАУ, БНСУ зэрэг улсууд Иргэний хуульдаа тусгасан байдаг.

Хоёр дахь үндэслэлийн хувьд бэлэг хүлээн авагч нь бэлэглэгчийн, эсхүл түүний төрөл төрөгсдийн эрүүл мэнд, амь насыг санаатай хохироосон, хохироохыг завдсан нь шүүхээр тогтоогдсон тохиолдолд бэлэглэлийг хүчингүй болгох үндэслэл болно. Бэлэг хүлээн авагчид бэлэглэгчид хүндэтгэлтэй хандах үүрэг ногддог. Шүүхийн шийдвэрүүдийг судлан үзэхэд ИХ-ийн 280 дугаар зүйлийн 280.1.2-той холбоотой маргааныг шийдвэрлэхдээ “*бэлэг хүлээн авагчийн үйлдэл нь шүүх, цагдаагийн байгууллагаар тогтоогдсон эсэх*”-ийг харгалзан, шийдвэрлэж байна. Түүнчлэн ИХ-ийн 280 дугаар зүйлийн 280.1.2 дахь үндэслэл нь бэлэглэгчийг гомдоосон ноцтой үйлдэлд хамаарах тул зарим тохиолдолд бэлэглэгчийн биед халдсан үйлдлийг гомдоосон ноцтой үйлдэл гэж дүгнэж байна. Энэ нь ИХ-ийн 280 дугаар зүйлийн 280.1.1-д “*Бэлэг хүлээн авагч нь бэлэглэгчийг гомдоосон ноцтой үйлдэл хийсэн*” бол бэлэглэлийг хүчингүй болгох шаардах эрхийг тусгасан боловч тус зохицуулалтыг хэлэлцэж, батлах үед бэлэглэгчийг гомдоосон ноцтой үйлдэл гэдэгт ямар үйлдлийг хамааруулах талаар тодорхой объектив шалгуурыг тусгаагүйтэй холбоотой.

Иймд “*Бэлэглэгчийг гомдоосон ноцтой үйлдэл хийсэн*” гэдэгт ямар үйлдлүүдийг тооцох вэ? гэдэг нь шүүгчийн субъектив үнэлэмжээр тогтоох асуудал болжээ. Өөрөөр хэлбэл, хууль

тогтоогч энэ асуудлыг шүүгчийн хууль хэрэглэх бүрэн эрхэд хамааруулж, объектив байдлаар зохицуулаагүй үлдээсэн байна. ИХ-ийн шинжлэх ухааны тайлбарт, ИХ-ийн 280 дугаар зүйлийн 280.1.1 дэх заалтыг “ямар тохиолдолд “ноцтой” гэж үзэх нь тухайн тохиолдлоос хамаарна. Энд тухайн тодорхой тохиолдлын нөхцөл байдал ач холбогдолтой. Бэлэглэгчийн нийгэмд эзлэх байр суурь, нэр хүнд, эсхүл бэлэглэгч болон бэлэг хүлээн авагчийн садан төрлийн байдал, мөн цаашлаад гомдоосон үйлдлийг нийтэд ил, эсхүл хувийн хүрээнд хийсэн эсэх, харилцан муудалцсан эсэх, бэлэглэгч нь бэлэг хүлээн авагчийг өөрөө өдөөн хатгасан эсэх, бэлэг хүлээн авагчийн үйлдлийг хууль, хүний хувьд ойлгох боломжтой байсан эсэх гэх мэт. Энэ гомдоох үйлдэл нь заавал бичгээр, эсхүл амаар хийгдсэн байх ёстой биш мөн бодит үйлдэл байж болохыг анхаарах ёстой. Гомдооно гэдэг ойлголт нь агуулгын хувьд тухайн этгээдийн нэр хүнд, нийгэмд эзлэх байр суурьд сөргөөр нөлөөлөхийг хэлнэ. Тийм учраас эхнэр нь нөхрөөсөө нууцаар өөр хүнтэй холбогдож, үүнийгээ нийтэд ил болгосон бол үүнийг гомдоосон ноцтой үйлдэл гэж үзнэ”<sup>7</sup> гэж тайлбарлажээ. Харин Ц.Амарсайхан нарын хамтран гаргасан ИХ-ийн тайлбарт, ИХ-ийн 280 дугаар зүйлийн 280.1.1 дэх заалтыг “Бэлэглэгчийг гомдоосон ноцтой үйлдлийг бэлэг хүлээн авагч хийсэн байдаг бөгөөд түүний үйлдэл нь заавал бэлэгтэй холбоотой байх ёсгүй гэж үздэг. Гэрээг хүчингүй болгохыг шаардахад гомдоосон үйлдэл нь ноцтой, бэлэглэгч гомдсон байхад л хангалттай байдаг”<sup>8</sup> гэж тайлбарлажээ.

“Гомдох” гэх үгийг хэл зүйн буюу үгчилсэн аргаар тайлбарлавал, Монгол хэлний тайлбар толь бичигт<sup>9</sup> “Гомдох -

<sup>7</sup> Ё.Каят нар, Монгол Улсын Иргэний хуулийн тайлбар (Шинжлэх ухааны тайлбар), 2015, 558 дахь тал.

<sup>8</sup> Ц.Амарсайхан нар, Монгол Улсын Иргэний хуулийн тайлбар (Гэрээний эрх зүй), 2007, 94 дэх тал.

<sup>9</sup> И.Дамбажав, Д.Алтан-Од, Д.Солонго, Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь бичиг, 2006, 430 дахь тал.

сэтгэл нь тохироогүй зүйлээс болж гуниглан шаналах”<sup>10</sup>, Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь бичигт “Гомдох - өнгөрсөн хэрэг явдлыг нэхэж сэтгэлээ зовоох, хямраах, гомрох, хорсох, хүсэл зорилго биелсэнгүйд гомдох”, Монгол хэлний товч тайлбар толь бичигт “Гомдох-өнгөрсөн хэрэг явдалд нэхэж гунирхах, гомрох, хорсох, Гоморхох - үйл явдалд санаа сэтгэл ханамжтай болоогүй, чамархал төрөгдөн хоцрох”<sup>11</sup> гэж тайлбарлажээ.

Англи хэлэнд гомдоох гэдгийг “*offend, to take offence*” гэж нэршсэн байдаг. Хууль зүйн англи хэлэнд болон бусад улсын ИХ-д гомдоох гэсэн үгийг “*ingratitude*” буюу “*ачийг мэдэхгүй байх, үл талархах байдал бий болгох*” гэсэн утгаар хэрэглэж буй юм. Хэл зүйн буюу үгчилсэн тайлбарын аргаар гомдох гэсэн үгийг тайлбарлавал сэтгэл нь тохироогүй зүйлээс болж гуниглан шаналах, өнгөрсөн хэрэг явдлыг нэхэж сэтгэлээ зовоох, хүсэл зоригоо биелсэнгүйд гомдох, үйл явдалд санаа сэтгэл нь ханамжгүй байх сэтгэл зүйн илэрхийлэл юм.

Ноцтой гэсэн үгийг хэл зүйн буюу үгчилсэн аргаар тайлбарлавал, Монгол хэлний товч тайлбар толь бичигт “*Ноцтой - оноцтой, ончтой, сүрхий, онцгой шинжтэй*”<sup>12</sup>, Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь бичигт “*Ноцтой - оноцтой, ончтой, онцгой шинжтэй*”<sup>13</sup> гэжээ.

“Ноцтой (Онцгой) үйлдэл” гэсэн үгийг хэл зүйн буюу үгчилсэн аргаар тайлбарлавал, “*бэлэглэгч этгээдийн хувьд онцгой, сүрхий шинжтэй, ач холбогдол бүхий үйл хөдлөл*” гэсэн утгыг илэрхийлж байна. Бэлэг хүлээн авагчийн ноцтой гэж тооцогдох үйлдэл нь үгийн шууд утгын тайлбарын үүднээс бэлэглэгчийн хувьд онцгой, сүрхий, ач холбогдол бүхий үйл хөдлөл байх юм. “Гомдоох” гэсэн үгийн хувьд тухайн этгээдийн сэтгэл хөдлөл,

10 А.Янжиндолгор (ерөнхий редактор), Монгол хэлний тайлбар толь, 2011, 274 дэх тал.

11 Я.Цэвэл, Монгол хэлний товч тайлбар толь, 150 дахь тал.

12 Я.Цэвэл, Монгол хэлний товч тайлбар толь, 134 дэх тал.

13 И.Дамбажав, Д.Алтан-Од, Д.Солонго, Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь бичиг, 2006, 1085 дахь тал.

сэтгэл зүйн учир холбогдлоос хамааралтай байх учраас өргөн утгаар тайлбарлан хэрэглэж буй аж.

Хуулийн ноцтой үйлдэл гэснийг зорилгоор нь тайлбарлавал, хууль тогтоогчийн зүгээс ИХ-ийн 280 дугаар зүйлийн 280.1.1-д бэлэглэгчийг гомдоосон үйлдэл нь ноцтой байх тухай тусгасан нь нэгд, бэлэглэлийн гэрээ нь нэг талт гэрээ буюу харилцан үүрэг нөхцөлдүүлдэггүй гэрээний төрөлд хамаардаг тул хүчингүй болгох тохиолдлыг энгийн нэгэн тохиолдол бус онцгой, ач холбогдол бүхий, сүрхий зүй бус үйлдэл байхыг шаардсан; хоёрд, бэлэглэл нь үүргийн гэхээс илүү ёс суртахууны хэм хэмжээг агуулж сайн санааны үүднээс үүсч байдаг тул ерөнхий хэм хэмжээгээр зохицуулсан гэж тайлбарлаж болохоор байна. Бэлэглэлийн гэрээгээр эд хөрөнгө шилжүүлэн авч буй бэлэг хүлээн авагч нь бэлэглэгчид талархаж, хүндэтгэлтэй харьцах ёс суртахууны үүргийг хүлээх тул энэхүү нөхцөлийг хуульд “гомдоосон ноцтой үйлдэл” гэсэн байдлаар томъёолжээ. Мөн “гомдох” гэдэг нь бэлэглэгчийн сэтгэлийн илэрхийлэл тул ямар ч зүйлд гомдох боломжтой юм. Иймд гомдох бүх нөхцөлийг хуулиар тогтоох нь хэлцлийн хүчин төгөлдөр байдалд нөлөөлж болзошгүй тул зөвхөн ноцтой үйлдэл гаргасан тохиолдолд бэлэглэлийн гэрээг хүчингүй болгохоор хуульчилсан байна. Шүүхийн шийдвэрүүдийг судлан үзэхэд, зарим тохиолдолд ноцтой үйлдэл нь шүүх, цагдаагийн эрх бүхий байгууллагаар тогтоогдсон байхыг шаардаж байна. Бусад тохиолдолд шүүх хэргийн үйл баримт, бэлэг хүлээн авагчийн гэм буруугийн хэлбэр, үйлдлийн хэр хэмжээ, үр дагаврыг харгалзан тогтоож, бэлэглэлийн гэрээг хүчингүй болгох эсэхийг шийдвэрлэж буй юм.

#### 1.4. БЭЛЭГЛЭЛИЙН ГЭРЭЭГ ХҮЧИН ТӨГӨЛДӨР БУС БАЙХ ХЭЛЦЭЛ ГЭЖ ҮЗЭХ НӨХЦӨЛ

ИХ-ийн тусгай ангид заасан бэлэглэлийн гэрээг хүчингүй болгох нөхцөлөөс гадна ИХ-ийн ерөнхий анги буюу ИХ-ийн 56 дугаар зүйлийн 56.1.3-д заасан үндэслэлээр хүчин төгөлдөр бус байх хэлцэл гэж үзэх тохиолдол гардаг. Шүүхийн шийдвэрүүдээс харахад, худалдах худалдан авах гэрээг халхавчлах зорилгоор бэлэглэлийн гэрээг байгуулсан гэж үзэж, ИХ-ийн 56 дугаар зүйлийн 56.1.3-д заасны дагуу хүчин төгөлдөр бус байх хэлцэл гэж шийдвэрлэж байна. Мөн гэр бүлийн гишүүдийн хамтран өмчлөх дундын эд хөрөнгийг бусдад бэлэглэхдээ гэр бүлийн насанд хүрсэн гишүүнээс зөвшөөрөл авч, нотариатаар батлуулаагүй гэсэн үндэслэлээр ИХ-ийн 56 дугаар зүйлийн 56.1.8-д заасны дагуу хүчин төгөлдөр бус байх хэлцэл гэж үзэх тохиолдол байна.

## **ХОЁР. ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭ**

Шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийх зорилгоор шүүхийн шийдвэрийн цахим сангаас (<https://www.shuukh.mn/>) 2013-2022 оны хооронд шийдвэрлэсэн “бэлэглэлийн гэрээг хүчингүй болгох болон хүчин төгөлдөр бус байх хэлцэл” гэж үзсэнтэй холбоотой Иргэний хэргийн шүүхийн нийт 282 шийдвэрийг судалсан бөгөөд эдгээрээс 30 шийдвэрийг сонгон авч, дүн шинжилгээ хийлээ.

### **2.1. БЭЛЭГ ХҮЛЭЭН АВАГЧ НЬ БЭЛЭГЛЭГЧИЙГ “ГОМДООСОН НОЦТОЙ ҮЙЛДЭЛ ХИЙСЭН” ҮНДЭСЛЭЛЭЭР ГЭРЭЭГ ХҮЧИНГҮЙ БОЛГОСОН ТАЛААРХ ШҮҮХИЙН ШИЙДВЭРТ ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ**

#### **2.1.1. Гэрлэлтээ батлуулаагүй, хамтын амьдралаа үргэлжлүүлээгүй үйлдэл хийсэн нь бэлэг хүлээн авагчийг гомдоосон ноцтой үйлдэл эсэхтэй холбоотой шүүхийн шийдвэр (Улсын Дээд шүүхийн 2018 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн 01379 дугаартай тогтоол)**

*Хэргийн үйл баримт:*

Нэхэмжлэгчийн зүгээс хүү Б болон Ц нар хүүхэдтэй болж байгаа тул цаашдаа гэр бүл болж амьдраасай гэж хүссэндээ Баян-Өндөр сумын Согоот багийн Х тоот 17.5 м.кв нэг өрөө орон

сууцаа бэлэглэлийн гэрээ хийж, 2014 оны 03 дугаар сарын 20-ны өдөр хүү Б, бэр Ц нарт шилжүүлсэн. Харин хүү Б болон бэр Ц нар нь таарч тохирохгүй боллоо гээд салсан. Хүү Б болон бэр Ц нар гэрлэлтээ батлуулаагүй, хоёр сарын хугацаанд л амьдарсан тул нэхэмжлэгчийн бэлэглэлийн зорилгыг зөрчсөн, мөн бэлэглэгчийг гомдоосон гэж үзэж шүүхэд хандсан.

Нэхэмжлэгчийн хүү болох Б шүүхэд гаргасан хариу тайлбартаа, *“Миний ээж Н өндөр насны тэтгэвэртээ гарсан, сахарын диатез өвчтэй байнгын эмчилгээ асаргаа хийлгэж, гэр хороололд амьдарч байна. Нэгэнт Ц бид хоёрыг үр хүүхдээ өсгөн сайн сайхан амьдраарай гэж байраа бэлэглэсэн зорилгыг нь хангаж чадаагүй тул орон сууцаа буцаан авахаар гаргасан нэхэмжлэлийг зөвшөөрч байна. Ц бид хоёр гэрлэлтээ батлуулаагүй тул орон сууц гэр бүлийн гишүүдийн хамтран өмчлөх дундын өмч болоогүй”* гэж дурдсан.

Харин бэр Ц *“Нэхэмжлэлийг хүлээн зөвшөөрөхгүй. Б бид хоёр гэр бүлийн харилцаатай, хамтын амьдралтай байсан бөгөөд гэр бүлийн харилцаа дуусгавар болж хамтран амьдруулахгүй гэсэн хүсэл Б болон нэхэмжлэгч нарт байсан. Нэхэмжлэгч бодит байдалд байрыг миний охин эрдэнийг хорвоод мэндэлж, ач охинтой боллоо гэж түүнд зориулж, өөрийн нэр дээрх байрыг бэлэглэсэн. Ингээд охин С болон миний нэрийг оролцуулан байрны өмчлөлийг шилжүүлсэн”* гэж хариу тайлбар өгсөн.

Бие даасан шаардлага гаргаагүй гуравдагч этгээд болох Нэхэмжлэгчийн нөхөр Д хариу тайлбартаа, *“Хүү Б гэр бүл болж тусдаа гарч байгаа тул гал голомтоо залгуулж байгаа”* гэж гэрээний зорилгыг тодорхой бичсэн. Сайхан айл орон болоорой гэж бэлэг өгсөн зорилгыг минь хөсөрдүүлсэн. Иймд бэлэглэлийн гэрээг хүчингүй болгож өгнө үү” гэжээ.

Анхан шатны шүүхийн шийдвэр болон Давж заалдах шатны шүүхийн магадлал:



Орхон аймаг дахь сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2018 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн 142/ШШ2018/00232 дугаар шийдвэрээр ИХ-ийн 280 дугаар зүйлийн 280.1.1, 280.2-д заасныг баримтлан 2014 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн орон сууц бэлэглэлийн гэрээг хүчингүй болгож, Орхон аймаг, Баян-Өндөр сум, Согоот багийн нэг өрөө орон сууцыг нэхэмжлэгчид буцаан олгож шийдвэрлэжээ.

Орхон аймгийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2018 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн 59 дүгээр магадлалаар Орхон аймаг дахь сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2018 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн 142/ШШ2018/00232 дугаар шийдвэрийг хэвээр үлдээж, хариуцагч Ц-гийн давж заалдах журмаар гаргасан гомдлыг хангахгүй орхижээ.

*Хяналтын шатны шүүхийн тогтоол:*

Хяналтын шатны шүүх тогтоолдоо “Бэлэглэлийн гэрээгээр бэлэглэгч нь бэлэг хүлээн авагчийн зөвшөөрснөөр түүний өмчлөлд тодорхой хөрөнгө хариу төлбөргүй шилжүүлнэ. Хуулиар тогтоосон хэлбэрээр гэрээ хийснээр өмчлөх эрх үүсдэг хөрөнгийн хувьд бэлэглэлийн гэрээг тухайн хэлбэрээр хийнэ. Иймд 2014 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн “Бэлэглэлийн гэрээ”-г шүүх хүчин төгөлдөр гэж үзсэн нь ИХ-ийн 276 дугаар зүйлийн 276.1, 276.3 дахь хэсэгт нийцсэн байна. Нэхэмжлэлийн үндэслэл болсон гэрээнд, “... хүү Б гэр бүл болж тусдаа гарч байгаа тул гал голомтоо залгуулж байна...” гэж заасан нь орон сууцыг дан ганц Б-т бэлэглэж буй агуулга байхгүй тул шүүх хэргийг шийдвэрлэхдээ “...гэрээг тайлбарлахдаа үгийн шууд утгыг анхаарна...” гэсэн ИХ-ийн 198 дугаар зүйлийн 198.1, 198.2 дахь заалтын зохицуулалтыг зөрчсөн. Нэхэмжлэлийн үндэслэл болсон бэлэглэлийн гэрээний 7 дахь заалтын агуулгыг гэрээний бусад нөхцөл, ерөнхий агуулга буюу гэрээний 1, 4 дэх

хэсгийн заалттай харьцуулбал, Д, Н нар орон сууцыг Б, Ц, охин С нарт бэлэглэсэн гэж тодорхойлохоор байна. Дээр дурдсан үндэслэлээр Д, Н нар тус нэг өрөө орон сууцыг Б-д бус, харин Б, Ц, охин С нарт бэлэглэсэн байна гэж хяналтын шатны шүүх бүрэлдэхүүн дүгнэв. Бэлэг хүлээн авагчийн зүгээс бэлэглэгч рүү чиглэсэн буюу гомдоосон үйлдэл хийсэн, уг үйлдэл нь ноцтой байгаа тохиолдолд ИХ-ийн 280 дугаар зүйлийн 280.1.1 дэх хэсэгт зааснаар бэлэглэлийн гэрээг хүчингүй болгох нөхцөл бүрдэнэ. Ц, Б нар нэхэмжлэгчийг гомдоосон ноцтой үйлдэл хийсэн гэх үйл баримт тогтоогдоогүй тул Н-ын нэхэмжлэлийг хангах боломжгүй байна” гэж анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож, нэхэмжлэгчийн гаргасан нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэжээ.

### **Шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээ:**

Шүүхийн шийдвэрээр хөндөгдөж буй асуудал: Нэхэмжлэгчийн зүгээс Б болон Ц нар хүүхэдтэй болж, гэр бүл болсон тул цаашдаа гэр бүл болж амьдраасай гэж хүссэндээ Баян-Өндөр сумын Согоот багийн Х тоот 17.5 м.кв нэг өрөө орон сууцаа бэлэглэлийн гэрээ хийж, 2014 оны 03 дугаар сарын 20-ны өдөр хүү Б, бэр Ц нарт шилжүүлсэн. Харин хүү Б болон бэр Ц нар нь таарч тохирохгүй боллоо гээд салсан. Хүү Б болон бэр Ц нар гэрлэлтээ батлуулаагүй, хоёр сарын хугацаанд л амьдарсан тул нэхэмжлэгчийн бэлэглэлийн зорилгыг зөрчиж, бэлэглэгчийг гомдоосон гэж үзэж шүүхэд хандсан.

Харин анхан болон давж заалдах шатны шүүх нэхэмжлэгчийн нэхэмжлэлийн шаардлагыг хангаж, ИХ-ийн 280 дугаар зүйлийн 280.1.1-д заасны дагуу бэлэглэлийн гэрээг хүчингүй болгож шийдвэрлэсэн. Харин Улсын Дээд шүүх анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож шийдвэрлэжээ. Дээд шүүх тус маргааныг шийдвэрлэхдээ: (1) ИХ-ийн 280 дугаар зүйлийн 280.1.1-д заасан “бэлэг хүлээн авагч

*нь бэлэглэгчийг гомдоосон ноцтой үйлдэл хийсэн” гэдэгт ямар үйлдэл хамаарах, (2) болзол заасан буюу тусгай зориулалттай бэлэглэлийн гэрээний нөхцөлийг биелүүлээгүй нь бэлэглэлийн гэрээг хүчингүйд тооцох үндэслэл болох эсэх, (3) бэлэглэлийн гэрээний зорилго заасан зохицуулалтыг гэрээний үгийн шууд утгаар тайлбарлаж, гэр бүлийн гишүүдэд зориулан бэлэглэсэн эсэхтэй холбоотой асуудлуудыг хөндсөнөөрөө ач холбогдолтой юм.*

Бэлэглэлийн гэрээг ИХ-ийн 280 дугаар зүйлийн 280.1.1-д заасан үндэслэлээр хүчингүй болгосон хэд хэдэн шийдвэр байна. Тухайлбал, Сүхбаатар дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх 2012 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн 1476 тоот шийдвэрээр Б-ийн нэхэмжлэлтэй Ж-д холбогдох “хувийн сууц болон газар бэлэглэсэн гэрээг хүчингүй болгуулах” шаардлага бүхий маргааныг шийдвэрлэсэн. Шүүх шийдвэрийнхээ үндэслэх хэсэгт *“Нэхэмжлэгч тухайн хөрөнгийг бэлэглэх болсон хүсэл зоригоо тайлбарлахдаа өөрийн төрсөн дүцг гэр бцл, цр хцүхэдтэй болсонд зориулж, сайн сайхныг бэлгэдэж гэрээ хийсэн гэснийг харууцагч үгүйсгээгүй. Бэлэг хүлээн авагч бэлгийн зүйлийг өөрийн өмчлөлд шилжүүлэхээр үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн газарт мэдүцүлэхдээ эхнэр, хцүхдийнхээ нэрийг хамтран өмчлөгчөөр бүртгүцүлэх эрх нээлттэй байхад нэг хүний өмчлөлд бүртгүцүлсэн нь бэлэглэгчийг гомдоосон үйлдэл гэж үзэх үндэслэлтэй”* гэж үзэж, ИХ-ийн 280 дугаар зүйлийн 280.1.1-д заасны дагуу бэлэглэлийн гэрээг хүчингүй болгож шийдвэрлэжээ. Энэхүү шийдвэр нь дүн шинжилгээ хийж буй шийдвэртэй харьцуулахад шүүхийн зүгээс тусгай зориулалттай гэрээ байсан эсэх, тусгай зориулалтыг гэрээнд тодорхой заасан эсэхийг тодруулаагүй, мөн ноцтой гомдоосон үйлдэл гэдэгт тухайн тохиолдолд дурдагдаж буй үйлдэл хамаарах эсэхийг тогтоож, тайлбарлаагүйгээрээ ихээхэн ялгаатай байна.

Бэлэглэлийн гэрээ нь бусад гэрээтэй харьцуулахад ихэнх тохиолдолд гэрээний талууд нь ойр дотнын хүмүүс байдгаараа онцлогтой. Дээрх Дээд шүүхийн шийдвэрээс харахад *“хүч Б гэр бүл болж тусдаа гарч байгаа тул гал голомтоо залгуулж байна”* гэж гэрээнд тусгай нөхцөл зааж хөрөнгийг, хариу төлбөргүйгээр шилжүүлжээ. Гэрээний тусгай нөхцөл болохын хувьд ИХ-ийн 279 дүгээр зүйл хэрэглэгдэнэ. ИХ-ийн 279 дүгээр зүйлийн 279.1-д *“Ямар нэгэн болзол хангасан, эсхүл тодорхой зорилгод хүрсэн нөхцөлд бэлэглэлийн гэрээ хүчин төгөлдөр болохоор талууд тохиролцож болно”* гэж заажээ.

Нэхэмжлэгч нь хүүдээ гэр бүл болж байгааг нь болзол болгож, сайхан амьдрахыг хүсэж бэлэглэсэн. Гэтэл хариуцагч нь гэрлэлтээ батлуулаагүй, 2 сарын хугацаанд амьдарч салсан. Иймээс бэлэглэлийн гэрээнд заасан тусгай нөхцөл биелээгүй гэж үзэж, энэ нөхцөлөө ноцтой гомдоосон үйлдэл гэж үзжээ. Анхан, Давах, Хяналтын шатны шүүхийн шийдвэрээс харахад нэхэмжлэгч нь тусгай зориулалттай хийсэн бэлэглэлийн гэрээнээс татгалзаж байна уу? эсхүл гомдоосон ноцтой үйлдэл гэж үзэж маргаж байна уу гэдгийг тодруулаагүй. Харин гомдоосон ноцтой үйлдэл мөн эсэх гэдэгт илүү анхаарч шүүхийн шийдвэрийн үндэслэх хэсгээ бичжээ. ИХ-ийн 279 дүгээр зүйлийн 279.3-д *“Бэлэг хүлээн авах эрх бүхий этгээд гэрээнд заасан болзол буюу зорилгыг биелүлээгүй бол бэлэглэгч гэрээнээс татгалзаж болно”* гэж заасан. Гэвч шүүх *“гэрээний болзлыг биелүүлээгүй үйлдэл”* болон *“бэлэглэгчийг гомдоосон ноцтой үйлдэл”* хоёрын ялгаатай асуудлын талаар дүгнэлт хийгээгүй.

Дээд шүүх тогтоолынхоо үндэслэх хэсэгт, *“Нэхэмжлэлийн үндэслэл болсон гэрээнд “... хүч Б гэр бүл болж тусдаа гарч байгаа тул гал голомтоо залгуулж байна...” гэж заасан нь орон сууцыг дан ганц Б-д бэлэглэж буй агуулга байхгүй тул шүүх хэргийг шийдвэрлэхдээ “...гэрээг тайлбарлахдаа үгийн шууд*

*утгыг анхаарна...” гэсэн ИХ-ийн 198 дугаар зүйлийн 198.1, 198.2 дахь хэсгийн зохицуулалтыг зөрчжээ. Нэхэмжлэлийн үндэслэл болсон бэлэглэлийн гэрээний 7 дахь заалтын агуулгыг гэрээний бусад нөхцөл, ерөнхий агуулга буюу гэрээний 1, 4 дэх хэсгийн заалттай харьцуулбал, Д, Н нар орон сууцыг Б, Ц, охин С нарт бэлэглэсэн гэж тодорхойлохоор байна” гэж дүгнэсэн.*

Анхан болон Давж заалдах шатны шүүх нь дээрх нөхцөлийг бэлэг хүлээн авагч биелүүлээгүй нь бэлэглэгчийг гомдоосон ноцтой үйлдэл гэж үзэж, нэхэмжлэлийг бүхэлд нь хангаж шийдвэрлэжээ. Гэтэл Улсын Дээд шүүх дээрх гэрээний нөхцөлийг тусгай зориулалттай хийсэн бэлэглэлийн гэрээ гэж үзээгүй байна. Харин хариуцагч Б-д бус түүнээс гадна гэр бүл болж буй гишүүдэд хамааралтай байна гэж гэрээг тайлбарлах замаар ИХ-ийн 280 дугаар зүйлийн 280.1.1-д заасан үндэслэлд тус үйлдэл хамаарахгүй гэж үзсэн. Тус шүүхийн шийдвэр нь үндэслэлтэй байна гэж дүгнэж байна. Учир нь нэхэмжлэгчийн зүгээс тусгай зориулалттай хийсэн бэлэглэлийн гэрээний нөхцөлийг хариуцагч биелүүлээгүй учраас гэрээнээс татгалзах шаардлагыг бус харин бэлэглэгчийг гомдоосон ноцтой үйлдэл хийсэн гэж үзэж маргасан. Гэтэл заавал гэр бүл болж, салахгүйгээр хамт амьдрах үүрэг ногдуулах нь зан суртахууны хэм хэмжээнд нийцэхгүй юм. Иймээс тус үйлдлийг бэлэг хүлээн авагчийг гомдоосон ноцтой үйлдэлд тооцох боломжгүй гэж үзсэн нь үндэслэлтэй байна.

Шүүхийн шийдвэрүүдийг судлан үзэхэд, бэлэг хүлээн авагчийг гомдоосон ноцтой үйлдэл гэдгийг “*тухайн этгээд буюу бэлэглэгчийн нийгэмд эзлэх байр суурьд сөргөөр нөлөөлөх, бэлэглэгчийн нийгэмд эзлэх байр суурь, нэр хүнд, эсхүл бэлэглэгч, бэлэг хүлээн авагчийн садан төрлийн байдал, гомдоосон үйлдлийг нийгэмд ил, эсхүл хувийн хүрээнд хийсэн эсэхийг харилцан харгалзахаас гадна бэлэглэгч, бэлэг хүлээн авагчийг өөрөө өдөөн хатгасан эсэх, бэлэг хүлээн авагчийн үйлдлийг хувь хүний*

*хувьд ойлгох боломжтой байсан эсэхийг харгалзаж” тогтоож байна. Харин дээрх гэрээний нөхцөлийг биелүүлээгүй үйлдэл нь бэлэглэгчийн нийгэмд эзлэх байр суурьд сөргөөр нөлөөлөөгүй, нэр хүндийг гутаагаагүй тул ноцтой гомдоосон үйлдэл гэж үзэх боломжгүй юм. Мөн бэлэглэлийн гэрээгээр бэлэглэлийн зүйлийг хариу төлбөргүйгээр өгөх болсон шалтгаан нь бэлэглэлийн гэрээгээр бэлэг хүлээн авагчид үүрэг болгож буй болзол, зорилго биш. Хариуцагч нар нь гэрлэлтээ батлуулаагүй, тусдаа амьдрах болсон нь гэр бүлийн харилцаанд хамааралтай гэж Дээд шүүх хянавал хэсэгтээ дүгнэсэн нь үндэслэлтэй болжээ.*

**2.1.2. Бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэрэгт гүтгэсэн үйлдэл нь бэлэглэгчийг гомдоосон ноцтой үйлдэл эсэхтэй холбоотой шүүхийн шийдвэр (Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2016 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн 1709 дугаартай магадлал)**

*Хэргийн үйл баримт:*

Нэхэмжлэгч нь хариуцагч Б-д холбогдуулан 2012 оны 09 дүгээр сарын 27-ны өдөр байгуулсан бэлэглэлийн гэрээнээс Б-д холбогдох хэсгийг хүчингүй болгож, хариуцагчийг гэрээгээр шилжүүлсэн орон сууцнаас албадан нүүлгэх нэхэмжлэлийг гаргажээ. Нэхэмжлэгч нь шүүхэд гаргасан нэхэмжлэлдээ “*хариуцагч нь удаа дараа дарамталж зоддог байсан, том охин У-г хүчиндсэн байна гэж онц хүнд гэмт хэрэгт гүтгэж цагдаагийн байгууллагад шалгуулсан. Энэ мэтчилэн хариуцагч нь бэлэглэгчийг байнга ноцтой гомдоодог”* гэж, хариуцагч нь “*...С-тэй 2007 онд гэрлэж, 2013 оны 08 дугаар сарын 13-ны өдөр гэрлэлтээ цуцлуулсан. С нь согтууруулах ундаа хэрэглэсэн цедээ хэл амаар доромжлон дарамталдаг, гэрлэлт цуцлуулах цедээ эд хөрөнгийн талаар маргаагүй байж одоо нэхэмжлэл гаргаж байгаа нь үндэслэлгүй”* гэж тайлбар өгчээ.

*Анхан шатны шүүхийн шийдвэр:*

Баянзүрх, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2016 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн 00168 дугаартай шийдвэрээр ИХ-ийн 280 дугаар зүйлийн 280.1.1, 280.1.2 дахь заалтыг баримтлан хариуцагч Б, нэхэмжлэгч С нарын хооронд 2012 оны 09 дүгээр сарын 27-ны өдөр байгуулсан бэлэглэлийн гэрээг хүчингүйд тооцуулж, орон сууцнаас Б-г гаргуулах тухай С-ийн нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэжээ.

*Давж заалдах шатны шүүхийн магадлал:*

Давж заалдах шатны шүүх магадлалынхаа хянавал хэсэгтээ, ““Бэлэглэлийн гэрээ”-г байгуулснаас хойш Сонгинохайрхан дүүргийн шүүхийн 2013 оны 08 дугаар сарын 13-ны өдрийн 1751 дугаартай шийдвэрээр зохигчдын гэрлэлтийг цуцалж, охин У, М нарыг эх Б-ийн асрамжид үлдээж, талууд эд хөрөнгийн маргаангүй болохыг дурдаж шийдвэрлэсэн, Дүүргийн 2 дугаар прокурорын газрын 2015 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн 751 дугаартай “Эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгох тухай” прокурорын тогтоолд тусгаснаар Б нь 2015 оны 04 дүгээр сарын 02-ны өдөр С-тэй маргалдаж биед нь хөнгөн гэмтэл санаатай учруулсан гэх хэрэгт хэрэг бүртгэлтийн ажиллагаа явуулахад... хохирогч С нь “гомдол саналгүй, эвлэрэх хүсэлтээ гаргасан” гэсэн үндэслэлээр эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн байх ба шүүх бэлэг хүлээн авагч нь бэлэглэгчийг гомдоосон ноцтой үйлдэл хийсэн, бэлэглэгчийн эрцүл мэнд, амь насыг санаатай хохироосон буюу хохироохоор завдсан үйлдэл хийсэн болох нь нотлогдоогүй гэж дүгнэсэн нь үндэслэлтэй бөгөөд хариуцагчийн уг үйлдэлтэй холбоотойгоор ИХ-ийн 280 дугаар зүйлийн 280.3 дахь хэсэгт заасан бэлэглэлийг хүчингүй болгох талаар шаардлага гаргах хугацаа өнгөрсөн байна.” гэжээ.

*Нийслэлийн Баянгол дүүргийн прокурорын газрын 2016 оны*

04 дүгээр сарын 06-ны өдрийн 3492 дугаартай “Эрцүгийн хэрэг үцсгэхээс татгалзах тухай” прокурорын тогтоолд тусгаснаар С нь 2016 оны 02 дугаар сард охин У, М нарыг гэртээ түр байлгахдаа охин У-г хүчиндсэн байж болзошгүй байгааг шалгаж өгнө үү гэсэн Б-ын гомдлыг шалгах явцад С нь төрсөн охин У-г хүчиндсэн болох нь нотлох баримтаар нотлогдоогүй тул түүнд эрцүгийн хэрэг үцсгэхээс татгалзжээ. Харин Б-ын гаргасан дээрх гомдол, мэдээлэл нь С-г 2006 оны 07 дугаар сарын 26-нд төрсөн, 10 настай буюу бага насны хүүхдийг хүчиндсэн гэх онц хүнд гэмт хэрэгт гүтгэсэн шинжтэй, Иргэний хуулийн 280 дугаар зүйлийн 280.1.1-д заасан бэлэг хүлээн авагч нь бэлэглэгчийг гомдоосон ноцтой үйлдэл хийсэн гэж үзэх үндэслэлтэй байхад шүүх уг үйл баримтад бодитой дүгнэлт хийгээгүй нь буруу байна. Иймд давж заалдах шатны шүүхээс шүүхийн шийдвэрийг өөрчилж, нэхэмжлэлийн шаардлагаас “2012 оны 09 дүгээр сарын 27-ны өдөр байгуулсан “Бэлэглэлийн гэрээ”-нээс Б-д холбогдох хэсгийг хүчингүй болгох” хэсгийг хангах нь зүйтэй байна” гэж анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож, нэхэмжлэлийг хангаж шийдвэрлэсэн.

### **Шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээ:**

Шүүхийн шийдвэрээр хөндөгдөж буй асуудал: Нэхэмжлэгч “хариуцагч нь удаа дараа дарамталж зоддог байсан, том охин У-г хүчиндсэн байна гэж онц хүнд гэмт хэрэгт гүтгэж цагдаагийн байгууллагад шалгуулсан. Энэ мэтчилэн хариуцагч нь бэлэглэгчийг байнга ноцтой гомдоодог” гэсэн үндэслэлээр “Бэлэглэлийн гэрээ”-г ИХ-ийн 280 дугаар зүйлийн 280.1.1-д заасны дагуу хүчингүй болгуулахаар шүүхэд ханджээ. Энэхүү маргааныг анхан болон давж заалдах шатны шүүхээр шийдвэрлүүлсэн байна. Анхан шатны шүүх нэхэмжлэгчийн гаргасан нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн бол Давж заалдах шатны шүүх анхан



шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож, нэхэмжлэгчийн нэхэмжлэлийг хангаж шийдвэрлэжээ.

Энэхүү хэргийг анхан болон давж заалдах шатны шүүх шийдвэрлэхдээ ИХ-ийн 280 дугаар зүйлийн 280.1.1-д заасан “*Бэлэг хүлээн авагч нь бэлэглэгчийг гомдоосон ноцтой үйлдэл хийсэн*” гэдэгт ямар үйлдлийг ойлгохыг авч үзэж шийдвэрлэсэнээрээ ач холбогдолтой юм. Бэлэглэлийн гэрээ байгуулсан талууд ихэнх тохиолдолд бэлэг хүлээн авагч бэлэглэгчийг гомдоосон ноцтой үйлдэл хийсэн гэж олон үндэслэл гаргаж маргадаг боловч шүүх ихэнх тохиолдолд өөрийн үзэмжээр хандаж шийдвэрлэсээр ирсэн. Харин энэхүү маргаанаар анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгохдоо Нийслэлийн Давж заалдах шатны шүүх гомдоосон ноцтой үйлдэлд юуг ойлгох, ямар үйлдэл, тохиолдлыг хамааруулах тухай тодорхой хүрээнд шийдэл өгсөн гэж үзэж байна.

Нийслэлийн Иргэний хэргийн Давж заалдах шатны шүүх тухайн хэргийг шийдвэрлэсэн магадлалдаа “*Б-ын гаргасан дээрх гомдол, мэдээлэл нь С-г 2006 оны 07 дугаар сарын 26-нд төрсөн, 10 настай буюу бага насны хүүхдийг хүчиндсэн гэх онц хүнд гэмт хэрэгт гүтгэсэн шинжтэй, Иргэний хуулийн 280 дугаар зүйлийн 280.1.1-д заасан бэлэг хүлээн авагч нь бэлэглэгчийг гомдоосон ноцтой үйлдэл хийсэн гэж үзэх үндэслэлтэй байхад шүүх уг үйл баримтад бодитой дүгнэлт хийгээгүй нь буруу байна*” гэж дүгнэжээ. Анхан шатны шүүх энэхүү үйл баримтыг үнэлэхдээ бэлэглэгчийг гомдоосон ноцтой үйлдэл биш гэж үзсэн. Харин Давж заалдах шатны шүүх бэлэглэгчийг тухайн гэмт хэргийг үйлдсэн гэж цагдаад хандсаныг гомдоосон ноцтой үйлдэл гэж үзээгүй, харин цагдаагийн газраас шалган үзэхэд бэлэглэгчийн гэм буруутай үйлдэл тогтоогдоогүй, гэмт хэргийн шинжгүй гэж тогтоосон тул бэлэглэгчийн нэр төр, алдар хүндэд сөргөөр нөлөөлсөн гэж үзжээ. Монгол Улсын Үндсэн хуулийн

Арван зургаадугаар зүйлийн 14 дэх хэсэгт, “Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж цэвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, ... гэм буруутай нь хуулийн дагуу шүүхээр нотлогдох хүртэл хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож цл болно” гэж зохицуулжээ.

Бэлэг хүлээн авагчийн бэлэглэгчийг бага насны хүүхдийг хүчиндсэн гэх онц хүнд гэмт хэрэг үйлдсэн гэж цагдаагийн газарт гомдол гаргасан үйлдэл нь Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлийн 14 дэх хэсэгт заасан эрх юм. Гэвч нөгөө талаас гэмт хэрэг үйлдсэн гэж гомдол гаргасан боловч шүүхээр нотлогдох хүртэл тухайн этгээдийг гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцох үндэслэлгүй. Үүнээс үзэхэд, бэлэг хүлээн авагч нь бэлэглэгчийг цагдаагийн газраар шалгуулахаар хандсанаар бэлэглэгчийн нэр төр, алдар хүнд унасан гэж үзэх нөхцөл биш юм. Харин давж заалдах шатны шүүх гомдоосон ноцтой үйлдэл гэдэгт “бэлэглэгчийг онц хүнд гэмт хэрэгт гүтгэсэн үйлдлийг хамруулсан ба энэхүү үйлдлийн улмаас бэлэглэгчийн нэр төр, алдар хүндэд сөргөөр нөлөөлсөн гэж үзэж нэхэмжлэлийг хангаж шийдвэрлэжээ. Шүүхийн шийдвэрүүдийг судлан үзэхэд ноцтой гомдоосон үйлдэлд “*тухайн этгээд буюу бэлэглэгчийн нийгэмд эзлэх байр суурьд сөргөөр нөлөөлөх*” үйлдлийг хамруулж, бэлэглэгч нь бэлэг хүлээн авагчийн тухайн үйлдлийг хүлцэн тэвчих боломжтой байсан эсэхийг харгалзаж байна. Бэлэг хүлээн авагч нь бэлэглэгчийг бага насны хүүхдийг хүчиндсэн гэмт хэрэгт буруутгаж, цагдаад хандсан үйлдэл нь бэлэглэгчийн нийгэмд эзлэх байр суурьд сөргөөр нөлөөлөх, нэр төр, алдар хүндийг гутаасан гэж тайлбарлаж, энэхүү үйлдлийг хүлцэн тэвчих боломжгүй гэж үзсэн давж заалдах шатны шүүхийн шийдвэрийг буруутгах боломжгүй юм.

Учир нь ИХ-ийн 280 дугаар зүйлийн 280.1.1-д заасан

“Бэлэг хүлээн авагч нь бэлэглэгчийг гомдоосон ноцтой үйлдэл хийсэн” гэсэн заалтын бүрэлдэхүүн нь (1) бэлэг хүлээн авагч нь бэлэглэгчийг гомдоосон, бэлэглэгч тухайн үйлдэлд гомдсон байх; (2) гомдоосон үйлдэл нь ноцтой байхыг шаарддаг. Нэхэмжлэгч нь бэлэг хүлээн авагчийн тухайн үйлдэлд гомдсон, хүлцэн тэвчих боломжгүй үйлдэл гэж үзсэн, мөн “бага насны хүүхдийг хүчиндсэн гэх онц хүнд гэмт хэрэгт буруутгаж гомдол гаргасан” үйлдэл нь ердийн гомдоох үйлдэлтэй харьцуулахад ноцтой үйлдэл гэж үзэж болох тул нэхэмжлэлийг хангаж шийдвэрлэсэн шийдвэр үндэслэлтэй болсон. Нөгөө талаас ИХ-ийн 280 дугаар зүйлийн 280.1.1-д заасан “Бэлэг хүлээн авагч нь бэлэглэгчийг гомдоосон ноцтой үйлдэл хийсэн” бол бэлэглэлийн гэрээг хүчингүй болгох заалт нь тодорхой байх зарчмыг алдагдуулсан, шүүгчийн ур чадвар, субъектив үнэлэмжээс хамааран хэрэглэх зохицуулалт юм. Иймээс ноцтой гомдоосон үйлдэл гэдгийг шүүхийн зүгээс хэргийн үйл баримт, нэхэмжлэгчийн нэхэмжлэлийн үндэслэл, тайлбар, хариуцагчийн хариу тайлбар, холбогдох нотлох баримтыг үндэслэн тогтоож, үнэлэх асуудал болж байгаа тул шүүхийг хуулийг буруу тайлбарлаж, хэрэглэсэн гэж буруутгахад хүндрэлтэй юм.

**2.1.3. Бэлэглэлийн зүйлийг бусдад барьцаалсан үйлдэл нь бэлэглэгчийг гомдоосон ноцтой үйлдэл эсэхтэй холбоотой шүүхийн шийдвэр (Улсын Дээд шүүхийн 2013 оны 10-р сарын 11-ний өдрийн 563 дугаартай тогтоол)**

*Хэргийн үйл баримт:*

Нэхэмжлэгч Г болон Б нар нь өөрийн өмчлөлийн орон сууцаа том хүү Т, бэр Н нартаа насан туршдаа харж, хандуулж, халамжлуулах зорилгоор орон сууц бэлэглэх гэрээ хийж, өмчлөх эрхээ шилжүүлэн өгчээ. Гэтэл 2012 оны 12 дугаар сарын 17-ны өдөр Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх газраас ирсэн бичигт дээрх бэлэглэсэн орон сууц нь “У” ХХК-ийн зээлийн төлбөрт

хураагдан дуудлага худалдаанд оруулан худалдагдаагүй тул “К” банкны өмчлөлд шилжих болсныг дурдаж, чөлөөлөхийг шаарджээ. Бэлэглэсэн хөрөнгийг барьцаанд тавьж, орох оронгүй болгосон үйлдэл нь ноцтой гомдоосон үйлдэл гэж үзэж, гэрээг хүчингүй болгож, бэлгийн зүйлийг буцааж, өмчлөгчөөр тогтоож өгөх нэхэмжлэлийг шүүхэд гаргасан байна. Хариуцагч нар хариу тайлбартаа, *“Хоёр хөгшнийг насан туршид нь асран хамгаалж, халамжлан тэтгэх болзолтойгоор байрны өмчлөлийг шилжүүлж авсан. Анх тохиролцсон ёсоор хоёр хөгшнийг насан туршид тайван амгалан байлгаж, асран хамгаалах үүргээ биелүлээгүй, бие нь муудаж магадгүй гэх шалтгаанаар хууран мэхэлж ноцтойгоор гомдоосноо хүлээн зөвшөөрч байна”* гэж дурджээ.

*Анхан шатны шүүхийн шийдвэр:*

Нийслэлийн Баянгол дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2013 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн 876 тоот шийдвэрийн үндэслэх хэсэгт, *“Гэрээгээр бэлэглэгч нар орон сууцаа Т-д шилжүүлсэн, бэлэг хүлээн авагч Т нь бэлгийг өмчлөлдөө шилжүүлэн авснаар бэлэглэгчийн өмчлөх эрх дуусгавар болжээ. ИХ-ийн 101 дүгээр зүйлд зааснаар өмчлөгч өмчлөлийн зүйлээ өөрийн үзэмжээр чөлөөтэй эзэмшиж, ашиглаж, захиран зарцуулах эрхтэй байна. Түүнчлэн бэлэглэлийн гэрээг тусгай зориулалтаар хийгээгүй байна. Хэдийгээр хариуцагч нь бэлэглэгчийг насан туршид нь асарч халамжлах үүргээ биелүлээгүй ноцтой гомдоосон гэж үзэж, нэхэмжлэлийн шаардлагыг зөвшөөрдөг боловч ноцтой гомдоосон үйлдэл хийгээгүй гэж дүгнэлээ”* гэж дурдаж, нэхэмжлэлийн шаардлагыг хэрэгсэхгүй болгон шийдвэрлэжээ.

*Давж заалдах шатны шүүхийн магадлал:*

Нийслэлийн Иргэний хэргийн Давж заалдах шатны шүүхийн 2013 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн 467 тоот магадлалын хянавал хэсэгт, *“Хэдийгээр хариуцагч нар нэхэмжлэлийн*

шаардлагыг зөвшөөрч байгаа боловч бэлэглэлийн гэрээгээр урьд шилжүүлсэн орон сууцтай холбоотой шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явагдаж байгаа бөгөөд ИХ-ийн 280 дугаар зүйлийн 280.2 дахь заалтын дагуу бэлэглэлийн зүйлийг буцаах нь гуравдагч этгээдийн эрх ашгийг зөрчин, хүлээсэн цүргээ биелүүлэхээс зайлсхийх зорилготой байж болохгүй юм” гэж үзэж, анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээж шийдвэрлэжээ.

*Хяналтын шатны шүүхийн тогтоол:*

Улсын Дээд шүүх тогтоолынхоо хянавал хэсэгт, “ИХ-ийн 276 дугаар зүйлийн 276.1-д зааснаар бэлэглэлийн гэрээгээр бэлэглэгч нь тодорхой эд хөрөнгийг бэлэг хүлээн авагчийн өмчлөлд шилжүүлдэг тул маргааны зүйл болох орон сууцыг эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрх гэрээ хүчин төгөлдөр болсон буюу 2001 оны 08 дугаар сард хариуцагч Т-д шилжжээ. Орон сууц өмчлөх эрхийг бэлэглэлийн гэрээгээр шилжүүлсэн тохиолдолд бэлэг хүлээн авагч уг орон сууцыг захиран зарцуулах эрхтэй болно гэдгийг нэхэмжлэгч нар мэдэх ёстой тул хууль ёсны өмчлөгчийн эрхээ хэрэгжүүлсний цр дагаврыг ИХ-ийн 3 дугаар зүйлийн 3.7-д зааснаар цугүйсгэх боломжгүй юм. Өөрөөр хэлбэл, өмчлөгч өөрийн эд хөрөнгийг барьцаалах, төлбөртөө тооцон шилжүүлэх, худалдах, худалдахыг зөвшөөрөх зэргээр захиран зарцуулах эрхтэй тул уг эрхийг бэлэглэлийн гэрээгээр шилжүүлсэн бэлэглэгч бэлэг хүлээн авагчийн эрхээ хэрэгжүүлсэн явдлыг ИХ-ийн 280 дугаар зүйлийн 280.1.1-д заасан бэлэглэлийг хүчингүй болгуулах үндэслэл болгож болохгүй юм.”

“ИХ-ийн 280 дугаар зүйлийн 280.1.1-д заасан “бэлэглэгчийг гомдоосон ноцтой үйлдэл” гэдэгт бэлэглэлийн гэрээгээр шилжсэн эд хөрөнгийн эрхийг хэрэгжүүлсэн үйлдэл хамаарах үндэслэлгүй. Эхийнхээ оршин сууж байгаа орон сууцыг зээлийн төлбөр барагдуулах хэрэгсэл болгохыг зөвшөөрсөн хариуцагчийн

*үйлдлийг ёс суртахууны хувьд учир дутагдалтай гэж үзэж болох боловч хууль ёсны эрхээ хэрэгжүүлсэн явдал эрх зүйн хувьд зөрчилгүй байна. Бэлэглэлийн гэрээнд орон сууцыг хэн эзэмших, хэрхэн ашиглах, хэрхэн захиран зарцуулж болохгүй байх талаар тухайлсан нөхцөл заагдаагүй ба ийм нөхцөлийн талаар тохиролцсон гэх тайлбарыг зохигчдын хэн алин нь гаргаагүй тул хариуцагч бэлэглэлийн журмаар шилжсэн өмчлөх эрхийг Иргэний хуулийн 101 дүгээр зүйлийн 101.1-д заасан хүрээнд хэрэгжүүлэхэд ямар нэгэн хязгаарлалт байхгүй гэж ойлгоно” гэж дурдаж, анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээж шийдвэрлэсэн.*

### **Шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээ:**

Шүүхийн шийдвэрээр хөндөж буй асуудал: Нэхэмжлэгч Г болон Б нар нь өөрийн өмчлөлийн орон сууцаа том хүү Т, бэр Н нартаа насан туршдаа харж, хандуулж, халамжлуулах зорилгоор орон сууц бэлэглэх гэрээ хийж, өмчлөх эрхээ шилжүүлэн өгсөн. Гэтэл 2012 оны 12 дугаар сарын 17-ны өдөр Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх газраас ирсэн бичигт дээрх бэлэглэсэн орон сууц нь “У” ХХК-ийн зээлийн төлбөрт хураагдан дуудлага худалдаанд оруулан худалдагдаагүй тул “К” банкны өмчлөлд шилжих болсныг дурдаж, чөлөөлөхийг шаарджээ. Бэлэглэсэн хөрөнгийг барьцаанд тавьж, орох оронгүй болгосон үйлдэл нь ноцтой гомдоосон үйлдэл гэж үзэж, гэрээг хүчингүй болгож, бэлгийн зүйлийг буцааж, өмчлөгчөөр тогтоож өгөх нэхэмжлэлийг шүүхэд гаргасан байна. Анхан болон Давж заалдах шатны шүүх, Хяналтын шатны шүүх нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэжээ. Энэхүү шийдвэрийн ач холбогдол нь бэлэглэлийн гэрээгээр шилжүүлсэн хөрөнгийг захиран зарцуулах эрхийг эдэлсэн нь гомдоосон ноцтой үйлдэл болохгүй гэдгийг тайлбарлаж, дүгнэсэн явдал юм.

Социалист загвар бүхий Иргэний хуулиудтай харьцуулахад

либерал хэв загвар бүхий иргэний хуулиуд нь өмчлөлийн эд хөрөнгөө өөрийн дураар захиран зарцуулах суурь эрхийг баталгаажуулж өгдгөөрөө онцлог юм. Манай улсын 2002 онд батлагдсан ИХ нь ардчилсан нийгэмд шилжихтэй холбогдуулан либерал үзэл баримтлалд нийцүүлэн хийсэн хууль мөн. Иймээс ИХ-д өмчлөлийн хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулах боломжийг тусгажээ. Эд хөрөнгийг захиран зарцуулах гэдэг ойлголтын агуулгад дээрх маргаан бүхий үйл баримтад байгаа *“бэлэглэсэн хөрөнгийг бусдад барьцаалах”* үйлдэл багтдаг. Учир нь барьцааны эрх нь аксиссор шинжтэй буюу өмчийн эрхийг дагалдаж үүсдэг эрх юм. Иймд хэн өмчлөгч байна тухайн этгээд хөрөнгөө бусдад барьцаалах эрхийг эдэлнэ. Бэлэглэлийн гэрээ нь хоёр талын бэлэг өгч авалцах тухай зөвшилцөл шаарддагаараа хоёр талт хэлцэл, харин үүсэх үүргийн тоогоор нь авч үзвэл зөвхөн бэлэглэгчид үүсэх тул нэг талт гэрээ болно.<sup>14</sup> Өөрөөр тайлбарлавал, бэлэглэлийн гэрээ нь хариу төлбөргүй гэрээнд багтана. Бэлэглэлийн гэрээний тусгай төрөлд тусгай зориулалттай хийсэн бэлэглэлийн гэрээг хамааруулдаг. Нэхэмжлэгч нар нь ИХ-ийн 279 дүгээр зүйлд заасан тусгай зориулалттай бэлэглэлийн гэрээг байгуулаагүй.

Нэхэмжлэгч Г болон Б нар нь өөрийн өмчлөлийн орон сууцаа том хүү Т, бэр Н нартаа насан туршдаа харж, хандуулж, халамжлуулах зорилгоор орон сууц бэлэглэх гэрээ хийж, өмчлөх эрхээ шилжүүлэн өгснийг шүүх дүгнэхдээ тусгай зориулалттай гэрээ гэж дүгнээгүй нь үндэслэлтэй юм. Учир нь ИХ-ийн 279 дүгээр зүйлийн 279.1-д *“ямар нэгэн болзол хангасан, эсхүл тодорхой зорилгод хүрсэн нөхцөлд бэлэглэлийн гэрээ хүчин төгөлдөр болохоор талууд харилцан тохиролцож болно”*, мөн зүйлийн 279.4-т *“Хуульд өөрөөр заагаагүй бол тусгай зориулалттай хийсэн бэлэглэлийн гэрээг бичгээр хийнэ”* гэж заасан. Талуудын хувьд бэлэглэлийн гэрээг бичгээр байгуулсан

<sup>14</sup> Б.Буянхишиг, Иргэний эрх зүйн тусгай анги: Гэрээний эрх зүй, 2015, 106 дахь тал.

боловч болзол, зорилго бүхий тусгай нөхцөлийг тус гэрээнд тусгаагүй байгаа тул тусгай зориулалттай хийсэн бэлэглэлийн гэрээ гэж үзэхгүй юм. Мөн маргаан бүхий гэрээний зүйл нь орон сууц буюу үл хөдлөх эд хөрөнгө байна. Үл хөдлөх эд хөрөнгө нь бусад хөрөнгөтэй харьцуулахад өмчлөх эрхийг олж авах эрх нь улсын бүртгэлд бүртгүүлснээр үүсдэг. ИХ-ийн 110 дугаар зүйлийн 110.1-д *“Үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрх хэлцлийн үндсэн дээр нэг этгээдээс нөгөөд шилжиж байгаа бол уг хэлцлийг үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн газар бүртгүүлснээр өмчлөх эрх шинэ өмчлөгчид үүсэж, өмнөх өмчлөгчийн өмчлөх эрх дуусгавар болно”* гэж зохицуулжээ. Үүнээс харахад үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрх бүртгүүлснээр үүсэх бөгөөд бүртгүүлснээс хойш хөрөнгийн өмчлөх эрх шинэ өмчлөгчид буюу хариуцагчид үүссэн байна.

Улсын Дээд шүүх тус маргааныг хянан үзээд хянавал хэсэгтээ, *“орон сууцыг эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрх гэрээ хүчин төгөлдөр болсон буюу 2001 оны 08 дугаар сард хариуцагч Т-д шилжжээ. Орон сууц өмчлөх эрхийг бэлэглэлийн гэрээгээр шилжүүлсэн тохиолдолд бэлэг хүлээн авагч уг орон сууцыг захиран зарцуулах эрхтэй болно гэдгийг нэхэмжлэгч нар мэдэх ёстой тул хууль ёсны өмчлөгчийн эрхээ хэрэгжүүлсний үр дагаврыг Иргэний хуулийн 3 дугаар зүйлийн 3.7-д зааснаар үгүйсгэх боломжгүй юм. Өөрөөр хэлбэл, өмчлөгч өөрийн эд хөрөнгийг барьцаалах, төлбөртөө тооцон шилжүүлэх, худалдах, худалдахыг зөвшөөрөх зэргээр захиран зарцуулах эрхтэй тул уг эрхийг бэлэглэлийн гэрээгээр шилжүүлсэн бэлэглэгч бэлэг хүлээн авагчийн эрхээ хэрэгжүүлсэн явдлыг ИХ-ийн 280 дугаар зүйлийн 280.1.1-д заасан бэлэглэлийг хүчингүй болгуулах үндэслэл болгож болохгүй юм”* гэж дүгнэсэн нь үндэслэлтэй байна. Бэлэг хүлээн авагч бэлэглэсэн орон сууцыг бусдад барьцаалсан үйлдэлд бэлэглэгч гомдож болох боловч бэлэг хүлээн авагчийн үйлдэл нь ноцтой үйлдэл биш тул ИХ-ийн 280 дугаар зүйлийн 280.1.1-д үл



хамаарах юм. Нөгөө талаар, бэлэглэгч орон сууцыг бэлэг хүлээн авагчид шилжүүлснээр, тухайн орон сууцыг захиран зарцуулах бүрэн эрх өмчлөгчид шилжсэн гэж үзэх тул барьцаалах үйлдлийг хийсэн нь хуульд нийцнэ.

**2.1.4. Бэлэг хүлээн авагч нь архи уусан үедээ бэлэглэгчид агсан тавих, өвчтэй байгаа эцгээ орон дээрээс унагах зэрэг үйлдэл хийсэн нь бэлэглэгчийг гомдоосон ноцтой үйлдэл эсэхтэй холбоотой шүүхийн шийдвэр (Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2008 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 63 тоот магадлал)**

*Хэргийн үйл баримт:*

Нэхэмжлэгчийн зүгээс том хүүгээ өрөвдөн хайрлаж, зан заншлаа бодож, гал голомтоо байранд минь залгуулж, улам бадрааж сайн сайхан амьдраасай гэж хүсээд 2006 оны 03 дугаар сарын 17-ны өдөр “Бэлэглэлийн гэрээ”-гээр өөрийн өмчлөлийн үл хөдлөх хөрөнгөө шилжүүлсэн. Энэхүү гурван өрөө байр нь зургаан хүний өмчлөлтэй байсан бөгөөд бид ярилцаад уг байрыг хариуцагч Б-д шилжүүлэх болсон. Шилжүүлэх болсон шалтгаан нь айлын ууган хүү, гал голомтыг минь үе залгамжилж явна гэж итгэсэн, байрыг зарж үрэхгүй, сайн сайхан явахыг захиж хэлсэн, уг байр олон жил улсад ажиллаж хөдөлмөрлөсний минь үр дүнд бий болсон бөгөөд олон өмчлөгчдийн эрх ашгийг хөндөж байсан, ажиллаж, амьдрах гэж зүтгэж байгаад нь тус дэм болох гэж, хоёр хүүхдээ өсгөн хүмүүжүүлэхэд дөхөм болох байх гэж бодож шилжүүлсэн.

Нэхэмжлэгч нь 2007 оны 07 дугаар сард буюу арваад хоногийн өмнө бэлэглэсэн байрыг хариуцагч бусдад шилжүүлэн үгүй хийж, өөрөө орох оронгүй болсон гэдгийг мэдлээ. Энэ нь нэхэмжлэгч болон хамтран өмчлөгч нарыг маш их гомдоож байна гэж үзэж ИХ-ийн 280.1.1-д заасан үндэслэлээр гэрээг хүчингүйд

тооцуулахаар нэхэмжлэл гаргажээ. Хариуцагч шүүхэд гаргасан хариу тайлбартаа, “Гэрийнхэн маань намайг ажилдаа хол, 2 хүүхдийг сургуульд ойртуулах, ганцаараа хүүхдээ харж, ажил хийж, хүүхдээ асарч тэтгэж байгаагийн зэрэгцээ гал голомтоо өвлүүлж, айлын том хүү гээд надад энэ байрыг өгсөн юм. Ээж, дүү нарын хэлсэн болон талийгаач аавын маань нэхэмжлэлдээ бичсэн зүйлс бүгд үнэн” гэж дурдсан.

*Анхан шатны шүүхийн шийдвэр:*

Сонгинохайрхан дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2007 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн 1139 тоот шийдвэрээр хариуцагч нь нэхэмжлэгчийг гомдоосон ноцтой үйлдэл хийсэн байх тул ИХ-ийн 280.1.1, 280.2-д зааснаар нэхэмжлэгч болон хариуцагч нарын хооронд 2006 оны 03 дугаар сарын 17-ны өдөр байгуулсан бэлэглэлийн гэрээг хүчингүй болгож, нэхэмжлэлийг хангаж шийдвэрлэжээ.

*Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн магадлал:*

Давж заалдах шатны шүүх гаргасан магадлалын хянавал хэсэгт, “Нэхэмжлэгч нар нь гурван өрөө сууцыг бэлэглэлийн гэрээгээр 2006 оны 03 дугаар сарын 17-ны өдөр хариуцагчийн өмчлөлд шилжүүлсэн. Дээрх орон сууцыг 2007 оны 02 дугаар сарын 06-ны өдөр хариуцагч нь бэлэглэлийн гэрээгээр Х, О, Ж нарын өмчлөлд шилжүүлж, Х нь уг орон сууцыг бусдад худалдсан байна. Нэхэмжлэгч нар хариуцагчийн өмчлөлд бэлэглэлийн гэрээгээр орон сууцыг шилжүүлэхдээ тухайн байрыг бусдын эзэмшил, өмчлөлд шилжүүлэхгүй байхаар тохиролцсон болох нь зохигчдын тайлбараар тогтоогдсон байна. Бэлэг хүлээн авагч нь бэлгийн зүйлийг бусдын өмчлөлд шилжүүлсэн, архи уусан үедээ бэлэглэгч нарт агсан тавих, өвчтэй байгаа эцгээ орон дээрээс унагах зэрэг бэлэглэгчдийг ноцтой гомдоосон үйлдэл хийсэн болох нь хэрэгт авагдсан зохигчдын тайлбар болон

гэрчийн мэдцүлгээр нотлогджээ” гэж дурдаж, бэлэглэлийн гэрээг хүчингүй болгосон анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээж шийдвэрлэжээ.

### **Шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээ:**

Шүүхийн шийдвэрээр хөндөгдөж буй асуудал: Нэхэмжлэгч нар нь *Бэлэг хүлээн авагч нь бэлгийн зүйлийг бусдын өмчлөлд шилжүүлсэн, архи уусан үедээ бэлэглэгч нарт агсан тавих, өвчтэй байгаа эцгээ орон дээрээс унагах зэрэг бэлэглэгчдийг ноцтой гомдоосон үйлдэл хийсэн* гэж үзэж ИХ-ийн 280 дугаар зүйлийн 280.1.1-д заасны дагуу орон сууц шилжүүлсэн бэлэглэлийн гэрээг хүчингүй болгуулахаар шүүхэд хандсан байна. Энэхүү маргааныг анхан болон давж заалдах шатны шүүх хянан үзээд, бэлэглэгч нарыг гомдоосон ноцтой үйлдэл хийсэн гэж үзэж, ИХ-ийн 280 дугаар зүйлийн 280.1.1-д заасны дагуу бэлэглэлийн гэрээг хүчингүй болгож шийдвэрлэсэн байна. Энэхүү шийдвэр, магадлалаар бэлэглэгчийн биед халдсан, ёс зүйгүй үйлдлүүдийг гомдоосон ноцтой үйлдэлд багтааж шийдвэрлэснээрээ бусад шийдвэрүүдээс ялгаа, онцлогтой байна. Маргааны үйл баримтаас харахад нэхэмжлэгч нь (1) **бэлэглэсэн орон сууцыг худалдсан**; (2) **архи уусан үедээ бэлэглэгч нарт агсан тавьсан**; (3) **өвчтэй байгаа эцгээ орон дээрээс унагах** зэрэг үйлдлийг гаргаж гомдоосон гэж үзэж шүүхэд хандсан. Харин анхан болон давж заалдах шатны шүүх энэхүү гурван үйлдэл тус бүрд хууль зүйн дүгнэлт өгөөгүй.

Нэхэмжлэгч нь гурван өрөө орон сууцыг “Бэлэглэлийн гэрээ”-гээр 2006 оны 03 дугаар сарын 17-ны өдөр хариуцагчийн өмчлөлд шилжүүлсэн. ИХ-ийн 101 дүгээр зүйлийн 101.1-д “*Өмчлөгч нь бусад этгээдэд хууль буюу гэрээгээр олгогдсон эрхийг зөрчихгүйгээр, хуулиар тогтоосон хэмжээ, хязгаарын дотор өмчлөлийн зүйлээ өөрийн үзэмжээр чөлөөтэй эзэмшиж, ашиглаж, захиран зарцуулах бөгөөд аливаа халдлагаас хамгаалах*”

*эрхтэй*” гэж заасны дагуу хариуцагч нь бэлэглэсэн эд хөрөнгийг бусдад барьцаалах, худалдах зэргээр өмчлөх эрхээ хэрэгжүүлсэн байна. Энэхүү маргаантай адил төсөөтэй маргаануудыг судлан үзэхэд бэлэглэсэн эд хөрөнгийг бусдад худалдсан, барьцаалсан зэрэг тохиолдлыг тусгай зориулалттай нөхцөл тусгаснаас бусад тохиолдолд бэлэглэгчийг гомдоосон ноцтой үйлдэл гэж үзэх нөхцөл биш гэж дүгнэж, тайлбарлаж байна.

Тусгай зориулалттай хийсэн бэлэглэлийн гэрээг ИХ-ийн 279 дүгээр зүйлийн 279.1-д зохицуулжээ. Тусгай зориулалттай хийсэн гэрээг бичгээр хийх хууль зүйн хэлбэрийн шаардлагыг тогтоож өгсөн. Харин маргаан бүхий үйл баримтаас харахад тусгай нөхцөлийг бичгээр тохиролцоогүй, харин гэрчийн мэдүүлэг, зохигчдын тайлбарыг үндэслэн шүүх үнэлсэн байна. Гэтэл ИХ-ийн 42 дугаар зүйлийн 42.11-д *“Энэ хуулийн 42<sup>1</sup>.1-д зааснаас бусад тохиолдолд бичгээр хийх хуулийн шаардлагыг зөрчсөн хэлцлийн талаар маргасан тохиолдолд энэ хуульд өөрөөр заагаагүй бол тэдгээр нь гэрчээр нотлох эрхээ алдах боловч нотолгооны бусад хэрэгслээр нотолж болно*” гэж заасныг шүүх анхаарч, хуулийг хэрэглээгүй байна. Өөрөөр тайлбарлавал, бичгээр хийх хэлцлийн шаардлагыг хангаагүй бол гэрчээр нотлох үүргээ алддаг атал шүүх гэрчийн мэдүүлгийг нотлох баримтаар үнэлэн, тус мэдүүлэгт үндэслэн тусгай зориулалттай нөхцөл гэж үзсэн нь үндэслэлгүй болжээ. Иймээс бэлэглэсэн хөрөнгийг худалдсан үйлдлийг *“бэлэглэгчийг гомдоосон ноцтой үйлдэл”* гэж үзсэн нь хуульд заасан шаардлага, нөхцөлийг хангаагүй, үндэслэлгүй байна.

Харин архи уусан үедээ бэлэглэгч нарт агсан тавьсан, өвчтэй байсан эцгээ орон дээрээс унагаасан үйлдлийг *“гомдоосон ноцтой үйлдэл”* гэж үзэж болох боловч хэд хэдэн шаардлагыг хангасан байх шаардлагатай юм. Шүүхийн шийдвэрүүдийг судлан үзэхэд *“тухайн этгээд буюу бэлэглэгчийн нийгэмд эзлэх*

байр суурьд сөргөөр нөлөөлөх, бэлэглэгчийн нийгэмд эзлэх байр суурь, нэр хүнд, эсхүл бэлэглэгч, бэлэг хүлээн авагчийн садан төрлийн байдал, гомдоосон үйлдлийг нийгэмд ил, эсхүл хувийн хүрээнд хийсэн эсэхийг харилцан харгалзахаас гадна бэлэглэгч, бэлэг хүлээн авагчийг өөрөө өдөөн хатгасан эсэх, бэлэг хүлээн авагчийн үйлдлийг хувь хүний хувьд ойлгох боломжтой байсан эсэхийг харгалзаж” тогтоож байна. Түүнчлэн ИХ-ийн 280 дугаар зүйлийн 280.1.1 зүйлийн бүрэлдэхүүн нь (1) бэлэглэгч нь гомдсон байх; (2) гомдсон үйлдэл нь ноцтой байхыг шаардаж байна. Харин дээрх маргааныг шийдвэрлэхдээ анхан болон давж заалдах шатны шүүх дээрх шаардлага, бүрэлдэхүүнийг анхаарч үзээгүй, шийдвэртээ тодорхой тусгаагүй байна.

Архи уусан үедээ бэлэглэгч нарт агсан тавьсан, өвчтэй байгаа эцгээ орон дээрээс унагасан үйлдлийг бэлэглэгч хүлцэн тэвчих боломжтой эсэх, ямар шалтгааны улмаас агсан тавьж, орноос унагасан эсэх, энэхүү үйлдлүүдэд бэлэглэгчийн үйлдэл нөлөөлсөн эсэх, бэлэглэгч гомдоох үйлдлийг гаргахад санаатай нөлөөлсөн эсэхийг тодруулж, анхаарах ёстой байсан. Хэргийн үйл баримтаас харахад агсан тавьсан үйлдэл болон өвчтэй эцгээ орноос унагасан үйлдэлд бэлэглэгч нөлөөлөөгүй, агсан тавих болсон үйлдлийн шалтгаан нөхцөл нь бэлэглэгч нарын санаатай үйлдэл байгаагүй байна. Гэхдээ агсан тавих болон эцгээ орноос унагахдаа бэлэглэгч нарын бие, эрүүл мэндэд сөргөөр нөлөөлсөн эсэх, хэл амаар доромжилж нэр хүнд, байр суурьд нь сөргөөр нөлөөлсөн эсэх, эд хөрөнгөд нь хохирол учруулсан эсэх, ямар өвчтэй хүнийг орноос унагасан эсэх нь тогтоогдоогүй, тодорхой бус, нэхэмжлэгч нар нотлох үүргээ гүйцэтгээгүй байна. Иймээс энэхүү үйлдлийг гомдоосон ноцтой үйлдэл гэж дүгнэсэн анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдвэр үндэслэлгүй болсон гэж үзэж байна.

**2.1.5. Бэлэглэгч болон хүүхдийн биед халдаж, сэтгэл санааны гүн дарамтад оруулсан үйлдэл нь бэлэглэгчийг гомдоосон ноцтой үйлдэл мөн эсэхтэй холбоотой шүүхийн шийдвэр (Улсын Дээд шүүхийн 2022 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн 568 дугаартай тогтоол)**

*Хэргийн үйл баримт:*

Нэхэмжлэгч нь гурван өрөө орон сууцны өөрт ногдох хэсгээс 30 хувийг хариуцагч М-д 2019 оны 07 дугаар сарын 29-ний өдөр бэлэглэжээ. Нэхэмжлэгч нь М бэлэглэгчийг ноцтой гомдоосон үйлдэл хийсэн гэж тайлбарлан ИХ-ийн 280 дугаар зүйлийн 280.1.1 дэх заалтыг үндэслэн хариуцагч М-тэй байгуулсан “Бэлэглэлийн гэрээ”-г хүчингүй болгуулах нэхэмжлэлийг гаргажээ.

*Анхан шатны шүүхийн шийдвэр:*

Хан-Уул дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн 00707 тоот шийдвэрийн үндэслэх хэсэгт, “Хариуцагч М нь нэхэмжлэгч болон хүү Ч нарын бие махбодод халдах, сэтгэл санааны гүн дарамтад оруулах үйлдлийг удаа дараа гаргасан нь ноцтой гомдоосон үйлдлийн үндсэн шинж чанарт хамаарна гэж тайлбарлаж байх боловч гомдооно гэдэг нь тухайн этгээд буюу бэлэглэгчийн нийгэмд эзлэх байр суурьд сөргөөр нөлөөлөхийг хэлнэ. Нөгөө талаар бэлэглэгчийн нийгэмд эзлэх байр суурь, нэр хүнд, эсхүл бэлэглэгч, бэлэг хүлээн авагчийн садан төрлийн байдал, гомдоосон үйлдлийг нийгэмд ил, эсхүл хувийн хүрээнд хийсэн эсэхийг харилцан харгалзахаас гадна бэлэглэгч, бэлэг хүлээн авагчийг өөрөө өдөөн хатгасан эсэх, бэлэг хүлээн авагчийн үйлдлийг хувь хүний хувьд ойлгох боломжтой байсан эсэхийг харгалзах бөгөөд хэргийн баримтаас харахад дээр дурдсан үндэслэл тогтоогдохгүй байна. Зохигчдын тайлбар, хэргийн үйл баримтаас маргаан бүхий орон сууцыг нэхэмжлэгч М, хариуцагч М нар орон

сууцны ипотекийн зээлд хамрагдаж худалдан авсан, банкнаас зээлж авсан мөнгөнөөс хариуцагч М БНСУ-д ажиллаж байхдаа мөнгө явуулж төлж байсныг нэхэмжлэгч тал үгүйсгээгүй, хамт амьдрах хугацаандаа буй болгосон хөрөнгө гэж үзэхээр байна” гэж үзэж нэхэмжлэлийн шаардлагыг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэжээ.

*Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн магадлал:*

Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх 2020 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн 1100 тоот магадлалын хянавал хэсэгт, “Хариуцагч М нь нэхэмжлэгч М болон хүүгийнх нь бие махбодод халдаж, сэтгэл санааны гүн дарамтад оруулсан гэх агуулгаар нэхэмжлэлийн шаардлагын үндэслэлээ тайлбарлажээ. Гэвч бэлэг хүлээн авагч бэлэглэгчийг ноцтой гомдоосон, бие махбодод халдсан, хүүгийнх нь эрүүл мэндэд халдсан гэх нөхцөл байдлыг эргэлзээгүйгээр нотолсон баримт хэрэгт авагдаагүй байна. Өөрөөр хэлбэл, нэхэмжлэгч нэхэмжлэлийн шаардлагын үндэслэлээ Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2.2, 38 дугаар зүйлийн 38.1 дэх хэсэгт заасны дагуу баримтаар нотлох үүргээ хэрэгжүүлээгүй гэж үзнэ. Зохигчид хамтран амьдрах хугацаанд хоорондын таарамжгүй харилцаанаас үүдэн эд хөрөнгийн маргаан үүссэн, уг орон сууцыг худалдан авахад оруулсан хөрөнгийн хэмжээний талаар нэхэмжлэлийн шаардлага, хариуцагчийн татгалзлаа тайлбарлаж байгаа нь ИХ-ийн 280 дугаар зүйлийн 280.1.1-д бэлэг хүлээн авагч нь бэлэглэгчийг гомдоосон ноцтой үйлдэл гаргасан гэх үндэслэлд хамаарахгүй болно” гэж дурдаж, анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээж шийдвэрлэсэн.

*Хяналтын шатны шүүхийн тогтоол:*

Улсын Дээд шүүх тогтоолынхоо хянавал хэсэгт, “Зохигчийн хооронд үүссэн маргааны үндэслэлээс үзвэл, нэхэмжлэгч

хариуцагчийн бие махбодод халдсан үйлдэл гаргаж ноцтой гомдоосон гэсэн, хариуцагч энэ үйлдлийг гаргасан нь тогтоогдсон боловч уг үйлдлийн хүрээнд “бэлэглэлийн гэрээ”-г хүчингүй болгох үндэслэл тогтоогдоогүй, тухайн бэлэглэлийн гэрээний зүйл нь нэхэмжлэгчийн буцаан шаардах хөрөнгөд хамаарахгүй байна. Бэлэглэлийн гэрээгээр шилжүүлж буй хөрөнгө болох орон сууц нь зөвхөн нэхэмжлэгч М, хүү Ч нарын өмч байсан бөгөөд тэд хөрөнгөө хуулиар олгогдсон хэмжээ, хязгаарын дотор өөрийн үзэмжээр чөлөөтэй захиран зарцуулах эрхийн хүрээнд хариуцагчид үнэ төлбөргүй шилжүүлсэн бус, уг хөрөнгө нэхэмжлэгч М, хариуцагч М нарын хамтын амьдралын явцад хамтын хөрөнгөөр шинээр бий болсон нь тогтоогдсон, хариуцагч хамтран өмчлөгчөөр бүртгэгдээгүй байсан нь түүний 20162019 онуудад БНСУ-д ажиллаж байсантай холбоотой гэж үзэхээр байх тул бэлэглэлийн гэрээгээр шилжүүлсэн хөрөнгийн хувьд хариуцагчийн гаргасан үйлдэлтэй холбож гэрээг хүчингүй болгох шаардах эрх үүсэхгүй байна” гэж үзэж, магадлалыг хэвээр үлдээж шийдвэрлэжээ.

### **Шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээ:**

Шүүхийн шийдвэрээр хөндөгдөж буй асуудал: Нэхэмжлэгч нь 2019 оны 07 дугаар сарын 29-ний өдөр гурван өрөө орон сууцны 30 хувийг өөрт ногдох хэсгээс бэлэглэх гэрээгээр хариуцагч М-д бэлэглэжээ. Нэхэмжлэгч нь хариуцагч М бэлэглэгчийг ноцтой гомдоосон үйлдэл хийсэн гэж тайлбарлан ИХ-ийн 280 дугаар зүйлийн 280.1.1 дэх хэсэгт заасныг үндэслэн хариуцагч М-тэй байгуулсан “Бэлэглэлийн гэрээ”-г хүчингүй болгуулах нэхэмжлэл гаргасан байна. Энэхүү маргааныг анхан, давах, хяналтын шатны шүүх шийдвэрлэхдээ тухайн бэлэглэлийн зүйл нь бэлэглэгчийн өмчийн хөрөнгө байсан эсэхэд анхаарч шийдвэрлэснээрээ ач холбогдолтой. Бэлэг хүлээн авагч нь бэлэглэгчийн бие махбодод халдсан үйлдэл гаргасныг Улсын Дээд шүүх тогтоожээ. Гэвч



тухайн бэлэглэлийн зүйл болох орон сууцыг худалдан авахад бэлэг хүлээн авагчийн оролцоо, үүрэг байсан эсэхийг шүүх тодруулсан нь маргааныг үндэслэлтэй шийдвэрлэхэд нөлөөлжээ.

Хяналтын шатны шүүх тогтоолынхоо хянах хэсэгт “*тухайн бэлэглэлийн гэрээний зүйл нь нэхэмжлэгчийн буцаан шаардах хөрөнгөд хамаарахгүй байна. Бэлэглэлийн гэрээгээр шилжүүлж буй хөрөнгө болох орон сууц нь зөвхөн нэхэмжлэгч М, хүү Ч нарын өмч байсан тэд хөрөнгөө хуулиар олгогдсон хэмжээ, хязгаарын дотор өөрийн үзэмжээр чөлөөтэй захиран зарцуулах эрхийн хүрээнд хариуцагчид үнэ төлбөргүй шилжүүлсэн бус, уг хөрөнгө нэхэмжлэгч М, хариуцагч М нарын хамтын амьдралын явцад хамтын хөрөнгөөр шинээр бий болсон нь тогтоогдсон*” гэж дүгнэсэн. Энэхүү дүгнэлтээс харахад хэдийгээр нэхэмжлэгч нь ИХ-ийн 280 дугаар зүйлийн 280.1.1-д заасан үндэслэлээр бэлэглэлийн гэрээг хүчингүй болгохоор шаардсан боловч шүүхийн зүгээс тухайн маргаан бүхий хөрөнгө нь бэлэглэлийн гэрээний зүйл байсан эсэхийг хянан үзсэн.

Дүгнэн шинжилж үзвэл, бэлэглэгч нь өөрийн эд хөрөнгийн өмчлөх эрхийг бусад этгээдэд үнэ төлбөргүйгээр буюу хариу төлбөргүйгээр шилжүүлж байгаа тал юм.<sup>15</sup> Бэлэглэх гэдэг нь бэлэглэгчийн хөрөнгө багасаж, бэлэг хүлээн авагчийн хөрөнгө тэр хэмжээгээр нэмэгдэж буй зөрүүг ойлгоно.<sup>16</sup> *Зохигчдын тайлбар, хэргийн үйл баримтаас маргаан бүхий орон сууцыг нэхэмжлэгч М, хариуцагч М нар орон сууцны ипотекийн зээлд хамрагдаж худалдан авсан, банкнаас зээлж авсан мөнгөнөөс хариуцагч М БНСУ-д ажиллаж байхдаа мөнгө явуулж төлж байсныг нэхэмжлэгч тал үгцүйсгээгүй, хамт амьдрах хугацаандаа буй болгосон хөрөнгө гэж дүгнэжээ. Үүнээс харахад хэдийгээр хэлцлийн агуулга нь бэлэглэлийн гэрээгээр орон сууцны зарим хэсгийг шилжүүлж байгаа боловч хариуцагч М, нэхэмжлэгч М*

<sup>15</sup> Ж.Оюунтунгалаг, Иргэний эрх зүй II: Гэрээний үүрэг, 2022, 161 дэх тал.

<sup>16</sup> Б.Буянхишиг, Иргэний эрх зүйн тусгай анги: Гэрээний эрх зүй, 2015, 108 дахь тал.

нарын хамтран амьдрах хугацаандаа бий болгосон хөрөнгө тул нэхэмжлэгч М-ын бэлэглэлийн гэрээгээр шилжүүлсэн орон сууц нь хариуцагчийн БНСУ-д ажиллаж байхдаа төлж авсан орон сууц байна. Иймээс тухайн бэлэглэлийн гэрээний хөрөнгө нь нэхэмжлэгчийн буцаан шаардах зүй ёсны хөрөнгө биш. Харин хариуцагч БНСУ-д ажиллаж байхдаа банкны зээлийг төлж, өмчийн өмчлөх эрхийг олж авахад хариу төлбөртэй оролцсон нь хөрөнгийн өмчлөгч болохыг илтгэж байна. Энэхүү агуулгаараа татвараас зайлсхийх, урьд нь орон сууц худалдан авахад оруулсан хөрөнгийг үнэлж, хариуцагч М-д “Бэлэглэлийн гэрээ”-гээр орон сууцны зарим хэсгийг шилжүүлж, хамтран өмчлөгчөөр бүртгүүлжээ. Иймээс шүүхийн шийдвэрүүд үндэслэлтэй болсон байна.

**2.1.6. Бэлэглэгчийн биед халдаж, олон жилийн турш тарчлаан зовоосон үйлдэл нь бэлэглэгчийг гомдоосон ноцтой үйлдэл эсэхтэй холбоотой шүүхийн шийдвэр (Дүцргийн иргэний хэргийн анхан шатны 2 дугаар шүүхийн 2014 оны 06 сарын 02-ны өдрийн 2335 тоот шийдвэр)**

*Хэргийн үйл баримт:*

Нэхэмжлэгч нь хариуцагчтай 2008 оны 2 дугаар сараас эхлэн хамтран амьдарч эхэлжээ. Нэхэмжлэгч нь хамтран амьдрах хугацаандаа өөрийн өмчлөлийн 22,500,000 төгрөгөөр автомашин худалдан авч хариуцагчид бэлэглэжээ. Гэтэл хариуцагчийг Өвөрхангай аймгийн сум дундын 1 дүгээр шүүхийн 2013 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн 1/103 дугаар шийтгэх тогтоолоор нэхэмжлэгчийг 2009 оны 03 дугаар сараас 2013 оны 3 дугаар сар хүртэл 4 жилийн хугацаанд удаа дараа зодож, тарчлаах шинжтэй үйлдэл хийж, бие махбодод нь хөнгөн гэмтэл санаатай учруулсан гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож, 4 сар баривчлах ялаар шийтгэх тогтоол гарч, хүчин төгөлдөр болжээ.

Нэхэмжлэгчийн хувьд энэхүү олон жилийн турш биед халдсан тарчлаасан үйлдэлд нь гомдсон тул ИХ-ийн 280 дугаар зүйлийн 280.1.1-д заасан үндэслэлээр бэлэглэлийн гэрээг хүчингүйд тооцуулах нэхэмжлэлийг гаргасан байна.

*Анхан шатны шүүхийн шийдвэр:*

Дүүргийн Иргэний хэргийн анхан шатны 2 дугаар шүүх 2014 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 2335 тоот шийдвэрийнхээ үндэслэх хэсэгт, “ИХ-ийн 276 дугаар зүйлийн 276.1-д “Бэлэглэлийн гэрээгээр бэлэглэгч нь бэлэг хүлээн авагчийн зөвшөөрснөөр түүний өмчлөлд тодорхой хөрөнгө хариу төлбөргүй шилжүүлнэ” гэж зааснаар нэхэмжлэгч нь “Ниссан Экстерра” маркийн, 00-00 УБЯ улсын дугаартай автомашиныг өөрийн хөрөнгөөр худалдан авч, хариуцагчийн өмчлөлд хариу төлбөргүй шилжүүлсэн байх тул талуудын хооронд бэлэглэлийн гэрээний харилцаа үүссэн гэж үзэх үндэслэлтэй байна. ИХ-ийн 280 дугаар зүйлийн 280.1-д бэлэг хүлээн авагч нь бэлэглэгчийг гомдоосон ноцтой үйлдэл хийсэн, эсхүл бэлэг хүлээн авагч нь бэлэглэгчийн, эсхүл түүний төрөл төрөгсдийн эрүүл мэнд, амь насыг санаатай хохироосон буюу хохироохыг завдсан тохиолдолд бэлэглэгч бэлэглэлийг хүчингүй болгохоор бэлэг хүлээн авагчаас шаардаж болохоор заажээ. Өвөрхангай аймаг дахь сум дундын 1 дүгээр шүүхийн 2013 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн 1/103 дугаар шийтгэх тогтоолоор хариуцагч нэхэмжлэгч Д-г 2009 оны 3 дугаар сараас 2013 оны 3 дугаар сар хүртэл хугацаанд удаа дараа зодож, тарчлаах шинжтэй үйлдэл хийж, бие махбодод нь хөнгөн гэмтэл санаатай учруулсан гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож, 4 сар баривчлах ялаар шийтгэсэн байх бөгөөд шүүхийн шийтгэх тогтоол хүчин төгөлдөр байна. Хариуцагч нэхэмжлэгчийг гомдоосон ноцтой үйлдэл хийсэн нь шүүхийн хүчин төгөлдөр шийтгэх тогтоолоор тогтоогдож байх тул нэхэмжлэгч нь ИХ-ийн 280 дугаар зүйлийн 280.1.1-

д зааснаар бэлэглэлийг хүчингүй болгуулахаар хариуцагчаас шаардах эрхтэй байна” гэж нэхэмжлэлийг бүхэлд нь хангаж шийдвэрлэжээ.

### **Шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээ:**

Шүүхийн шийдвэрээр хөндөгдөж буй асуудал: Энэхүү маргааны үйл баримтаас харахад нэхэмжлэгч нь хамтран амьдрагч Б-тай 4 жилийн хугацаанд хамтран амьдрахдаа өөрийн өмчлөлийн 22,500,000 төгрөгөөр автомашин худалдан авч, хариуцагчид бэлэглэжээ. Харин хариуцагч автомашиныг шилжүүлэн авснаас хойш нэхэмжлэгчийн биед халдаж, тарчлаах үйлдлийг удаа дараа үйлдсэн нь шүүхийн шийтгэх тогтоолоор тогтоогдож, шийтгэл хүлээсэн байна. Анхан шатны шүүх энэхүү үйл баримтыг үнэлэн, нэхэмжлэгчийн биед халдсан нь шүүхээр тогтоогдсон тул ИХ-ийн 280 дугаар зүйлийн 280.1.1 дүгээр зүйлд заасны дагуу “Бэлэглэлийн гэрээ”-г хүчингүйд тооцжээ. Энэхүү шийдвэрээр анхан шатны шүүх маргааныг шийдвэрлэхдээ бэлэг хүлээн авагч нь бэлэглэгчийн амь нас, эрүүл мэндэд халдсан үйлдлийг ноцтой гомдоосон үйлдэл гэж үзэж, гэрээг хүчингүйд тооцсоноороо ач холбогдолтой. Шүүхийн практикаас харахад шүүх бүр гомдоосон ноцтой үйлдэл гэдгийг харилцан адилгүй үзэж байгаа боловч ихэнх тохиолдолд бэлэг хүлээн авагчийн үйлдэл нь эрх бүхий байгууллагаар тогтоогдсон бол гомдоосон ноцтой үйлдэл мөн гэж үзэж, шийдвэрлэж байна.

Нэхэмжлэгч нь нэхэмжлэлдээ ИХ-ийн 280 дугаар зүйлийн 280.1.1-д заасан бэлэг хүлээн авагч нь бэлэглэгчийг гомдоосон ноцтой үйлдэл хийсэн гэж үзэж шаардлагаа тодорхойлсон байна. Шүүх энэхүү нэхэмжлэлийн шаардлагын хүрээнд шийдвэрлэжээ. Харин ИХ-ийн 280 дугаар зүйлийн 280.1-д бэлэглэлийн гэрээг хүчингүйд тооцож болох хоёр үндэслэлийг тусгайлан зааж өгчээ. Хоёр дахь үндэслэл нь, “бэлэг хүлээн авагч нь бэлэглэгчийн, эсхүл түүний төрөл төрөгсдийн эрцүл мэнд, амь насыг хохироосон,

хохиоохыг завдсан” үйлдэл юм. Энэ зүйлээс харахад нэгдүгээрт, бэлэглэгчийн эрүүл мэндэд гэмтэл буюу хохирол учруулсан, эсхүл амь насыг хохироосон, хохироохыг завдсан, хоёрдугаарт, бэлэглэгчийн төрөл төрөгсдийн эрүүл мэндэд гэмтэл буюу хохирол учруулсан, эсхүл амь насыг хохироосон, хохироохыг завдсан үйлдлүүдийг багтаажээ. Өвөрхангай аймаг дахь сум дундын 1 дүгээр шүүхийн 2013 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн 1/103 дугаар шийтгэх тогтоолоор хариуцагч нэхэмжлэгч Д-г 2009 оны 3 дугаар сараас 2013 оны 3 дугаар сар хүртэл хугацаанд удаа дараа зодож, тарчлаах шинжтэй үйлдэл хийж, бие махбодод нь хөнгөн гэмтэл санаатай учруулсан гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож, 4 сар баривчлах ялаар шийтгэсэн байгаа баримтаас харахад ИХ-ийн 280 дугаар зүйлийн 280.1.1 дэх заалтыг хэрэглэж гэрээг хүчингүйд тооцохоос илүү мөн зүйлийн 280.1.2 дахь үндэслэлийг баримтлах нь үндэслэлтэй байсан гэж үзэж байна. Учир нь бэлэг хүлээн авагч нь бэлэглэгчийн биед хөнгөн гэмтэл санаатай учруулсан байх ба энэхүү үйлдэл нь бэлэглэгчийн эрүүл мэндэд халдсан үйлдэл мөн тул ИХ-ийн 280 дугаар зүйлийн 280.1.2-д заасан зохицуулалтыг хэрэглэх үндэслэл болно.

## **2.2. ГЭР БҮЛИЙН ГИШҮҮДИЙН ХАМТРАН ӨМЧЛӨХ ДУНДЫН ЭД ХӨРӨНГИЙГ БУСДАД БЭЛЭГЛЭСЭН БОЛОН ХАЛХАВЧИЛЖ ХИЙСЭН ХЭЛЦЭЛТЭЙ ХОЛБООТОЙ МАРГААНЫГ ШИЙДВЭРЛЭСЭН ШҮҮХИЙН ШИЙДВЭРТ ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ**

### **2.2.1. Бэлэглэгч нь гэр бүлийн маргаан шүүхээр хянан шийдвэрлэж байх явцад гэр бүлийн гишүүдийн дундын хөрөнгийг бусдад бэлэглэсэнтэй холбоотой шүүхийн шийдвэр (Улсын Дээд шүүхийн 2018 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн 01379 дугаартай тогтоол)**

*Хэргийн үйл баримт:*

Нэхэмжлэгч нь М-д холбогдуулан гэр бүл цуцлуулах, хүүхдийн асрамж, тэтгэлэг тогтоолгож, дундын эд хөрөнгөөс өөрт болон хоёр хүүхдэд ногдох хэсгийг гаргуулахаар нэхэмжлэл гаргасан ба хэргийг эцэслэн шийдвэрлээгүй байхад хариуцагч М нь маргаантай орон сууц болох үл хөдлөх эд хөрөнгийн зарим хэсгийг А-д бэлэглэлийн гэрээгээр шилжүүлсэн байна. Гэр бүлийн гишүүдийн дундын эд хөрөнгийн маргаантай байхад зарим хэсгийг бэлэглэлийн гэрээгээр бусдад шилжүүлснээс гэр бүлийн бусад гишүүдэд ногдох хэсэгт өөрчлөлт орох тул М болон А нарын хооронд хийгдсэн бэлэглэлийн гэрээг хүчин төгөлдөр бусд тооцож, улсын бүртгэлийн гэрчилгээнд өөрчлөлт оруулж өгнө үү гэсэн нэхэмжлэлийг гаргасан байна.

Хариуцагч хариу тайлбартаа, *“Бид гэрлэлтээ бүртгүүлснээс хойш Голомт банктэй орон сууцны зээлийн гэрээ байгуулж, байрыг худалдан авсан хэдий ч миний ээж А зээлийг төлдөг байсан”* гэж дурджээ.

*Анхан шатны шүүхийн шийдвэр:*

Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх 2019 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн 389 тоот шийдвэрийн үндэслэх хэсэг, *“Уг орон сууцны үнийг төлөхөөр гэрлэгчид 2010 оны 11 дүгээр сарын 18-нд “Голомт банк” ХХК-аас 30,000,000 төгрөгийг зээлсэн. Уг зээлийн гэрээний үүргийг хариуцагч А, М нар төлж барагдуулан биелүүлсэн талаар зохигчид маргаагүй байна. ИХ-ийн 128 дугаар зүйлийн 128.2, 128.3-д “Хуульд өөрөөр заагаагүй бол энэ хуулийн 128.2-д заасны дагуу зөвшөөрөл аваагүй хийсэн хэлцэл хүчин төгөлдөр бус байна” гэж тус тус заасан бөгөөд хариуцагч М нь гэр бүлийн гишүүдийн хамтран өмчлөх дундын эд хөрөнгө болох дээрх үл хөдлөх эд хөрөнгийн зарим хэсгийг бусдад шилжүүлэн бэлэглэхдээ нэхэмжлэгч У-ын бичгээр гаргаж нотариатаар гэрчилүүлсэн зөвшөөрлийг аваагүй байна.*

*Иймд Иргэний хуулийн 56 дугаар зүйлийн 56.1.1, 56.1.8-д заасны дагуу бэлэглэлийн гэрээг хүчин төгөлдөр бус хэлцэл гэж үзэх үндэслэлтэй” гэж дурдан, нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хангаж шийдвэрлэжээ.*

*Нийслэлийн Иргэний хэргийн Давж заалдах шатны шүүхийн магадлал:*

*Нийслэлийн Иргэний хэргийн Давж заалдах шатны шүүх 2019 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн 915 тоот магадлалын хянавал хэсэгт, “Хариуцагч М уг хөрөнгийн өмчлөх эрхийн 50 хувийг гэр бүлийн насанд хүрсэн гишүүний зөвшөөрөл авахгүйгээр хариуцагч А-д бэлэглэж, түүнийг өмчлөгчөөр улсын бүртгэлд нэмж бүртгүүлсэн болох нь бэлэглэлийн гэрээ, үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээ зэрэг баримтаар тогтоогджээ. Дээрх бэлэглэлийн гэрээ нь Иргэний хуулийн 128 дугаар зүйлийн 128.2 дахь заалтыг зөрчсөн байх тул мөн зүйлийн 128.3 дахь заалтаар хүчин төгөлдөр бус хэлцэл гэж үзнэ” хэмээн дурдаж, анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээж, шийдвэрлэсэн байна.*

*Хяналтын шатны шүүхийн тогтоол:*

*Улсын Дээд шүүх тогтоолынхоо хянавал хэсэгт, “Гэрлэлтийг бүртгэсэн өдрөөс эхлэн гэрлэгчдийн эрх, үүрэг үүсэх бөгөөд гэрлэгчид, гэр бүлийн бусад гишүүний хэн нэгний нэр дээр байгаагаас үл шалтгаалан гэрлэснээс хойш бий болсон хөрөнгө нь гэр бүлийн гишүүдийн хамтран өмчлөх дундын өмчид хамаарна. Гэр бүлийн гишүүдийн хэн нэг нь хамтран өмчлөх дундын өмчийн үл хөдлөх эд хөрөнгийг захиран зарцуулахад гэр бүлийн насанд хүрсэн гишүүний бичгээр гаргаж, нотариатаар гэрчлүүлсэн зөвшөөрлийг авах тухай заасан бөгөөд энэ шаардлагыг хангаагүй гэрээ хуульд зааснаар хүчин төгөлдөр бус юм” гэж анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээж шийдвэрлэсэн байна.*

### **Шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээ:**

Шүүхийн шийдвэрээр хөндөгдөж буй асуудал: Нэхэмжлэгч нь М-д холбогдуулан гэр бүл цуцлуулах, хүүхдийн асрамж, тэтгэлэг тогтоолгож, дундын эд хөрөнгөөс өөрт болон хоёр хүүхдэд ногдох хэсгийг гаргуулахаар нэхэмжлэл гаргажээ. Хэргийг эцэслэн шийдвэрлээгүй байхад М нь 2018 оны 09 дүгээр сарын 05-ны өдөр маргаантай орон сууц болох үл хөдлөх эд хөрөнгийн зарим хэсгийг А-д бэлэглэлийн гэрээгээр шилжүүлсэн байна. Гэр бүлийн дундын эд хөрөнгийн маргаантай байхад зарим хэсгийг бэлэглэлийн гэрээгээр бусдад шилжүүлснээс гэр бүлийн бусад гишүүнд ногдох хэсэгт өөрчлөлт орох тул М болон А нарын хооронд хийсэн бэлэглэлийн гэрээг хүчин төгөлдөр бусд тооцож, улсын бүртгэлийн гэрчилгээнд өөрчлөлт оруулж өгнө үү гэсэн нэхэмжлэлийг гаргасан байна. Энэхүү маргааныг гурван шатны шүүх эцэслэн шийдвэрлэсэн бөгөөд анхан шатны шүүх, давж заалдах шатны шүүх, хяналтын шатны шүүх нэхэмжлэлийг хангаж шийдвэрлэжээ.

Энэхүү маргааныг шийдвэрлэсэн шийдвэрийн ач холбогдол нь гэр бүлийн хамтран өмчлөх дундын эд хөрөнгийг бэлэглэлийн гэрээний дагуу шилжүүлэхэд гэр бүлийн гишүүдийн бичгээр гаргасан зөвшөөрлийн үндсэн дээр шилжүүлэх, хэрэв бичгээр зөвшөөрөл аваагүй бол тухайн бэлэглэлийн гэрээ хүчин төгөлдөр бус болохыг дүгнэж, шийдвэрлэсэнээрээ ач холбогдолтой байна. Нөгөө талаас, шүүхийн практикт хамтран өмчлөх дундын эд хөрөнгийн хуваарилалттай холбоотой маргааныг эцэслэн шийдвэрлээгүй байх үед тухайн хөрөнгийг бусдад худалдах, ойр дотнын хүмүүстээ бэлэглэлийн журмаар шилжүүлэх үйлдлийг гаргадаг. Энэ тохиолдолд гэр бүлийн гишүүдийн өмчийн эрх зөрчигдөх тул тэрхүү өмчийн эрхийг хэрхэн хамгаалах зохицуулалт ИХ-д тусгагджээ. Иймд энэхүү маргаан нь бэлэглэлийн гэрээний зүйл буюу хамтран өмчлөх дундын эд хөрөнгийг бусдад бэлэглэх



бол хууль зүйн ямар шаардлагыг хангаж байж, гэрээ хүчин төгөлдөр болохыг шийдвэрлэснээрээ онцлогтой.

Хэргийн үйл баримтаас харахад (1) зохигчид гэрлэлтээ хууль ёсны дагуу батлуулж, гэрлэлтийн гэрчилгээ авсан, гэр бүл мөн; (2) маргаан бүхий орон сууцны үнийг 2010 оны 11 дүгээр сарын 18-нд “Голомт банк” ХХК-аас 30,000,000 төгрөгийг зээлж төлсөн байх бөгөөд зээлийн гэрээний дагуу зохигчид үндсэн зээл, хүүг хугацаандаа төлж, гэрээг дуусгавар болгосон байна. Энэхүү үйл баримтуудыг анхан, давах, хяналтын шатны шүүхүүд зөв дүгнэж, шийдвэртээ тусгажээ. Хариуцагч нь хариу тайлбартаа, *“Бид гэрлэлтээ бүртгүүлснээс хойш Голомт банкттай орон сууцны зээлийн гэрээ байгуулж, байрыг худалдан авсан хэдий ч миний ээж А зээлийг төлдөг байсан”* гэж хэлдэг боловч энэхүү үйл баримт нь бэлэглэлийн гэрээний зүйл болох хамтран өмчлөх дундын эд хөрөнгийг гэр бүлийн гишүүдийн зөвшөөрөлгүйгээр шилжүүлэх үндэслэл биш. Харин хариуцагчийн ээж А нь тухайн орон сууцыг худалдан авахад хөрөнгө оруулсан гэж үзвэл үүнтэй холбоотой маргаанаа Иргэний шүүхэд хандаж шийдвэрлүүлэх боломжтой. Иймээс энэхүү үйл баримтыг шүүхийн зүгээс зөв дүгнэн, шийдвэрлэсэн байна.

Бэлэглэлийн гэрээний зүйл маргаан хэрхэн шийдвэрлэгдэхэд нөлөөлсөн байна. Гэр бүлийн хөрөнгийг ИХ-ийн Гуравдугаар дэд бүлгээр зохицуулж байна. ИХ-ийн 126 дугаар зүйлийн 126.1-д *“Гэрлэснээс хойш хамтран амьдарсан хугацаанд бий болсон гэр бүлийн гишүүдийн хуваарьт хөрөнгөөс бусад хөрөнгө нь гэр бүлийн гишүүдийн хамтран өмчлөх дундын өмч мөн”* гэж зохицуулжээ. Бэлэглэлийн гэрээгээр шилжүүлсэн орон сууц нь зохигчдын гэрлэлтээ батлуулснаас хойших хугацаанд бий болсон гэр бүлийн хамтран өмчлөх дундын эд хөрөнгө мөн байна. Түүнчлэн ИХ-ийн 126.4-д *“Гэрлэснээс хойш гэр ахуйн ажил эрхэлсэн, хүүхэд асарсан, өвчтэй байсан болон хүндэтгэн үзэх*

*бусад шалтгаанаар орлого олоогүй байсан эхнэр, нөхөр, гэр бүлийн бусад гишүүн хөрөнгөө хамтран өмчлөх эрх эдэлнэ*” гэж зааснаар нэхэмжлэгч нь хүүхдээ асарсан нь гэр бүлийн гишүүдийн хамтран өмчлөх дундын эд хөрөнгийн өмчлөгч болоход саад учруулах нөхцөл биш болно. Иймд бэлэглэлийн гэрээний зүйл нь гэр бүлийн гишүүдийн хамтран өмчлөх дундын эд хөрөнгө мөн байна. Улсын Дээд шүүх тогтоолынхоо хянавал хэсэгт, “Гэрлэлтийг бүртгэсэн өдрөөс эхлэн гэрлэгчдийн эрх, үүрэг үүсэх бөгөөд гэрлэгчид, гэр бүлийн бусад гишүүний хэн нэгний нэр дээр буйгаас үл шалтгаалан гэрлэснээс хойш бий болсон хөрөнгө нь гэр бүлийн гишүүдийн хамтран өмчлөх дундын өмчид хамаарна. Гэр бүлийн гишүүдийн хэн нэг нь хамтран өмчлөх дундын өмчийн үл хөдлөх эд хөрөнгийг захиран зарцуулахад гэр бүлийн насанд хүрсэн гишүүний бичгээр гаргаж, нотариатаар гэрчлүүлсэн зөвшөөрлийг авах тухай заасан бөгөөд энэ шаардлагыг хангаагүй гэрээ хуульд зааснаар хүчин төгөлдөр бус юм” гэж дүгнэсэн нь үндэслэл бүхий байна.

Учир нь ИХ-ийн 126 дугаар зүйлийн 126.2.4-д “гэрлэгчид, гэр бүлийн бусад гишүүний хэн нэгний нэр дээр буйгаас үл шалтгаалан гэрлэснээс хойш бий болсон бусад хөрөнгө” гэр бүлийн гишүүдийн хамтран өмчлөх дундын эд хөрөнгө байхаар зохицуулжээ. Иймээс хариуцагчийн нэр дээр орон сууцны өмчлөл байгаагаас үл хамааран тухайн эд хөрөнгө нь гэрлэснээс хойш бий болсон хөрөнгө тул гэр бүлийн гишүүдийн хамтран өмчлөх дундын эд хөрөнгө гэж үзнэ. Гэр бүлийн хамтран өмчлөх дундын эд хөрөнгийг захиран зарцуулахад ИХ-д заасан тусгай журам үйлчилнэ. ИХ-ийн 128 дугаар зүйлийн 128.1-д “Гэр бүлийн гишүүд нь хамтран өмчлөх дундын эд хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулах адил эрх эдэлж, **харилцан тохиролцсоны үндсэн дээр эд хөрөнгөө эзэмшиж, ашиглаж, захиран зарцуулна**”, 128.2-д “Гэр бүлийн гишүүдийн хэн нэг нь хамтран өмчлөх дундын өмчийн үл хөдлөх эд хөрөнгөө **захиран**

**зарцуулахдаа гэр бүлийн насанд хүрсэн гишүүний бичгээр гаргаж, нотариатаар гэрчлүүлсэн зөвшөөрлийг авна**”, 128.3-т “Хуульд өөрөөр заагаагүй бол энэ хуулийн 128.2-д заасны дагуу зөвшөөрөл аваагүй хийсэн хэлцэл хүчин төгөлдөр бус байна” гэж зохицуулсан. Дээрх хуулийн зохицуулалтаас харахад хариуцагч нь гэр бүлийн гишүүдийн хамтран өмчлөх дундын эд хөрөнгө болох орон сууцыг бэлэглэхдээ нэхэмжлэгчид мэдэгдээгүй, харилцан тохиролцоогүй, түүнээс бичгээр зөвшөөрөл авч, хууль ёсны дагуу нотариатаар батлуулаагүй зөрчлийг гаргажээ.

ИХ-ийн 56 дугаар зүйлд хэлцэл хүчин төгөлдөр бус болох нөхцөлүүдийг зааж өгсөн байдаг. Тус хуулийн 56 дугаар зүйлийн 56.1.8-д “**хуульд заасан тохиолдолд зохих этгээдийн зөвшөөрөлгүй хийсэн хэлцэл**” хүчин төгөлдөр бус байна. Хуульд заасан тохиолдол гэдэгт ИХ-ийн 128 дугаар зүйлийн 128.1.2, 128.1.3 дахь зохицуулалт хамаарна. Өөрөөр тайлбарлавал, хуульд тусгайлан зохих этгээдээс зөвшөөрөл авах тухай, аваагүй тохиолдолд хэлцэл хүчин төгөлдөр бус болох тухай заасан заалтыг зөрчсөн бол тухайн хэлцэл нь хүчин төгөлдөр бус болох үр дагавартай. Хариуцагч нь гэр бүлийн гишүүдийн хамтран өмчлөх дундын эд хөрөнгийг бусад этгээдэд бэлэглэхдээ нэхэмжлэгчийн бичгэн зөвшөөрлийг аваагүй нь хэлцлийг хүчин төгөлдөр бус гэж үзэхэд хүргэсэн байна. Иймд анхан, давах, хяналтын шатны шүүхийн шийдвэр нь үндэслэл бүхий болсон байна.

**2.2.2. Бэлэглэлийн гэрээ байгуулж, худалдах, худалдан авах гэрээг халхавчилсан шүүхийн шийдвэр (Улсын Дээд шүүхийн 2019 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн 867 дугаартай тогтоол)**

*Хэргийн үйл баримт:*

Нэхэмжлэгч нь шүүхэд гаргасан нэхэмжлэлдээ амины зориулалттай хоёр газар, үл хөдлөх хөрөнгийг О нь худалдан

авахаар тохиролцож, бэлэглэлийн гэрээ байгуулан өөрийн нэр дээр газар, эд хөрөнгийн эрхийг шилжүүлэн авсан боловч төлбөр мөнгөө өгөхгүй явсаар өнөөдрийг хүртэл биднийг хохироосоор байгаа тул бэлэглэлийн гэрээг хүчингүйд тооцож өгнө үү гэж дурджээ. Хариуцагч шүүхэд гаргасан хариу тайлбартаа, “Бэлэглэлийн гэрээ Иргэний хуулийн 40, 41, 42, 43 дугаар зүйлд заасан талуудын хүсэл зоригийн дагуу хийгдсэн хүчин төгөлдөр гэрээ болно” гэж дурджээ. Бие даасан шаардлага гаргаагүй гуравдагч этгээд “К” банк тайлбартаа, “Хариуцагч О нь 2014 оны 01 дүгээр сарын 31-ний өдөр байгуулсан зээлийн гэрээний дагуу барьцааны гэрээ байгуулж, эдгээр дөрвөн төрлийн эд хөрөнгийг барьцаалсан. Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2015 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 8900 дугаартай шийдвэрээр барьцааны зүйл болох дээрх дөрвөн төрлийн үл хөдлөх эд хөрөнгүүдээс үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар шийдвэрлэжээ. Бэлэглэлийн гэрээнүүдийг хүчин төгөлдөр буст тооцох үндэслэл тогтоогдоогүй байна” гэж дурдсан байна.

*Анхан шатны шүүхийн шийдвэр болон давж заалдах шатны шүүхийн магадлал:*

Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх 2018 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн 2207 тоот шийдвэрээр ИХ-ийн 56 дугаар зүйлийн 56.1.2, 56.1.3, 56.5 дахь хэсэгт заасныг баримтлан нэхэмжлэгч Б болон хариуцагч О нарын хооронд байгуулсан 2013 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн бэлэглэлийн гэрээ болон 2013 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн бэлэглэлийн гэрээнүүдийг тус тус хүчин төгөлдөр бус гэж үзэн нэхэмжлэлийг хангаж шийдвэрлэсэн байна. Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх 2019 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн 80 дугаар магадлалаар анхан шатны шүүхийн шийдвэрийг хянаж үзээд хэвээр үлдээж шийдвэрлэжээ.

*Хяналтын шатны шүүхийн тогтоол:*

Улсын Дээд шүүх тогтоолынхоо хянавал хэсэгт, “Дээрх дөрвөн төрлийн үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрхийг хариу төлбөргүйгээр хариуцагчид шилжүүлэх хүсэл зориг байгаагүй, харин 375,000,000 төгрөгөөр О-д худалдах, О нь Хүнс, хөдөө аж ахуйн яамнаас зарласан төслийн санхүүжилт орж ирсэн цед үнийг төлөхөөр тохиролцсон гэх нэхэмжлэгч нарын тайлбарыг хариуцагч О үгүйсгээгүй боловч эдгээр эд хөрөнгийг барьцаанаас чөлөөлсөн, мөнгө төлсөн гэж нэхэмжлэлийг татгалзсан байдлаа баримтаар нотлоогүй байна. Анхан болон давж заалдах шатны шүүх зохигчийн хооронд байгуулсан бэлэглэлийн гэрээг хүчин төгөлдөр бус хэлцэл гэж үзэж, нэхэмжлэлийн шаардлагыг хангасан нь ИХ-ийн 56 дугаар зүйлийн 56.1.3-д заасан шаардлагад нийцжээ. Өөр хэлцлийг халхавчлах зорилгоор хийсэн хэлцэл хүчин төгөлдөр бус байна. Бэлэглэлийн гэрээг хүчингүй болгохыг зохицуулсан ИХ-ийн 280 дугаар зүйлийн холбогдох заалт тухайн нэхэмжлэлийн шаардлага болон үндэслэлд хамааралгүй, шүүх хуулийн энэхүү хэм хэмжээг зохигчийн хоорондох маргаанд хэрэглээгүй байх тул хууль буруу тайлбарлаж хэрэглэсэн гэх гуравдагч этгээдийн гомдол үндэслэлгүй байна” гэж анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээж шийдвэрлэжээ.

*Шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээ:*

Шүүхийн шийдвэрээр хөндөгдөж буй асуудал: Нэхэмжлэгч амины зориулалттай хоёр газар, үл хөдлөх хөрөнгүүдийг О нь худалдан авахаар тохиролцож бэлэглэлийн гэрээ байгуулан өөрийн нэр дээр газар, эд хөрөнгийн эрхийг шилжүүлэн авсан боловч төлбөр мөнгөө өгөхгүй хохироосоор байгаа тул бэлэглэлийн гэрээг хүчингүйд тооцуулахаар шүүхэд ханджээ. Анхан, давах, хяналтын шатны шүүхүүд нэхэмжлэгчийн гаргасан нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хангаж шийдвэрлэсэн байна. Энэхүү

шийдвэрээр бэлэглэлийн гэрээг байгуулахдаа худалдах, худалдан авах гэрээг халхавчилж хийсэн тул бэлэглэлийн гэрээг хүчин төгөлдөр бус гэж үзэж шийдвэрлэжээ. Маргааны үйл баримтаас харахад бэлэглэгч өөрийн өмчлөлийн амины зориулалттай хоёр газар, үл хөдлөх хөрөнгүүдийг О-д бэлэглэсэн байх боловч О нь “Хүнс, хөдөө аж ахуйн яам”-наас зарласан төслийн санхүүжилт орж ирсэн үед дээрх үл хөдлөх эд хөрөнгүүдийн үнийг төлнө, харин мөнгө орохоос өмнө бэлэглэлийн гэрээний дагуу өмчлөлд шилжүүлэхийг шаардаж, гэрээг байгуулсан байна.

Энэхүү маргааны үйл баримтаас үзвэл, хэдийгээр бэлэглэлийн гэрээ байгуулсан боловч мөн чанартаа тус гэрээг худалдах, худалдан авах гэрээг халхавчилж хийжээ. Практикт ихэнх тохиолдолд бэлэглэлийн гэрээ байгуулж буй зорилго нь татвараас зайлсхийх, татварын орлогыг бага болгож харагдуулах, түүнтэй холбоотой бага татвар төлөх байдаг. Харин дээрх шүүхийн шийдвэрт тусгасан маргаанаас харахад гэрээний талууд татвараас зайлсхийх зорилгоор бэлэглэлийн гэрээ байгуулсан гэж харагдахгүй байх боловч татварын асуудлыг бодолцож, хариуцагчид нэн даруй хугацаанд үл хөдлөх хөрөнгүүдийг шилжүүлэхээр зорьж, бэлэглэлийн гэрээг байгуулжээ.

Халхавчилсан хэлцлийн агуулга нь өөрсдийн жинхэнэ хүсэж хийж байгаа хэлцлийн сөрөг үр дагаврыг өөр хэлцлээр далдлахыг хүссэн байдаг.<sup>17</sup> Халхавч хэлцлийн хувьд ИХ-ийн 56 дугаар зүйлийн 56.1.3-д заасны дагуу хийсэн үеэсээ эхлэн хүчин төгөлдөр бус байна. Харин халхавчлагдаж буй хэлцэл нь хуулиар заасан шаардлагуудыг бүрэн хангаж байгаа тохиолдолд шүүх талуудын хүсэл зоригийг харгалзан хүчин төгөлдөр гэж үзэх нь элбэг юм. Учир нь гэрээний талууд тухайн хэлцлийг хийх хүсэл эрмэлзэлтэй байсан эсэх, тухайн халхавчлагдаж буй хэлцлийн үр дагаврыг ойлгож байсан эсэх, халхавчлагдсан хэлцэл нь түүнд тавигдах шаардлагыг хангаж байгаа эсэхийг харгалзан үздэг.

<sup>17</sup> Э.Байгаль, Иргэний эрх зүй: Ерөнхий анги, 2009, 194 дэх тал.

Анхан, Давах, Хяналтын шатны шүүхүүд халхавчлагдсан хэлцлийг хүчин төгөлдөр эсэхэд дүгнэлт өгөөгүй байна. Харин бэлэглэлийн гэрээг ИХ-ийн 56 дугаар зүйлийн 56.1.3-д заасны дагуу хийсэн үеэсээ хүчин төгөлдөр бус хэлцэл гэж үзэж, ИХ-ийн 56 дугаар зүйлийн 56.5-д заасны дагуу авсан, өгснөө буцаах үр дагавар бүхий шийдвэрийг гаргасан байна. Халхавчилсан хэлцлийн гол онцлог нь талууд харилцан зөвшилцөж, гадаад харилцаанд тодорхой агуулгаар хэлцэл хийсэн мэт дүрийг буй болгоход орших бөгөөд уг хэлцэлтэй холбоотой эрх зүйн үр дагавар үүсэхгүй гэдэгтэй санал нэгтэй байдаг.<sup>18</sup>

Нэхэмжлэгч, хариуцагч нь анхнаасаа бэлэглэлийн гэрээ хийх хүсэл эрмэлзэлгүй байсан бөгөөд харин бэлэглэлийн гэрээгээр худалдах, худалдан авах гэрээг халхавчилж хийхийг хүссэн нь халхавчилсан хэлцлийн үндсэн шинж мөн. Иймд шүүх ИХ-ийн 56 дугаар зүйлийн 56.1.3-д заасны дагуу бэлэглэлийн гэрээг хүчин төгөлдөр бус гэж үзсэн нь үндэслэлтэй байна. Харин халхавчлагдаж буй хэлцэл буюу худалдах, худалдан авах гэрээ нь хүчин төгөлдөр эсэхэд дүгнэлт өгч, шийвэрлээгүй явдал нь дутагдалтай болжээ. **Халхавчлах зорилгоор хийсэн хэлцлийн цаана хэлцэл хийгч талуудын хүсэж буй хэлцэл нуугдаж буй бөгөөд халхавчлах зорилгоор хийсэн хэлцэл хүчин төгөлдөр бус байхад, халхавчлагдаж буй хэлцэл хүчин төгөлдөр бус байна гэсэн үг биш юм.**<sup>19</sup> Тухайн халхавчлагдаж буй хэлцэл нь хуулиар тавигдах шаардлагыг хангаж байгаа бол хүчин төгөлдөр гэж үзнэ. Хэргийн үйл баримтаас үзвэл, бэлэглэлийн гэрээ нь нотариатаар баталгаажуулагдаж гэрээ байна. Иргэний хуулийн 109 дүгээр зүйлийн 109.2-д “*Үл хөдлөх эд хөрөнгийг шилжүүлэх хэлцэл, холбогдох бусад баримт бичигт өмчлөх эрх шилжүүлэх болсон үндэслэлийг тодорхой зааж нотариатаар гэрчлүүлэх бөгөөд хэрэв талуудын аль нэг нь төлөөлөгчөөр*

<sup>18</sup> Б.Буянхшиг, Иргэний эрх зүйн удиртгал, 2012, 190 дэх тал.

<sup>19</sup> Б.Тэмүүлэн, Д.Энхзул, Б.Буянхшиг, Иргэний эрх зүй ерөнхий анги, 2013, 144 дэх тал.

дамжуулан уг харилцаанд оролцож байвал төлөөлөгч болон түүний итгэмжлэлийг дээрх баримт бичигт тэмдэглэх буюу хавсаргана” гэж зохицуулсан байдаг. Өөрөөр тайлбарлавал, үл хөдлөх хөрөнгийг бусдад шилжүүлэх бол тухайн хэлцлийг нотариатаар баталгаажуулсан байх шаардлага тавигджээ. Энэхүү шаардлагыг дээрх гэрээ нь хангахгүй байх тул халхавчлагдсан худалдах, худалдан авах гэрээ нь мөн хүчин төгөлдөр бус байна.

**2.2.3. Татвараас зайлсхийж бэлэглэлийн гэрээ байгуулсантай холбоотой шүүхийн шийдвэр (Улсын Дээд шүүхийн 2009 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн 145 дугаартай тогтоол)**

Хэргийн үйл баримт:

Нэхэмжлэгч нь шүүхэд гаргасан нэхэмжлэлдээ, “Сүхбаатар сумын 2 дугаар багийн 9 дүгээр байрны 2 тоотод оршин сууж, тэр байрны өмчлөгч болон амьдарч байсан. Тухайн цед наймаа хийж, байраа барьцаанд тавин зээл авсан. Наймаа хийж байгаад бүтэлгүйтсэн. Мөн орон сууцаа түрээслэн сууж байсан хүнээс мөнгө зээлж түүнийгээ төлж чадахгүй болсон. Гэтэл банк, байр түрээслэгч нар намайг цагдаад өгч үүнээс болж би их айж сандарсан. Гэтэл банк намайг байраа хурдан зарж, өрөө төл гэж дарамт шахалт үзүүлсэн тул гурван өрөө байраа зарах болсон юм. Байраа худалдах, худалдан авах гэрээ байгуулан Э-д зарсан болгож, банкны зээл гаргуулсан ба энэ гэрээг үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн газарт бүртгүүлэх гэтэл мөнгө хэрэгтэй болсноос бэлэглэлийн гэрээ болгон байраа шилжүүлсэн юм. Би Э-тэй хамаатан садан биш учир байр бэлэглэх ямар ч үндэслэл байхгүй. Татвараас зайлсхийж ийм гэрээ байгуулсан. Иймд дээрх бэлэглэлийн гэрээг хүчин төгөлдөр бус хэлцэлд тооцож, байрыг минь буцаан олгож өгнө үү” гэж дурдсан. Хариуцагч нь “Миний хувьд энэ гаргаж байгаа нэхэмжлэлийг хүлээн зөвшөөрөхгүй. Би байр худалдах зар телевизээс харж, банканд дээр ирж уулзаж,



*тэр байрыг авсан. Нэхэмжлэгч бид эхлээд худалдах, худалдан авах гэрээ байгуулсан ба уг гэрээнээс татвар төлөхөөр боллоо гээд гэрээгээ өөрчлөн бэлэглэлийн гэрээ болгон үл хөдлөх эд хөрөнгийн газар бүртгүүлсэн. Би байрыг банкттай хуйвалдаж, энэ хүнд дарамт шахалт үзүүлж аваагүй. Худалдах, худалдан авах гэрээг хүчин төгөлдөр хэвээр үлдээж өгнө үү” гэсэн хариу тайлбарыг шүүхэд гаргажээ.*

*Анхан шатны шүүхийн шийдвэр болон давж заалдах шатны шүүхийн магадлал:*

Сэлэнгэ аймаг дахь сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүх 2008 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн 529 дүгээр шийдвэрээр Иргэний хуулийн 56 дугаар зүйлийн 56.1.8, 243 дугаар зүйлийн 243.1, 245 дугаар зүйлийн 245.2-д зааснаар А, Э нарын хооронд 2006 оны 11 дүгээр сарын 10-нд байгуулсан “Орон сууц худалдах, худалдан авах гэрээ”, ИХ-ийн 56 дугаар зүйлийн 56.1.10, 276 дугаар зүйлийн 276.1-д зааснаар зохигчдын хооронд мөн өдөр байгуулсан орон сууц бэлэглэлийн гэрээ зэрэг хэлцлийг тус тус хүчин төгөлдөр бус хэлцэлд тооцож, ИХ-ийн 56 дугаар зүйлийн 56.5-д зааснаар Э-д байрны үнэ болох 110,000,000 төгрөгийг А-аас гаргуулан олгож, Сүхбаатар сумын 2-р баг, 9 дүгээр байрны 2 тоот гурван өрөө байрыг А-д буцаан олгож шийдвэрлэжээ. Сэлэнгэ аймгийн давж заалдах шатны шүүх 2009 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 05 дугаартай магадлалаар анхан шатны шүүхийн дээрх шийдвэрийг хэвээр үлдээж шийдвэрлэжээ.

*Хяналтын шатны шүүхийн тогтоол:*

*Хяналтын шатны шүүх тогтоолынхоо хянавал хэсэгт, “Нэхэмжлэгч нь орон сууцаа борлуулахдаа эд хөрөнгө борлуулсны татвараас зайлсхийх зорилгоор бэлэглэлийн гэрээ байгуулж, Үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн газарт бүртгүүлжээ. Бэлэглэлийн гэрээ нэхэмжлэгчийн хүсэл зоригоос гадуур*

хийгдээгүй нь хэрэгт авагдсан баримтаар нотлогджээ. Гэтэл шүүх орон сууц бэлэглэлийн гэрээг Үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн газар бүртгүүлсэн, харин худалдах худалдан авах гэрээг бүртгүүлээгүй нь ИХ-ийн 182 дугаар зүйлийн 182.1-д Улсын бүртгэлд үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрх болон түүнтэй холбоотой бусад эд хөрөнгийг бүртгүүлнэ гэж заасныг зөрчсөн гэх үндэслэлээр хүчин төгөлдөр буст тооцно хэмээн алдаатай дүгнэлт хийжээ. Түүнчлэн орон сууц бэлэглэлийн гэрээ нь орон сууц худалдах, худалдан авах гэрээг халхавчлан, зөвхөн үл хөдлөх эд хөрөнгийг бусдад шилжүүлэн, дараагийн үр дагавар болох банкны зээл олгох боломжийг бүрдүүлэх нөхцөлтэйгөөр хийсэн хүчин төгөлдөр бус хэмээн дүгнэсэн нь бодит байдалд нийцээгүй байна. Нэхэмжлэгч нь өөрийн хүсэл зоригийн дагуу гэрээ байгуулан үл хөдлөх эд хөрөнгийн газарт бүртгүүлсэн нь хүчин төгөлдөр хэлцэл гэж үзэх үндэслэлтэй юм. Шүүх ИХ-ийн 56 дугаар зүйлийн 56.1-д заасан үндэслэлээр орон сууц худалдах, худалдан авах тухай хэлцэл хүчин төгөлдөр бус гэж үзсэн тохиолдолд мөн зүйлийн 56.5 дахь заалтын дагуу шилжүүлсэн бүх зүйлээ харилцан буцааж өгөх, боломжгүй бол үнийг төлөх үүрэгтэйгээс гадна 56.5 дахь заалтын дагуу хүчин төгөлдөр бус хэлцэл хийсэн буруутай этгээд нь бусдад учруулсан хохирлыг нөхөн төлнө гэсэн заалтыг хэрэглэх үндэслэлтэй болно. Сэлэнгэ аймгийн сум дундын 1 дүгээр шүүхийн шийдвэр, аймгийн шүүхийн магадлалд хуулийн эдгээр зохицуулалтыг буруу хэрэглэснээс гадна ИХ-ийн 56 дугаар зүйлийн 56.1.8, 56.1.10 заалтыг буруу тайлбарласан алдаа гаргажээ” гэж үзэж анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож, нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэжээ.

### **Шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээ:**

Шүүхийн шийдвэрээр хөндөгдөж буй асуудал: Нэхэмжлэгчийн

хувьд байраа худалдах, худалдан авах гэрээ байгуулан Э-д зарсан болгож, банкны зээл гаргуулсан ба тус гэрээг үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн газарт бүртгүүлэх гэтэл мөнгө хэрэгтэй болсноос бэлэглэлийн гэрээ болгон байраа шилжүүлжээ. Энэхүү маргааныг анхан болон давж заалдах шатны шүүх шийдвэрлэхдээ ИХ-ийн 56 дугаар зүйлийн 56.1.3, 56.1.10, 56.5-ыг тус тус үндэслэн нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хангаж шийдвэрлэсэн. Харин хяналтын шатны шүүх анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож, нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэжээ. Хяналтын шатны тогтоолын үндэслэл нь анхан болон давж заалдах шатны шүүх ИХ-ийн 56 дугаар зүйлийн 56.1.3, 56.1.10 дахь заалтыг буруу тайлбарлаж хэрэглэсэн, мөн нэхэмжлэгч өөрийн хүсэл зоригийн дагуу өмчлөлийн хөрөнгөө шилжүүлсэн буюу худалдах, худалдан авах гэрээ нь хүчин төгөлдөр атал хүчин төгөлдөр бус гэж дүгнэсэн нь буруу байна гэж үзжээ. Энэхүү маргааныг шийдвэрлэхдээ халхавчлагдаж буй хэлцлийн хүчин төгөлдөр эсэх асуудлыг хөндөж, бэлэглэлийн гэрээгээр халхавчлан гэрээг байгуулахдаа талууд ямар хүсэл зоригийн илэрхийллээр энэхүү хэлцлийг хийсэн бэ гэдгийг дүгнэн тогтоосон байна.

Нэгдүгээрт, Анхан шатын шүүх болон давж заалдах шатны шүүх талуудын хооронд байгуулагдсан бэлэглэлийн гэрээг ИХ-ийн 56 дугаар зүйлийн 56.1.3-д заасны дагуу хүчин төгөлдөр гэж үзсэн нь үндэслэлтэй байна. Нэхэмжлэгч нь нэхэмжлэлдээ, *“Татвараас зайлсхийж ийм гэрээ байгуулсан”* гэж бичсэн байдаг. ИХ-ийн 56.1.3 дахь заалт хэрэглэгдэх сонгодог тохиолдол нь үл хөдлөх эд хөрөнгийг худалдан борлуулсны улмаас төлөх орлогын татвараас зугтаах зорилгоор бэлэглэлийн гэрээ байгуулдаг, үнийг бууруулан бичсэн хэлцэл<sup>20</sup> байдаг. Иймээс нэхэмжлэгч, хариуцагчийн татвараас зайлсхийхийн тулд хийсэн тус гэрээ нь

<sup>20</sup> Э.Байгаль, Иргэний эрх зүй: Ерөнхий анги, 2009, 194 дэх тал.

ИХ-ийн 56 дугаар зүйлийн 56.1.3-д хамаарах хүчин төгөлдөр бус гэрээ мөн байна. Үүнээс харахад, анхан болон давж заалдах шатны шүүх өөр хэлцлийг халхавчлах зорилгоор хийсэн хэлцэл гэж үзэж бэлэглэлийн гэрээг хүчингүй болгосон нь үндэслэлтэй болжээ. Харин анхан, давж заалдах шатны шүүх халхавчлагдаж буй үл хөдлөх эд хөрөнгө худалдах, худалдан авах гэрээг хүчин төгөлдөр эсэхийг шийдвэрлэхдээ хүчин төгөлдөр бус гэж үзэж, ИХ-ийн 56 дугаар зүйлийн 56.1.10 дахь заалтыг хэрэглэсэн нь хэрэглэх ёсгүй хуулийг хэрэглэсэн явдал юм. Монгол Улсын Дээд шүүх 2010 оны 06 дугаар сарын 22-ны өдөр 17 дугаартай “Иргэний хуулийн 5, 6, 7 дугаар бүлгийн зарим зүйл заалтыг тайлбарлах тухай” тогтоолоор ИХ-ийн 56 дугаар зүйлийн 56.1.10 заалтыг тайлбарлажээ. Тус тогтоолд **“хүчин төгөлдөр бус хэлцлийн үндсэн дээр хийсэн бусад хэлцэл”** гэдэгт *хүчин төгөлдөр бус хэлцэлтэй шалтгаант нөхцөл байдлаар салиггүй холбогдсон, энэ хэлцэл хүчин төгөлдөр бус болсноор эрх зүйн үндэслэл нь үгүйсгэгдэх хэлцлийг хамааруулан ойлговол зохино. Хүчин төгөлдөр бус хэлцлийн дараа хэлцлийн зүйл болох эд хөрөнгө болон эрхийн талаар хийсэн хэлцэл болгоныг хүчин төгөлдөр бус гэж үзэх үндэслэлийг уг заалтын зохицуулалт үүсгэхгүй*” гэж тайлбарлажээ. Өөрөөр тайлбарлавал, үндсэн зээлийн гэрээ хүчин төгөлдөр бус болсон тохиолдолд түүнтэй туслах байдлаар хийсэн барьцааны гэрээ хүчин төгөлдөр бус байна гэсэн үг юм. Гэтэл анхан шатны шүүх энэхүү заалтыг буруу тайлбарлан бэлэглэлийн гэрээ хүчингүй болсон тул халхавчлагдсан худалдах, худалдан авах гэрээ хүчин төгөлдөр бус гэж үзжээ.

Дээрх хуулийг буруу хэрэглэсэн явдлыг Улсын Дээд шүүх тогтоолдоо зөвтгөн заасан. Гэхдээ Улсын Дээд шүүхээс халхавчлагдсан худалдах, худалдан авах гэрээг хүчин төгөлдөр гэж үзэхдээ тухайн гэрээний хэлбэрийн шаардлагыг хангаж байгаа эсэхэд дүгнэлт өгөөгүй байна. Тухайн халхавчлагдаж буй хэлцэл нь хуулиар тавигдах шаардлагыг хангаж байгаа

бол хүчин төгөлдөр гэж үзнэ. Шүүхийн шийдвэрээс үзэхэд, халхавчлагдсан хэлцэл буюу худалдах, худалдан авах гэрээг аман хэлбэрээр байгуулсан байна. Харин бэлэглэлийн гэрээг нотариат орж, байгуулжээ. ИХ-ийн 109 дүгээр зүйлийн 109.2-д *“Үл хөдлөх эд хөрөнгийг шилжүүлэх хэлцэл, холбогдох бусад баримт бичигт өмчлөх эрх шилжүүлэх болсон үндэслэлийг тодорхой зааж нотариатаар гэрчлүүлэх бөгөөд хэрэв талуудын аль нэг нь төлөөлөгчөөр дамжуулан уг харилцаанд оролцож байвал төлөөлөгч болон түүний итгэмжлэлийг дээрх баримт бичигт тэмдэглэх буюу хавсаргана”* гэж зохицуулжээ. Гэтэл талууд үл хөдлөх эд хөрөнгө худалдах, худалдан авах гэрээг бичгээр байгуулаагүй, нотариатаар баталгаажуулаагүй тул тухайн халхавчлагдсан гэрээг ИХ-ийн 56 дугаар зүйлийн 56.1.8-д заасны дагуу хүчин төгөлдөр бус гэрээ гэж үзэх үндэслэлтэй байна. Иймд Улсын Дээд шүүх халхавчлагдсан үл хөдлөх эд хөрөнгө худалдах, худалдан авах гэрээг хүчин төгөлдөр хэмээн үзэхдээ зөвхөн талуудын хүсэл зоригийг харгалзсан нь үндэслэлгүй байна. ИХ-ийн 56 дугаар зүйлийн 56.3-д *“Энэ хуулийн 56.1.2-56.1.4, 56.1.8-д заасан хэлцлийг хийсэн этгээд уг хэлцлээр илэрхийлсэн хүсэл зоригоо хүчин төгөлдөр болохыг хожим хүлээн зөвшөөрч, хуульд заасан хэлбэрээр илэрхийлсэн бол шинээр хийсэнтэй адилтгаж хүчин төгөлдөр хэлцэл гэж үзнэ”* гэж заасан. Гэхдээ энэхүү хуулийн урьдчилсан нөхцөл нь хэлцлийг хийсэн этгээд хуульд заасан хэлбэрээр илэрхийлсэн байх ёстой юм. Учир нь үл хөдлөх эд хөрөнгө худалдах, худалдан авах гэрээ нь бусад гэрээтэй харьцуулахад хэлбэрийн шаардлагыг хангасны үндсэн дээр хүчин төгөлдөр болох хэлцэл юм. Гэтэл нэхэмжлэгч болон хариуцагч нар энэхүү хүсэл зоригоо хуульд заасан хэлбэрээр илэрхийлээгүй тул хүчин төгөлдөр хэлцлийн үр дагавар үүсэхгүй гэж дүгнэж байна.

**2.2.4. ИХ-ийн 56 дугаар зүйлийн 56.1.3 болон 280 дугаар зүйлийн 280.1.1 дэх зохицуулалтын хууль хэрэглээний асуудалтай холбоотой шүүхийн шийдвэр (Улсын Дээд шүүхийн 2010 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 66 дугаартай тогтоол)**

*Хэргийн үйл баримт:*

Нэхэмжлэгч нь шүүхэд гаргасан нэхэмжлэлдээ, “Би 2007 оны 7 дугаар сарын 17-ны өдөр С-тай тохиролцож, 245 м<sup>2</sup> талбайтай үйлчилгээний төвийг бэлэглэлийн гэрээ хийж, нотариатаар гэрчлүүлэн С-д шилжүүлсэн. Бэлэг хүлээн авагч үйлчилгээний төвийг хүлээж авахдаа 1-2 өрөө байрыг надад шилжүүлэхээр тохирсон боловч амлалтаа биелүүлсэнгүй. Үйлчилгээний төвийн хашаан дотор байсан гараашаас нэр бүхий эд зүйлс алдагдсан. Үүнээс гадна бэлэглэсэн үйлчилгээний төвийг бусдад худалдахаар болж, “Бэлэглэлийн гэрээ”-г ноцтой зөрчиж байх тул С-тай байгуулсан дээрх бэлэглэлийн гэрээг хүчингүй болгож өгнө үү” гэж дурдсан. Хариуцагч нь “Б хадгаламж зээлийн хоршоо нь 2007 оны 07 дугаар сарын 23-ны өдөр нэхэмжлэгчээс 245 м<sup>2</sup> талбай бүхий 1 давхар үйлчилгээний байрыг 51,150,000 төгрөгөөр худалдаж авчээ. Байрыг хүлээж авснаас хойш уг барилгад 12.4 сая төгрөгийн засвар хийсэн. Уг байрыг худалдах, худалдан авах гэрээгээр авах ёстой байсан боловч нэхэмжлэгч Б нь татвар төлөхөөс зайлсхийж бэлэглэлийн гэрээгээр шилжүүлсэн” гэсэн хариу тайлбарыг шүүхэд гаргажээ.

*Анхан шатны шүүхийн шийдвэр болон давж заалдах шатны шүүхийн магадлал:*

Баян-Өлгий аймаг дахь сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүх 2007 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн 270/А тоот шийдвэрээр ИХ-ийн 280 дугаар зүйлийн 280.1.1, 280.2-д заасныг баримтлан нэхэмжлэгч Б болон хариуцагч С нарын хооронд байгуулсан 2007 оны 07 дугаар сарын 17-ны өдрийн бэлэглэлийн

гэрээ болон худалдах, худалдан авах гэрээг хүчингүй болгож шийдвэрлэснийг давж заалдах шатны шүүх 2009 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн 94 магадлалаар өөрчилж, улмаар бэлэг хүлээн авагч С-аас бэлэглэлийн зүйл 245 м<sup>2</sup> талбайтай үйлчилгээний байрыг буцаан гаргуулж, нэхэмжлэгч Б-д олгож, бэлэглэгч Б-ээс 51,150,000 төгрөгийг гаргуулж, С-д буцаан олгохоор шийдвэрлэжээ.

*Хяналтын шатны шүүхийн тогтоол:*

Улсын Дээд шүүх тогтоолынхоо хянавал хэсэгт, “Баян-Өлгий аймгийн Өлгий сумын 5-р багт байрлах 245 м<sup>2</sup> талбайтай үйлчилгээний төвийг С-д бэлэглэсэн 2007 оны 07 дугаар сарын 17-ны өдрийн бэлэглэлийн гэрээг хүчингүй болгуулах нэхэмжлэлийг Б шүүхэд гаргахдаа хариуцагч гэрээ зөрчиж бэлэглэгчийг ноцтой гомдоосон гэсэн үндэслэл дурджээ. Өөрөөр хэлбэл, Б 2007 оны 07 дугаар сарын 17-ны өдөр байгуулсан бэлэглэлийн гэрээ хүчин төгөлдөр гэж үзэж, харин бэлэг хүлээн авагч бэлэглэгчийг гомдоосон учир бэлэглэлийн гэрээг хүчингүй болгохыг хүссэн, улмаар бэлэглэлийн зүйлийг буцаан шаардсан агуулгатай нэхэмжлэл гаргасан байна. Нэхэмжлэгч нь С-д 245 м<sup>2</sup> талбай бүхий үйлчилгээний төвийг бэлэглээгүй, уг гэрээгээр эрх цэрэг хүлээх хүсэл зориг эрмэлзэлгүй байсан нь тогтоогдож байх тул 2007 оны 07 дугаар сарын 17-ны өдрийн бэлэглэлийн гэрээ дүр үзүүлэн хийсэн бэлэглэлийн гэрээ байна гэж хяналтын шатны шүүх бүрэлдэхүүн үзлээ. Зохигчдын хооронд байгуулсан бэлэглэлийн гэрээ хүчин төгөлдөр бус байгаа нь худалдах, худалдан авах талуудын хүсэл зоригийг үгүйсгэхгүй тул шилжүүлсэн эд хөрөнгийг нэхэмжлэгчид буцаан олгох үндэслэлгүй байна” гэж үзэж анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож, нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэжээ.

### **Шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээ:**

*Шүүхийн шийдвэрээр хөндөгдөж буй асуудал:* Нэхэмжлэгчийн хувьд 2007 оны 7 дугаар сарын 17-ны өдөр С-тай тохиролцож, 245 м<sup>2</sup> талбайтай үйлчилгээний төвийг бэлэглэлийн гэрээ хийж, нотариатаар гэрчлүүлэн С-д шилжүүлсэн. Бэлэг хүлээн авагч үйлчилгээний төвийг хүлээж авахдаа 1-2 өрөө байрыг надад шилжүүлэхээр тохирсон боловч амлалтаа биелүүлсэнгүй. Үйлчилгээний төвийн хашаан дотор байсан гараашаас нэр бүхий эд зүйлс алдагдсан. Үүнээс гадна бэлэглэсэн үйлчилгээний төвийг бусдад худалдахаар болж “бэлэглэлийн гэрээ”-г ноцтой зөрчиж байх тул С-тай байгуулсан дээрх “Бэлэглэлийн гэрээ”-г хүчингүй болгож өгнө үү гэсэн нэхэмжлэлийг шүүхэд гаргажээ. Тус маргааныг анхан болон давж заалдах шатны шүүх шийдвэрлэхдээ ИХ-ийн 280 дугаар зүйлийн 280.1.1, 280.2 дахь заалтыг тус тус үндэслэн нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хангаж шийдвэрлэсэн. Харин хяналтын шатны шүүх анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож, нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэжээ. Хяналтын шатны тогтоолын үндэслэл нь анхан болон давж заалдах шатны шүүх ИХ-ийн 280 дугаар зүйлийн 280.1.1, 280.2 дахь заалтыг буруу тайлбарлаж хэрэглэсэн, мөн нэхэмжлэгч өөрийн хүсэл зоригийн дагуу өмчлөлийн хөрөнгөө шилжүүлсэн буюу гэрээ нь хүчин төгөлдөр байхад хүчин төгөлдөр бус гэж дүгнэсэн нь буруу байна гэж үзжээ. Энэхүү маргааныг шийдвэрлэхдээ бэлэглэлийн гэрээний үндсэн шинжийг тодорхойлж, анхнаасаа талууд бэлэглэлийн гэрээ байгуулах хүсэл зоригийн илэрхийлэлтэй байсан эсэх, бэлэг хүлээн авагч нь бэлэглэгчийг гомдоосон ноцтой үйлдэл хийсэн эсэх, ИХ-ийн 280 дугаар зүйлийн 280.2, 56.5 дахь зүйл заалтын хууль хэрэглээний асуудлыг хөндсөнөөрөө ач холбогдолтой байна.



Анхан шатын шүүх болон давж заалдах шатны шүүх талуудын хооронд байгуулсан бэлэглэлийн гэрээг ИХ-ийн 280 дугаар зүйлийн 280.1.1-д заасны дагуу хүчингүй гэж үзсэн байна. Улмаар ИХ-ийн 280 дугаар зүйлийн 280.2-д “Бэлэглэлийн гэрээ хүчингүй болсон бол бэлэглэлийн зүйлийг бэлэглэгчид, эсхүл түүний өвлөгчид буцаан олгоно” гэж заасны дагуу авсан, өгсөн зүйлийг буцаан гаргуулахаар шийдвэрлэсэн. Үүнийг Улсын Дээд шүүхээс хуулийг буруу тайлбарлан хэрэглэсэн гэж үзсэн нь үндэслэлтэй болжээ. Учир нь анхан шатны шүүх нь “хариуцагч гэрээ зөрчиж бэлэглэгчийг гомдоосон” гэсэн үндэслэлээр нэхэмжлэлийг хангаж шийдвэрлэсэн. Гэтэл ИХ-ийн 280 дугаар зүйлийн 280.1.1 дэх заалтыг хэрэглэхийн тулд бэлэглэгч гомдсон байх, гомдоосон үйлдэл нь ноцтой байх ёстой. Мөн Шүүхийн шийдвэрийг судлан үзэхэд “тухайн этгээд буюу бэлэглэгчийн нийгэмд эзлэх байр суурьд сөргөөр нөлөөлөх, бэлэглэгчийн нийгэмд эзлэх байр суурь, нэр хүнд, эсхүл бэлэглэгч, бэлэг хүлээн авагчийн садан төрлийн байдал, гомдоосон үйлдлийг нийгэмд ил эсхүл хувийн хүрээнд хийсэн эсэхийг харилцан харгалзахаас гадна бэлэглэгч, бэлэг хүлээн авагчийг өөрөө өдөөн хатгасан эсэх, бэлэг хүлээн авагчийн үйлдлийг хувь хүний хувьд ойлгох боломжтой байсан эсэхийг харгалзаж” тогтоож байна. Нэхэмжлэгч нэхэмжлэлдээ, “Бэлэг хүлээн авагч үйлчилгээний төвийг хүлээж авахдаа 1-2 өрөө байрыг надад шилжүүлэхээр тохирсон боловч амлалтаа биелүүлсэнгүй. Үйлчилгээний төвийн хашаан дотор байсан гараашнаас нэр бүхий эд зүйлс алдагдсан. Үүнээс гадна бэлэглэсэн үйлчилгээний төвийг бусдад худалдахаар болж бэлэглэлийн гэрээг ноцтой зөрчсөн” гэж бичжээ. Гэтэл бэлэглэлийн гэрээ нь хариу төлбөргүйгээр гэрээний зүйлийг шилжүүлэх үндсэн шинжийг агуулж байдаг. Иймээс нэг талаас дээрх гэрээг бэлэглэлийн гэрээгээр халхавчилсан арилжааны гэрээ гэж дүгнэх боломжтой юм. Энэ талаар шүүх дүгнэлт өгөөгүй. Түүнчлэн халхавчилсан гэрээ нь хүчин төгөлдөр бус гэрээ тул

ноцтой гомдоосон гэх үндэслэлээр бэлэглэлийн гэрээг хүчингүй болгохоор шаардах боломжгүй. Мөн бэлэглэлийн гэрээний хариуд орон сууц шаардаж, тухайн үүргийг биелүүлээгүй үйлдэл нь гомдоосон ноцтой үйлдэл биш гэж Улсын Дээд шүүх дүгнэсэн нь үндэслэлтэй болжээ.

Зохигчид тайлбартаа, “Татвараас зайлсхийж бэлэглэлийн гэрээгээр шилжүүлсэн” гэж бичсэн байдаг. ИХ-ийн 56 дугаар зүйлийн 56.1.3 дахь заалт хэрэглэгдэх сонгодог тохиолдол нь үл хөдлөх эд хөрөнгийг худалдан борлуулсны улмаас төлөх орлогын татвараас зугтаах зорилгоор бэлэглэлийн гэрээ байгуулах байдаг.<sup>21</sup> Иймээс нэхэмжлэгч, хариуцагчийн татвараас зайлсхийхийн тулд хийсэн тус гэрээ нь ИХ-ийн 56 дугаар зүйлийн 56.1.3-д хамаарах хүчин төгөлдөр бус гэрээ мөн байна. Харин Улсын Дээд шүүх 56 дугаар зүйлийн 56.1.2-д заасан “Дүр цэццлэн хийсэн хэлцэл” гэж дүгнэсэн нь үндэслэл муутай болжээ. Анхан болон давж заалдах шатны шүүх өөр хэлцлийг халхавчлах зорилгоор хийсэн хэлцэл гэж үзээгүй, харин ноцтой гомдоосон үйлдэл гаргасан гэж бэлэглэлийн гэрээг хүчингүй болгосон нь үндэслэлгүй байна.

Улсын Дээд шүүхээс халхавчлагдсан худалдах, худалдан авах гэрээг хүчин төгөлдөр гэж үзэхдээ тухайн гэрээний хэлбэрийн шаардлагыг хангаж байгаа эсэхэд дүгнэлт өгөөгүй байна. Тухайн халхавчлагдаж буй хэлцэл нь хуулиар тавигдах шаардлагыг хангаж байгаа бол хүчин төгөлдөр гэж үзнэ. Шүүхийн шийдвэрээс үзэхэд, халхавчлагдсан хэлцэл буюу “Худалдах, худалдан авах гэрээ”-г аман хэлбэрээр байгуулсан байна. Харин бэлэглэлийн гэрээг нотариат орж, байгуулжээ. ИХ-ийн 109 дүгээр зүйлийн 109.2-д “Үл хөдлөх эд хөрөнгийг шилжүүлэх хэлцэл, холбогдох бусад баримт бичигт өмчлөх эрх шилжүүлэх болсон үндэслэлийг тодорхой зааж нотариатаар гэрчлүүлэх бөгөөд хэрэв талуудын аль нэг нь төлөөлөгчөөр дамжуулан уг харилцаанд оролцож байвал төлөөлөгч болон түүний итгэмжлэлийг дээрх баримт

<sup>21</sup> Э.Байгаль, Иргэний эрх зүй: Ерөнхий анги, 2009, 194 дэх тал.

*бичигт тэмдэглэх буюу хавсаргана” гэж зохицуулсан. Гэтэл талууд үл хөдлөх эд хөрөнгө худалдах, худалдан авах гэрээг бичгээр байгуулаагүй, нотариатаар баталгаажуулаагүй тул тухайн халхавчлагдсан гэрээг ИХ-ийн 56 дугаар зүйлийн 56.1.8-д заасны дагуу хүчин төгөлдөр бус гэрээ гэж үзэх үндэслэлтэй байна. Иймд Улсын Дээд шүүх халхавчлагдсан үл хөдлөх эд хөрөнгө худалдах, худалдан авах гэрээг хүчин төгөлдөр хэмээн үзэхдээ зөвхөн талуудын хүсэл зоригийг харгалзсан нь үндэслэлгүй байна. ИХ-ийн 56 дугаар зүйлийн 56.3-д “Энэ хуулийн 56.1.2-56.1.4, 56.1.8-д заасан хэлцлийг хийсэн этгээд уг хэлцлээр илэрхийлсэн хүсэл зоригоо хүчин төгөлдөр болохыг хожим хүлээн зөвшөөрч, хуульд заасан хэлбэрээр илэрхийлсэн бол шинээр хийсэнтэй адилтгаж хүчин төгөлдөр хэлцэл гэж үзнэ” гэж заажээ. Гэхдээ энэхүү хуулийн урьдчилсан нөхцөл нь хэлцлийг хийсэн этгээд хуульд заасан хэлбэрээр илэрхийлсэн байх ёстой юм. Учир нь үл хөдлөх эд хөрөнгө худалдах, худалдан авах гэрээ нь бусад гэрээтэй харьцуулахад хэлбэрийн шаардлагыг хангасны үндсэн дээр хүчин төгөлдөр болох хэлцэл юм. Гэтэл нэхэмжлэгч болон хариуцагч нар энэхүү хүсэл зоригоо хуульд заасан хэлбэрээр илэрхийлээгүй тул хүчин төгөлдөр хэлцлийн үр дагавар үүсэхгүй гэж дүгнэж байна.*

Анхан шатны шүүх бэлэглэлийн гэрээгээр халхавчлан худалдах, худалдан авах гэрээ байгуулсныг дүгнэхгүйгээр бэлэглэлийн гэрээний дагуу бэлэг хүлээн авагч нь бэлэглэгчийг гомдоосон ноцтой үйлдэл гаргасан эсэхийг хянасан нь буруу байна. Үүнийг хянахын өмнө тухайн бэлэглэлийн гэрээ ИХ-ийн 56 дугаар зүйлд заасан нөхцөлүүдэд хамаарч байгаа эсэх, хүчин төгөлдөр эсэхийг заавал хянах ёстой юм. Гэрээ хүчин төгөлдөр болсны дараа бэлэг хүлээн авагч бэлэглэгчийг ноцтой гомдоосон үйлдэл гаргасан эсэхийг хянана. Үүний улмаас анхан шатны шүүх ИХ-ийн 280 дугаар зүйлийн 280.1.1, 280.2 дахь заалтыг хэрэглэн бэлэглэлийн гэрээг хүчингүй болгосон бол Улсын Дээд

шүүх бэлэглэлийн гэрээг ИХ-ийн 56 дугаар зүйлийн 56.1.3-д заасны дагуу хүчин төгөлдөр бус гэж үзсэн нь үндэслэлтэй боловч халхавчилсан худалдах, худалдан авах гэрээг хүчин төгөлдөр гэж үзсэн нь үндэслэлгүй болжээ. Гэхдээ энэхүү шийдвэрээр ИХ-ийн 56 дугаар зүйлийн 56.5 болон 280 дугаар зүйлийн 280.2 дахь зохицуулалтын хууль хэрэглээний зөрүү, ялгаатай байдлыг харуулсан байна. Түүнчлэн Улсын Дээд шүүх тогтоолынхоо хянавал хэсэгт энэхүү үндэслэлүүдийг дэлгэрэнгүй, тайлбарлаж дүгнэлт өгөөгүй нь дутагдалтай болжээ. Иймээс Улсын Дээд шүүхийн тогтоол нь адил төстэй маргаануудыг шийдвэрлэхэд ач холбогдолтой байдаг тул хянавал хэсэгтээ илүү анхаарч, онолын болон практик хууль хэрэглээний асуудлыг хослуулан дэлгэрэнгүй, тодорхой байдлаар дүгнэлтээ өгөх нь ач холбогдолтой байх юм.

**2.2.5. Компанийн хувьцааны эрхийг шилжүүлсэн бэлэглэлийн гэрээг өөр хэлцлийг халхавчлах зорилгоор хийсэн хүчин төгөлдөр бус хэлцэл гэж шийдвэрлэсэнтэй холбоотой шүүхийн шийдвэр (Улсын Дээд шүүхийн 2013 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн 253 дугаартай тогтоол)**

*Хэргийн үйл баримт:*

Нэхэмжлэгч нь “2011 оны 12 дугаар сард Баянзүрх дүүргийн 20-р хороо, Гачуурт тосгон, Хар-Усан тохойд байрлах 13 нэр төрлийн хөдлөх болон үл хөдлөх эд хөрөнгө бүхий объектоо О, П нарт 300,000,000 төгрөгөөр зарахаар тохирсон байдаг. Хариуцагч У ирж, “Би О-ийн төрийн бус байгууллагын нэр дээр төрөөс төслийн санхүүжилт авах гэж байгаа, урьдчилж өгсөн 115,600,000 төгрөг их хэмжээний мөнгө тул компанийг миний нэр дээр шилжүүлж өгвөл үлдэгдэл мөнгийг төлө” гэсэн үгэнд нь итгэж 2012 оны 03 дугаар сарын 21-нд “Ч” ХХК-ийг бэлэглэлийн гэрээгээр түүнд шилжүүлсэн боловч өнөөдрийг

*хүртэл үлдэгдэл мөнгийг шилжүүлээгүй. Компанийн хөрөнгийг худалдан авахаар амаар тохиролцож, татвар төлөхөөс зайлсхийж бэлэглэлийн гэрээг хийсэн. Хариуцагч “У” намайг хуурч мэхлэн дээрх бэлэглэлийн гэрээ хийж, компанийг өөрийн өмчлөлдөө шилжүүлж авсан тул ИХ-ийн 59 дүгээр зүйлийн 59.1, 59.2-д зааснаар дээрх бэлэглэлийн гэрээг хүчин төгөлдөр буст тооцож, “Ч” ХХК-ийг өмчлөгчөөр тогтоож өгнө үү” гэсэн нэхэмжлэлийг шүүхэд гаргажээ.*

*Харин хариуцагч нь “Бэлэглэлийн гэрээг өөрсдөө сайн дурын үндсэн дээр байгуулсан, нэхэмжлэгчийг хуурч мэхлэн үйлдсэн зүйл огт байхгүй. 115,600,000 төгрөгийг нэхэмжлэгч бодитоор авсан бөгөөд хариуцагчийн тооцоогоор 233,604,000 төгрөг төлсөн. Нэхэмжлэгч дээрх хөрөнгүүдийг оруулсан учраас тохиролцсон ёсоороо компанийг шилжүүлж өгөхөөр болж, 2012 оны 03 дугаар сарын 21-нд компанийн хувьцааг бэлэглэх, мөн эрх шилжүүлэх гэрээг хийсэн ба дээрх гэрээнүүдийг үндэслэн Улсын бүртгэлийн албанд бүртгүүлж, өөрчлүүлсэн. Дээрх бэлэглэлийн гэрээг хуурч мэхлэх арга хэрэглэн үйлдсэн гэх боломжгүй” гэсэн хариу тайлбарыг шүүхэд гаргажээ.*

*Анхан шатны шүүхийн шийдвэр болон давж заалдах шатны шүүхийн магадлал:*

*Баянгол дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх 2013 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 146 дугаар шийдвэрээр ИХ-ийн 59 дүгээр зүйлийн 59.1, 59.2, 280 дугаар зүйлийн 280.1.1, 280.1.2-д заасныг баримтлан, У-д холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэжээ. Харин Нийслэлийн Иргэний хэргийн Давж заалдах шатны шүүх 2013 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн 214 дүгээр магадлалаар Баянгол дүүргийн шүүхийн 2013 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн 146 дугаар шийдвэрт өөрчлөлт оруулж, нэхэмжлэлээс “Бэлэглэлийн гэрээг хүчин төгөлдөр бус болохыг тогтоолгох” шаардлагыг хангаж, нэхэмжлэгчээс 115 сая*

төгрөг гаргуулж хариуцагчид олгож, “Ч” ХХК-ийн өмчлөгчөөр тогтоох хэсгийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэжээ.

*Хяналтын шатны шүүхийн тогтоол:*

Улсын Дээд шүүх 253 дугаартай тогтоолынхоо хянавал хэсэгт, ““Ч” ХХК-ийг У-ийн өмчлөлд шилжүүлэхээр тохирохдоо нэхэмжлэгч хариуцагчаас 115,600,000 төгрөг авсан нь тогтоогдсон тул компани шилжүүлэх асуудал талуудын хооронд хариу төлбөртэй явагдсан талаарх хоёр шатны шүүхийн дүгнэлт зөв байна. Хөрөнгө оруулах зорилгоор компанийг шилжүүлэн авсан тухай хариуцагчийн тайлбар нотлогдоогүй, харин тэдгээрийн хооронд худалдах, худалдан авах гэрээний харилцаа үүссэн болох нь шүүхэд гаргасан зохигчдын тайлбар, компанийг хариуцагчид шилжүүлсний төлбөрт авсан мөнгөний баримт, хуулийн этгээдийн гэрчилгээ, Гачуурт дахь хцлэмжийн аж ахуйд төлсөн төлбөрийн баримт зэргээр тогтоогдсон тул нэхэмжлэгч К нь “Ч” ХХК-ийг 100 хувь У-д худалдсан талаарх шүүхийн дүгнэлт ИХ-ийн 243 дугаар зүйлд нийцжээ. Хариуцагчийн өмчлөлд тодорхой хөрөнгө хариу төлбөргүй шилжүүлэх, нэхэмжлэгчээс бэлэг хцлэн авах хүсэл зориг зохигчид байгаагүй тул К нь “Ч” ХХК-ийг У-д бэлэглэсэн гэж үзэх нь ИХ-ийн 276 дугаар зүйлийг зөрчинө.

Компанийг нэхэмжлэгч хариуцагчид шилжүүлэх талаарх гэрээний тохиролцоо, нөхцөл зэргээс үзвэл талууд “Ч” ХХК-ийг 100 хувь У-д худалдах, худалдан авах хэлцэл хийж, татвараас зайлсхийх зорилгоор 2012 оны 03 дугаар сарын 21-ний өдөр бэлэглэлийн гэрээ байгуулж, хуулийн этгээдийг шилжүүлсэн баримт тогтоогдсон буюу “Худалдах, худалдан авах” гэрээг халхавчлах зорилгоор бэлэглэлийн гэрээ байгуулсан байна. Өөр хэлцлийг халхавчлах зорилгоор хийсэн хэлцэл хүчин төгөлдөр бус байна гэж ИХ-ийн 56 дугаар зүйлийн 56.1.3 дахь заалтад заасан тул “Ч” ХХК-ийг 100 хувь У-д худалдах, худалдан авах

гэрээг халхавчлах зорилгоор хийсэн 2012 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн бэлэглэлийн гэрээ хийгдсэн үеэсээ хүчин төгөлдөр бус байна. Талуудын хооронд 2012 оны 03 дугаар сарын 12-ны өдөр байгуулсан бэлэглэлийн гэрээ хүчин төгөлдөр бус байгаа нь уг гэрээний цаана халхавчлагдаж буй бодит хэлцлийн цр дагавар буюу худалдах, худалдан авах гэрээний дагуу шилжсэн эд хөрөнгийг нэхэмжлэгчид буцаан өгөх үндэслэл болохгүй” гэж үзэж анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээж, давж заалдах шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож, нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн байна.

### **Шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээ:**

Шүүхийн шийдвэрээр хөндөгдөж буй асуудал: Нэхэмжлэгч нь 2011 оны 12 дугаар сард Баянзүрх дүүргийн 20-р хороо, Гачуурт тосгон, Хар-Усан тохойд байрлах 13 нэр төрлийн хөдлөх болон үл хөдлөх эд хөрөнгө бүхий объектоо О, II нарт худалдахаар тохиролцсон боловч татвараас зайлсхийх зорилгоор бэлэглэлийн гэрээ байгуулжээ. Нэхэмжлэгчийн хувьд хариуцагч нь бэлэглэлийн гэрээ байгуулан хууран мэхэлсэн тул тус хэлцлийг ИХ-ийн 59 дүгээр зүйлийн 59.1, 59.2-д зааснаар хүчин төгөлдөр буст тооцуулахаар нэхэмжлэл гаргажээ. Нэхэмжлэгчийн гаргасан нэхэмжлэлийн шаардлагыг анхан шатны шүүх бүхэлд нь хэрэгсэхгүй болгож, давж заалдах шатны шүүх бэлэглэлийн гэрээг хүчин төгөлдөр буст тооцож, компанийн өмчлөгчөөр тогтоолгох нэхэмжлэлийн шаардлагыг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэжээ. Харин хяналтын шатны шүүх анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээж, нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн байна. Улсын Дээд шүүх анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээж шийдвэрлэхдээ бэлэглэлийн гэрээг хүчин төгөлдөр бус гэж үзэж, халхавчлагдсан худалдах, худалдан авах гэрээний харилцааг хүчин төгөлдөр гэж дүгнэснээрээ ач холбогдолтой байна. Учир нь

шүүхийн шийдвэрүүдийг судлах явцад бэлэглэлийн гэрээг хүчин төгөлдөр буст тооцож, авсан өгснөө харилцан буцаах үр дагаврыг шийдэж байжээ. Гэвч энэхүү маргаанаар хариуцагчийн эрх ашиг сонирхлыг зөрчихгүй байхад анхаарч, гэрээгээр тохиролцсон амлалт, итгэл, хүсэл зоригийг харгалзаж, халхавчлагдсан хэлцлийн үр дагаврыг шийдвэрлэсэн байна.

Зохигчид тайлбартаа, *“Татвараас зайлсхийх зорилгоор бэлэглэлийн гэрээ байгуулсан”* гэж бичсэн байдаг. ИХ-ийн 56 дугаар зүйлийн 56.1.3 дахь заалт хэрэглэгдэх нийтлэг тохиолдол нь татвараас зайлсхийх зорилго байдаг. Иймд нэхэмжлэгч, хариуцагчийн татвараас зайлсхийхийн тулд хийсэн тус гэрээ нь ИХ-ийн 56 дугаар зүйлийн 56.1.3-д хамаарах хүчин төгөлдөр бус гэрээ мөн байна. Анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож, нэхэмжлэлийн шаардлагын зарим хэсгийг хангаж шийдвэрлэсэн давж заалдах шатны шүүхийн магадлал үндэслэлгүй болжээ.

Харин хяналтын шатны шүүх дээрх магадлалыг хүчингүй болгож, бэлэглэлийн гэрээг ИХ-ийн 59 дугаар зүйлийн 59.1, 59.2 дахь заалтын дагуу хууран мэхэлж хийсэн хэлцэл гэж үзээгүй, ИХ-ийн 56 дугаар зүйлийн 56.1.3 дахь заалтын дагуу өөр хэлцлийг халхавчлах зорилгоор хийсэн хэлцэл гэж үзэж, шийдсэн нь үндэслэлтэй болсон байна. Улсын Дээд шүүхээс халхавчлагдсан худалдах, худалдан авах гэрээг хүчин төгөлдөр гэж үзэхдээ тухайн гэрээний хэлбэрийн шаардлагыг хангаж байгаа эсэхэд дүгнэлт өгөөгүй. Тухайн халхавчлагдаж буй хэлцэл нь хуулиар тавигдах шаардлагыг хангаж байгаа бол хүчин төгөлдөр гэж үзнэ. Шүүхийн шийдвэрээс харахад хувьцаа шилжүүлэх хэлцэл болон эрх шилжүүлэх гэрээг бичгээр байгуулж, нотариатаар баталгаажуулсан нь хуульд заасан хэлбэрийн шаардлагыг хангасан байна. Иймд хяналтын шатны шүүхийн шийдвэр нь үндэслэл бүхий болсон байна.



## ГУРАВ. ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

Уг судалгаагаар бэлэглэлийн гэрээг хүчингүйд тооцсон эсхүл хүчин төгөлдөр бус гэж үзсэн шүүхийн шийдвэрүүдийг шинжилж дүгнэхийг зорилоо. Энэ хүрээнд бусад улс оронд бэлэглэлийн гэрээг хүчингүйд тооцох зохицуулалтыг хэрхэн тусгасныг харьцуулан судлах шаардлага тулгарсан тул ХБНГУ, БНСУ, БНХАУ-ыг харьцуулан судлах улсаар сонгосон билээ. Дээрх улсуудын хуульд манай улсын ИХ-ийн 280 дугаар зүйлийн 280.1-д тусгагдсан бэлэглэлийн гэрээг хүчингүй болгох үндэслэлүүдтэй төстэй хэм хэмжээг зааж өгсөн байхаас гадна эрх зүйн бүл, газар зүйн онцлог зэргийн хамааралт нөхцөл байдлыг үндэслэн харьцуулан судлах боломжтой улсууд гэж үзлээ. Мөн эх газрын эрх зүйн бүлийн төлөөлөл болсон улсуудыг сонгосноороо судалгааны ач холбогдлыг нэмэгдүүлж байгаа болно.

### 3.1. ХБНГУ

ХБНГУ нь эх газрын эрх зүйн бүл улсуудын нэг тул төлөөлөл болгон сонгон судаллаа. ХБНГУ нь бэлэглэлийн гэрээтэй холбоотой харилцааг 1896 онд баталж, 1900 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжүүлж эхэлсэн ИК-оор зохицуулж байна. ХБНГУ-ын ИК-ын 4 дүгээр бүлэг буюу 516-534 дүгээр зүйлд бэлэглэлийн гэрээний тухай тусгажээ. ХБНГУ-ын ИК-ын 516 дугаар зүйлд *“Хэн нэг этгээд нь нөгөө этгээдэд хариу төлбөргүйгээр өөрийн өмчлөлийн тодорхой хөрөнгө шилжүүлэхийг зөвшөөрсөн бол*

*бэлэглэл гэж үзнэ<sup>22</sup>*” гэж зохицуулжээ. Энэхүү зохицуулалт нь манай улсын ИХ-ийн 276 дугаар зүйлийн 276.1-д “*Бэлэглэлийн гэрээгээр бэлэглэгч нь бэлэг хүлээн авагчийн зөвшөөрснөөр түүний өмчлөлд тодорхой хөрөнгө хариу төлбөргүй шилжүүлнэ*” гэж заасантай адил байна. Учир нь бэлэглэл нь талууд харилцан зөвшилцөх шинжээрээ хоёр талт хэлцлийн агуулгыг илэрхийлэх ба бэлэглэлийн гэрээний гол онцлог нь хариу төлбөргүй байдаг.

Түүнчлэн ХБНГУ-ын ИК-ын 530 дугаар зүйлийн 530.1-д “*Хэрэв бэлэг хүлээн авагч нь өөрийн ноцтой буруутай үйлдлийн улмаас бэлэглэгч, эсхүл түүний ойрын төрөл садны хүнийг бүдүүлгээр үл талархах байдал бий болгосон гэм буруутай бол бэлэглэлийг хүчингүй болгож болно<sup>23</sup>*”, 530.2-д “*Бэлэг хүлээн авагч нь бэлэглэгчийн амь насыг санаатайгаар, хууль бусаар хөнөөсөн эсхүл гэрээг хүчингүй болгоход саад учруулсан бол зөвхөн бэлэглэгчийн өвлөгч нь бэлэглэлийн гэрээг хүчингүй болгох эрхийг хэрэгжүүлнэ*” гэж зохицуулжээ.

Манай улсын ИХ-ийн 280 дугаар зүйлийн 280.1 дүгээр зүйлд заасан бэлэглэлийн гэрээг хүчингүйд тооцох нөхцөлтэй харьцуулахад адил төстэй байдлаар тусгасан байна. Гэхдээ ХБНГУ-ын Иргэний хуулийн 530.1 дэх заалт нь “бэлэг хүлээн авагчийн ноцтой үйлдлийн улмаас” гэж хэм хэмжээний шалтгаант холбоо бүхий зохицуулалтыг тусгаж өгснөөрөө илүү тодорхой болгож өгчээ. Түүнчлэн зөвхөн бэлэглэгчийг гомдоосон үйлдэлд бус, бэлэглэгчийн ойрын төрөл садны хүнийг гомдоосон ноцтой үйлдэл нь гэрээг хүчингүйд тооцох үндэслэл болж байгаагаараа манай улсын ИХ-ийн 280 дугаар зүйлийн 280.1.1 дэх заалтаас ялгаатай байна.

<sup>22</sup> ХБНГУ-ын Иргэний кодекс, <https://www.gesetze-im-internet.de/> (2022 оны 06 дугаар сарын 20-ны өдөр хамгийн сүүлд нэвтрэн үзсэн)

<sup>23</sup> ХБНГУ-ын Иргэний кодекс, <https://www.gesetze-im-internet.de/> (2022 оны 06 дугаар сарын 20-ны өдөр хамгийн сүүлд нэвтрэн үзсэн)

ХБНГУ-ын шүүх тухайн маргааныг шийдвэрлэх замаар “бэлэг хүлээн авагчийн ямар үйлдлийг ноцтой гэж үзэх вэ?” гэдгийг бүрэн тогтоодог байна. ХБНГУ-ын хувьд бэлэг хүлээн авагч нь бэлэглэгчийн амь насыг санаатайгаар, хууль бусаар хөнөөсөн, эсхүл гэрээг хүчингүй болгоход саад учруулсан бол зөвхөн бэлэглэгчийн өвлөгч нь “Бэлэглэлийн гэрээ”-г хүчингүй болгох эрхийг хэрэгжүүлэхээр заасныг харьцуулан үзэхэд (1) бэлэг хүлээн авагч нь бэлэглэгчийн эрүүл мэндэд хохирол, гэмтэл учруулсан тохиолдолд ХБНГУ-ын ИК-ын 530.2 дахь хэсэгт үл хамаарах бөгөөд харин ИК-ын 530.1-д хамаарахаар байна, (2) Манай улсын ИХ-д амь нас хохироохыг завдсан үйлдэл нь гэрээг хүчингүйд тооцох нөхцөл болохыг заасан бол ХБНГУ-ын ИК-ын 530-д тус үйлдлийг зааж өгөөгүйгээрээ ялгаатай байна, (3) ХБНГУ-ын ИК-д гэрээг хүчингүй болгоход саад учруулсан үйлдэл гаргасан бол бэлэглэлийн гэрээг хүчингүйд тооцох нөхцөлд заасан бол манай улсын ИХ-д тус үндэслэлийг зааж өгөөгүй, (4) манай улсын ИХ-д бэлэглэгч, түүний төрөл төрөгсдийн амь нас, эрүүл мэндийг хохироосон, хохироохыг завдсан бол бэлэглэлийн гэрээг хүчингүйд тооцох нөхцөлд тооцсон бол ХБНГУ-ын ИК-д зөвхөн бэлэглэгчийн амь насыг хөнөөсөн бол гэрээг хүчингүйд тооцохоор зааж өгснөөрөө ялгаатай байна. Үүнээс харахад, ХБНГУ-ын ИК-ын 530.1 дэх хэсэгт заасан *“бэлэг хүлээн авагч нь өөрийн ноцтой буруутай үйлдлийн улмаас бэлэглэгч эсхүл түүний ойрын төрөл садны хүнийг бүдүүлгээр үл талархах байдал бий болгосон”* гэдэгт бэлэглэгчийн болон түүний төрөл төрөгсдийн эрүүл мэндэд хохирол, гэмтэл учруулсан, амь насыг хөнөөсөн болон хөнөөхийг завдсан үйлдлүүд хамаарахаар байна.

ХБНГУ-ын ИК-ын 530 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу бэлэглэлийн гэрээг хүчингүй болгоход бэлэг хүлээн авагч нь бэлэглэгчийн эсрэг “ноцтой буруутай үйлдэл” хийсэн байхыг урьдчилсан нөхцөл болгодог. Объектив талаас нь харвал, зүй бус үйлдлийн хэр хэмжээ нь өндөр, субъектив талаас нь харвал,

үл талархах байдлын илэрхийлэл нь ноцтой байх ёстой<sup>24</sup> гэж ХБНГУ-ын ИК-ын шинжлэх ухааны тайлбарт дурджээ. Үүнээс харахад, ХБНГУ-ын ИК-ын 530 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “ноцтой буруутай үйлдэл” гэж заасан нөхцөл нь бэлэг хүлээн авагчийн үйлдлийн объектив талыг, бүдүүлгээр үл талархах байдал бий болгосон гэж заасан нөхцөл нь бэлэг хүлээн авагчийн үйлдлийн субъектив талыг илэрхийлж байна. Жишээлбэл: ХБНГУ-ын хувьд ноцтой гомдоосон үйлдэл гэдэгт гүтгэлэг, хүчирхийлэл, бэлэглэгчийн эсрэг бэлэг хүлээн авагч нь асран хамгаалах үүргээ умартах, гэр бүлийн зохисгүй үйлдлүүдийг хамааруулдаг.<sup>25</sup> Бэлэг хүлээн авагч нь бэлэглэгчтэй харилцан зөвшилцөлгүйгээр бэлэглэлийн зүйлийг худалдсан бол тус үйлдлийг ноцтой буруутай үйлдэл гэж үздэггүй.<sup>26</sup>

### 3.2. БНХАУ

БНХАУ-ын Иргэний хууль нь ерөнхий болон тусгай заалтуудаас бүрддэг. Ерөнхий ангийн заалтуудыг 2017 оны 03 дугаар сарын 15-ны өдөр баталж, 2017 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрджээ. Харин тусгай ангийн заалтуудыг 2018 оны 08 дугаар сарын 27-ны өдөр Бүх Хятадын Ардын Төлөөлөгчдийн хуралд өргөн барьж, 2020 оны 05 дугаар сарын 28-нд болсон Бүх Хятадын Ардын Төлөөлөгчдийн XIII их хурлын чуулганаар баталсан байдаг. Улмаар БНХАУ анхны иж бүрэн системчлэгдсэн Иргэний хуультай болж, 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хэрэгжүүлж эхэлсэн түүхтэй.

Хятад Улсын ИХ-ийн 11 дүгээр бүлэг буюу 657-666 дугаар зүйлд бэлэглэлийн гэрээний харилцааг зохицуулжээ. Хятад

<sup>24</sup> Dannemann/Schule, (2020), German Civil code: Article by Article Commentary, Volume I: Books 1-3, p.935

<sup>25</sup> Dannemann/Schule, (2020), German Civil code: Article by Article Commentary, Volume I: Books 1-3, p.935

<sup>26</sup> Dannemann/Schule, (2020), German Civil code: Article by Article Commentary, Volume I: Books 1-3, p.935

Улсын Иргэний хуулийн 657 дугаар зүйлд “Бэлэглэгч нь бэлэг хүлээн авагчид өөрийн эд хөрөнгийг үнэгүй/хариу төлбөргүйгээр (*gratuitously*) шилжүүлэх, бэлэг хүлээн авагч нь тус илэрхийллийг хүлээн зөвшөөрсөн хэлцлийг бэлэглэлийн гэрээ гэнэ”<sup>27</sup> гэж зохицуулжээ. Бэлэглэлийн гэрээг хүчингүй болгох харилцааг ИХ-ийн 663 дугаар зүйлд зохицуулжээ. БНХАУ-ын ИХ-ийн 663 дугаар зүйлд “Бэлэг хүлээн авагч нь дараах үйлдлийн аль нэгийг хийсэн тохиолдолд бэлэглэгч нь бэлэглэлийг хүчингүй (*revoke*) болгож болно: (1) Бэлэглэгч эсхүл түүний ойрын төрөл төрөгсдийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг ноцтой (эсхүл бүдүүлгээр) зөрчсөн (*infring*); (2) Бэлэглэгчийг дэмжин туслах үүрэгтэй боловч тус үүргээ биелүүлээгүй, эсхүл; (3) Бэлэглэлийн гэрээгээр тохиролцсон үүргээ биелүүлээгүй”<sup>28</sup> гэж зохицуулжээ.

Түүнчлэн БНХАУ-ын ИХ-ийн 664 дүгээр зүйлд “Бэлэг хүлээн авагчийн хууль бус үйлдлийн улмаас бэлэглэгч нас барсан эсхүл иргэний эрх зүйн чадамжгүй болсон бол бэлэглэгчийн өвлөгч эсхүл хууль ёсны асран хамгаалагч нь бэлэглэлийг хүчингүй болгож болно”<sup>29</sup> гэж хуульчилжээ. Манай улсын хувьд бэлэглэгчийг гомдоосон ноцтой үйлдэл гэдэгт бэлэглэгчийн дэмжин туслах үүрэг, гэрээгээр тохиролцсон үүргээ биелүүлээгүй үйлдэл болон бэлэглэгч, эсхүл түүний ойрын төрөл төрөгсдийн хууль ёсны эрх ашиг сонирхлыг ноцтой зөрчсөн үйлдлүүдийг багтааж ойлгож, хэрэглэж байна. Харин Хятад Улсын Иргэний хуульд дээрх үндэслэлүүдийг тусад нь объектив байдлаар зааж өгснөөрөө ялгаатай байна.

Түүнчлэн манай улсын хувьд тусгай зориулалттай хийсэн бэлэглэлийн гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд бэлэглэгчийг гомдоосон ноцтой үйлдэл гэж үзэж байгаа бол Хятад Улсын хувьд тус нөхцөлийг тусгайлан зааж, бэлэглэгчийн гэрээг

<sup>27</sup> БНХАУ-ын Иргэний хууль, [www.gov.cn](http://www.gov.cn)

<sup>28</sup> БНХАУ-ын Иргэний хууль, [www.gov.cn](http://www.gov.cn)

<sup>29</sup> БНХАУ-ын Иргэний хууль, [www.gov.cn](http://www.gov.cn)

хүчингүйд тооцох нэг нөхцөлд багтаажээ. Манай улсын шүүхийн практикт эцэг эх нь хүүхдүүдээ дэмжих туслах, хүүхдүүд нь эцэг эхээ дэмжин туслах зорилготой хийсэн бэлэглэлийн гэрээг тусгай зориулалттай бэлэглэлийн гэрээнд тооцож, тусгайлан заасан тохиолдолд бэлэглэгчийг гомдоосон ноцтой үйлдэл гэж үзэж, шийдвэрлэж буй юм. Харин БНХАУ-ын хувьд тусгай зориулалттай бэлэглэл болон дэмжин туслах үүрэг гэдгийг өөр байдлаар хуульчилснаараа онцлог байна.

### 3.3. БНСУ

БНСУ-ын Иргэний хууль (Civil act) 1958 оны 02-р сарын 22-ны өдөр батлагдсан.<sup>30</sup> Солонгос Улсын Иргэний хууль нь Хятадын нөлөө, Германы нөлөө гэсэн хоёр томоохон хэсэгт хуваагддаг байна. Солонгос Улсын Иргэний хууль нь пандектын системийг баримталсан бөгөөд Иргэний хуулиа боловсруулахдаа ХБНГУ-ын Иргэний хууль (BGB)-ийг харгалзсанаараа онцлогтой.<sup>31</sup>

Солонгос Улсын Иргэний хуулийн II дэд хэсэгт буюу 554-562 дугаар зүйлд бэлэглэлийн гэрээний харилцааг зохицуулжээ. Тус улсын Иргэний хуулийн 554 дүгээр зүйлд *“Бэлэглэлийн гэрээ нь гэрээний аль нэг тал нь өөрийн өмчлөлийн хөрөнгийг үнэ төлбөргүйгээр шилжүүлэхийг мэдэгдэж, нөгөө тал нь тухайн эд хөрөнгийг шилжүүлэн авахыг зөвшөөрснөөр хүчин төгөлдөр болно”*<sup>32</sup> гэж заасан. Энэхүү зохицуулалт нь эх газрын эрх зүйн тогтолцоо бүхий улсуудын адилаар бэлэглэгч нь өөрийн өмчлөлийн эд хөрөнгөө үнэ төлбөргүйгээр шилжүүлэх, бэлэг хүлээн авагч нь тус саналыг хүлээн зөвшөөрөх үндсэн шинжийг тусгаж өгчээ. Түүнчлэн Солонгос Улсын Иргэний хуулийн 556 дугаар зүйлд *“Бэлэглэлийн гэрээ”-г цуцлах нөхцөл болон бэлэг хүлээн авагчийн хууль бус үйлдлүүдийг зааж өгчээ. Тухайлбал:*

<sup>30</sup> [www.koreanlii.or.kr](http://www.koreanlii.or.kr)

<sup>31</sup> [www.koreanlii.or.kr](http://www.koreanlii.or.kr)

<sup>32</sup> БНСУ-ын Иргэний хууль, [www.elaw.klri.re.kr](http://www.elaw.klri.re.kr)

556 дугаар зүйлийн 556.1-д “Бэлэглэгч нь дор дурдсан бэлэг хчлээн авагчийн үйлдлүүдийн улмаас бэлэглэлийн гэрээг цуцалж болно”, 556.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Бэлэг хчлээн авагч нь бэлэглэгч болон түүний эхнэр эсхүл нөхөр, цусан төрлийн төрөл төрөгсдийнх нь эсрэг гэмт хэрэг үйлдсэн бол”, 2 дахь хэсэгт “Бэлэг хчлээн авагч нь бэлэглэгчийг дэмжин туслах цүрэгтэй бөгөөд тус цүргээ биелцүлээгүй бол”<sup>33</sup> гэж тусгажээ.



---

<sup>33</sup> БНСУ-ын Иргэний хууль, [www.elaw.klri.re.kr](http://www.elaw.klri.re.kr)

## **ДҮГНЭЛТ**

***ИХ-ийн 280 дугаар зүйлийн 280.1.1 дэх заалтыг хэрэглэж буй шүүхийн практик, хууль хэрэглээний асуудал:***

Аливаа этгээдийн хийсэн үйлдлийг ноцтой, эсхүл ердийн гэж үзэх нь харьцангуй ойлголт бөгөөд үнэлэлт, дүгнэлт өгч байгаа этгээдийн субъектив итгэл үнэмшлээс ихээхэн хамааралтай тул объектив шалгуурыг харгалзан шийдвэрлэх шаардлага бий болсон. Энэхүү объектив шалгуур зөрчигдөх дүрмийн бус тохиолдол нь бусдын эрх, ашиг сонирхлыг санаатайгаар зөрчих нь буруу болно гэсэн үзэл санаа болно. Энэ үүднээс хуулийг хэрэглэхдээ ИХ-ийн 280 дугаар зүйлийн 280.1.1-д заасан “гомдоосон ноцтой үйлдэл” гэдгийг хэрхэн ойлгох нь тодорхойгүй боловч санаатайгаар бэлэглэгчийг гомдоосон үйлдэл нь ноцтой үйлдэлд шууд хамаарахаар байна. ИХ-ийн 280 дугаар зүйлийн 280.1.1-д заасан заалтын хүрээнд шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрүүдийг шинжилж дүгнэхэд, гомдоосон ноцтой үйлдэл гэдэгт (1) бэлэглэлийн гэрээний зорилго, эсхүл болзлыг биелүүлээгүй, (2) бэлэглэгчийн нэр төр, алдар хүндэд халдсан, (3) бэлэглэгчийн болон түүний төрөл төрөгсдийн амь насанд халдсан үйлдэл хийсэн, (4) бэлэг хүлээн авагч нь бэлэглэгчийн болон төрөл төрөгсдийн эрүүл мэндэд гэмтэл, хохирол учруулсан үйлдэл, (5) бэлэглэгчийг ноцтой гомдоосон үйлдлүүд хамаарч байна.



Шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийж үзэхэд ИХ-ийн 280 дугаар зүйлийн 280.1.1-д заасан үндэслэлээр “бэлэглэлийн гэрээ”-г хүчингүй болгоход шүүхийн зүгээс (1) бэлэглэлийн зүйл нь бэлэглэгчийн өмчлөлийн хөрөнгө мөн эсэх, буцаан шаардах хөрөнгө мөн эсэх, (2) бэлэглэгч бэлэг хүлээн авагчийг тус үйлдэл хийхэд өдөөн хатгасан эсэх, (3) бэлэг хүлээн авагчийн тус үйлдлийг бэлэглэгч хувь хүний хувьд хүлцэн тэвчиж, ойлгох боломжтой байсан эсэх, (4) бэлэглэлийн гэрээг хүчингүйд тооцох нэхэмжлэл гаргах хөөн хэлэлцэх хугацаа дууссан эсэх, (5) бэлэг хүлээн авагчийн үйлдлийн хэр хэмжээ, гэм буруугийн хэлбэрийг харгалзаж байна.

ИХ-ийн 280 дугаар зүйлийн 280.1.1 дэх заалтыг (1) бэлэг хүлээн авагч бэлэглэгчийг гомдоосон эсэхийг харгалзахаас илүүтэй ноцтой үйлдэл хийсэн эсэхийг илүү тодруулж байна; (2) бэлэглэлийн зүйлийг хүлээн авсан бэлэг хүлээн авагч нь бэлэглэлийн зүйлийг захиран зарцуулсан тохиолдолд тус үйлдлийг бэлэглэгчийг гомдоосон ноцтой үйлдэл гэж үзэхгүй байх тохиолдол нийтлэг байна; (3) тусгай зориулалттай хийсэн бэлэглэлийн гэрээний үүргийг биелүүлээгүй тохиолдолд тус үйлдлийг бэлэглэгчийг гомдоосон ноцтой үйлдэл гэж үзэж байна; (4) тусгай зориулалттай хийсэн бэлэглэлийн гэрээнээс татгалзах болон гэрээг хүчингүй болгох гэсэн үндэслэлүүдийг ялгаж хэрэглэхгүй байх зөрчил гарч байна; (5) ИХ-ийн 280 дугаар зүйлийн 280.1.2-д заасан бэлэглэлийн гэрээг хүчингүйд тооцох үндэслэлийг ИХ-ийн 280 дугаар зүйлийн 280.1.1 дэх заалтад буй гомдоосон ноцтой үйлдэл гэсэн үндэслэлд хамааруулж шийдвэрлэж буй юм.

***Гэр бүлийн гишүүдийн хамтран өмчлөх дундын эд хөрөнгийг бусдад бэлэглэсэн, халхавчилж хийсэн хэлцэлтэй холбоотой маргааныг шийдвэрлэж буй шүцхийн практик ба дүгнэлт:***

Гэр бүлийн гишүүдийн хамтран өмчлөх дундын эд хөрөнгийг бусдад бэлэглэсэнтэй холбоотой маргааныг Улсын Дээд шүүх шийдвэрлэхдээ ИХ-ийн 56 дугаар зүйлийн 56.1.1 болон 56.1.8 дахь заалтыг салгаж хэрэглэх, эсхүл хамтатган хэрэглэсэн хууль хэрэглээний асуудал гарч байна. Гэхдээ шүүхийн практикт гэр бүлийн гишүүн нь хамтран өмчлөх дундын эд хөрөнгийг гэр бүлийн насанд хүрсэн гишүүний зөвшөөрөлгүйгээр бэлэглэсэн тохиолдолд гэрээг ИХ-ийн 56 дугаар зүйлийн 56.1.1, эсхүл 56.1.8-д заасан үндэслэлээр хүчин төгөлдөр бус байх хэлцэл гэж шийдвэрлэжээ. Мөн гэр бүлийн гишүүдийн хамтран өмчлөх дундын эд хөрөнгийг хууль зөрчиж бусдад бэлэглэсэн бол ИХ-ийн 56 дугаар зүйлийн 56.1.8 дахь зохицуулалтыг хэрэглэх нь зүйтэй гэж судлаачдын зүгээс үзэж байна. Учир нь ИХ-ийн 128 дугаар зүйлийн 128.1-д “Гэр бүлийн гишүүд нь хамтран өмчлөх дундын эд хөрөнгөө эзэмшиж, ашиглах, захиран зарцуулах адил эрх эдэлж, **харилцан тохиролцсоны үндсэн дээр эд хөрөнгөө эзэмшиж, ашиглаж, захиран зарцуулна**”, 128.2-д “Гэр бүлийн гишүүдийн хэн нэг нь хамтран өмчлөх дундын өмчийн үл хөдлөх эд хөрөнгөө **захиран зарцуулахдаа гэр бүлийн насанд хүрсэн гишүүний бичгээр гаргаж, нотариатаар гэрчлүүлсэн зөвшөөрлийг авна**”, 128.3-д “Хуульд өөрөөр заагаагүй бол энэ хуулийн 128.2-д заасны дагуу зөвшөөрөл аваагүй хийсэн хэлцэл хүчин төгөлдөр бус байна” гэж зохицуулжээ. Хэдийгээр ИХ-ийн 128.3 дахь хэм хэмжээ нь хориглосон хэм хэмжээ мөн боловч энэ тохиолдолд ИХ-ийн 56 дугаар зүйлийн 56.1.8-д “**хуульд заасан тохиолдолд зохих этгээдийн зөвшөөрөлгүй хийсэн хэлцэл**” гэж заасны дагуу тус зохицуулалтыг хэрэглэх нь зүйтэй байна.

Шүүхийн практикт хамтран өмчлөх дундын эд хөрөнгийн хуваарилалттай холбоотой маргааныг эцэслэн шийдвэрлээгүй байх үед тухайн хөрөнгийг бусдад худалдах, ойр дотнын хүмүүстээ бэлэглэлийн журмаар шилжүүлэх үйлдлийг гаргадаг. Энэ тохиолдолд гэр бүлийн гишүүдийн хамтран өмчлөх дундын

эд хөрөнгийн өмчийн эрх зөрчигдөх тул тэрхүү өмчийн эрхийг хамгаалах зохицуулалтыг ИХ-ийн 128 дугаар зүйлийн 128.2, 128.3 болон 56 дугаар зүйлийн 56.1.8-д тусгасан байна.

Шүүхийн шийдвэрүүдийг судлан үзэхэд, бэлэглэлийн гэрээг татвараас зайлсхийх болон татварын орлогыг бага болгож харагдуулах, түүнтэй холбоотой бага татвар төлөх зорилгоор их байгуулжээ. Халхавч хэлцлийн хувьд ИХ-ийн 56 дугаар зүйлийн 56.1.3-д заасны дагуу хийсэн үеэсээ эхлэн хүчин төгөлдөр бус байна. Харин халхавчлагдаж буй хэлцэл нь хуулиар заасан шаардлагуудыг хангаж байгаа тохиолдолд шүүх талуудын хүсэл зоригийг харгалзан хүчин төгөлдөр гэж үздэг. Гэтэл зарим шүүхийн шийдвэрүүдийг шинжилж дүгнэхэд, бэлэглэлийн гэрээг ИХ-ийн 56 дугаар зүйлийн 56.1.3 дахь зохицуулалтын дагуу хүчин төгөлдөр бус гэж үзсэн боловч халхавчлагдаж буй хэлцлийн үр дагаврыг шийдвэрлэхгүйгээр орхиж шийдвэрлэх тохиолдол гарч байна. Түүнчлэн ИХ-ийн 56 дугаар зүйлийн 56.1.3-д заасан үндэслэлээр бэлэглэлийн гэрээг хүчин төгөлдөр бус гэж тооцуулахаар нэхэмжлэл гаргаж буй этгээд нь бэлэглэгч байдаг. Олж буй ашгийнхаа хувиар орлогын албан татвар төлөх үүрэг нь ашиг олж буй бэлэглэгчид үүсэх ёстой. Бэлэглэгч энэхүү үүргээсээ зайлсхийх зорилгоор бэлэглэлийн гэрээ байгуулж байна. Гэтэл нэхэмжлэгч буюу бэлэглэгч нь нэхэмжлэл гаргаж, тухайн хэлцлийг хүчин төгөлдөр буст тооцож, авсан өгснөө буцаах үр дагаврыг үүсгэж байгаа нь бэлэг хүлээн авагч (бодит байдалд худалдан авагч болно)-ийн эрхийг зөрчиж байгаа үйлдэл болж байна. Иймээс халхавчлагдаж буй хэлцлийн хүчин төгөлдөр эсэх асуудлыг дээрх маргааныг шийдвэрлэх замаар зөвтгөх нь шүүхийн чиг үүрэгт нийцнэ гэж үзлээ. Мөн шүүхийн шийдвэрүүдийг түүвэрлэн судалж үзэхэд, бэлэглэлийн гэрээг хүчин төгөлдөр бус гэж тооцуулахаар маргаж байгаа үндэслэл нь халхавчлагдаж буй хэлцлийн төлбөрийг төлөөгүй эсхүл дутуу

төлсөн, эсхүл наймаанаасаа эргэж буцах зэрэг асуудалтай холбоотой байна.

Шүүхийн зүгээс халхавчлагдаж буй хэлцлийн хүчин төгөлдөр эсэхийг шийдвэрлэхдээ ИХ-ийн 56 дугаар зүйлийн 56.1.10 заалтыг хэрэглэж байна. Монгол Улсын Дээд шүүх 2010 оны 06 дугаар сарын 22-ны өдөр 17 дугаартай “Иргэний хуулийн 5, 6, 7 дугаар бүлгийн зарим зүйл заалтыг тайлбарлах тухай” тогтоолоор ИХ-ийн 56 дугаар зүйлийн 56.1.10 заалтыг тайлбарлажээ. Тус тогтоолд **“хүчин төгөлдөр бус хэлцлийн үндсэн дээр хийсэн бусад хэлцэл”** гэдэгт *хүчин төгөлдөр бус хэлцэлтэй шалтгаант нөхцөл байдлаар саллигцй холбогдсон, энэ хэлцэл хүчин төгөлдөр бус болсноор эрх зүйн үндэслэл нь үгцйсгэгдэх хэлцлийг хамааруулан ойлговол зохино. Хүчин төгөлдөр бус хэлцлийн дараа хэлцлийн зүйл болох эд хөрөнгө болон эрхийн талаар хийсэн хэлцэл болгоныг хүчин төгөлдөр бус гэж үзэх үндэслэлийг уг заалтын зохицуулалт үцсгэхгүй”* гэж тайлбарласан. Өөрөөр тайлбарлавал, үндсэн зээлийн гэрээ хүчин төгөлдөр бус болсон тохиолдолд түүнтэй туслах байдлаар хийгдсэн барьцааны гэрээ хүчин төгөлдөр бус байна гэсэн үг юм. Гэтэл энэхүү тайлбарыг буруу хэрэглэж, бэлэглэлийн гэрээ хүчин төгөлдөр бус тохиолдолд халхавчлагдаж буй хэлцэл хүчин төгөлдөр бус гэж шийдвэрлэх нь буруу юм. **Халхавчлах зорилгоор хийсэн хэлцлийн цаана хэлцэл хийгч талуудын хүсэж буй хэлцэл нуугдаж буй бөгөөд халхавчлах зорилгоор хийсэн хэлцэл хүчин төгөлдөр бус байхад, халхавчлагдаж буй хэлцэл хүчин төгөлдөр бус байна гэсэн үг биш юм.**

Мөн шүүхийн шийдвэрүүдийг судлан үзэхэд, тухайн маргаан бүхий бэлэглэлийн гэрээ нь ИХ-ийн 56 дугаар зүйлийн 56.1-д заасны дагуу хүчин төгөлдөр бус гэрээ байх атал тус гэрээг ИХ-ийн 280 дугаар зүйлийн 280.1.1-д заасан үндэслэлээр хүчингүйд тооцож шийдвэрлэсэн тохиолдол байна. Анхан болон

давж заалдах шатны шүүхийн зүгээс маргаан бүхий бэлэглэлийн гэрээг ИХ-ийн 280 дугаар зүйлийн 280.1.1-д заасан үндэслэлээр хүчингүйд тооцож шийдвэрлэсэн бол Улсын Дээд шүүх нь анхан, давж заалдах шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож, бэлэглэлийн гэрээг ИХ-ийн 56 дугаар зүйлийн 56.1.3-д заасан үндэслэлээр хүчин төгөлдөр буст тооцож, халхавчлагдсан хэлцлийг хүчин төгөлдөр гэж шийдвэрлэсэн байна. ИХ-ийн 280 дугаар зүйлийн 280.1.1-д заасан үндэслэлээр бэлэглэлийн гэрээг хүчингүйд тооцохын өмнө тухайн гэрээ нь ИХ-ийн 56 дугаар зүйлийн 56.1-д заасны дагуу хүчин төгөлдөр эсэхэд дүгнэлт өгөх хэрэгтэй юм. Учир нь гэрээ байгуулагдсан боловч тухайн гэрээ хүчин төгөлдөр байгаа тохиолдолд ИХ-ийн 280 дугаар зүйлийн 280.1.1 дэх зохицуулалт нь хэрэглэгдэх боломжтой болно. Харин ИХ-ийн 56 дугаар зүйлийн 56.1-д заасны дагуу хүчин төгөлдөр бус гэрээ байгаа тохиолдолд ИХ-ийн 280 дугаар зүйлийн 280.1.1 дэх зохицуулалт хэрэглэгдэхгүй. Иймээс шүүхийн зүгээс ИХ-ийн 280 дугаар зүйлийн 280.1 болон мөн хуулийн 56 дугаар зүйлийн 56.1 дэх хэм хэмжээг хэрэглэхдээ дээрх хууль хэрэглээний асуудлыг анхаарах шаардлагатай.

***“Бэлэглэлийн гэрээ”-г хүчингүйд тооцохтой холбоотой харьцуулсан судалгааны дүгнэлт:***

“Бэлэглэлийн гэрээ”-г хүчингүйд тооцохтой холбоотой хэм хэмжээг харьцуулан судлах зорилгоор эх газрын эрх зүйн бүлийн улс орнууд болох ХБНГУ, БНСУ, БНХАУ-ын Иргэний хуулиудыг сонгон авч судалсан болно. Харьцуулсан судалгаанаас үзэхэд, бэлэглэлийн гэрээг хүчингүйд тооцох нөхцөлүүдийг дээрх улс орнууд Иргэний хуульдаа тодорхой зааж өгсөн байна. Тухайлбал: ХБНГУ-ын хувьд манай улсын адилаар “Хэрэв бэлэг хүлээн авагч нь өөрийн ноцтой буруутай үйлдлийн улмаас бэлэглэгч, эсхүл түүний ойрын төрөл садны хүнийг бүдүүлгээр үл талархах байдал бий болгосон гэм буруутай бол бэлэглэлийг

хүчингүй болгож болно”<sup>34</sup> гэж зохицуулсан. Гэхдээ ХБНГУ-ын Иргэний хуулийн 530.1 дэх заалт нь “бэлэг хүлээн авагчийн ноцтой үйлдлийн улмаас” гэж хэм хэмжээний шалтгаант холбоо бүхий зохицуулалтыг тусгаж өгснөөрөө илүү тодорхой болгож өгчээ. Түүнчлэн зөвхөн бэлэглэгчийг гомдоосон үйлдэлд бус, бэлэглэгчийн ойрын төрөл садны хүнийг гомдоосон ноцтой үйлдэл нь гэрээг хүчингүйд тооцох үндэслэл болж буйгаараа манай улсын ИХ-ийн 280.1.1 дэх заалтаас ялгаатай байна.

Харин БНХАУ-ын хувьд “Бэлэглэгч эсхүл түүний ойрын төрөл төрөгсдийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг ноцтой (эсхүл бүдүүлгээр) зөрчсөн (*infring*) бол бэлэглэлийн гэрээг хүчингүйд тооцно” гэж заасан. Дээрх зохицуулалт нь манай улсын Иргэний хуулийн 280 дугаар зүйлийн 280.1.1 дэх хэм хэмжээтэй төстэй боловч бэлэглэгчээс гадна ойрын төрөл төрөгсдийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг ноцтой зөрчсөн гэж тусгаснаараа ялгаатай аж. Хууль ёсны эрх, ашиг сонирхлыг зөрчих гэдэгт хуулиар олгогдсон эрх, ашиг сонирхлыг зөрчих үйлдэл, эс үйлдлүүдийг ойлгох бөгөөд тухайн үйлдэл нь бэлэглэгч болон бэлэглэгчийн ойрын төрөл, төрөгсдийг илт бүдүүлгээр гомдоосон “ноцтой” үйлдэл байхыг шаардсанаараа онцлогтой. Үүнийг гомдоосон ноцтой үйлдэл гэдэгтэй төсөөтэй байдлаар ойлгож болохоор байна. Гэхдээ ямар үйлдлийг ноцтой үйлдэл гэж үзэх вэ гэдгийг шүүх тогтоож байгаагаараа адил юм.

БНСУ-ын Иргэний хуульд гомдоосон ноцтой үйлдэл гаргасан тохиолдолд бэлэглэлийн гэрээг хүчингүйд тооцох нөхцөлийг зааж өгөөгүй байна. Гомдоосон ноцтой үйлдэлд бэлэг хүлээн авагчийн санаатай үйлдсэн гэм буруутай үйлдэл шууд байдлаар хамаарна гэдгийг дээрх улс орнууд хүлээн зөвшөөрч байна. Иймээс манай улс ИХ-ийн 280 дугаар зүйлийн 280.1.1 дэх хэм хэмжээг илүү тодорхой байдлаар тусгаж, гомдоосон ноцтой үйлдэлд ямар

<sup>34</sup> ХБНГУ-ын Иргэний кодекс, [www.gesetze-im-internet.de](http://www.gesetze-im-internet.de) (2022 оны 06 дугаар сарын 20-ны өдөр хамгийн сүүлд нэвтрэн үзсэн)

үйлдэл хамаарахыг объектив байдлаар тусгах нь зүйтэй.

Манай улс болон ХБНГУ-ын Иргэний хуульд тусгай зориулалттай нөхцөл, зорилго заасан “Бэлэглэлийн гэрээ”-ний харилцааг бэлэглэлийн гэрээг цуцлах, хүчингүйд тооцох хэм хэмжээнээс ялгаатай байдлаар зохицуулсан. ХБНГУ-ын хувьд гэрээнд заасан нөхцөлийг үл биелүүлсэн тохиолдолд бэлэг хүлээн авагчийг үндэслэлгүй хөрөнгөжсөн гэсэн үндэслэлээр бэлгийг буцаан шаардах эрхтэй гэж тусгажээ. Харин манай улсын хувьд *“Бэлэг хүлээн авах эрх бүхий этгээд гэрээнд заасан болзол буюу зорилгыг биелүлээгүй бол бэлэглэгч гэрээнээс татгалзаж болно”* гэж заажээ. Үүнээс харахад, ХБНГУ болон Монгол Улсын Иргэний хуульд бэлэглэлийн гэрээнд заасан тусгай нөхцөлийг биелүлээгүй тохиолдолд гэрээг хүчингүйд тооцох бус харин гэрээг цуцлах, татгалзах байдлаар буцаан шаардах зохицуулалтыг зааж өгчээ. Харин БНХАУ болон БНСУ-ын Иргэний хуульд “Бэлэглэлийн гэрээ”-нд заасан тусгай нөхцөлийг бэлэг хүлээн авагч биелүлээгүй бол гэрээг хүчингүйд тооцож, бэлэглэсэн зүйлийг буцаан шаардах зохицуулалтыг тусгаж өгснөөрөө ялгаатай байна. БНСУ болон БНХАУ-ын Иргэний хуульд бэлэглэгчийг дэмжин туслах үүрэгтэй боловч тус үүргээ биелүлээгүй бол бэлэглэлийг хүчингүйд тооцох үндэслэл байхаар тусгаснаараа адил байна. Харин манай улс болон ХБНГУ-ын Иргэний хуульд дэмжин туслах үүрэг гэдгийг зааж өгөөгүй. Дэмжин туслах үүргийг гэрээний тусгай нөхцөл болгож, бичгээр байгуулсан гэрээнд тусгайлан заасан тохиолдолд гэрээний үүрэг байхаар зохицуулжээ. БНСУ-ын Иргэний хуулийн зохицуулалтаас үзэхэд, дэмжин туслах үүргийг бэлэглэлийн гэрээнд зааж өгсөн тохиолдолд хэрэглэгдэх байдлаар тусгасан байна. Харин БНХАУ-ын Иргэний хуульд (1) *Бэлэглэгчийг дэмжин туслах үүрэгтэй боловч тус үүргээ биелүлээгүй, эсхүл;* (2) *Бэлэглэлийн гэрээгээр тохиролцсон үүргээ биелүлээгүй* гэж

хоёр өөр нөхцөлийг зааж өгснөөрөө ялгаатай юм. Эхний нөхцөл нь бэлэглэгч эд хөрөнгөгүй болсон эсхүл асран дэмжих үүрэг хүлээсэн этгээд дэмжээгүй тохиолдолд хэрэглэгдэх юм. Харин хоёр дахь тохиолдол нь бэлэглэлийн гэрээгээр тусгайлан заасан үүргээ биелүүлээгүй тохиолдолд хэрэглэнэ. Эхний тохиолдол нь манай улсын ИХ-ийн 280 дугаар зүйлийн 280.1.1 дэх нөхцөлтөй, хоёр дахь тохиолдол нь тусгай зориулалттай хийсэн бэлэглэлтэй адил байна. Нийтлэг байдлаар ХБНГУ, БНСУ, БНХАУ-ын Иргэний хуульд бэлэглэлийн гэрээг хүчингүйд тооцох нөхцөлд бэлэг хүлээн авагч нь бэлэглэгчийн эсхүл түүний цусан төрөл төрөгсдийн эсрэг гэмт хэрэг үйлдсэн, эрүүл мэнд, амь насанд нь халдсан тохиолдолд бэлэглэлийн гэрээг хүчингүйд тооцох зохицуулалтыг тусгажээ.



## САНАЛ

*Дээрх судалгааны дүгнэлтэд тулгуурлан дараах судалгааны саналыг гаргаж байна.*

Хэм хэмжээг сайжруулахтай холбоотой санал:

- 1) ИХ-ийн 280 дугаар зүйлийн 280.1.1-д тусгасан “гомдоосон ноцтой үйлдэл хийсэн” гэсэн зохицуулалтыг эрх зүйн тодорхой байдлын зарчимд нийцүүлж, өөрчлөн тусгах;  
Тухайлбал: ИХ-ийн 280 дугаар зүйлийн 280.1.1 дэх зохицуулалтыг “Бэлэг хүлээн авагч нь бэлэглэгч болон түүний гэр бүлийн гишүүд, цусан төрөл төрөгсдийн нэр төр, алдар хүнд, бэлгийн халдашгүй байдал зэрэгт илт бүдцүлгээр халдсан, хуулиар хүлээсэн дэмжин туслах үүргээ биелүлээгүй, эсхүл бэлэглэгч болон түүний гэр бүлийн гишүүд, цусан төрөл төрөгсдийн эд хөрөнгөд бага бус бус хэмжээний, эсхүл түүнээс дээш хэмжээний хохирол учруулсан, эсхүл эрүүл мэндэд нь гэмтэл санаатай учруулсан, учруулахыг завдсан, эсхүл бэлэглэгчийн гэрээг хүчингүй болгоход саад учруулсан бол” гэж өөрчлөн тусгах саналтай байна.
- 2) ИХ-ийн 280 дугаар зүйлийн 280.1.2 “бэлэг хүлээн авагч нь бэлэглэгчийн, эсхүл түүний төрөл төрөгсдийн эрүүл мэнд, амь насыг санаатай хохироосон буюу хохироохыг завдсан” гэх заалтыг “Бэлэг хүлээн авагч нь бэлэглэгчийн болон түүний гэр бүлийн гишүүд, цусан төрөл төрөгсдийн амь

*насыг санаатай хохироосон, эсхүл хохироохыг завдсан, эсхүл бэлэг хүлээн авагчийн хууль бус, гэм буруутай үйлдлийн улмаас бэлэглэгч эрх зүйн чадамжгүй болсон бол” гэж өөрчлөн тусгах саналтай байна.*

Хууль хэрэглээтэй холбоотой санал:

- 1) Бэлэг хүлээн авагч нь тусгай зориулалттай хийсэн “Бэлэглэлийн гэрээ”-ний үүргээ биелүүлээгүй тохиолдолд ИХ-ийн 280 дугаар зүйлийн 280.1 дэх хэм хэмжээг хэрэглэхгүй байх, харин ИХ-ийн 279 дүгээр зүйлийн 279.3 дахь зохицуулалтыг хэрэглэх;
- 2) ИХ-ийн 56 дугаар зүйлийн 56.1.3 “Өөр хэлцлийг халхавчлах зорилгоор хийсэн хэлцэл” гэж үзэж, бэлэглэлийн гэрээг хүчин төгөлдөр бус гэж үзэж байгаа тохиолдолд халхавчлагдаж буй гэрээг хүчин төгөлдөр эсэхэд дүгнэлт өгч, шүүхийн шийдвэрт тусгах;
- 3) Гэр бүлийн гишүүдийн хамтран өмчлөх дундын эд хөрөнгийг гэр бүлийн насанд хүрсэн гишүүний зөвшөөрөлгүйгээр бусдад бэлэглэсэн тохиолдолд ИХ-ийн 56 дугаар зүйлийн 56.1.8, 56.5 дахь зохицуулалтыг хэрэглэх;
- 4) Бэлэглэлийн гэрээг ИХ-ийн 280 дугаар зүйлийн 280.1-д заасан үндэслэлээр хүчингүйд тооцохдоо бэлэглэлийн зүйл нь бэлэглэгчийн өөрийнх нь өмчлөлийн хөрөнгө мөн эсэх, буцаан шаардах хөрөнгө мөн эсэх, бэлэглэгч бэлэг хүлээн авагчийг тус үйлдэл хийхэд өдөөн хатгасан эсэх, бэлэг хүлээн авагчийн тухайн үйлдлийг бэлэглэгч хувь хүний хувьд хүлцэн тэвчиж, ойлгох боломжтой байсан эсэх, бэлэглэлийн гэрээг хүчингүйд тооцох нэхэмжлэл гаргах хөөн хэлэлцэх хугацаа дууссан эсэхийг харгалзаж хэрэглэх;

- 5) ИХ-ийн 280 дугаар зүйлийн 280.1.2 дахь үндэслэлийг хэрэглэхдээ ИХ-ийн 280 дугаар зүйлийн 280.1.1-д заасан үндэслэлд багтааж хэрэглэх бус, ялгамжтай байдлаар хэрэглэх;
- 6) Бэлэглэлийн зүйлийг захиран зарцуулах эрхийг бэлэглэлийн гэрээгээр хязгаарласан эсэхэд дүгнэлт өгч, хэрэв бэлэглэлийн зүйлийг захиран зарцуулах эрхэд хязгаар тогтоогоогүй, болзол тавиагүй бол бэлэг хүлээн авагч бэлэглэлийн зүйлийг захиран зарцуулсан үйлдлийг “гомдоосон ноцтой үйлдэл”-д хамааруулж, хэрэглэхгүй байх гэсэн саналтай байна.



## **ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ**

### **Хууль тогтоомж**

1. МУ-ын Иргэний хууль, <https://legalinfo.mn/mn>
2. ХБНГУ-ын Иргэний кодекс, <https://www.gesetze-im-internet.de/>
3. БНХАУ-ын Иргэний хууль, [www.gov.cn](http://www.gov.cn)
4. БНСУ-ын Иргэний хууль, <https://elaw.klri.re.kr/>

### **Ном, сурах бичиг**

1. Ж.Оюунтунгалаг, Иргэний эрх зүй II: Гэрээний үүрэг, 2022.
2. Б.Буянхишиг, Иргэний эрх зүйн тусгай анги, 2021.
3. Ё.Кают нар, Монгол Улсын Иргэний хуулийн тайлбар, 2015.
4. Ц.Амарсайхан нар, Монгол Улсын Иргэний хуулийн тайлбар, 2007.
5. А.Янжиндолгор, Монгол хэлний тайлбар толь, 2011.
6. И.Дамбажав, Д.Алтан-Од, Д.Солонго, Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь бичиг, 2006.
7. Я.Цэвэл, Монгол хэлний товч тайлбар толь, 1996.
8. Б.Буянхишиг, Иргэний эрх зүйн тусгай анги: Гэрээний эрх зүй, 2015.
9. Э.Байгаль, Иргэний эрх зүй: Ерөнхий анги, 2009.

10. Б.Буянхишиг, Иргэний эрх зүйн удиртгал, 2012.
11. Б.Тэмүүлэн, Д.Энхзул, Б.Буянхишиг, Иргэний эрх зүй ерөнхий анги, 2013.
12. Dannemann/Schule, German Civil code: Article by Article Commentary, Volume I: Books 1-3, 2020.

### **Ашигласан шүүхийн шийдвэрүүд**

1. Улсын Дээд шүүхийн 2018 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн 01379 дугаартай тогтоол.
2. Улсын Дээд шүүхийн 2013 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн 563 дугаартай тогтоол.
3. Улсын Дээд шүүхийн 2022 оны 05-р сарын 05-ны өдрийн 568 дугаартай тогтоол.
4. Улсын Дээд шүүхийн 2018 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн 01379 дугаартай тогтоол.
5. Улсын Дээд шүүхийн 2019 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн 867 дугаартай тогтоол.
6. Улсын Дээд шүүхийн 2009 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн 145 дугаартай тогтоол.
7. Улсын Дээд шүүхийн 2010 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 66 дугаартай тогтоол.
8. Улсын Дээд шүүхийн 2013 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн 253 дугаартай тогтоол.
9. Орхон аймгийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2018 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн 59 дугаартай магадлал.
10. Нийслэлийн Иргэний хэргийн Давж заалдах шатны шүүхийн 2016 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн 1709 дугаартай магадлал.
11. Нийслэлийн Иргэний хэргийн Давж заалдах шатны шүүхийн 2013 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн 467 тоот магадлал.

12. Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2008 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 63 дугаартай магадлал.
13. Нийслэлийн Давж заалдах шатны шүүхийн 2020 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн 1100 дугаартай магадлал.
14. Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2019 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн 915 дугаартай магадлал.
15. Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2019 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн 80 дугаартай магадлал.
16. Сэлэнгэ аймгийн Давж заалдах шатны шүүхийн 2009 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 05 дугаартай магадлал.
17. Баян-Өлгий аймгийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2009 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн 94 дугаартай магадлал.
18. Нийслэлийн Иргэний хэргийн Давж заалдах шатны шүүхийн 2013 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн 214 дугаартай магадлал.
19. Орхон аймаг дахь сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2018 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн 232 дугаартай шийдвэр.
20. Сүхбаатар дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2012 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн 1476 дугаартай шийдвэр.
21. Баянзүрх, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2016 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн 00168 дугаартай шийдвэр.
22. Нийслэлийн Баянгол дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2013 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн 876 дугаартай шийдвэр.
23. Сонгинохайрхан дүүргийн Иргэний хэргийн анхан шатны

- шүүхийн 2007 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн 1139 дугаартай шийдвэр.
24. Хан-Уул дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн 00707 дугаартай шийдвэр.
  25. Дүүргийн Иргэний хэргийн анхан шатны 2 дугаар шүүхийн 2014 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 2335 дугаартай шийдвэр.
  26. Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2019 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн 389 дугаартай шийдвэр.
  27. Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2018 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн 2207 дугаартай шийдвэр.
  28. Сэлэнгэ аймаг дахь сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2008 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн 529 дугаартай шийдвэр.
  29. Баян-Өлгий аймаг дахь сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2007 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн 270/А дугаартай шийдвэр.
  30. Баянгол дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2013 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 146 дугаартай шийдвэр.

# ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН СУДАЛГАА ХАРИУЦСАН РЕДАКЦЫН ЗӨВЛӨЛИЙН ТАНИЛЦУУЛГА

ДАШНЯМЫН ЗОЛЖАРГАЛ (LL.M.)  
GREEN CLIMATE FUND, АХЛАХ ХУУЛЬЧ



Д.Золжаргал нь Монголын санхүү, хөрөнгийн зах зээлийн чадварлаг мэргэжилтнүүдийн нэг бөгөөд компанийн эрх зүй, эрчим хүч, эрдэс баялгийн салбараар мэргэшсэн хуульч юм. ОУ-ын байгууллагад уригдан ажиллахаасаа өмнө монголын томоохон арилжааны банк, бүс нутагт хүлээн зөвшөөрөгдсөн тэргүүлэх хуулийн фирм байгуулж ажилласан туршлагатай.

МУИС-ийн ХЗС-ийн Олон улсын эрх зүйн бакалавр, 2004 онд АНУ-ын Оклахомагийн их сургуулийг Бизнесийн удирдлагын магистр, Харвардын их сургуулийн Хуулийн сургуулийг Хууль зүйн магистр зэрэгтэй тус тус дүүргэсэн.

СҮХЭЭГИЙН БИЛГҮҮН (LL.M.)  
ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ХӨГЖЛИЙН ХҮРЭЭЛЭНГИЙН СУДЛААЧ



С.Билгүүн нь хууль зүйн судалгаа, сургалт, шүүхийн захиргааны чиглэлээр ажилладаг.

Монгол Улсын Их Сургуулийн Хууль зүйн сургуульд суралцаж, “Монгол Улсад эрх зүйн зайлшгүй процессыг төлөвшүүлэх нь” сэдвээр, Япон улсын Кьюсюгийн их сургуульд суралцаж “Монгол Улс дахь нийтийн ашиг сонирхлыг шүүхэд төлөөлөн хамгаалах тогтолцоог бэхжүүлэх нь” сэдвээр хууль зүйн магистрын зэрэг тус тус хамгаалсан.

Харьцуулсан эрх зүй, хүний эрхийн чиглэлээр судалгаа хийдэг.



**НАРАНЧУЛУУНЫ ОТГОНЧИМЭГ (LL.M.)  
ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮН**



Н.Отгончимэг нь Захиргааны эрх зүйн чиглэлээр мэргэшсэн хуульч, судлаач бөгөөд УИХ-ын тамгын газар, Олон улсын хөгжлийн хөтөлбөрүүдэд зөвлөх хийх зэргээр мэргэжлээрээ 22 жил ажилласан туршлагатай хуульч юм. 2021 оноос УДШ-ийн дэргэд байгуулагдсан Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн захирлаар ажиллаж байна.

МУИС-ийн ХЗС-ийг Магистрын зэрэгтэй, Лондоны Kings college-ийг Хууль зүйн Магистр зэрэгтэй төгссөн.

**ГАНЧУЛУУНЫ ОЮУНБОЛД (LL.M.),  
МХХ-НЫ ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН ХОРООНЫ ТЭРГҮҮН**



Г.Оюунболд нь криминологи, эрүүгийн болон эрүүгийн байцаан шийтгэх эрх зүй, шүүхийн шийдвэр биелүүлэх эрх зүйн чиглэлээр мэргэшиж судалдаг практикийн болон судалгааны байгууллагад 18 жил ажилласан туршлагатай.

Цагдаагийн академид эрх зүйн бакалавр зэрэгтэй төгсөж “Эрүүгийн байцаан шийтгэх хугацаа” сэдвээр хууль зүйн ухааны магистр зэрэг хамгаалсан. Хүмүүнлэгийн ухааны их сургуульд Менежментийн бакалаврын зэрэгтэй мэргэжлийн англи хэлний ангид суралцан төгссөн.

**АЛТАНГЭРЭЛИЙН БЯМБАЖАРГАЛ (S.J.D.),  
МУ-ЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ХУУЛЬ ЗҮЙН БОДЛОГЫН ЗӨВЛӨХ**



МУИС-ийн ХЗС-д төрийн захиргаа, Монгол Улсын Үндсэн хуулийн эрх зүй, ҮХ-ийн процессын эрх зүй, харьцуулсан эрх зүйн хичээл заадаг. ХЗС-ийн эрдэмтэн нарийн бичгийн даргын хувиар эрдэм шинжилгээний ажил, бүтээл туурвил, Эрх зүй улирал тутмын сэтгүүлийг эрхлэн гаргах ажлыг хариуцан ажиллаж байв. 2021 оноос МУ-ын Ерөнхийлөгчийн Хууль зүйн бодлогын зөвлөхөөр томилогдон ажиллаж байна.

МУИС-ийн ХЗС-ийг дүүргэж, БНСУ-ын Күүкмений сургуульд Хууль зүйн докторын зэрэг хамгаалсан.

